



ЖИЛИЙН ТАЙЛАН 2012

АГУУЛГА

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН МЭНДЧИЛГЭЭ	3
ЭДИЙН ЗАСГИЙН ТОЙМ	6
ЭДИЙН ЗАСГИЙН ӨСӨЛТ	6
ИНФЛЯЦИ	7
ГАДААД ХУДАЛДАА	8
САНХҮҮГИЙН ЗАХ ЗЭЭЛ	8
УЛСЫН ТӨСӨВ	8
БАЙГУУЛЛАГЫН ХӨГЖИЛ	9
ХЭТИЙН ЗОРИЛГО, ЭРХЭМ ЗОРИЛГО	10
КОМПАНИЙН ЗАСАГЛАЛ	10
ХУВЬ НИЙЛҮҮЛЭГЧИД	11
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛ	11
БАЙГУУЛЛАГЫН БҮТЭЦ	12
УДИРДЛАГЫН БАГ	14
ХҮНИЙ НӨӨЦ	16
ДЭД БҮТЭЦ	18
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТОЙМ	19
ИРГЭДИЙН БАНКНЫ ҮЙЛ АЖИЛЛАГАА	19
САНХҮҮГИЙН БАЙГУУЛЛАГУУД БА ХУДАЛДААНЫ САНХҮҮЖИЛТ	22
БАЙГУУЛЛАГЫН БАНКНЫ ҮЙЛ АЖИЛЛАГАА	24
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН БАНКНЫ ҮЙЛ АЖИЛЛАГАА	24
НӨӨЦИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА	26
САНХҮҮГИЙН ҮР ДҮН	27
ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГА БА ХЯНАЛТ	31
КОМПАНИЙН НИЙГМИЙН ХАРИУЦЛАГА	44
ХАРИЛЦАГЧ БАНКУУД	47
САЛБАР СҮЛЖЭЭ	48
ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	51





ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН МЭНДЧИЛГЭЭ

Гүйцэтгэх захирал
Г.ГАНБОЛД



Голомт банк нь 2012 онд банкны системдээ санхүүгийн зохистой харьцааны хамгийн эрсдэлгүй, сайн үзүүлэлтүүдийг хадгалсан хэвээр байна. Үүнд: Өөрийн хөрөнгийн хүрэлцээ 13.3 хувь; Төлбөр түргэн гүйцэтгэх чадвар банкны системийн хамгийн өндөр буюу 41.1 хувь; Зээл татан төвлөрүүлсэн хөрөнгийн харьцаа системийн хамгийн бага буюу 69.4 хувь байлаа.

Эрхэм хүндэт харилцагчид, хувьцаа эзэмшигчид, түншүүд болон хамтран ажиллагсад аа!

Та бүхэнд Голомт банкныхаа амжилт бүтээлийн 18 дахь жил, 2012 оны үйл ажиллагааны үр дүнг тайлагнаж байгаадаа баяртай байна.

2012 он дэлхийн ихэнх хөгжингүй орнуудын эдийн засаг сулхан өсөлттэй, харин хөгжиж буй орнуудын эдийн засгийн өсөлт удааширсан он байлаа. Евро бүсийн өрийн хямрал болон АНУ-ын бодлогын тодорхойгүй байдал нь тэдгээр бүс нутгуудад хөрөнгө оруулалт, ажил эрхлэлтийн түвшин буурах шалтгаан болсноор хөгжиж буй орнуудын, тэр дундаа БНХАУ-ын аж үйлдвэрийн бараа бүтээгдэхүүний эрэлт буурахад нөлөөлсөн. Энэ нь дэлхийн зах зээл дээрх түүхий эдийн үнэ буурах шалтгаан болж Канад, Австрали болон бусад байгалийн баялагт суурилсан эдийн засагтай орнуудын өмнө томоохон сорилт бий болсны дотор Монгол Улс ч мөн багтаж байна.

Монголын нүүрсний экспортын хэмжээ 2012 онд төдийлөн буураагүй боловч нүүрсний борлуулалтын үнэ 15 хувиар унаснаас нүүрсний экспортын орлого 400 сая ам.доллараар буурсан байна. Энэ нь өмнөх онд 17.5





хувьтай байсан Монгол Улсын эдийн засгийн өсөлтийг өнгөрөгч онд 12.3 хувь болж буурахад нөлөөлжээ. Харин 2012 онд Монголын хөдөө аж ахуйн салбар түүхэн өндөр буюу бодит дүнгээр 21.3 хувиар өссөн нь эдийн засгийн өсөлтөд чухал нөлөө үзүүлж, мөн бусад салбарын тогтвортой өсөлтийн дүнд Монгол Улс эдийн засгийн өсөлтөөр дэлхийд тэргүүлэх байр сууриа хадгалсан билээ.

Эдийн засаг дахь нийт мөнгөний нийлүүлэлт 7.6 их наяд төгрөгт хүрч өссөн боловч энэ нь өмнөх оны өсөлтөөс хоёр дахин бага байлаа. Монголбанкны зүгээс мөнгөний бодлогыг чангатгаж банкуудын заавал байлгах нөөцийг 13 хувьд, бодлогын хүүг 13.25 хувь хүргэж тус тус өсгөсөн. Эдгээр болон бусад хүчин зүйлс нь 2012 онд хадгаламж болон зээлийн хүү нэмэгдэхэд нөлөөлсөн байна.

Дээрх тийм ч таатай биш гадаад хүчин зүйлсийн нөхцөлд Голомт банк өөрийн дотоод нөөц бололцоо, найдвартай сайн харилцагчид, чадварлаг хичээнгүй ажиллагсдынхаа хүчээр тайлант онд амжилттай ажиллан нийт активын хэмжээг өмнөх оноос 18 хувиар өсгөж 2.53 их наяд төгрөгт хүрсэн нь Монголын банкны системийн 21.1 хувийг эзэлж байна. Харилцагчдаас татсан хадгаламжийн хэмжээгээр системдээ тэргүүлэгч хэвээр байгаа бөгөөд тус онд 12 хувиар өсч 2.06 их наяд төгрөг болсон нь банкны системийн 26 хувийг эзэлж байна. Нийт зээлийн хэмжээ 14 хувиар өсч 1.43 их наяд болсон нь системийн 20.6 хувийг эзэлж байна. Нийт өөрийн хөрөнгийн хэмжээ 18.2 хувиар өсч 222.1 тэрбум төгрөг болсон. Үүнээс 1-р зэрэглэлийн өөрийн хөрөнгө 48.2 тэрбум төгрөгөөр өсч 187.3 тэрбум төгрөг болсон байна. Энэ нь Trafigura Beheer B.V. компанийн Голомт банкны хувьцаанд оруулсан 21 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалт болон банкны тус оны 26.6 тэрбум төгрөгийн цэвэр ашиг нэмэгдсэнтэй холбоотой юм.

Тайлант онд шинээр 12 нэгж байгуулж, нийт салбар, тооцооны төвийн тоо 92 боллоо. Биет салбараас гадна банк нь орлого хүлээн авах 6 машиныг суурилуулан, “Өөртөө үйлчлэх банк”-ны цогц үйлчилгээ бүхий 3 нэгжийг Монгол Улсад анх удаа ашиглалтад орууллаа. Мөн нийт АТМ-ийн сүлжээний тоог 36 хувиар нэмэгдүүлж 165-д хүргэлээ.

Арилжааны банкуудаас анх удаа ухаалаг утсанд зориулсан банкны аппликэйшн болох “Смарт банк”

үйлчилгээг бий болгов. Уг аппликэйшн нь “App Store”-ийн “Монгол Улсын №1 Санхүүгийн Аппликэйшн” нэр хүндийг хүртэж, Монголын Үндэсний Худалдаа Аж Үйлдвэрийн Танхимаас “Олны Таашаалд Нийцсэн Бүтээгдэхүүн Үйлчилгээ” шагналыг авсан юм.

Банкны бизнесийн амжилтын гол тулгуур хүчин зүйлсийн нэг нь аюулгүй байдлыг өндөр түвшинд хамгаалсан мэдээллийн технологийн сайн систем, дэд бүтэц юм. Бид тайлант онд банкныхаа мэдээллийн технологийн аюулгүй байдалд олон улсад нэр хүнд бүхий Deloitte & Touche Enterprise Risk Services –ээр аудит хийлгэж, мэдээллийн аюулгүй байдлын бодлогын баримт бичгийг олон улсын ISO 27001 стандартад нийцүүлэн боловсруулах, банкны нөөц төвийг шинэчлэн байгуулах, дэд бүтцийн өргөтгөл болон тоног төхөөрөмжийн шинэчлэлийг үе шаттай хийх, 24/7 мониторингийн системийг сайжруулах зэрэг олон ажлуудыг хийв. Олон үе шаттай сонгон шалгаруулалтын үр дүнд банкны үндсэн бүртгэлийн системийг шинэчлэхэд хамтран ажиллах компаниар дэлхийд тэргүүлэгч систем нийлүүлэгч болох InfoSys компанийг сонгож хамтран ажиллаж эхлэв.

Голомт банк нь 2012 онд банкны системдээ санхүүгийн зохистой харьцааны хамгийн эрсдэлгүй, сайн үзүүлэлтүүдийг хадгалсан хэвээр байна. Үүнд: Өөрийн хөрөнгийн хүрэлцээ 13.3 хувь; Төлбөр түргэн гүйцэтгэх чадвар банкны системийн хамгийн өндөр буюу 41.1 хувь; Зээл татан төвлөрүүлсэн хөрөнгийн харьцаа системийн хамгийн бага буюу 69.4 хувь байлаа.

2012 оны байдлаар Moody’s нь Голомт банкинд санхүүгийн чадамжаар E+, дотоод валютын нөөцөөрөө B1, тогтвортой төлөвтэй гэсэн үнэлгээг тус тус өгөөд байна. Түүнчлэн Standard and Poor’s байгууллагаас Голомт банкны урт хугацааны төлбөр түргэн гүйцэтгэх чадварт B+, богино хугацааны төлбөр түргэн гүйцэтгэх чадварт B үнэлгээнүүдийг өгөв. Энэ нь Голомт банк нь дотоодын банк санхүүгийн салбартаа тэргүүлэгч байр суурь эзэлдэгийн зэрэгцээ, тал бүрийн хөрөнгийн эх үүсвэрийг цогцлоож чадсан хүчирхэг банк болохыг бататгаж буй хэрэг юм.

Компанийн нийгмийн хариуцлагын хүрээнд Голомт банк нь байгаль орчинд хор хөнөөлтэй бизнесийн төслийг дэмжихгүй зээлийн бодлогыг хэрэгжүүлэхийн зэрэгцээ өнгөрөгч онд Эко бизнес төслийн зээлийн уралдааныг

зохион байгуулж шалгарсан байгальд ээлтэй төслийг бага хүүтэй зээлээр санхүүжүүлж эхэллээ. Голомт банкны нэрэмжит оюутны Эрдэм Шинжилгээний Бага Хурлыг 11 дэх удаагаа, “Оюутны тэтгэлэгт хөтөлбөр”-ийг 10 дахь жилдээ амжилттай зохион байгуулж боловсролын салбарт өөрийн хувь нэмрээ оруулж байна. Мөн соёл урлаг, спортын салбарын хөгжилд дэмжлэг үзүүлэн ажиллаж Монголын Үндэсний Олимпын Хорооны “Алтан Түнш”, Монгол Улсын Морин Хуурын Чуулгын Албан ёсны түншээр ажиллаж, Дуурь Бүжгийн Эрдмийн Театрыг 5 жил дараалан дэмжиж ажиллалаа.

Банкны үнэт зүйл болох хүний нөөцийн бодлогод онцгой анхаарч тайлант онд 300 гаруй чадварлаг ажилтнаар бүл нэмж нийт 1,655 ажилтантай боллоо.

Ажилтнуудаа урт хугацаанд тогтвортой ажиллахад шаардлагатай урамшууллын системийг бий болгох, тэдний байгууллага дахь оролцоог нэмэгдүүлэх, мэргэжлийн ур чадварыг дээшлүүлэхэд чиглэсэн бодлого гарган хэрэгжүүлэв. Ажилтнуудын бүтээмжийг дээшлүүлэх, санхүүгийн баталгаагаар хангах хувийн тэтгэврийн хөтөлбөр, ажилтнуудад хувьцаа эзэмшүүлэх хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэн ажиллаж байна.

Монгол Улс томоохон бүтээн байгуулалтын үйлсийг эхэлж буй өнөө үед Голомт банк Та бүхэнтэйгээ мөр зэрэгцэн, улсынхаа хөгжилд гар бие оролцож, санхүүгийн хамгийн таатай цогц үйлчилгээг үзүүлж, нийгмийн хариуцлагатай, тэргүүлэгч банк байх зорилтоо хэрэгжүүлэн ажиллах болно.



Гүйцэтгэх захирал
Г.ГАНБОЛД

ЭДИЙН ЗАСГИЙН ТОЙМ




6

Уул уурхайн салбарын бууралтаас хамаарч Монголын эдийн засгийн өсөлт 2012 онд удааширсан хэдий ч хөдөө аж ахуйн салбарын өсөлт, оновчтой төсөв, мөнгөний бодлогын үр дүнд хоёр оронтой тоонд хэвээр хадгалагдав.

ЭДИЙН ЗАСГИЙН ӨСӨЛТ

Манай улсын Дотоодын Нийт Бүтээгдэхүүн (ДНБ) 2011 онд 11.1 их наяд төгрөг байсан бол 2012 онд 13.9 их наяд төгрөгт хүрч 25.8 хувиар өсчээ. Харин бодит ДНБ 2011 онд 17.5 хувиар өсч байсан бол 2012 онд 12.3 хувиар өсч өсөлтийн хурд нь саарчээ. Өсөлтийн хурд саарахад голчлон бүтээгдэхүүний цэвэр татварын орлогын өсөлтийн сааралт нөлөөлөв. Бүтээгдэхүүний цэвэр татварын орлого 2011 онд бодит дүнгээр 57.9 хувиар өсч байсан бол 2012 онд ердөө 6.1 хувиар нэмэгджээ. Татварын орлого өсч чадаагүй нь нүүрсний экспорт буурсантай холбоотой.


Бодит ДНБ-ий өсөлт (%)



ИНФЛЯЦИ

Улсын инфляцийн түвшин 2011 онд 10.2 хувь байсан бол 2012 онд 14 хувьд хүрч бага зэрэг хурдасчээ. Үүнээс хүнсний бараа, согтууруулах ундааны үнэ 17.5 хувиар, хувцас бөс барааны бүлгийн үнэ 16.1 хувиар, орон сууц ус цахилгаан түлшний бүлгийн үнэ 11 хувиар, боловсролын үйлчилгээ 15.2 хувиар тус тус өсчээ. Хүнсний бүтээгдэхүүний үнийн өсөлтөд мах махан бүтээгдэхүүний үнэ 43.7 хувиар, жимс жимсгэнэ 21 хувиар өссөн нь голчлон нөлөөлсөн байна.

Инфляцийн задаргаа (%)




ГАДААД ХУДАЛДАА

Нийт экспортын 93 хувийг БНХАУ, 2.7 хувийг Канад, 1.8 хувийг ОХУ, харин нийт импортын 27.6 хувийг БНХАУ, 27.4 хувийг ОХУ, 8 хувийг АНУ тус тус эзэлж байна.

Нийт экспортын 89 хувийг эрдэс бүтээгдэхүүн, 5.3 хувийг нэхмэл бүтээгдэхүүн, 2.8 хувийг металллаг гоёлын зүйлс тус тус эзэлж байна. Эрдэс бүтээгдэхүүний экспорт 2011 онд 4.3 тэрбум ам.долларт хүрч байсан бол 2012 онд 3.9 тэрбум ам.доллар болж 9.1 хувиар буурсан бөгөөд үүнд голчлон нүүрс, зэсийн баяжмалын экспортын бууралт нөлөөлсөн байна.

Гадаад худалдаа (сая ам.доллараар)






САНХҮҮГИЙН ЗАХ ЗЭЭЛ

Эдийн засаг дахь нийт мөнгөний нийлүүлэлт буюу M2 мөнгө 2012 онд 7.6 их наяд төгрөгт хүрч өмнөх оноос 1.2 их наяд төгрөгөөр өсчээ. Мөнгөний нийлүүлэлт өссөн хэдий ч жилийн өсөлтийн хурд нь 2010 онд 62.6 хувь, 2011 онд 37 хувь байсан бол 2012 онд 18.8 хувьд хүрч саараад байна. Санхүүгийн зах зээлийн хөгжлийг хэмжигч үзүүлэлт болох M2 мөнгөний ДНБ-д эзлэх хувь 2011 онд 57.8 хувь байсан бол 2012 онд 54.6 хувь болж бага зэрэг буурчээ.

Санхүүгийн зах зээлийн мөчлөг




Банкуудын нийт зээлийн өрийн үлдэгдэл 2011 онд 5.6 их наяд төгрөг байсан бол 2012 онд 7 их наяд төгрөгт хүрч 1.4 их наяд төгрөгөөр нэмэгджээ. Гэсэн хэдий ч зээлийн багцын жилийн өсөлт 2011 онд 72.8 хувь байсан бол 2012 онд 23.9 хувьд хүрч саараад байна. Банкуудын чанаргүй зээлийн нийт зээлийн багцад эзлэх хувь 2011 онд 2.9 байсан бол 2012 онд 2.1 хувьд хүрч тасралтгүй буурсаар байгаа нь дотоод эдийн засагт нэмж зээл олгох бизнесийн орчин байсаар байгааг илэрхийлж байна.

УЛСЫН ТӨСӨВ

Өнгөрсөн 2012 онд улсын нэгдсэн төсвийн нийт орлого 4 их наяд 968.3 тэрбум төгрөгт хүрч өмнөх оноос 11.2 хувиар, төсвийн нийт зарлага, эргэж төлөгдөх цэвэр зээлийн дүн 6 их наяд 43.9 тэрбум төгрөгт хүрч өмнөх оноос 20.9 хувиар тус тус өсчээ. Ингэснээр төсвийн нийт алдагдал 1 их наяд 75.7 тэрбум төгрөг буюу ДНБ-ий 7.7 хувьтай тэнцэх хэмжээнд хүрсэн байна.

Улсын Нэгдсэн Төсөв (тэрбум төгрөгөөр)



БАЙГУУЛЛАГЫН ХӨГЖИЛ

Компанийн засаглалын бүтцийг дэмжих үүднээс бид дотоод хяналт шалгалт, тэнцвэрт байдлын тогтолцоог Хороодын үйл ажиллагаагаараа дамжуулан хэрэгжүүлж, олон улсын жишигт нийцүүлдэг.


ХЭТИЙН ЗОРИЛГО, ЭРХЭМ ЗОРИЛГО

Эрхэм зорилго

Санхүүгийн цогц үйлчилгээ үзүүлдэг, өндөр үр ашиг бүхий хөгжих чадвартай, нийгмийн хариуцлагатай, тэргүүлэгч банк байна.

Хэтийн зорилго

Монголын банкны салбарт тэргүүлэгч, дэлхийн жишигт нийцсэн үйл ажиллагаатай, нэр хүнд бүхий найдвартай банк байна.






КОМПАНИЙН ЗАСАГЛАЛ

Бидний амжилтын нэгэн чухал хэсэг бол компанийн сайн засаглал билээ. Компанийн засаглалын бүтцийг дэмжих үүднээс бид дотоод хяналт шалгалт, тэнцвэрт байдлын тогтолцоог Хороодын үйл ажиллагаагаараа дамжуулан хэрэгжүүлж, олон улсын жишигт нийцүүлдэг. Банкны удирдлага нь томоохон хувьцаа эзэмшигчдийн аливаа зохист бус нөлөөллөөс ангид бие даасан үйл ажиллагаа явуулдаг бөгөөд Төлөөлөн Удирдах Зөвлөл болон Хорооддоо хараат бус гишүүдтэй юм. Үйл ажиллагаагаа ил тод, нээлттэй байдлаар Аудит, Эрсдэлийн Удирдлага, Цалин Урамшуулал, Нэр Дэвшүүлэх Хороодоор дамжуулан Төлөөлөн Удирдах Зөвлөлд гүйцэтгэх удирдлага танилцуулдаг нь хууль болон дотоодын дүрэм журмын хэрэгжилтийг хянах тогтолцоог бий болгодог.

Голомт банк нь Олон Улсын Санхүүгийн Тайлагналын стандартыг дагаж мөрдөн ил тод, нээлттэй байдлыг эрхэмлэн ажилладаг. 2010 онд шинэчлэгдэн батлагдсан Банкны тухай хууль, олон улсын жишигт нийцүүлэн компанийн засаглалын хэм хэмжээний цогц байдлыг ханган ажиллаж байна. ТУЗ-д харъяалагдан үүрэг хариуцлага хүлээдэг хороодууд нь одоо байгаа болон шинээр сонгогдсон ТУЗ-ийн гишүүдийн хувь нэмэр, оролцооны хүрээнд улам сайжран бэхжсээр байна.

Компанийн засаглалын бүтэц



ХУВЬ НИЙЛҮҮЛЭГЧИД

	31/12/2011	31/12/2012
Бодь Интернэшнл ХХК	89.19%	84.66%
Swiss-MO Investment AG	10.7%	10.16%
Trafigura Beheer B.V.	-	5.02%
Ажилтнуудад Хувьцаа Эзэмшүүлэх Хөтөлбөр	0.10%	0.16%
Нийт	100%	100%

Бодь Интернэшнл ХХК

Бодь Интернэшнл ХХК нь Бодь Группийн толгой компани бөгөөд банк санхүү, үл хөдлөх хөрөнгийн удирдлага, хөдөө аж ахуй, худалдаа үйлчилгээ, барилга хөрөнгө оруулалт зэрэг салбаруудад идэвхитэй үйл ажиллагаа явуулдаг ба 2700 гаруй ажиллагсадтай Монголын тэргүүлэгч группуудын нэг юм. Групп нь оновчтой менежмент, чадварлаг, бүтээлч баг хамт олны хүч хөдөлмөрөөр үйл ажиллагаагаа амжилттай явуулж, жилээс жилд өргөжин тэлж улс орныхоо нийгэм эдийн засгийн хөгжилд хувь нэмрээ оруулсаар байна.

Swiss-MO Investment AG

Swiss-MO Investment AG нь хөрөнгө оруулалтын сан бөгөөд дэлхий даяар үйл ажиллагаагаа явуулж хөрөнгө оруулалтын худалдан авалт, худалдаа, удирдлагыг хэрэгжүүлж хөрөнгө оруулалтын зөвлөгөөг өгдөг. Уг компани нь Швейцарийн Гризонс-д үүсгэн байгуулагдсан бөгөөд гол хувьцаа эзэмшигч нь Швейцарийн нэртэй бизнесмэн, санхүүч, Швейцарь дах өргөмжит Консул Ноён Урс И. Шварценбах билээ.

Trafigura Beheer B.V.

Trafigura Beheer B.V. нь 1993 онд үүсгэн байгуулагдсанаас хойш дэлхийн газрын тосны гурав дах том төмөр агуулаагүй баяжмалын газрын тосны арилжаалагч болж чадсан олон улсын корпораци юм.

Ажилтнуудад Хувьцаа Эзэмшүүлэх Хөтөлбөр (АХЭХ)

Ажилтнуудад Хувьцаа Эзэмшүүлэх Хөтөлбөрийг 2011 оноос хэрэгжүүлж тэдний урт хугацааны ашиг сонирхлыг хангахыг зорьсон болно. 2012 оны эцэст олон жил банкиндаа хувь нэмэр оруулсан 44 ажилтан, албан хаагчдаа шинээр Голомт банкны хувьцаа эзэмшигч болгосон нь нийт өөрийн хөрөнгийн 0.16 хувийг эзэлж байна.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛ

Төлөөлөн Удирдах Зөвлөл нь улиралд нэг удаа хуралдаж удирдлагын багт хяналт тавьж ажилладаг. Төлөөлөн Удирдах Зөвлөл нь удирдлагын багийн гишүүдийг сонгож ажиллуулдаг бөгөөд удирдлагын багтай хамтран банкны дунд болон урт хугацааны төлөвлөгөөг боловсруулдаг. Онц ач холбогдолтой шийдвэр гаргалтыг Төлөөлөн Удирдах Зөвлөлөөс хэрэгжүүлдэг бөгөөд компанийн сайн засаглал болон дотоод үйл ажиллагааны тайлагналын үр бүтээмжийг дээшлүүлэх зорилгоор ТУЗ-ийн дэргэдэх хороодуудыг ажиллуулдаг.

Төлөөлөн Удирдах Зөвлөл олон улсын банк, санхүү, бизнесийн өргөн мэдлэг туршлагатай долоон гишүүнээс бүрддэг. Энэ онд Хатагтай Ч.Мөнхцэцэг, Ноён З.Тэмүүн, Ноён Д.Мөнхтөр нарыг ТУЗ-д нэр дэвшүүлэн сонгож бүтэц бүрэлдэхүүнээ улам өргөжүүллээ.





Аудитын Хороо

Аудитын Хороо нь Төлөөлөн Удирдах Зөвлөлөөс томилогдон зөвлөлд ажлаа шууд тайлагнан ажиллах бөгөөд банкны санхүүгийн үйл ажиллагаанд хяналт тавих зорилгоор санхүү, нягтлан бодох бүртгэлийн бодлого, зарчмууд, хууль, дүрэм журмын нийцэл хийгээд хяналтын бусад тогтолцооны зохистой байдал зэргийн талаар дүгнэлт зөвлөмжүүдийг гаргах замаар хяналт тавин ажилладаг.

2010 оны Банкны тухай хуулийн дагуу Аудитын хороо нь банкны Дотоод Аудитын Газарт хяналт тавихын зэрэгцээ хөндлөнгийн аудиторуудтай хийх хамтын ажиллагааг удирдан ажилладаг.

Дотоод Аудитын Газрыг банкны Гүйцэтгэх удирдлагаас хараат бус байх бүтцийг бий болгосон. Төлөөлөн Удирдах Зөвлөл нь Аудитын хороогоор дамжуулан Дотоод аудитын газрын бүтэц, зохион байгуулалт, үйл ажиллагааны дүрэм, удирдлага, ажилтнуудын цалин урамшууллыг батлах зэргээр хяналт тавин ажилладаг.

Эрсдэлийн Удирдлагын Хороо

Эрсдэлийн Удирдлагын Хороо нь Төлөөлөн Удирдах Зөвлөлөөс томилогдон, үйл ажиллагаагаа зөвлөлд шууд тайлагнах бөгөөд банкны бүхий л эрсдэлийг удирдах зорилгоор эрсдэлийг хэмжих, хязгаарлах, сулруулах зэрэг санал зөвлөмжийг гарган ажилладаг.

Цалин Урамшуулал, Нэр Дэвшүүлэх Хороо

Цалин Урамшуулал, Нэр Дэвшүүлэх Хороо нь Төлөөлөн Удирдах Зөвлөлийн дэргэд байгуулагдсан бөгөөд ТУЗ-ийн гишүүд болон Гүйцэтгэх удирдлагыг сонгон шалгаруулах, томилох, чөлөөлөх, цалин хөлс, урамшууллын системийг боловсруулах, батлахад ТУЗ-д санал, зөвлөмж өгч хараат бус гишүүний бүрэлдэхүүнтэй ажилладаг. Хороо нь ТУЗ-н гишүүд, банкны гүйцэтгэх удирдлагатай холбоотой шалгаруулалт, цалин, урамшууллыг зөв зохистой тодорхойлж, тэдний ажлын үр дүнг хэлэлцэж, дүгнэх, ТУЗ-д санал болгох, зөвлөх зорилго, үүрэгтэй хороо юм.

БАЙГУУЛЛАГЫН БҮТЭЦ

Бид банкныхаа харилцагч төвтэй байгууллага байх үндсэн зорилтыг үндэслэн өдрөөс өдөрт өргөжин тэлж байгаа бизнесийн цар хүрээ, зах зээлийн эрэлт хэрэгцээнд тохируулж, байгууллагын бүтэц зохион байгуулалтаа тогтмол өөрчлөн сайжруулж байна.

2012 онд байгууллагын бүтэц зохион байгуулалтад дараах өөрчлөлт шинэчлэлүүдийг хийлээ.

- Монгол Улсад цахим үйлчилгээгээр тэргүүлэгч байр сууриа бэхжүүлэх зорилгоор Иргэдийн Банкны Газарт харъяалагддаг байсан Цахим Банкны Хэлтэс, Картын Удирдлагын Төвийг банкны бүтцээс хасч Цахим Банкны Газрыг шинээр байгууллаа;
- Бизнес эрхлэгчдэд бүтцэт санхүүжилтийн үйлчилгээг хүргэх үйл ажиллагааг өргөжүүлэхийн тулд Байгууллагын Банкны Газрын харьяа Төслийн Санхүүжилтийн Хэлтсийн нэрийг Бүтцэт Санхүүжилтийн Хэлтэс болгож өөрчлөв;
- Үйлчилгээ Харилцагчийн Хэлтэс буюу шинэ нэрээр Салбарын Удирдлагын Хэлтсийн чиг үүрэгт багтаж буй лавлах төв болон үйлчилгээний чанарын чиг үүргүүдийг нэгтгэж лавлах төвийн үйлчилгээ, банкны бүхий л түвшний үйлчилгээний чанарыг сайжруулах үүрэгтэй Харилцагчийн Үйлчилгээний Алба болголоо;
- Мэдээллийн Технологийн Газрын бүтэц зохион байгуулалтыг шинэчилж, өргөжүүлэн Системийн Хэлтэс, Төлөвлөлт, Хөгжүүлэлтийн Хэлтэс, Техник Үйлчилгээний Албатай болгож өөрчлөв;
- Ерөнхий Зохицуулалтын Газарт харъяалагддаг Аюулгүй Байдлын Алба нь Аюулгүй Байдлын Хэлтэс болж өөрчлөгдөв. Аюулгүй Байдлын Хэлтэс нь Хяналтын Алба ба Аюулгүй Байдлын Албатай болов.

Банкны бизнесийг дэмжих болон мэдээллийн аюулгүй байдал, эрсдэлийг зохистой түвшинд хангахад чиглэгдсэн мэдээллийн технологийн стратеги, бодлого, дэд бүтэц, хөрөнгө оруулалт, систем хөгжүүлэлт, тасралтгүй ажиллагаа болон аюулгүй байдлыг хэлэлцэх, батлах, хянах Мэдээллийн Технологийн Хороог байгуулав.

The diagram illustrates the organizational structure of the Mongolian Financial System, organized into three main functional groups:

- Төвлөлөн Удирдах Зөвлөл (Central Management Council):**
 - Эрсдэлийн Удирдлагын Хороо (Risk Management Committee)
 - Аудитын Хороо (Audit Committee)
 - Дотоод Аудитын Газар (Internal Audit Department)
 - Цалин Урамшуулал, Нэр Дрешүүлэх Хороо (Salary and Incentive Committee)
 - Гүйцэтгэх Захирал (General Director)
 - Удирдлагын Хороо (Management Committee)
- Иргэдийн Банкны Групп (Retail Bank Group):**
 - Байгууллагын Банкны Газар (Institutional Bank Department)
 - Хөрөнгийн Удирдлагын Газар (Equity Management Department)
 - Хөрөнгө Оруулалтын Банкны газар (Investment Bank Department)
 - Эзэлийн Газар (Share Department)
 - Эрсдэлийн Удирдлагын Газар (Risk Management Department)
 - Санхүү Удирдлагын Газар (Credit Management Department)
 - Цахим Банкны Газар (Fixed Income Bank Department)
 - Иргэдийн Банкны Газар (Retail Bank Department)
- Үйл Ажиллагааны Групп (Operating Group):**
 - Бүртгэл Тооцооны Газар (Registration and Accounting Department)
 - Мэдээллийн Технологийн Газар (Information Technology Department)
 - Ерөнхий Зохицуулалтын Газар (General Administration Department)

Each department is further subdivided into specific units or functions, such as 'Салбар Нэгжийн Аудитын Хэлтэс' (Branch Unit Audit Department) under Internal Audit, or 'Хүний Нөөцийн Хэлтэс' (Human Resources Department) under General Administration.

УДИРДЛАГЫН БАГ

Банк нь мэргэжлийн өндөр ур чадвар бүхий туршлагатай удирдлагын багтай бөгөөд энэ нь үйл ажиллагааны болон санхүүгийн үр дүнгээс тодорхой харагддаг. Тэдний зарим нь банк байгуулагдсан цагаас эхлэн өнөөг хүртэл ажиллаж байна. Бүтэц зохион байгуулалтын дагуу Гүйцэтгэх захирал, Үйл Ажиллагаа Хариуцсан Тэргүүн Дэд захирал, Дэд захирал, Газрын захирал гэсэн бүрэлдэхүүнтэй ажиллаж байна.



1	2	3	4		
	5	6	7	8	
		9	10	11	12

1. **Д.Мөнхтөр** Үйл ажиллагаа хариуцсан Тэргүүн Дэд захирал
2. **М.Чимэгмөнх** Дэд захирал, Санхүүгийн Удирдлагын Газрын захирал
3. **Б.Загал** Дэд захирал, Хөрөнгө Оруулалтын Банкны Газрын захирал
4. **Л.Оюун-Эрдэнэ** Дэд захирал, Байгууллагын Банкны Газрын захирал
5. **Б.Энхтуяа** Дэд захирал, Иргэдийн Банкны Газрын захирал
6. **М.Чингүн** Дэд захирал, Эрсдэлийн Удирдлагын Газрын захирал
7. **Б.Мөнхбаатар** Хөрөнгийн Удирдлагын Газрын захирал
8. **Р.Батсүрэн** Дотоод Аудитын Газрын захирал
9. **Ё.Пүрэвбат** Бүртгэл Тооцооны Газрын захирал
10. **Т.Нямсүрэн** Зээлийн Газрын захирал
11. **Н.Цэрэндаваа** Мэдээллийн Технологийн Газрын захирал
12. **З.Хайдар** Цахим Банкны Газрын захирал



ХҮНИЙ НӨӨЦ




16

Ажилдаа чин сэтгэлээсээ ханддаг, мэргэжлийн өндөр ур чадвар бүхий ажилтнууд маань манай банкны ололт амжилтыг бүтээгчид байдаг. Ажилтнуудын маань ажилдаа зориулсан хүчин чармайлт, ажлын гүйцэтгэлийн үр дүнд бид өнгөрөгч 2012 онд ч мөн адил бизнесээ амжилттай явууллаа. Банк чадварлаг ажилтнуудыг бүрдүүлэх, тэдэнд амжилттай ажиллах бүхий л талын дэмжлэг үзүүлэх зорилгоор хүний нөөцийн бодлого, карьер хөгжлийн төлөвлөгөөг амжилттай хэрэгжүүлж байна.

2012 онд банкны хүний нөөцийн бодлого нь ажилтнуудаа урт хугацаанд тогтвортой ажиллахад шаардагдах урамшууллын системийг бий болгох, тэдний байгууллага дахь оролцоог нэмэгдүүлэх, мэргэжлийн ур чадварыг дээшлүүлэхэд чиглэсэн.

Ажилтнуудын тоо



Оны эцэст банкны нийт ажилтны тоо 1655-д хүрч, үүнээс 67 хувь нь салбар нэгжээр дамжуулан харилцагчдад үйлчилгээ үзүүлж байна. Үлдсэн 33 хувь нь төвийн нэгж болон дэмжлэг үзүүлэх чиг үүрэгтэй ажиллаж байна. 2012 онд “Ажлаа зөв сонгохоос амжилт эхэлдэг” уриан дор 4 дэх удаагийн хүний нөөцийн бүрдүүлэлтийн аяныг зохион байгуулсан бөгөөд үүний үр дүнд 300 гаруй шинэ ажилтан манай гэр бүлийн гишүүн

болсон. Ажиллах хүчний энэхүү өсөлт нь бидэнд шинэ салбар нэгж нээж, бизнесийн хүрээгээ тэлэх боломжийг бий болгосон.

Хүний нөөцийн үзүүлэлтүүд

	2011	2012
Нийт ажилтнуудын тоо	1,329	1,655
Салбар, тооцооны төв	809	1,113
Төвийн нэгж	520	542
Хүйсийн харьцаа (Эрэгтэй/Эмэгтэй)	30/70	32/68
Салбар, тооцооны төв	25/75	23/77
Төвийн нэгж	32/68	46/54
Дунд түвшний удирдлага	46/54	49/51
Удирдлагын баг	75/25	71/29
Нийт ажилтнуудын дундаж нас	26.9	28.8
Мэргэжил, боловсрол		
Мэргэжил сургалт үйлдвэрлэлийн төв, бүрэн дунд	10%	9.4%
Бакалаврын зэрэг /Дотоодын их дээд сургууль/	73.4%	73%
Магистрын зэрэг /Дотоодын их дээд сургууль/	11.5%	9.8%
Бакалаврын зэрэг /Гадаадын их дээд сургууль/	3.6%	4.4%
Магистрын зэрэг /Гадаадын их дээд сургууль/	1.5%	3.4%

Цалин урамшууллын систем

Ажилтнуудыг өндөр бүтээмжтэй ажиллахад сайн боловсруулсан урамшууллын систем гол хүчин зүйл болдог. Тийм ч учраас ажиллах хүчний зардлыг үр ашигтай зарцуулах, ажилтнуудын хөдөлмөрийн бүтээмжийг дээшлүүлэх, чадварлаг ажилтнуудыг урт хугацаанд тогтвортой ажиллах боломжийг бүрдүүлэхийн тулд ажлын онцлогт тохирсон цалин урамшууллын багц системийг бий болгосон.

- Ажилтнуудад Хувьцаа Эзэмшүүлэх Хөтөлбөр: Бид ажилтнуудаа урт хугацаанд тогтвортой ажиллахад нь хөшүүрэг болох үүднээс АХЭХ-ийг хэрэгжүүлж эхлээд багагүй хугацаа өнгөрч, 2012 оны эцсээр нийт 507 ажилтан

Опционы эрх авч, үүнээс 44 ажилтан хувьцаа эзэмшигч болсон;

- Тэтгэврийн Ууган Сан: Ажилтнуудаа урт хугацаанд тогтвортой ажиллуулах, тэдэнд тэтгэвэрт гарсны дараа санхүүгийн баталгааг бий болгохын тулд Монголд анх удаа Тэтгэврийн Ууган Санг байгуулсан. 2010 онд байгуулагдсанаас хойш Голомт банкны нийт 964 ажилтан тус санд сайн дураараа элсэж, байгууллагаас тэдгээр ажилтнуудаа оруулсан хөрөнгө оруулалт өмнөх оноос 376 сая төгрөгөөр өссөн.

Цалин хөлсний бодлого

Ажилтны ажил албан тушаалын онцлог, ажлын бүтээмж, ажлын туршлага, ур чадвар, мэргэжил мэргэшлийн бэлтгэгдсэн байдлыг харгалзан нийт ажилтнуудад 6 түвшний цол олгон, түүнтэй уялдсан цалин, урамшуулал тогтоох системийг шинээр амжилттай нэвтрүүлсэн. Олгосон цолны онцлогоос хамаарч ажилтны цалин урамшуулал, албан тушаалын төлөвлөлт, сургалт хөгжлийн бодлогыг оновчтой хэрэгжүүлэх гол үндэс болж байна.

Сургалт ба хөгжил

Банкны зүгээс ажилтнуудын мэргэжлийн мэдлэгийг дээшлүүлэхэд чиглэсэн хөтөлбөрүүд, мэргэжлийн сургалтуудыг тогтмол зохион байгуулдаг.

Сургалтын үзүүлэлтүүд

		2011		2012
Сургалтын зардал /төгрөг/		315,800,659		397,845,108
Тоон үзүүлэлтүүд	Сургалтанд оролцогчид	Сургалтын цаг	Сургалтанд оролцогчид	Сургалтын цаг
Гадаад сургалт	34	1,512	28	1,372
Дотоод сургалт	2,573	30,392	2,555	47,627
Гадны сургалт	624	8,632	750	11,231
Бүгд	3,231	40,536	3,333	60,230

Бид 2012 онд дараах сургалт, хөгжлийн хөтөлбөрүүдийг зохион байгуулсан. Үүнд:

- Ирээдүйн удирдах ажилтан, залгамж халааг бэлтгэх зорилгоор “Удирдах ажилтан бэлтгэх” хөтөлбөрийг амжилттай хэрэгжүүллээ;
- Ажилтнуудыг чадваржуулах, ур чадвараа нэмэгдүүлэхэд нь банкны хүний нөөцийн бодлогын хүрээнд албан тушаалын сэлгээг амжилттай хэрэгжүүллээ;
- Ажилтнуудын албан тушаалын төлөвлөлтийн хүрээнд албан тушаал бүрийн онцлогт тохирсон Харилцааны менежер, Хянагч нягтлан бодогч, Харилцагчийн үйлчилгээний ажилтан бэлтгэх, хөгжүүлэх хөтөлбөрүүдийг тасралтгүй зохион байгууллаа;
- Ажилтнуудын мэргэжлийн мэдлэгийг дээшлүүлэх, олон улсын хэмжээнд ажиллах чадвартай ажилтнуудыг бэлтгэхийн тулд гадаад сургалтуудад тасралтгүй хамруулсаар байна. 2012 онд Энэтхэг, Герман, Сингапур, Хонгконг, Их Британи зэрэг 12 оронд зохион байгуулагдсан 30 гаруй сургалтанд ажилтнуудаа хамрууллаа;
- Олон улсын түвшинд ажиллах чадвартай ажилтнуудын тоог нэмэгдүүлэх зорилгоор “Англи хэлийг бэрхшээл биш давуу талаа болгоцгооё” хөтөлбөрийг нийт ажилтнуудын дунд амжилттай хэрэгжүүлж байна;
- Ажилтнуудын шинэ санал санаачлагыг дэмждэг, бүтээлч ажиллах орчныг бүрдүүлэхийн тулд урт хугацааны бүтээмжийн хөтөлбөр “Кайзен” системийг шинэчлэн хэрэгжүүлсэн. Өнгөрөгч онд 100 гаруй ажилтан 380 санал ирүүлж, үүнээс 8 чанарын дугуйлан шалгарч, дээрхи саналуудыг хэрэгжүүллээ;
- Голомт банкнаас гадаад улсад сургалт, судалгаа, туршлага судлах хөтөлбөрт хамрагдсан нийт ажилтнуудын гаргах шинэ санаа, санаачлагыг дэмжих, мэдээллийг нийт ажилтнуудад хүргэх, нөгөө талаас нийгэм соёлын тэргүүн туршлагаадаас өөрийн банкинд нэвтрүүлэх, хэрэгжилтэд ажилтнуудын оролцоог нэмэгдүүлэх зорилготой “Шинэ санааны форум” уулзалтыг анх удаа амжилттай зохион байгуулж, нийт 40 гаруй ажилтан мэдлэг, туршлагаа хуваалцлаа.





ДЭД БҮТЭЦ

Банкны үйл ажиллагаа бизнесийн цар хүрээ өдөр ирэх тусам өргөжин тэлж зах зээлд тэргүүлэгч байр сууриа хадгалж харилцагчдын хэрэгцээ шаардлагад нийцсэн үйлчилгээг үзүүлэхийн тулд шилдэг програм хангамж, хөрөнгө оруулалт, мэдээллийн технологийн аюулгүй байдлыг сайжруулах хэрэгцээ шаардлага, мэдээллийн технологид суурилсан бүтээгдэхүүн үйлчилгээний тоо, хамрах хүрээ нь нэмэгдсээр байна.

Тайлант онд хэрэгжүүлсэн ажлуудыг дурьдвал:

- Банкныхаа мэдээллийн технологийн аюулгүй байдлын бодлогын баримт бичгийг олон улсын ISO 27001 стандартад нийцүүлээ;
- Олон улсад нэр хүнд бүхий Deloitte & Touche Enterprise Risk Services компаниар мэдээллийн технологийн аюулгүй байдлын аудит хийлгэлээ;
- 24/7 мониторингийн систем, нууцлалын системийг сайжруулж, банкны нөөц төвийг газар хөдлөлтийн бүсээс холдуулж орчин үеийн тасралтгүй онлайн горимын ажиллагаатай нөөц төвийг шинэчлэн бий болгож нэгдсэн удирдлага бүхий дэд бүтцийн өргөтгөл болон тоног төхөөрөмжийн шинэчлэлийг үе шаттай хийж хэрэгжүүллээ;
- Хөрөнгө оруулалтын банк, хувьцааны хөрөнгө оруулалт, брокер дилер, олон улсын худалдаа болон нягтлан бодох бүртгэлийн системийг өргөжүүлж хяналт аюулгүй байдлыг сайжрууллаа;
- Байгууллага болон иргэдэд зориулсан интернэт банкны үйлчилгээг шинэчлэн сайжрууллаа;
- Ухаалаг утас (Blackberry, iPhone болон Android)-д зориулсан банкны аппликэйшн болох "Смарт банк" үйлчилгээг зах зээлд анхлан нэвтрүүлэв;
- Бэлэн мөнгө хүлээн авах үйлдэл бүхий өөртөө үйлчлэх банкны дэд бүтцийг бий болгохын зэрэгцээ олон улсын цахим төлбөр тооцооны технологийн тэргүүлэгч компани болох PBC компанитай хамтран АТМ-ийн менежментийн системээ цогц шинэчиллээ;
- Банкны утасны системийг бүрэн шинэчилж Cisco Unified IP утасны системд шилжүүлж хурал уулзалтуудыг илүү үр дүнтэй болгох үүднээс видео хурлын цогц системийг суурилуулав;
- Харилцагчтай харилцах гол суваг болсон Лавлах төвийн үйл ажиллагаанд CISCO системийг нэвтрүүлэв;
- Мөн их хэмжээний бэлэн төгрөгийн дэвсгэртийг тоолох, таних, ялгах, багцлах үйлдэл бүхий бэлэн мөнгөний цогц систем, брокер дилер болон хөрөнгийн биржтэй холбогдож ажиллах клирингийн банкны системийг шинээр нэвтрүүлэв;
- Үйл ажиллагаа хариуцсан Тэргүүн Дэд захирлаар удирдуулсан банкны мэдээллийн технологийн аюулгүй байдлыг хэлэлцэх, батлах, хянах үүрэгтэй Мэдээллийн Технологийн Хороог байгуулав.

ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТОЙМ

2012 онд зах зээлд тэргүүлэгч байгууллагын банк байр сууриа хадгалж олон улсын нэр хүндтэй банкуудтай харилцах харилцаагаа өргөжүүлэхийн зэрэгцээ иргэдийн банкны бизнес ялангуяа цахим банкны бизнесийг өргөжүүлэхэд онцгой анхаарч ажиллалаа.

ИРГЭДИЙН БАНКНЫ ҮЙЛ АЖИЛЛАГАА


Монгол Улсын эдийн засгийн эрчимтэй өсөлтийг даган өргөжин тэлж буй жижиг дунд бизнес, дунд орлоготой иргэдийн эрэлт хэрэгцээнд нийцсэн санхүүгийн иж бүрэн үйлчилгээг чанарын өндөр түвшинд үзүүлж, улмаар тэдний өсөлт хөгжилтөд хувь нэмэр оруулах нь иргэдийн банкны бизнесийн гол зорилго юм.

Салбар сүлжээ болон цахим сувгийн өргөжилт

Тайлант онд, салбар сүлжээнийхээ хүртээмжийг нэмэгдүүлэх стратегиа үргэлжлүүлэн ажилласан ба шинээр 12 нэгж байгуулж, нийт салбар, тооцооны төвийнхөө тоог 92-т хүргэсэн. Шинээр байгуулсан нэгжийн 8 нь Улаанбаатар хотод, 4 нь хөдөө орон нутагт үйл ажиллагаа явуулж байгаа ба Монгол Улсын баруун бүсийн аймгууд болох Увс, Баянхонгор аймагт шинээр салбар сүлжээгээ нээлээ.

Биет салбар сүлжээгээ өргөжүүлэхээс гадна банк нь орлого хүлээн авах 6 машиныг суурилуулан, “Өөртөө үйлчлэх банк”-ны цогц үйлчилгээ бүхий 3 нэгжийг Монгол Улсад анх удаа ашиглалтад орууллаа. Ингэснээр харилцагчид, ялангуяа иргэд, жижиг дунд бизнес эрхлэгчид хүссэн үедээ орлогоо дансандаа хуримтлуулж, бэлэн мөнгөний эрсдэлээс сэргийлэх, төлбөр тооцоогоо түргэн шуурхай хийх боломжтой болж буй юм. Тайлант 2012 онд банкны нийт АТМ-ийн сүлжээний тоо 36 хувиар нэмэгдэж 165-д хүрлээ.





Үйлчилгээнийхээ хурд, түргэн шуурхай байдлыг улам сайжруулах үүднээс цахим банкны үйлчилгээ, цахим сувгийг хөгжүүлэхэд онцгойлон анхаарсаар байна. Монгол Улсын банк санхүүгийн салбарт үргэлж шинийг санаачлагч банкны хувьд ухаалаг утас буюу iPhone, Blackberry, Android утсанд зориулсан банкны аппликэйшн болох “Смарт банк”-ны үйлчилгээг Монгол Улсад анх удаа нэвтрүүлэв. Энэхүү үйлчилгээ зах зээлд нэвтэрснээс хойш даруй 6 сарын хугацаанд буюу 2012 оны эцэс гэхэд Монгол Улсын ухаалаг утас хэрэглэгчдийн 12 хувь нь уг үйлчилгээг гар

утсандаа татан авч хэрэглэж байгаа нь харилцагчдын эрэлт хэрэгцээнд нийцсэн, цаг зав, зардал мөнгийг нь хэмнэсэн үйлчилгээ болсны илрэл юм. Мөн уг Смарт банкны үйлчилгээ буюу Голомт банкны ухаалаг утсанд зориулсан аппликэйшн нь “Монгол Улсын банкны анхны аппликэйшн”-ээр App Store, Play Store, Blackberry world-д бүртгэгдсэний зэрэгцээ нэвтрүүлсэн цагаасаа хойш “App Store”-ийн “Монгол Улсын №1 санхүүгийн аппликэйшн” нэр хүндийг хүртэж байгаа ба Монголын Үндэсний Худалдаа Аж Үйлдвэрийн Танхимаас “Олны таашаалд нийцсэн бүтээгдэхүүн үйлчилгээ” шагналыг авсан юм.

SMART BANK



Тайлант онд иргэд болон байгууллагын хэрэгцээнд зориулсан интернэт банкны үйлчилгээнийхээ боломжийг улам нэмэгдүүлж, аюулгүй байдал, хяналтын системийг сайжруулах чиглэлээр цогц шинэчлэлт хийлээ. Мөн хүссэн цаг хугацаанд, хүссэн данснаас цаг алдалгүйгээр автоматаар шилжүүлэг хийх “Захиалгат шилжүүлэг” үйлчилгээг нэвтрүүлээ.

Нэвтрүүлж буй цахим үйлчилгээний шинэчлэлүүд болон мэдээлэл, харилцаа холбооны технологийн салбарт гарч буй хөгжил дэвшил нь харилцагчдийн цахим үйлчилгээний мэдлэг, хэрэглээг нэмэгдүүлж, улмаар бэлэн мөнгөний гүйлгээг багасгаж, зардал бууруулахад онцгой дэмжлэг болж байна. Тухайлбал тайлант онд:

- Идэвхтэй интернэт банк хэрэглэгчдийн тоо 281 хувиар;
- Цахим банкны бусад үйлчилгээний хэрэглэгчдийн тоо /Мобайл банкны үйлчилгээ, Мессэж банкны үйлчилгээ, Easy Info үйлчилгээ, Онлайн данс үйлчилгээ/ дунджаар 270 хувиар;
- Смарт банкны үйлчилгээг тайлант оны 6-р сард анхлан нэвтрүүлснээс хойш 25000 гаруй хэрэглэгч уг аппликэйшнийг татаж авсан /Монгол Улсын ухаалаг утас хэрэглэгчдийн 12 хувь/;

- Интернэт банкаар хийгдсэн гүйлгээний дүн, тооны өсөлт;
 - Интернэт банкаар банк дотроо хийгдсэн гүйлгээний тоо 330 хувиар, дүн 105 хувиар;
 - Интернэт банкаар банк хооронд хийгдсэн гүйлгээний тоо 238 хувиар, дүн 87 хувиар;
 - Интернэт банкаар хийгдсэн гадаад гуйвуулгын тоо 229 хувиар, дүн 114 хувиар тус тус өслөө.

Тайлант онд Монгол Улсад төлбөрийн картын зах зээлд манлайлагч байр сууриа хадгалахуйц олон ажлуудыг хийж гүйцэтгэлээ. Тухайлбал:

- Төлбөр тооцооны үндэсний зөвлөлийн Монгол үндэсний төгрөгийн брэнд карт нэвтрүүлэх төслийг дэмжиж “Үндэсний Т брэнд карт”-ыг зах зээлд нэвтрүүллээ;
- ОХУ-ын тэргүүлэгч технологийн компани болох РВС компанитай хамтран АТМ-ийн менежментийн системээ цогц шинэчиллээ;
- Олон жилийн түншлэлтэй SunGard системтэй хамтран төлбөрийн картын системийг шинэчлэх төслийг амжилттай эхлүүллээ;
- Голомт банкны картаар үйлчлэгч байгууллагуудын үйлчилгээний нэгдсэн сан бүхий нийтийн вэб сайтыг ашиглалтад орууллаа;
- Монгол Улсын Засгийн газраас хэрэгжүүлж буй “Хүүхдийн мөнгө”, “Оюутны тэтгэлэг”-ийг үндэсний төлбөрийн картаар тавих төслийг дэмжин оролцов.

2012 онд кредит карт хэрэглэгчдийн тоо өмнөх оноос 41 хувиар, олон улсад хэрэглэгдэх төлбөрийн картын тоо 45 хувиар, АТМ болон ПОС терминал машинаар хийгдэх гүйлгээний тоо 50 хувиар, нийт төлбөрийн картын гүйлгээний тоо 60 хувиар тус тус өслөө. Нийт картаар үйлчлэгч байгууллагын тоо 1700-д, интернэт мерчантын тоо 300-д хүрлээ.

Харилцагчтай харилцах гол суваг болсон Лавлах төвийн үйл ажиллагаанд CISCO системийг нэвтрүүлж, үйлчилгээгээ сайжруулах төслийг хэрэгжүүллээ.

Жижиг дунд бизнест хандсан банкны үйл ажиллагаа

Үйл ажиллагааны цар хүрээгээ хурдацтайгаар тэлж буй жижиг дунд бизнес эрхлэгчид нь Монгол Улсын нийгэм эдийн засгийн хөгжлийн нэн чухал бүрэлдэхүүн хэсэг юм. Жижиг дунд бизнес нь хүн амын амьжиргааны түвшин, ажлын байрны тоо болон дунд, бага орлоготой иргэдийн орлогыг нэмэгдүүлэхэд голлох үүргийг гүйцэтгэж байна.

Банк нь жижиг дунд бизнес эрхлэгчдийг дэмжих зорилгоор Засгийн Газрын болон Олон улсын байгууллагуудтай хамтран төсөл хөтөлбөрүүдийг хэрэгжүүлж байна. Үүнд:

- Хөгжлийн банк, ЖДҮХСан болон Голомт банк хоорондын 3 талт санхүүжилтийн гэрээний хүрээнд “ЖДҮХСангийн төслийн зээл”;
- Японы ОУХАБайгууллагын “ЖДҮХ, БО хамгаалах 2 үе шаттай зээлийн төсөл”
- “Ноос, ноолуурын төслийн зээл”;
- ХБНГУ-ын КФВ банкны санхүүжилттэй “Хувийн хэвшлийн жижиг, дунд үйлдвэрийг дэмжих төслийн зээл”;
- Азийн Хөгжлийн банкны “Ажлын Байр Нэмэгдүүлэх Төслийн Зээл”.

Бизнес эрхлэгчдийн бизнесийн болон хувийн санхүүгийн хэрэгцээ шаардлагыг бүрэн хангахуйц банкны цогц үйлчилгээг санал болгох зорилго бүхий банкны бүсчилсэн салбарын загвар болох “Бизнес Төв”-үүд үйл ажиллагаагаа амжилттай явуулж байна. Тайлант онд 2 Бизнес төвийг шинээр байгуулсан ба жижиг дунд бизнесийн харилцагчиддаа зориулсан бизнесийн зөвлөх үйлчилгээг үзүүлсээр байна.





Орон сууцны зээл

Хүн амыг оронсууцжуулах замаар хүрээлэн буй орчинг хамгаалах, дунд орлоготой иргэд ялангуяа залуу гэр бүлийг өөрийн орон байр, эд хөрөнгөтэй болох боломжийг дэмжих нь орон сууцны зээлийн үйл ажиллагааны гол зорилго юм. Энэ зорилгынхоо хүрээнд дотоодын тэргүүлэгч 20 орчим барилгын компанитай хамтран ажиллаж тэдгээр компанийн барьж буй барилгаас уян хатан нөхцөл бүхий орон сууцны зээлд хамрагдан худалдан авах боломжийг иргэдэд олгож байна.

Тайлант онд орон сууцны зээлийн багц өмнөх оны 187.1 тэрбум төгрөгөөс 28 хувиар өсөж 239.6 тэрбум төгрөгт хүрсэн ба банкны систем дэх орон сууцны зээлийн багцын 29 хувийг банк дангаар эзэлж байна. Тайлант онд орон сууцны зээлдэгчийн тоо 20 хувиар өсөж 7,619-т хүрлээ.

Монгол Улсад орон сууцны зээлийн хоёрдогч зах зээл хөгжих нөхцөл бололцоог бий болгоход банк идэвхтэй дэмжин ажилладаг бөгөөд тайлант онд Монголын Ипотекийн Корпорацид 2 тэрбум төгрөгийн орон сууцны зээлийн багцыг худалдлаа.

Банк үнэ цэнэ бүхий харилцагч албан байгууллагуудынхаа түлхүүр ажилтнуудад хөнгөлөлттэй нөхцөлөөр орон сууцны зээлийг санал болгож, ажилтан тухайн байгууллагадаа урт удаан хугацаанд тогтвортой ажиллах боломжийг олгох замаар дэмжлэг үзүүлж байна.

Хэрэглээний зээл

Эдийн засгийн бүхий л салбаруудад гарсан хурдацтай өсөлтийн үр дүнд дунд орлоготой иргэдийн тоо нэмэгдэж байгаа билээ. Дундаж давхаргын иргэдийн худалдан авах чадвар сайжирч байгаа нь тээврийн хэрэгсэл, өргөн хэрэглээний бараа, электрон хэрэгсэл болон боловсролын салбарын үйлчилгээний эрэлт өсч буйгаас харагдаж байна. Банк харилцагчдын өсөн нэмэгдэж буй энэхүү эрэлтийг хангахын тулд хүчин чадлынхаа зохистой хэм хэмжээний хүрээнд хэрэглээний зээлийн бүтээгдэхүүнээ санал болгон тогтмол өргөжүүлэн хянаж байна. Тайлант онд хэрэглээний зээл 1.89 тэрбум төгрөгөөр өсч 126.15 тэрбум төгрөгт хүрчээ.

САНХҮҮГИЙН БАЙГУУЛЛАГУУД БА ХУДАЛДААНЫ САНХҮҮЖИЛТ

Голомт банк дэлхийд тэргүүлэгч олон улсын банк, санхүүгийн байгууллагуудтай санхүүгийн нягт харилцаатай ажилладаг бөгөөд өнгөрсөн оны хувьд олон улсын хөрөнгө оруулалтын болон арилжааны томоохон банкууд болох Deutsche Bank AG, Standard Chartered Bank NY, Standard Bank, Taiwan Export Import Bank /Taiwan EXIM/ мөн Швейцарь улсын Atlantic Forfaiterungs AG зэрэг нэр хүндтэй банк санхүүгийн байгууллагуудтай хамтын ажиллагаагаа өргөжүүлэн харилцагчдынхаа, өсөн нэмэгдэж буй олон талт санхүүгийн хэрэгцээ шаардлагыг хангаж нийт 15 орны 30 гаруй банк, санхүүгийн байгууллагатай 11 төрлийн валютаар олон улсын төлбөр тооцоо гүйцэтгэж, корреспондент банкны харилцаагаа хадгалан ажиллалаа.



Бид дээрх олон улсад нэр хүндтэй банк, санхүүгийн байгууллагуудтай хамтран ажиллаж харилцагчдынхаа санхүүгийн эрэлт хэрэгцээнд зориулан хамгийн боломжит нөхцөл бүхий аккредитив, аккредитивийн дараах санхүүжилт, зээл баталгааны цогц шийдэл бүхий бүтээгдэхүүнүүдийг санал болгодог.

Одоогийн байдлаар бид ING, Baoshang, Industrial Commercial Bank of China, Agricultural Bank of China, Bank of China, Taiwan Exim, BHF, Deutsche Bank, Commerzbank болон Atlantic Forfaiterungs AG, Export Import Bank of Korea /KEXIM/ зэрэг нийт 20 орчим орны олон улсын банк, санхүүгийн байгууллагуудаас импортын зээл болон шууд санхүүжилтийн бүтээгдэхүүнүүдийг харилцагчиддаа дамжуулан хүргэсээр байна.

Мөн China Development Bank-наас урт хугацаатай төслийн санхүүжилтийн хамтарсан зээл /Syndicated loan/ болон Standard банкны санхүүжилтээр дамжуулан уул уурхай болон бусад томоохон төслүүд дээр хамтарч ажиллах

Боломжийг тус тус бүрдүүлээд байна. Түүнчлэн Солонгос улсаас бараа бүтээгдэхүүн импортолдог бизнес эрхлэгч харилцагчиддаа зориулж Export Import Bank of Korea /KEXIM/ банктай хамтран уян хатан, бага хүүтэй, урт хугацааны импортын зээлийн бүтээгдэхүүнийг санал болгож байна. Уг зээлд Солонгос улсаас бараа импортолж буй Монгол Улсын компани эсвэл Солонгос компанийн 10-аас дээш хувийн хөрөнгө оруулалттай компаниуд хамрагдах боломжтой юм.

Худалдааны санхүүжилтийн гол харилцагч банкууд

Standard Bank, London	
Commerzbank AG, Frankfurt am Main	
ING Bank N.V., Amsterdam	
Deutsche Bank AG, Frankfurt am Main	
Atlantic Forfaitierungs AG, Zurich Switzerland	
Asian Development Bank, Manila	
Industrial & Commercial Bank of China	
Baoshang Bank, China	
The Export-Import Bank of the ROC, Taiwan	
BHF-Bank AG, Frankfurt am Main	
The Export-Import Bank of Korea, Seoul	
Nordea Bank Finland PLC, Helsinki	
Kuveyt Turk Katilim Bankasi A.S., Istanbul	
BNP Paribas, Switzerland	
Daegu bank, Korea	
Kazkommertsbank, Kazakhstan	





БАЙГУУЛЛАГАД ХАНДСАН БИЗНЕСИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА

Байгууллагын Банкны Газар нь 2012 онд өөрийн харилцагч болох гадаад дотоодын төр, хувийн хэвшлийн томоохон байгууллагууд, Засгийн Газрын хэрэгжүүлэгч агентлагууд, элчин сайдын яамд, дипломат төлөөлөгчийн газрууд, Олон улсын хөгжлийн агентлагууд болон Монгол Улсад хөгжлийн төсөл хөтөлбөр хэрэгжүүлэгч томоохон аж ахуйн нэгжүүдтэй нягт хамтран ажиллаж, амжилтаа бататгасан жил байлаа. Харилцааны өндөр ур чадвар, мэдлэг бүхий Бизнес хөгжлийн менежерүүдээр дамжуулан өсөн нэмэгдэж буй байгууллагын хэрэгцээт бүхий л төрлийн үйлчилгээ болох төлбөр тооцоо, зээл, гадаад худалдааны санхүүжилт, хамтарсан санхүүжилт, төслийн санхүүжилт, экспортын санхүүжилт, санхүүгийн түрээс, валют арилжаа, төлбөр тооцооны үйлчилгээ гэх мэт санхүүгийн цогц үйлчилгээг нэг цэгээс хүргэж харилцагчдынхаа талархлыг хүлээсээр байна.

Байгууллагын Банкны Газар нь Германы BHF Bank, Commerzbank-уудтай байгуулсан экспортын санхүүжилтийн агентлагаар даатгагдсан импортын санхүүжилт хийх хамтран ажиллах гэрээний хүрээнд Эдийн Засгийн Хамтын Ажиллагаа Хөгжлийн байгууллага, Европын холбооны гишүүн орнуудаас техник, тоног төхөөрөмж импортлогч, шинэ технологийг нэвтрүүлэгч үндэсний томоохон үйлдвэрлэгчид болон бүтээн байгуулалтын төсөл хөтөлбөр хэрэгжүүлэгч байгууллагуудад урт хугацааны бага хүүтэй зээлүүдийг дамжуулан олгож тэдэнд санхүүгийн таатай орчинг бий болгон ажиллаж байна. Түүнчлэн Taiwan Exim Bank, Atlantic Forfaiterungs AG зэрэг банкуудаас экспортын санхүүжилтийн шууд зээлүүдийг таатай нөхцөлөөр харилцагчиддаа олгож хамтын ажиллагааны шинэ боломжуудыг нээсээр байна.

Олон улсад нэр хүндээрээ танигдсан чанар, хийц, гүйцэтгэлээрээ тэргүүлэгч хүнд машин механизм, тоног төхөөрөмжийг Монголын зах зээлд нийлүүлдэг олон байгууллагатай хамтран ажиллаж тэдгээрийн борлуулалтыг Голомт банкны өөрийн эх үүсвэрийн санхүүгийн түрээсийн бүтээгдэхүүнээр борлуулан ажилладаг. Бид эдгээр байгууллагуудтай харилцан ашигтай хамтран ажиллахаас гадна тэдэнд санхүүгийн иж бүрэн үйлчилгээ үзүүлэх, хамтдаа өдөрлөг зохион байгуулах, дотоод гадаадад зохиогдож буй үзэсгэлэн, форум, хурал зөвлөгөөнд идэвхтэй оролцож ирлээ.

Уул уурхайн салбарт зориулсан банкны үйлчилгээ

Голомт банкны Уул Уурхайн Хэлтэс нь үүсгэн байгуулагдсанаас хойш Монголын томоохон уул уурхайн компаниудад болон тэдгээрийн бэлтгэн нийлүүлэгчдэд банкны цогц үйлчилгээг найдвартай хүргэж дэмжиж ажилладаг билээ. Голомт банк нь байгууллагад зориулсан банкны үйлчилгээнд тэргүүлэгч банкуудын нэг бөгөөд уул уурхайн болоод дагалдах салбаруудад чиглэгдсэн банкны үйлчилгээг туршлагатай, мэдлэг чадвар бүхий мэргэжилтнүүдтэй тус хэлтсээр дамжуулан тухайн салбарын онцлогоос хамааран тэдний бизнест тохирсон санхүүгийн болоод зөвлөх үйлчилгээг хүргэдэг.

Түүнчлэн Голомт банк нь уул уурхайн хөрөнгө оруулагч гадаад дотоодын хөрөнгө оруулагчид, банк, санхүүгийн байгууллагуудтай нягт хамтран ажилладаг ба уул уурхайн төсөл хэрэгжүүлэгч аж ахуйн нэгж байгууллагуудад гадаад, дотоодын хөрөнгийн зах зээлээс шаардлагатай хөрөнгө оруулалтыг бий болгох боломжийг хамтран судлах, хөрөнгө оруулагчдыг зуучлах, цаашдын хамтын ажиллагааг дэмжин ажилладаг билээ.

ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН БАНКНЫ ҮЙЛ АЖИЛЛАГАА

Хөрөнгө Оруулалтын Банкны үйл ажиллагааны үндсэн чиглэл нь хурдацтай өсч хөгжиж буй манай эдийн засгийн нөхцөлд хувийн болон төрийн эзэмшилт компаниуд, бусад агентлаг байгууллагуудад хөрөнгө оруулалт татах, санхүүжилт босгоход зуучлах, хэлэлцээр хийх, зөвлөгөө өгөх, амжилттай хөрөнгө босгож өгөх үйлчилгээ үзүүлэх юм.

Хөрөнгө Оруулалтын Банкны Газрын хэтийн зорилго нь хамгийн чанартай хөрөнгө оруулалтын банкны үйлчилгээгээр харилцагчдынхаа бизнес хөгжлийг дэмжиж, улмаар урт хугацааны ашигтай хамтын ажиллагааг бий болгоход оршино. Банкны өндөр туршлага, мэргэжлийн ур чадвар бүхий хөрөнгө оруулалтын мэргэжилтнүүдээс бүрдсэн баг харилцагч нэг бүрийн эрэлт, хүсэлтийг бүрэн дүүрэн хангасан үйлчилгээг үзүүлснээр урт удаан хугацааны харилцааг бүтээх болно.

Голомт банкны Хөрөнгө Оруулалтын Банкны Газар нь хөрөнгө оруулалтын цогц үйлчилгээг хүргэхээр зорьж ажиллаж байгаа бөгөөд үйл ажиллагаа нь доорх хүрээг хамарч байна.

- Өрийн хэрэгсэл, бонд, хувьцаат капитал, бусад бүтэцлэгдсэн бүтээгдэхүүнүүдийг олон нийтэд болон хаалттай хүрээнд санал болгон зохион байгуулж, хөрөнгө оруулалт татах;
- Компани - бизнесийн үнэлгээ хийх, салбарын болон зах зээлийн судалгаа шинжилгээ хийх;
- Компанийн өргөжилт, санхүүгийн бүтэц стратегийн талаар зөвлөгөө өгөх;
- Компанийн нэгдэлт, өөрчлөн байгуулалт, худалдан авалтыг зохион байгуулах;
- Боломжит хөрөнгө оруулагчдыг нээж, холбоо тогтоох;
- Хөрөнгө оруулагчидтай гэрээ хэлэлцээр хийх, санхүүжилтийн нөхцөл тохирох;
- Санхүүжилт татах баримт бичгүүд болох меморандум болон проспектус бэлдэж танилцуулах.

Байгуулагдсан цагаасаа хойш Голомт банк нь олон улсын нэр хүнд бүхий байгууллагуудтай үр ашигтай харилцааг бүтээсэн бөгөөд урт хугацааны үнэ цэнэтэй харилцагчдаас гадна томоохон хувийн хөрөнгө оруулалтын институтууд, хөрөнгө оруулалтын венчур сангууд, бүсийн болон глобал банкууд, даатгалын болон үндэсний хөгжлийн сангууд зэрэг байгууллагуудтай идэвхитэй хамтран ажиллаж байна.

Энэхүү харилцаа, хамтын ажиллагаа нь Голомт банкныг хувьцаа болон өрийн санхүүжилтийн олон улсын зах зээлд гарах гарц болж өгч байгаа бөгөөд хөрөнгө оруулалтын зах зээлийн мэдлэг туршлагын хамтаар харилцагчдын хүсэл сонирхол, шаардлагад дээд зэргээр нийцсэн, зах зээлтэй уялдсан, эрсдэлээс хамгаалсан уян хатан, төрөл бүрийн санхүүжилтийн бүтээгдэхүүнийг санал болгох, хөгжүүлэх замаар сэтгэл ханамжийг нь дээд түвшинд хүргэх боломжтой.

Монголын Хөрөнгийн Бирж нь Millennium IT системийг нэвтрүүлэх үйл ажиллагааны хүрээнд 2012 онд Голомт банк дотоодын төлбөр тооцоо гүйцэтгэгч-клиринг банкаар сонгогдсон бөгөөд Хөрөнгө Оруулалтын Банкны газар нь бусад газар, хэлтэс, нэгжүүдтэй хамтран Монголын хөрөнгийн зах зээлийн хөгжилд хувь нэмрээ оруулан ажиллаж байна.

Хөрөнгө Оруулалтын Банкны газар нь харилцагчдын хүсэл сонирхлыг дээд зэргээр хангах зорилгын хүрээнд андеррайтерын тусгай зөвшөөрөл болон Голомт банкны 100 хувь охин компани болох Голомт Секюритиз ХХК-ийг байгуулж үнэт цаасны цогц үйлчилгээг үзүүлж байна. Мөн хөрөнгийн зах зээлийн хөгжлийн томоохон дэвшил болох кастодиан банкны үйлчилгээ үзүүлэхээр зорьж ажиллаж байна.





Голомт Секюритиз ХХК

Банкны 100 хувийн хөрөнгө оруулалттай Голомт Секюритиз ХХК нь 2011 оноос эхлэн олон нийтэд хөрөнгө оруулалтын үйлчилгээгээ санал болгож эхэлсэн билээ. Байгуулагдсан цагаасаа хойш СЗХ-ны харилцагчийн нэрийн өмнөөс түүний даалгавраар гүйцэтгэсэн хөрөнгө оруулалтын бусад ажил үйлчилгээ үзүүлэх тусгай зөвшөөрлийн хүрээнд харилцагчиддаа:

- Монголын хөрөнгийн бирж дээр үнэт цаасны арилжаа буюу Брокер;
- Олон улсын хөрөнгийн биржүүдийн арилжаа буюу Нью-Йорк, Австрали, Хонконг, Торонто, Насдакийн хөрөнгийн биржүүд дээр арилжаанд оролцох;
- Зах зээл, түүхий эд болон компанийн судалгаа, үнэлгээ;
- Хувийн компанийн санхүүгийн зөвлөх, шууд хөрөнгө оруулалт гэсэн чиглэлүүдээр үйлчилгээгээ үзүүлж харилцагчдынхаа тоог нэмсэн.

Монголын Засгийн Газраас дотоодын хөрөнгийн зах зээлийг шинэчилж, олон улсын жишигт нийцүүлэн хөгжүүлэх зорилгын хүрээнд Төрийн өмчийн хороо, Монголын Хөрөнгийн Бирж, Лондонгийн хөрөнгийн бирж групп нь “Ажлын мастер гэрээ”-г байгуулж “Миллениум Ай Ти” арилжаа, төлбөр тооцоо, хяналт, хадгаламжийн цогц системийг зах зээлд нэвтрүүлэх үе шатуудад Голомт Секюритиз компани Голомт банкны клирингийн үйлчилгээтэй хамтран амжилттай оролцож байна.

НӨӨЦИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА

Хөрөнгийн Удирдлагын Газрын зорилго нь банкны өдөр тутмын хөрвөх чадвар, бэлэн мөнгөний хэрэгцээг хангах, ба илүүдэл нөөц, зах зээлийн эрсдэл, санхүүжилтийн зардлыг зохистой удирдах юм.

2012 онд илүүдэл нөөцийг эрсдэлийн хорооноос тогтоосон лимитийн хүрээнд хөрвөх чадвар бүхий Төв банкны үнэт цаас, Засгийн Газрын үнэт цаас болон Монголбанк, олон улсын корреспондент харилцаатай банкуудад байршуулан ажиллалаа. Засгийн Газрын үнэт цаас нь Монголбанкаар арилжаалагдаж эхэлсэн ба санхүүгийн зах зээлийн гол оролцогчийн хувьд манай банк шууд оролцогчоор сонгогдож, арилжаанд идэвхитэй оролцож байна.

Оны эцсийн байдлаар манай банк 2012 онд Төв банкны нийт үнэт цаасны 32.8 хувь, Засгийн Газрын нийт үнэт цаасны 18 хувийг тус тус эзэмшиж байна.

Валют арилжаа

2012 онд төгрөгийн ам.доллартай тэнцэх ханш харьцангуй тогтвортой байсан ба жилийн 2 дугаар хагаст төгрөгийн стандарт хазайлт 1.5 хувьтай хөдөлж нэгдүгээр хагасаас харьцангуй тогтвортой хөдөлсөн байна. Олон улсын болон дотоодын зах зээлийн тодорхойгүй байдал болон сонгуулийн жилд төгрөгийн ханшийн хөдөлгөөн тогтвортой байгаа нь зах зээлийн төгрөгт итгэх итгэл сайн байгааг харуулж байна. Түүнчлэн 2012 онд гадаадын шууд хөрөнгө оруулалт нэмэгдэж улмаар гадаад валютын албан нөөц анх удаа 4.2 тэрбумд хүрсэн байна.

Банк нь валютын зах зээл дээр гол тоглогчийн хувьд валютын форвард, своп зах зээлийг улам идэвхижүүлэн ажиллаж арилжааны үйл ажиллагаагаа өргөтгөлөө. Мөн форвард зах зээлийн хөгжилд хувь нэмрээ оруулж Монголбанкнаас зохион байгуулсан семинар, Валютын арилжааны 5-р зөвлөгөөнд оролцож форвард, своп арилжааны хэрэглээ болон ашиглах давуу талуудыг харилцагчдад таниуллаа.


САНХҮҮГИЙН ҮР ДҮН

Бид эдийн засгийн тодорхойгүй орчинд төлбөрийн чадвартаа анхаарч, харилцагчдынхаа эрх ашгийг нэн тэргүүнд тавьж ажиллалаа.


2012 онд эдийн засаг буурах мөчлөгтөө байсан ба энэ нь банкны системийн өсөлтөд сөргөөр нөлөөлж байсан хэдий ч манай банкны хувьд эдийн засгийн орчны бэрхшээлүүдийг даван, амжилттай ажилласаар системд эзлэх байр суурь болон хүчирхэг санхүүгийн үзүүлэлтүүдээ хадгалсан амжилттай ажиллалаа.

Бид эдийн засгийн тодорхойгүй орчинд төлбөрийн чадвартаа анхаарч, харилцагчдынхаа эрх ашгийг нэн тэргүүнд тавьж ажиллалаа.

Нийт актив (тэрбум төгрөг)



Нийт харилцах хадгаламж (тэрбум төгрөг)





- Нийт активын хэмжээ 392.8 тэрбум төгрөгөөр буюу 18 хувиар өсч 2.53 их наяд төгрөг (1.82 тэрбум ам.доллар)-т хүрсэн нь банкны системийн 21.1 хувийг эзэлж байна.
- Нийт харилцах, хадгаламжийн хэмжээ 217.3 тэрбум төгрөгөөр буюу 12 хувиар өсч 2.06 их наяд төгрөг (1.48 тэрбум ам.доллар)-т хүрсэн нь банкны системийн 26 хувийг эзэлж, системийн хэмжээнд харилцах, хадгаламжийн хэмжээгээрээ тэргүүлэгч банк байр сууриа хадгалж ажиллалаа.








- Цэвэр зээл 178.6 тэрбум төгрөгөөр буюу 14 хувиар өсч 1.43 их наяд төгрөг (1.03 тэрбум ам.доллар)-т хүрсэн нь банкны системийн 20.6 хувийг эзэлж байна. Бид зээлийн төвлөрлийг бууруулахыг зорьж ажилласны үр дүнд нийт зээлийн багцад эзлэх корпорэйт зээлийн хэмжээ 57 хувиас 53 хувь болж буурсан.
- 26.6 тэрбум төгрөгийн цэвэр ашиг болон 21.0 тэрбум төгрөг (15.9 сая ам.доллар)-ийн Trafigura Beheer B.V.-ын хөрөнгө оруулалтын үр дүнд нэгдүгээр зэрэглэлийн өөрийн хөрөнгө 48.2 тэрбум төгрөгөөр өсч 187.3 тэрбум төгрөгт, хоёрдугаар зэрэглэлийн өөрийн хөрөнгө 34.7 тэрбум төгрөгт хүрсэн. Нийт өөрийн хөрөнгө 222.1 тэрбум төгрөг (159.6 сая ам.доллар)-т хүрсэн байна.

Цэвэр зээл (тэрбум төгрөг)**Өөрийн хөрөнгө (тэрбум төгрөг)**

- Татварын дараах ашиг 26.6 тэрбум төгрөг (19.1 сая ам.доллар)-т хүрсэн.
- Үйл ажиллагааны орлого 11.5 тэрбум төгрөг (15 хувь)-өөр өсч 89.9 тэрбум төгрөгт хүрлээ.
- Цэвэр хүүгийн орлого 8.2 тэрбум төгрөг (17 хувь)-өөр өсч 57.1 тэрбум төгрөгт хүрсэн ба Цэвэр хүүгийн ахиуц харьцааг 3.5 хувьд барьж ажиллалаа.


Цэвэр хүүгийн маржин (%)**Үйл ажиллагааны орлого (тэрбум төгрөг)**

- Балансын бүтцийг зохистой түвшинд удирдсаны үр дүнд Зээл депозитын харьцаа 69.4 хувьд хүрсэн нь банкны системийн дундаж үзүүлэлт болох 87.8 хувиас харьцангуй бага байна.


Зээл депозитын харьцаа (%)**Чанаргүй зээлийн харьцаа (%)**

- Өөрийн хөрөнгө эрсдэлээр жигнэсэн активын харьцаа 13.3 хувьд хүрсэн нь Монголбанкны шалгуур үзүүлэлт болох 13 хувиас илүү буюу Монголбанкны шаардлагыг хангаж байна.
- Төлбөрийн чадварын харьцаа 41.1 хувьд хүрсэн нь Монголбанкны шалгуурыг хангахаас гадна Монголын банкны системийн хэмжээнд хамгийн өндөр үзүүлэлт боллоо.

Өөрийн хөрөнгийн хүрэлцээ (%)



Төлбөрийн чадварын харьцаа (%)



- Банкны системд санхүүгийн хүчирхэг үзүүлэлтүүдээ хэвээр хадгаллаа:

- Өөрийн хөрөнгийн хүрэлцээ 13.3%;
- Хамгийн өндөр төлбөр түргэн гүйцэтгэх чадвар 41.1%;
- Хамгийн зохистой зээл депозитийн харьцаа 69.4%;
- Хамгийн зохистой цэвэр хүүгийн маржин 3.5%;

Зээлийн үнэлгээ

Standard and Poor's байгууллага нь Голомт банкны урт хугацааны төлбөр түргэн гүйцэтгэх чадварт B+, богино хугацааны төлбөр түргэн гүйцэтгэх чадварт B үнэлгээнүүдийг өгсөн.

Moody's байгууллага нь Голомт банкинд санхүүгийн чадамжаар E+, гадаад валютын нөөцөөрөө B2, дотоод валютын нөөцөөрөө B1, тогтвортой төлөвтэй гэсэн үнэлгээг тус тус өгөөд байна.



Таван жилийн санхүүгийн үр дүн

	2008	2009	2010	2011	2012
Балансын үзүүлэлтүүд (сая төгрөг)					
Нийт актив	697,179	1,013,109	1,573,413	2,134,683	2,527,483
Нийт харилцах, хадгаламж	505,171	795,251	1,317,499	1,839,324	2,056,581
Цэвэр зээл	447,787	505,299	784,605	1,249,341	1,427,922
Нийт өөрийн хөрөнгө	63,548	78,471	127,774	187,959	222,115
Орлогын тайлангийн үзүүлэлтүүд (сая төгрөг)					
Хүүгийн орлого	69,318	81,832	111,157	165,165	200,245
Хүүгийн зардал	(43,569)	(57,905)	(81,448)	(116,240)	(143,127)
Цэвэр хүүгийн орлого	25,749	23,927	29,708	48,925	57,118
Цэвэр хүүгийн бус орлого	8,912	13,333	16,749	29,503	32,831
Үйл ажиллагааны орлого	34,661	37,260	46,457	78,428	89,949
Үйл ажиллагааны зардал	(15,178)	(16,712)	(21,242)	(32,515)	(45,419)
Эрсдэлийн сангийн зардал	(3,958)	(3,240)	983	(6,324)	(10,790)
Санхүүгийн хөрөнгө оруулалтын үнэ цэнийн бууралт	-	-	-	(2,340)	(1,041)
Татварын өмнөх ашиг	15,525	17,308	26,198	37,249	32,699
Татварын зардал	(3,324)	(4,138)	(6,145)	(9,022)	(6,080)
Татварын дараах ашиг	12,201	13,170	20,053	28,226	26,619
Санхүүгийн бүтцийн харьцаанууд					
Нийт харилцах, хадгаламж / Нийт актив (%)	72.5%	78.5%	83.7%	86.2%	81.4%
Өөрийн хөрөнгө (1-р зэрэглэл) / Нийт актив (%)	7.3%	6.3%	5.3%	6.5%	7.4%
Цэвэр зээл / Нийт актив (%)	64.2%	49.9%	49.8%	58.5%	56.5%
Цэвэр зээл / Нийт харилцах, хадгаламж (%)	88.6%	63.5%	59.6%	67.9%	69.4%
Чанаргүй зээл / Нийт зээл (%)	3.9%	4.4%	2.1%	2.0%	2.6%
Хөшүүргийн харьцаа (Нийт пассив / Нийт Капитал)	10.0	11.9	11.3	10.4	10.4
Ашигт ажиллагааны харьцаанууд					
Дундаж активын өгөөж (%)	1.8%	1.6%	1.7%	1.6%	1.2%
Дундаж өөрийн хөрөнгийн өгөөж (%)	24.3%	22.5%	26.6%	24.6%	15.3%
Цэвэр хүүгийн ахиуц (%)	4.2%	4.1%	3.6%	3.6%	3.5%
Зардал, орлогын харьцаа (%)	43.8%	44.9%	44.0%	41.3%	50.3%
Шалгуур үзүүлэлтүүд					
Өөрийн хөрөнгийн хүрэлцээ >13%	12.8%	13.4%	13.5%	12.9%	13.3%
Гадаад валютын эрсдэлийн үзүүлэлтүүд:					
Нийт гадаад валютын хувьд <+/-40%	11.9%	11.8%	17.1%	10.6%	17.8%
Нэгж гадаад валютын хувьд <+/-15%	9.5%	10.0%	11.2%	-5.1%	-9.5%
Нэг зээлдэгчид олгосон зээлийн харьцаа <20%	19.5%	19.9%	17.6%	19.8%	18.9%
Холбогдох этгээдэд олгосон зээлийн харьцаа <5%	3.7%	3.5%	3.4%	3.4%	3.5%
Холбогдох этгээдэд олгосон нийт зээлийн харьцаа <20%	10.5%	15.9%	10.3%	12.7%	9.5%
Төлбөр түргэн гүйцэтгэх чадвар >25%	37.0%	51.7%	51.2%	38.9%	41.1%
Үндсэн хөрөнгийн харьцаа <8%	1.0%	0.7%	1.6%	1.5%	1.5%



ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГА БА ХЯНАЛТ

Голомт банк оновчтой эрсдэлийн удирдлагын бодлого хэрэгжүүлсний үр дүнд банкны төлбөр түргэн гүйцэтгэх чадвар болон өөрийн хөрөнгийн хүрэлцээ өндөр хэвээр хадгалагдав.

Зээлийн эрсдэлийн удирдлага

Зээлийн эрсдэл бол харилцагч зээлийн гэрээгээр хүлээсэн үүргээ хугацаандаа биелүүлээгүйгээс үүдэх эрсдэл юм. Бидэнд учирч болох зээлийн эрсдэл нь зээлийн багц, хөрөнгө оруулалтын актив болон хүлээж болзошгүй өр төлбөрүүд болно. Зээлийн эрсдэлийг зээлдэгч тус бүрээр болон эдийн засгийн салбараар зээл, баталгаа, батлан даалт, аккредитив, банк хоорондын хадгаламж, санхүүгийн бусад хэрэгслүүдийг хамруулан цогцоор нь хэмжээ хязгаарлалт тогтоох замаар удирддаг. Мөн хөрөнгийн удирдлагын бүхий л үйл ажиллагаанд шаардлагатай гэж үзвэл хэмжээ хязгаарлалт тогтоох замаар эрсдэлийг удирддаг.

Голомт банкны зээлийн үйл ажиллагаа, стратеги, бодлого, журмууд нь Базелын хорооноос баталсан Зээлийн эрсдэлийн удирдлагын үндсэн 16 суурь зарчмуудыг мөрдлөг болгодог. Энэхүү 16 суурь зарчмууд нь нэгд зохистой зээлийн эрсдэлийн орчинг бий болгох, хоёрт ул суурьтай зээл олгох, гуравт зээлийн хэрэг бүртгэл, хэмжих хэмжүүр, тайлагналын тогтолцоог бий болгох, дөрөвт ул суурьтай үр дүн бүхий хяналтын тогтолцоог бий болгох зэрэг үндсэн 4 бүлэг 16 зарчмуудыг тогтоосон байдаг.

Голомт банкны зээлийн бодлого нь банкны өсөлтийг дэмжих үндсэн стратегийн хүрээнд зээлийн эрсдэлийг боломжит хамгийн бага түвшин хүртэл бууруулахад чиглэгддэг. Бидний таамаглаж буйгаар Монгол Улсын эдийн засгийн өсөлт дунд хугацаанд хадгалагдах учир зээлийн багц, зээл олголтын хэмжээ өсөх хэдий ч зээл олгох үйл ажиллагааг ул суурьтай дүрэм журмын хүрээнд удирдаж ажиллах ёстой. Банкны Төлөөлөн Удирдах Зөвлөл, Эрсдэлийн Удирдлагын Хороо, удирдлагын баг нь зээлийн бодлого, стратегийг батлах, хэрэгжилтийг тогтмол хугацаанд хянах үүрэгтэй. Мөн түүнчлэн Төлөөлөн Удирдах Зөвлөл нь эрсдэлийн удирдлагын үндсэн харьцаануудаас гадна нийт актив, өөрийн хөрөнгийн харьцаа, өөрийн хөрөнгийн хүрэлцээ, зээл-хадгаламжийн харьцааг тогтоох, удирдах үүрэгтэй.





Бид дотоод зээлийн рейтингийн системийг хөгжүүлснээр том байгууллагын болон жижиг дунд байгууллагын 50 сая төгрөгөөс дээш дүн бүхий зээл хүсэгчдийн зээлээ эргэн төлөх чадварыг судлах, зээлийн зарцуулалтыг нарийвчлан судлах замаар бие даасан хараат бус дүгнэлт өгдөг. Уг систем нь гурван хүчин зүйлийг дэлгэрэнгүй тооцоолдог. Энэ нь зээлдэгчийн үйл ажиллагааны үндсэн болон туслах салбар, бизнесийн үндэс суурь, хэтийн төлөв (зээлдэгчийн туршлага, хэрэглэгчид болон бизнесийн сегментийн диверсификаци, зах зээлд эзлэх хувь болон бренд) болон зээлдэгч тус бүрийн санхүүгийн ил тод байдал юм. Эдгээр зээлийн үр дүн, үнэлгээг Зээлийн Хороо, Зээлийн Дэд Хороо болон Салбарын Зээлийн Хороогоор хэлэлцүүлэн шийдвэрлэдэг ба зээлийн үлдэгдэлд хяналт тавьдаг.

Бид том байгууллагын болон жижиг дунд байгууллагын зээлийг судлахдаа зээлдэгчийн зээлийн түүх чадамж, салбар, маркетинг ба хэрэглэгчийн зан төлөв, менежмент болон хяналт, санхүүгийн нөхцөл байдал, зээлийн барьцаа зэргийг бусад зүйлсээс илүү ач холбогдолтойгоор авч үздэг.

Зээл олгох бодлого, үйл явц

Бид зээлийн эрсдэлийг нягт нямбай хяналт ба зээл, хөрөнгө оруулалтын багцуудын чанарт менежмент хийх байдлаар удирддаг. Зээлийн Хороо нь бидний зээлийн бодлоготой холбоотой бүхий л асуудлыг ТУЗ болон Эрсдэлийн Удирдлагын хорооны чиглэлтэй уялдуулан хариуцан ажилладаг. Зээлийн Хороо нь зээлдэгчийн зээлийн эрсдэлийн түвшинд хязгаарлалт тавьж ажилладаг бөгөөд нэг зээлдэгч болон холбоо бүхий бүлэг зээлдэгчийн зээлийн хэмжээг хязгаарлах үзүүлэлтийг балансын эхний болон сүүлийн үзүүлэлтүүдэд тулгуурлан дээд лимит тогтоодог. Зээлийн Хороо нь зээлийн эрсдэлийг улирлаар болон илүү нарийн давтамжтайгаар хийгдсэн мэдээлэл дүгнэлтэд үндэслэн тасралтгүй хянадаг. Бид томоохон зээлдэгч бүрийн дэлгэрэнгүй мэдээлэл, дүгнэлтийг жилдээ нэгээс багагүй удаа хийдэг.

Зээлийн хороо нь мөн дэд хороотой бөгөөд энэ нь боломжит зээлийн шийдвэрийг батлах ажлыг хариуцдаг. Зээлийн Хороо нь 300 сая төгрөгөөс дээш дүнтэй зээлд тохирох нөхцөлийг баталдаг бөгөөд Зээлийн Дэд Хороо нь 300 сая төгрөгөөс бага дүнтэй зээлд тохирох нөхцөлийг баталдаг.


Дээр дурьдсанчлан салбар бүр тогтоосон хязгаарлалтын хүрээнд салбарын зээлийн хороогоор хэлэлцэн зээлийн шийдвэрийг гаргадаг. Салбар бүрийн зээл шийдвэрлэх эрхийн хэмжээг Зээлийн Хороо тогтоодог. Салбарын зээл бие даан шийдвэрлэх эрхийн хэмжээг зээлийн бодлоготой нийцэж байгаа байдал, тэдний ажлын туршлага, эдийн засгийн орчин зэргээс хамааран нэмэгдүүлэх ба бууруулдаг.

Зээл олгох үйл явц

Зээл шийдвэрлэх үйл явцыг доорхи байдлаар тайлбарлаж болно.

- Том байгууллагын зээл: Том байгууллагын зээлийн үзүүлэлтүүд нь манай зээлийн активт хамгийн их хувийг эзэлдэг. Том байгууллагын зээлийн хүсэлтийг бизнес хөгжлийн менежер хүлээн авдаг. Том байгууллагын харилцагчид бизнес хөгжлийн менежертэй урьдчилж хүсэлтээ танилцуулан уулзалт хийдэг. Уулзалт бүрийн үр дүнд бизнес хөгжлийн менежер хүсэлтийн нөхцлийг Зээлийн Газрын Том Байгууллагын Хэлтэстэй зөвшилцөн тогтоох ба уг зээлийг Зээлийн Газрын гишүүд хэлэлцэн боломжтой гэж үзвэл Зээлийн Хороо, Зээлийн Дэд Хороо болон салбарын зээлийн хороонд танилцуулахаар бэлддэг. Дараа нь зээлийн мэргэжилтэн хүсэлтийг хүлээн авч, харилцагчийн тухай болон түүний ажилладаг салбарын талаар гүнзгий мэдлэгтэй болохын тулд санхүүгийн шинжилгээг хийдэг. Уг шинжилгээ нь том байгууллагын зээлдэгчийн зах зээлд эзлэх байр суурь, нэр хүнд, зээлжих чадвар, туршлага болон боломжит бүх судалгаа, шинжилгээг багтаасан байдаг. Бид зээлдэгчийн бусад банкууд дахь зээлийн үлдэгдэл, зээлдэгчдийн зээлийн түүхийг хадгалж байдаг Монголбанкны зээлийн мэдээллийн сангаас лавлагаа авдаг ба, хэрэв боломжтой бол татварын газар гэх мэт төрийн байгууллагууд болох гуравдагч этгээдээс зээлдэгчийн талаарх бусад лавлагааг олж авдаг. Хэрэв зээл барьцаагаар хангагдсан бол санал болгосон барьцаа хөрөнгийн үнэлгээг дотооддоо бие даасан экспертээр үнэлүүлдэг ба хөрөнгийг барьцаалах тал дээр мэргэжлийн хууль зүйн зөвлөгөөгөөр хангагддаг.

- Жижиг дунд байгууллагын зээл: Жижиг дунд байгууллагын зээл нь 300 сая төгрөгөөс дээш дүнтэй бөгөөд том байгууллагын зээл олгох процесстэй ижил юм. 50 сая төгрөгөөс 300 сая төгрөг хүртэлх дүнтэй жижиг дунд байгууллагын зээлийг салбарын болон Зээлийн Газрын Жижиг дунд байгууллагын гишүүд хэлэлцэн боломжтой гэж үзвэл Зээлийн Дэд Хороо болон салбарын зээлийн хороонд танилцуулдаг. Салбарууд болон Зээлийн Газрын Жижиг Дунд байгууллагын хэлтэс зээлийн хүсэлтэд зээлийн үнэлгээ өгч, дотоод үнэлгээний системээр шинжилгээ хийн дүгнэлт гаргаж, Зээлийн Хороо болон салбарын зээлийн хороогоор хэлэлцүүлдэг. Шаардлагатай тохиолдолд олгогдсон зээл дээр ч мөн адил шинжилгээ хийдэг. 50 сая төгрөгөөс дээш дүнтэй бүх зээлүүд Зээлийн Газрын Мониторингийн Хэлтсийн эрсдэлийн дүгнэлтэйгээр холбогдох Зээлийн хороодоор хэлэлцэгдэн батлагддаг.





- Эрсдэлийн үнэлгээ хийх явц: Зээлийн газар нь Байгууллагын Банкны Газар буюу Салбарууд, Жижиг Дунд Байгууллагын Хэлтсээс ирүүлсэн зээлийн хүсэлтүүдэд бие даасан шинжилгээ хийдэг. Уг хүсэлтүүд нь зээлийн програмд “Зээл батлагдахаар хүлээгдэж байгаа” төлөвт бүртгэлтэй байдаг. Зээлийн газар нь ихэвчлэн дотоод процедурын хүчин зүйлд тулгуурлан шинжилгээ хийдэг. Энэ нь олон төрлийн эдийн засгийн салбар, бүтээгдэхүүний секторын лимит, нэг болон хоорондоо холбоо бүхий бүлэг этгээдийн лимит, хүссэн зээлийн үнэлгээг тогтоох, зээлийн багцын дуусах хугацааг тодорхойлох, зээлийн багцад харьцуулалт ба жигнэлт хийх болон бусад макроэкономикийн үзүүлэлтүүд ба Зээлийн Газрын бодлогод заасан бидний зээл шийдвэрлэх дотоод зааварчилгааны дагуу үнэлгээг хийх юм. Зээлийн хүсэлтүүдийг туршлагатай зээлийн мэргэжилтнүүд судалж зээлийн судалгааг зээлдэгчийн зээл төлөх чадварын үнэлгээнд тулгуурлан бэлтгэдэг. Ингэхдээ статистикийн мэдээ болон гадны эх сурвалжаас зээлдэгчийн зээл төлөх чадварын үнэлгээг авч ашигладаг. Зээл шийдвэрлэх бодлогын дагуу зээлийн хүсэлтүүд хэмжээнээсээ хамаарч Зээлийн Хороо, Зээлийн Дэд Хороо болон салбарын зээлийн хороогоор орж шийдвэрлэгддэг.
- Жижиг зээлүүд: Жижиг зээл олгох үйл явц том зээл олгох үйл явцтай ижил. Ихэнх харилцагчид салбарын зээлийн мэргэжилтнүүдэд хүсэлтээ гаргадаг. Хэрэв харилцагчдын хүссэн зээлийн нөхцөл, зээлийн материалууд банкны шаардлага хангаж байвал зээлийн мэргэжилтэн хүсэлтийг Зээлийн Газарт бүртгүүлж, холбогдох судалгаа дүгнэлтүүдийг салбарын зээлийн хороонд танилцуулах ба зээлийг шийдвэрлэх эрх нь салбарын зээлийн хороонд байдаг. Хэрэв зээлийн дүн салбарын зээл шийдвэрлэх эрхийн хэмжээнээс өндөр бол зээлийн бодлогын дагуу салбарын зээлийн хорооны хурлаар хэлэлцээд, зээлийн хүсэлтийг шийдвэрлэх эрхийг Зээлийн Хороо болон Зээлийн Дэд Хороонд шилжүүлнэ.

Зээлийн мониторинг

Бид зээлдэгчийн зээлээ эргүүлэн төлөх чадварыг тодорхойлохдоо зээлдэгчийн нөхцөл байдал, барьцаа хөрөнгө, зээлдэгчийн зээл, хүүгийн төлбөрийг төлөх боломж зэрэгт шинжилгээ хийж зээлийн хэмжээ, төлөгдөх хугацаа зэргийг тодорхойлдог. Зээлийн Газрын Мониторингийн Хэлтэс зээлийн багцыг бүхэлд нь хянадаг ба “watch list-хянах жагсаалт”-ын аргаар байнгын хяналтыг хэрэгжүүлдэг ба энэ нь сард нэгээс доошгүй удаа байна. Энэхүү хяналтын хүрээнд эрсдэлийн үнэлгээ болон бизнесийн салбарын эрсдэлийг харгалзан үзэж, зээлийн ангиллыг хийдэг. Хяналтын процесс нь зээлийн багцын эрдсэл ба эдийн засгийн салбаруудын эрсдэлийн түвшинг ерөнхийд нь үнэлдэг. Харилцааны менежерүүд энэхүү тогтмол хяналтад оролцдог ба харилцаа холбоон дээрээ тулгуурлан анхаарал, шаардлагуудаа тавьж ажилладаг. Зээл “watch list-хянах жагсаалт”-д орсон тохиолдолд харилцааны менежер харилцагчтай холбогдож зээлийн төлбөр төлөгдөхгүй байх эрсдэлийг бууруулахаар төлөвлөгөө гарган ажилладаг. Мөн энэ үйл ажиллагаанд тухайн зээлийг хариуцсан хэлтэс болон зээлийн мэргэжилтэн, зээлийн ахлах мэргэжилтэн оролцдог. Зээлийн Газрын Мониторингийн Хэлтэс нь холбогдох ажилтнуудын оролцоотойгоор зээлийн багцын харьцаа, тэнцвэрийг үнэлж, удирдахад зориулж эцсийн дүгнэлт тайлангуудыг бэлтгэдэг. Ингэснээр зээлийн чанар, эрсдэл, үр ашиг хэмжүүрийг тодорхойлох, үнэлгээнд хамаарах бусад чухал үзүүлэлтүүдийг онцгойлон авч үзэх ач холбогдолтой юм.

Зээлийг эргүүлэн төлүүлэх үйл явц

Зээлийг эргэн төлүүлэх ажиллагааг харилцааны менежерүүд хариуцдаг. Бүх харилцагчдад зээлийг эргүүлэн төлөхтэй холбоотой аливаа мэдээллийг бичгээр болон аман хэлбэрээр өгдөг ба зээлийг эргэн төлүүлэх чиглэлээр гэрээний дагуу эрчимтэй ажилладаг. Зээлийг эргэн төлөх хугацаа хэтэрснээс хойш 5 хоногийн дотор зээлийн түүх болон, өмнө хугацаа хэтрүүлж байсан эсэх, зээлийн хэмжээ зэргээс хамаарч харилцагчидтай зээлийн эргүүлэн төлөх талаар холбоо тогтоодог. Зээлийн өрийн хэмжээ өндөр байгаа болон зээлийг эргүүлэн төлөх үйл явц удаашралтай байгаа харилцагчдыг түлхүү анхаарч, тогтмол эргэх холбоотойгоор ажилладаг. Байгууллагын Банк болон Иргэдийн Банкны Газрын удирдлага зээлийн хугацаа хэтрэлттэй харилцагчдад анхны удаад утсаар мэдэгддэг ба уг харилцааны үр дүн ямар байгаагаас хамаарч дараагийн арга хэмжээг хэрэгжүүлдэг. Бүх зээлдэгчидтэй харилцах аман болон бичгийн харилцаа нь мэргэжлийн өндөр түвшинд, ёс зүйн шаардлагыг хангасан байдлаар явагддаг.

Зээлийг эргүүлэн төлүүлэх үйл явцыг тоймловол:

- Бид бүх зээлдэгчиддээ зээлийн дансны хуулга, зээл төлөгдсөн байдал, зээл төлөх хэмжээ, хугацаа хэтрэлтийн мэдээллийг агуулсан тайланг сар бүр илгээдэг. Харилцааны менежер хариуцсан зээлийн дансуудаа тогтмол хянах ба зарим нэг сонгогдсон дансуудыг Зээлийн Газрын зүгээс хамтран хянадаг. Явцын хяналтын үндсэн дээр хугацаа хэтэрсэн болон муудсан зээл дээр зээл эргэн төлүүлэх хөтөлбөрийг боловсруулдаг.
- Эдгээр харилцагчид төлбөрөө 30 хоногоос дээш хугацаа хэтрүүлбэл зээлийн мэргэжилтэн зээлдэгчийн зээлээ төлөх чадварыг дахин үнэлж, тэдгээр харилцагчдад бизнесийн боломжит хувилбаруудыг санал болгодог. Үүнд харилцагчийн өнөөгийн болон ирээдүйн мөнгөн урсгалын чадамжийг бэхжүүлэхийн тулд дансны авлагын бодлого, маркетингийн стратеги, борлуулалтаа өсгөх стратеги, үнийн бодлого болон түүхий эд, барааны эргэлтийг өсгөх зэрэг орно.
- Бүхий л шаардлагатай арга хэмжээг авч хэрэгжүүлсэн хэдий ч хугацаа хэтрэлт хэвээр байсаар, 90-ээс дээш хоног болсон тохиолдолд уг зээлийн удирдлага, хяналтыг Эрсдэлийн Удирдлагын Газрын Тусгай Активын хэлтэст шилждэг.
- Зээлийг эргүүлэн төлүүлэх бүхий л боломжийг судалж, шаардлагатай арга хэмжээг авч хэрэгжүүлсэн хэдий ч зээл төлөгдөөгүй, зээлдэгч зээл төлөх чадваргүй нь тогтоогдсон, эсвэл ямар нэг маргаан гарсан тохиолдолд Тусгай активын хэлтэст шилжүүлж, 30 хоногийн дотор хуулийн дагуу төлүүлэх арга хэмжээг авдаг.

Зээлийн эрсдэлийн загварчлал ба багцын чанар

Бид зээлийн хугацаа хэтрэлт (PD), алдагдлын магадлал (LGD) болон зээлийн эрсдэлийн бусад үзүүлэлтүүдийг тооцоолох загварчлалыг боловсруулан ашиглаж байна. Уг аргачлал нь IAS 39 болон Базелийн хорооноос гаргасан зээлийн эрсдэлийн загварчлалын шаардлагуудыг бүрэн хангаж, хүлээгдэж буй хугацаа хэтрэлт, алдагдлын хэмжээг тооцоолон зээлийн эрсдэлийн хязгаарлалтууд, бусад зохистой үзүүлэлтүүдийг тогтоох замаар зээлийн эрсдэлийг хянах үр ашигтай хэрэгсэл болж чадсан юм. Чанаргүй зээлд хугацаа нь хэтэрч үнэ цэнэ нь буурсан зээлүүд хамаарна. Зээлийн үнэ цэнийн бууралтыг IAS 32-ын дагуу тогтоодог бөгөөд уг стандартын дагуу зээлийн өнөөгийн үлдэгдэл нь ирээдүйн мөнгөн урсгалаас төлөгдөх зээл, хүүний төлбөрийн өнөөгийн үнэ цэнээс их байх зээлүүдийг чанаргүй буюу үнэ цэнэ буурсан зээл гэж үзнэ. Энэхүү дүрэм зээлийн чанарын ангилалд зээлдэгчийн санхүүгийн чадавхиас гадна гадаад хүчин зүйлсийг авч үздэгээрээ давуу талтай юм.

Салбарын шинжилгээ ба төвлөрөл

Бид зээлийн багцын чанарыг урьдчилан тодорхойлсон түвшинд барих үүднээс төвлөрлийн хязгаарлалтыг тогтоож, хэрэгжүүлдэг. Бизнесийн нэг салбарт, эсвэл эдийн засгийн аль нэг сегментэд зээлийн хэт төвлөрөл үүсэхээс зайлсхийх зорилгоор банкны зээлийн бодлогод эдийн засгийн нэг салбарт олгох зээлийн дээд хэмжээг нийт багцын 20 хувиас хэтрэхгүй байхаар заасан. Нэг зээлдэгчид олгох зээлийн дээд хэмжээ, холбоотой буюу хамааралтай зээлдэгчдэд олгох зээлийн дээд хэмжээ болон рейтинг, улс орны хязгаарлалт зэрэг үзүүлэлтүүд ч зээлийн бодлогод тусгагдсан байдаг. Манай зээлийн төвлөрлийн үзүүлэлтүүд өнөөгийн Монгол Улсын эдийн засгийн бүтэц төвлөрсөн, төрөлжилт муутайг харуулж байгаа бөгөөд удирдлагууд салбарын төвлөрлийн эрсдэлийг бууруулах боломжтой гэж үзэж байгаа ба зээлийн багцаа төрөлжүүлэх боломжуудыг олж харахын тулд эдийн засгийн секторт тогтмол шинжилгээ хийж байдаг. 2012 оны 12-р сарын 31-ний байдлаар нийт зээлийн багцын 10.3 хувийг худалдааны сектор, 10.2 хувийг уул уурхайн сектор тус тус эзэлж байгаа нь багцад хамгийн өндөр дүнг эзэлж байгаа юм.

Зээлийн ангилал ба зээлийн алдагдлыг хүлээн зөвшөөрөх бодлого


Зээлийн хороо нь зээлийн багцын чанарыг зохицуулж, сайжруулахыг хариуцдаг. Эрсдэлийн Удирдлагын Газрын Багцын Эрсдэлийн Удирдлагын хэлтэс нь төвлөрсөн систем ашиглан зээлийн багцын чанарыг үнэлэх ба зээлийг алдагдал болсон үед шаардлагатай нөөцийг бүрдүүлж зээлийн багцыг бүхэлд нь хянаж байдаг.

Зээлийн ангилал: Зээлүүд тогтмол хяналтанд байдаг ба энэ нь зээлд байгаа аливаа асуудлыг эрт илрүүлэхэд тусалдаг. Мөн 1 тэрбум төгрөгнөөс дээш дүнтэй зээлүүдийн хувьд улирал бүр болон төлбөрийн график хуанлийн 14 хоногоос илүү зөрчигдсөн тохиолдолд зээлдэгч бүрийн санхүүгийн нөхцөл байдалд гүнзгий шинжилгээг хийдэг.





Зээлийн эрсдэлийг хэмжих аргачлал



Бид барьцаа хөрөнгийн төлөв байдалд үнэлгээг жилд дөрвөөс багагүй удаа хийдэг. Зээлийн эргэн төлөлт нэг өдрөөр хоцроход л Зээлийн Газар уг асуудлыг арилгах ажлаа эхэлдэг.

Зээл болон балансын бус үзүүлэлтүүд нь дараах зүйлсээр ангилагддаг: Харилцагчийн санхүүгийн гүйцэтгэл, үндсэн зээлийн ба хүүгийн эргэн төлөлтийн хугацаа, барьцаа хөрөнгийн чанар, зээлийн нөхцөлд өөрчлөлт оруулсан эсэх, бусад зээлүүдийн эргэн төлөлтийн хугацаа, зээлийг зориулалтын дагуу ашигласан эсэх, бусад зээлүүдийн хувьд уг зээлдэгч алдагдал учруулсан эсэх болон харилцагчийн рейтинг болно.

Багцын Эрсдэлийн Удирдлагын Хэлтэс нь зээлийн багцын эрсдэлийн шинжилгээг хийж сар бүр тайлагнадаг. Зээлийн Газар нь зээлийн эргэн төлөлтийн хугацаа ба ангилагдсан зээлүүд, болзошгүй өр төлбөрүүдийн талаарх нарийн анхааруулгыг уг тайланд тусгадаг. Хэрэв үндсэн болон хуримтлагдсан хүүний эргэн төлөлтөд асуудал үүсвэл зээлийн эргэн төлөлтөд хяналт тавин хариуцан ажилладаг хэлтсүүд шууд арга хэмжээ авдаг. Зээлийн багцад хамаарах хөрөнгүүдийн чанар болон болзошгүй өр төлбөрүүдийн талаар бүхэлд нь Зээлийн Газар мэдээлэл хийдэг. IFRS зээлийн алдагдлыг хүлээн зөвшөөрөх: Бидний санхүүгийн тайлан болон уг тайланд тусгагдсан санхүүгийн бусад мэдээллүүд IFRS-ийн дагуу бэлтгэгддэг. IFRS санхүүгийн тайланд тусгасан зээлийн алдагдлыг хүлээн зөвшөөрөх тооцоолол нь хагас жилийн санхүүгийн мэдээлэлд үндэслэн хийгдсэн ба хяналт болон зээлийн алдагдлын тооцоолол нь өдөр тутмын мэдээнд үндэслэн хийгддэг. Бид IFRS -ын дагуу санхүүгийн тайлангаа бэлтгэхийн тулд зээлийн алдаглыг хүлээн зөвшөөрөхдөө бүх зээлүүдийг хамааруулан тооцдог.

Хөрвөх чадварын эрсдэл

Хөрвөх чадварын эрсдэл гэдэг нь банк өөрийн санхүүгийн үүргүүдээ цаг хугацаанд нь зах зээлийн үнээр гүйцэтгэж чадахгүйд хүрэх эрсдэл юм. Санхүүгийн үүргүүд гэдэгт хадгаламж эзэмшигчдэд өгөх өглөг, санхүүгийн хэрэгслүүдийн гэрээний дагуух төлбөрүүд, үнэт цаас, зээл, худалдан авалтын төлбөр тооцоонууд болон хөрөнгө оруулалт, зээлтэй холбоотой бүхий л үүргүүдийг ойлгоно. Хөрвөх чадварын эрсдэл нь позицийг удирдах, санхүүжилт болон хөрөнгө оруулалтын үйл ажиллагаа явуулахад тохиолддог эрсдэл. Уг эрсдэлд тухайн актив талын багцын хугацаа болон хүүгийн зөрүүнээс шалтгаалсан хүлээгдээгүй зардлын өсөлтийг хамааруулан авч үздэг.


Голомт банкны хөрвөх чадварын удирдлагын тогтолцоо нь зах зээлийн хэвийн болон хэвийн бус нөхцөлд дээр дурдсан санхүүгийн үүргүүдээ бүрэн гүйцэтгэж чадахуйц хөрвөх чадварын баталгаат түвшингүүдийг тогтоох, хянах, удирдахад чиглэдэг. Түүнчлэн хөрвөх чадварын эрсдлийг удирдах бодлого нь хэрэглэгчийн бэлэн мөнгөний хэрэгцээ шаардлагыг хангахуйц сан, хөрвөх чадвар өндөртэй нөөцтэй байх, үйл ажиллагааны өөрийн хөрөнгийн хүрэлцээг хангуулах, хүүгийн болон бусад орлогыг нэмэгдүүлэх зэрэгт чиглэгддэг.

Банкны төлбөр түргэн гүйцэтгэх чадварыг Хөрөнгийн Удирдлагын Газар банкны бүх салбар нэгжээр дамжуулан зохистой түвшин болон таамаглалын үндсэн дээр удирддаг. Хөрөнгийн Удирдлагын Газрын захирал нь банкны хөрвөх чадварыг хангах үүднээс зээлийн шийдвэр гаргалтад шууд оролцдог. Мөн Актив Пассивын Хорооны хурал нь сард хамгийн багадаа 2 удаа хуралддаг бөгөөд уг хурлаар хөрвөх чадварыг удирдах бодлогоос гадна шаардлагатай өөрчлөлт, шийдвэрүүдийг гаргаж, хөрвөх чадварын стандарт болон бусад бодлогуудтай нийцсэн дахин хяналтыг тавьж ажилладаг. Эрсдэлийн Удирдлагын Хороогоор банкны хөрвөх чадварын эрсдлийг удирдах, олон улсын практик туршлага болон хуулийн шаардлагуудад нийцүүлэн хөрвөх чадварын эрсдлийн удирдлагын стандартыг гаргадаг.

Актив Пассивын Хороо нь дараах зүйлүүдэд хяналт тавин, хэрэгжүүлэх шийдвэр гаргадаг. Үүнд, (i) богино болон урт хугацааны мөнгөн урсгалын удирдлага, (ii) баланс тайлангийн бүтэц, (iii) гадаад валютын хөрвөх чадварын удирдлага, (iv) татан төвлөрүүлсэн хөрөнгийг тогтвортой байлгах, (v) хөрвөх чадварын стресс тест гүйцэтгэх, (vi) хөрвөх чадварыг хангах зорилгоор хөрөнгийн хүрэлцээг хангуулан ажиллах зэрэг багтана.

Актив Пассивын Хорооны хурлын мониторингийн процесс нь дотоод болон гадаад хяналтын системээр дамжин хэрэгждэг. Уг дотоод болон гадаад хяналтын системүүдийн тусламжтайгаар хөрвөх чадварын эрсдэлийг дараах арга хэрэгслүүдээр үнэлж, хэрэгжүүлдэг. Үүнд (i) сарын давтамж дээр үндэслэсэн хүү, хугацаа, гадаад валютын зөрүүний шинжилгээ, (ii) өдөр бүрийн мөнгөн урсгал, гарах мөнгөн урсгалын таамаглал, тайлан балансын урт хугацааны таамаглал, (iii) Санхүүгийн Удирдлагын Газраас сар бүрээр гаргасан актив пассивын оновчтой бүтцэд хяналт тавих, (iv) төлбөр түргэн гүйцэтгэх чадварын харьцаанууд, өдрийн давтамжтайгаар тооцсон хамгийн бага нөөцийн шаардлагууд, (v) Хөрөнгийн Удирдлага, Байгууллагын банк, бусад дотоод газар хэлтсээс гаргасан аналитик тайлан, хөрөнгийн зах зээлийн таамаглал, хөрвөх чадварын тайлан зэрэг дээр үндэслэсэн хүлээгдэж буй хөрвөх чадвартай холбоотой үйл ажиллагаа, (vi) Эрсдэлийн Удирдлагын Газраас гаргасан үйл ажиллагааны хязгаарлалтууд, хөрвөх чадварын харьцаанууд, зөрүүний хэмжээний хязгаарууд, нэг сарын зээлийн лимит гэх зэрэг багтана.

Хөрвөх чадварын харьцаа



Эргэн төлөгдөх хугацааны шинжилгээ нь хөрвөх чадварыг балансын бүтцийг удирдах, үр ашигтай цогц удирдлагын тогтолцооны суурь болдог. Хүлээгдэж буй мөнгөн урсгал нь эргэн төлөгдөх хугацаа өөрчлөгдөх бүрт тодорхой дүнгээр өөрчлөгдөж байдаг. Иймд банкны хөрөнгө, эх үүсвэр болон тэнцлийн гадуурх үүргүүдийг эргэн төлөгдөх хугацааны хувьд шинжлэхдээ хугацаа нь тодорхойгүй, эсвэл хугацаанаас өмнө хэрэгжих магадлалтай үүргүүдийг чанараар нь ангилж, хугацааны боломжуудыг тодорхойлдог. Энэхүү үйл явц нь балансын бүтэц алдагдсанаас үүсэх хөрвөх чадварын

эрсдэл, түүнийг нөхөхөд зарцуулагдах нэмэлт эх үүсвэрийн хэмжээг тодорхойлоход ашиглагддаг. Хугацааны ялгаатай үеүд дэх хүлээгдэж буй орох, гарах хөрөнгийн урсгалын зөрүүг тодорхой хязгаарт барих, хөрвөх чадварын харьцааг хангалттай өндөр түвшинд байлгах үүднээс зохих хязгаарлалт, шаардлагуудыг тогтоон мөрддөг. Энэхүү хязгаарлалт, шаардлагуудыг хангуулах үр ашиг бүхий механизмуудыг нэг нь богино хугацааны хөрөнгө, эх үүсвэрийн харьцааг тооцож, үр ашигтайгаар удирдах юм. Эдгээр түгээмэл хэрэглэгддэг харьцаануудыг дараах байдлаар тооцдог:

- Цэвэр зээл / Харилцах, хадгаламж;
- (Монголбанкинд байршуулсан хадгаламж + Мөнгөн хөрөнгө) / Харилцах, хадгаламж;
- Нэг сар хүртэлх хугацааны актив / Нэг сар хүртэлх хугацааны пассив;
- Банк санхүүгийн байгууллагуудаас татсан хөрөнгө / Харилцах, хадгаламж;
- Банк санхүүгийн байгууллагад байршуулсан хадгаламж / Харилцах, хадгаламж;
- Хөрвөх актив / (Харилцах, хадгаламж + Банк санхүүгийн байгууллагуудаас татсан хөрөнгө);
- Хөрвөх актив / (Харилцах, хадгаламж + Банк санхүүгийн байгууллагуудаас татсан хөрөнгө + Хүлээж болзошгүй үүргүүд);
- Хөрвөх актив / Нийт актив;
- Цэвэр зээл / Нийт актив;
- Цэвэр зээл / Харилцах, хадгаламж;
- Цэвэр зээл / (Харилцах, хадгаламж + Банк санхүүгийн байгууллагуудаас татсан хөрөнгө);
- Хугацаатай хадгаламж / Нийт пассив;
- Гадаад валютын актив / Нийт актив;





- (Банк санхүүгийн байгууллагаас авсан зээл + Гадаад валютын хадгаламж) / Гадаад валютын харилцах, хадгаламж;
- Гадаад валютын цэвэр зээл / Нийт актив;
- Гадаад валютын хөрвөх актив / Гадаад валютын харилцах, хадгаламж;
- Том харилцагчдын харилцах, хадгаламж / Харилцах, хадгаламж;
- Засгийн газрын харилцах, хадгаламж / Харилцах, хадгаламж;
- Бусад харьцаа үзүүлэлтүүд

Гадаад валютын хөрвөх чадварын удирдлага

Гадаад валютын ханшийн эрсдэл нь банкны балансын актив болон пассивын дүн төгрөгөөс өөр бусад валютаар байршсанаас хамааран гарч ирдэг эрсдэл юм. Гадаад валют тус бүрээр байгаа татан төвлөрүүлсэн хөрөнгөтэйгээ уялдуулан зээлээ ямар валютаар олгох шийдвэр гарган ажилладаг. Бидний гадаад валютын эрсдэлийг удирдах бодлогын зорилго нь тухайн валютаар байршиж буй актив, пассив хөрөнгүүдийн хоорондын зөрүүг бага байлгахыг хичээдэг. Банк гадаад валютын эрсдэлийг байнгын удирдан ажиллаж байгаа бөгөөд уг хөрвөх чадварын эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлэх гол бодлогын сонголт нь гадаад валютаар олгох зээлийн хэмжээг тухайн валютаар татсан эх үүсвэртэй нь уялдуулах явдал юм.

Төвлөрөл багатай багц буюу хөрөнгийн тараан байршуулалт

Банкны хөрөнгө, эх үүсвэрийг эдийн засгийн секторууд болон том, групп харилцагчдаас хэт хамааралтай болохоос урьдчилан сэргийлэх, төвлөрлийг сааруулах зорилгоор төвлөрлийн эрсдэлийн хязгаарлалтуудыг тогтоодог. Эх үүсвэрийн дийлэнхийг урт хугацаат харилцах, хадгаламж болон харилцагчдын оновчтой түүврээс (том, жижиг харилцагчдын хувьд) бүрдүүлэх замаар төвлөрлийн эрсдэлийг бууруулдаг.

Хөрвөх чадварын стресс тест

Гэнэтийн давагдашгүй хүчин зүйлсийн улмаас банкны хөрвөх чадварт үүсч болзошгүй нөлөөллийг үнэлэх зорилгоор тусгайлан болон системчилсэн стресс сценаруудыг гарган, тэдгээрт нийцсэн мөнгөн урсгалын төсөөллүүдийг хийдэг. Сценарууд нь түүхэн эсвэл төсөөлсөн үйл явдлын (жишээ нь нэг банкны санхүүгийн нөхцөл байдал хүндэрсэн нь түүхэн явдал бол үүнээс банкны системд үзүүлэх нөлөөллийг тооцох нь төсөөлсөн явдал юм) аль алинд суурилж болох бөгөөд стресс тестийн үр дүнгүүд нь хөрвөх чадварын зорилтот түвшингүүдийг тодорхойлох, төлөвлөхөд хамгийн зөв, оновчтой өгөгдлүүд болдог.

Хөрвөх чадварын нөөц төлөвлөгөө

Эдийн засаг зогсонги байдалд орсонтой холбоотойгоор банк хөрвөх чадварын нөөц төлөвлөгөөг боловсруулан хэрэгжүүлдэг. Энэ нь хөрвөх чадварын хүндрэлийг хохиролгүйгээр даван туулахуйц түвшний итгэлцлийг зах зээлд бий болгох, хувь нийлүүлэгчдийн ашиг сонирхлыг хамгаалахад чиглэгдсэн цогц төлөвлөгөө бөгөөд хямралын үед баримтлах тодорхой стратегид суурилсан, хямралыг урьдчилан мэдээлэх өргөн хүрээтэй үзүүлэлтүүдийг агуулсан байдаг. Урьдчилан мэдээлэх үзүүлэлтүүд нь тодорхой давтамжтайгаар, нарийвчлалын өндөр түвшинд хянагдан шинэчлэгддэг бол хямралын эсрэг стратеги нь эрсдэлийн удирдлагын тогтолцооны хүрээнд зохион байгуулагдаж, дотоод гадаад харилцаа, хөрвөх чадвар болон нөхцөл байдлын шаардлагаар бий болох нэмэлт мэдээллийн шаардлагуудыг тусгасан байдаг.

Зах зээлийн эрсдэл

Зах зээлийн эрсдэл нь хүүгийн түвшин, гадаад валютын ханш, өөрийн хөрөнгийн үнэ цэнэ гэх мэт зах зээлийн хэлбэлзэлтэй холбоотой эрсдэлийн хүчин зүйлсийн сөрөг өөрчлөлтийн нөлөөгөөр банкинд үүсч болзошгүй эрсдэл юм. Банк арилжааны болон арилжааны бус багцын аль алинаас нь зах зээлийн эрсдэлд өртөж болох бөгөөд энд банкны хөрөнгийн удирдлагын үйл ажиллагаа ч хамаардаг.

Төлөөлөн Удирдах Зөвлөлөөс банкны эрсдэлийн удирдлагын бодлогын хүрээнд зах зээлийн эрсдэлийн ерөнхий хязгаарлалт болон түүнд агуулагдах үзүүлэлт нэг бүрийн нарийвчилсан хязгаарлалтуудыг тогтоож, хэрэгжилтийг Актив Пассивын хороо хянадаг. Энэхүү хяналт нь банк одоо болон ирээдүйд хүү, ханшийн өөрчлөлтөөс хүлээж болох эрсдэлийн нийт багцыг тодорхойлох, тогтмол хянах зарчмаар хийгддэг.

Хөрөнгийн Удирдлагын Газрын захирал Төлөөлөн Удирдах Зөвлөл болон Актив Пассивын Хорооноос тогтоосон бодлого, журмын хэрэгжилтийг хангуулах, бүтээгдэхүүн, хөрөнгө оруулалтын төрлүүд, арилжааны хэлцлүүд болон санхүүгийн хэрэгслүүдийн хувьд танигдсан хязгаарлалтуудыг үйл ажиллагаандаа мөрдлөг болгох замаар зах зээлийн эрсдэлийн өдөр тутмын удирдлагыг гүйцэтгэж ирсэн. Эрсдэлийн Удирдлагын Газар нь зах зээлийн эрсдэлийн удирдлагын үйл ажиллагаанд голлох үүрэгтэйгээр оролцож үйл ажиллагаагаа Актив Пассивын Хороо болон Гүйцэтгэх захиралд шууд тайлагнадаг.

Хүүгийн эрсдэл

Банкны арилжааны бус багцаас урган гардаг зах зээлийн гол эрсдэл нь хүүгийн түвшний өөрчлөлтөөс банкны ашиг, эсвэл өөрийн хөрөнгөд үзүүлэх сөрөг нөлөөлөл буюу хүүгийн эрсдэл юм. Банк дараах шалтгаануудын улмаас хүүгийн түвшний эрсдэлд өртдөг.

- Хөрөнгө, эх үүсвэрийн дахин үнэлэгдэх эсвэл төлөгдөх хугацаа ялгаатай байх (жишээ нь, хөрөнгө нь эх үүсвэрээс хурдан хугацаанд дахин үнэлэгддэг тохиолдолд хүү буурвал ашиг буурна);
- Хөрөнгө, эх үүсвэр ижил хугацаанд ялгаатай дүнгээр дахин үнэлэгдэх (жишээ нь, зах зээл дэх хүүгийн түвшин буурахад Банк эх үүсвэрийн хүүгээ түүнээс бага түвшнээр бууруулах);
- Урт хугацаанд зах зээлийн хүүгийн түвшин ялгаатай дүнгээр өөрчлөгдөх (жишээ нь, өгөөжийн муруй шинээр олгогдож буй зээлийн өгөөж болон эх үүсвэрийн зардалд өөрөөр нөлөөлөх);
- Хүүгийн түвшний өөрчлөлтөөс хамаарч хөрөнгө, эх үүсвэрийн үлдсэн хугацаа уртсах эсвэл богиносох (жишээ нь, хэрэв урт хугацаат моргейжийн хүү огцом буурвал моргейж төлөвлөсөн хугацаанаас өмнө ихээр төлөгдөж, орлого буурна).

Хүүгийн эрсдэлийг удирдах үйл ажиллагааны үндсэн зорилго нь хүүгээс хамаарсан активыг удирдах замаар цэвэр хүүгийн орлогыг өсгөх, хүүгийн сөрөг өөрчлөлтийн банкинд үзүүлэх нөлөөг хязгаарлах замуудаар ашгийг нэмэгдүүлэхэд чиглэгддэг. Бид хүүгийн эрсдэлийг удирдахдаа хүүгээс хамаарсан хөрөнгүүдэд хяналт тавих, хүүгийн эрсдэлийг хамгийн бага байлгах, хэмжээнд хязгаарлалт тавих зэрэг арга хэрэгслүүдийг ашигладаг. Эдгээр арга хэрэгслүүд нь хүүгийн зөрүүний шинжилгээ, хугацааны зөрүүний шинжилгээ, хүүгийн орлогын төсөөлөл зэргийг тооцоход ашиглагддаг. Хүүгийн хязгаарлалтын систем нь дараах хэсгүүдээс бүрддэг. Үүнд: (i) хамгийн их алдагдлын хязгаар, (ii) хүүгийн зөрүүний хязгаар, (iii) нөөцийн хуваарилалтад хүүг хамгийн бага байлгах зэрэг болно.

Зах зээлийн хүүгийн түвшин болон актив пассивын хугацааны зөрүүгээс хамаарсан цэвэр хүүгийн орлогын хоорондын хамаарлаар хүүгийн мэдрэмж тодорхойлогддог. Сөрөг хүүгийн зөрүү нь балансын пассив талд мэдрэмжтэй бөгөөд энэ тохиолдолд хүүгийн түвшин буурах нь цэвэр хүүгийн орлогод эерэг, харин өсөх нь хүүгийн орлогод сөрөг нөлөөтэй. Бид хүүгийн эрсдэлд хяналт тавихдаа хүү болон хүүгийн маржины өөрчлөлтөөс хамаарах хөрөнгүүдийг үнэлэх, тогтоосон хязгаарлалтуудтай харьцуулан дүгнэлт өгөх болон хүүгийн позицт нөлөөлөх банкны бусад шинэ бүтээгдэхүүн, арга хэрэгслийг ашигладаг. Түүнчлэн бид банкны актив, пассив, балансын бус тайлан, арга хэрэгслүүдийн үр дүнд шинжилгээ хийн уг эрсдэлээс хамгаалдаг.

Гадаад валютын ханшийн эрсдэл

Арилжааны багцын гол эрсдэл нь гадаад валют болон санхүүгийн хэрэгслүүдийн хүү, зах зээл дэх хөрвөх чадвар, үнийн өөрчлөлтөөс үүсдэг. Арилжааны багцаас хүлээх эрсдэл нь гадаад валют болон санхүүгийн хэрэгслүүдийн хэмжээ, зах зээл дэх хөрвөх чадвар болон үнийн өөрчлөлтөөс голлон хамаарах ба эрсдэлийн үндсэн хүчин зүйлс нь хүүгийн түвшин, ханш, хувьцааны үнэ юм.





Банкны арилжааны үйл ажиллагааны гол цөм нь харилцагчдад өрсөлдөхүйц үнээр бүтээгдэхүүн, үйлчилгээгээ нийлүүлэх буюу харилцагчдад чиглэсэн үйл ажиллагаа юм. Үүнээс гадна банк ашиг олох зорилгоор өөрөө янз бүрийн арилжаа хийдэг. Үүнд:

- зах зээлийн давуу байдлаа ашиглан авах, зарах үнийн зөрүүгээр ашиг олох зорилгоор валютын арилжаа хийх,
- хоорондоо холбоотой өөр өөр зах зээлийн төгс бус байдлаас ашиг олох зорилгоор позиц үүсгэх,
- ирээдүйд давуу тал олох зорилгоор санхүүгийн хэрэгслүүдийг эзэмших гэх мэт.

Бизнесийн үйл ажиллагааныхаа явцад зах зээлийн эрсдэлтэй холбогддог банкны бүтцийн бүхий л нэгжүүд банкны арилжааны бодлогыг дагаж мөрдөх ёстой. Зах зээлийн эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлэх үндсэн хэрэгсэл нь нарийвчлан тогтоосон, хатуу хязгаарлалтууд бөгөөд эдгээр нь дилерийн эрх хэмжээ гэх мэт эрсдэлийн удирдлагын үндсэн үзүүлэлтүүдийг бүхэлд нь тогтоосон байдаг. Хязгаарлалтууд зөрчигдсөн тохиолдолд авах арга хэмжээнүүдийг арилжааны бодлогод мөн тусгасан байдаг.

(мянган төгрөгөөр)	Delta Normal	Monte Carlo	Historical Simulation
Оны эцэст	114,443	118,334	129,954
Өдрийн дундаж	140,253	141,948	183,030
Хамгийн их	561,410	648,023	740,283
Хамгийн бага	14,366	14,132	16,130

Бид валютын арилжаа болон хөрөнгийн багцын зах зээлийн эрсдэлийг хэмжихийн тулд гурван төрлийн VaR аргыг ашигладаг. VaR аргаар тухайн сонгосон багцын зах зээлийн үнэ цэнийн боломжит сөрөг өөрчлөлтийг гаргаж авахад ашигладаг. Бид нэг болон арван өдрийн хугацаатайгаар VaR-ыг тооцож байгаа бөгөөд үүнийг өнгөрсөн үеийн бодит ашиг алдагдлын утгатай нь харьцуулах байдлаар загвараа буцааж тест хийн шалгадаг. Арван өдрийн VaR-т 99 хувийн ач холбогдлын түвшинд Монголбанкнаас суурь хязгаарлалтуудыг тавин ажилладаг. Түүнчлэн бид VaR-аар олж авсан боломжит алдагдлын хэмжээгээр банкны стресс тест хийж гүйцэтгэдэг.

Үйл ажиллагааны эрсдэлийн удирдлага

Үйл ажиллагааны эрсдэлийн удирдлага нь бизнесийн өргөн цар хүрээг хамардаг бөгөөд дотоод үйл ажиллагаа, системийн сул хангалтгүй байдал, хүний санамсаргүй алдаа, санаатай үйлдлүүд, гадаад хүчин зүйлээс шалтгаалан үүсэх шууд болон шууд бус аливаа алдагдлыг авч үздэг. Олон улсын стандартын дагуу үйл ажиллагааны эрсдэлд хуулийн болон нэр хүндийн эрсдэлийг оруулж тооцох бөгөөд стратегийн эрсдэлийг авч үздэггүй. Голомт банкны үйл ажиллагааны эрсдэлийн удирдлагын гол зорилго нь банкны зорилтот ашгийн түвшинд эрсдэлийг хамгийн бага байлгахад оршино.

Голомт банк оновчтой эрсдэлийн удирдлагыг бизнесийн үе шат бүрд хэрэгжүүлж, үйл ажиллагааг нарийн тодорхой зааж зохицуулсан дотоод журам, заавар, шалгуур үзүүлэлт, стандартуудыг нэвтрүүлж чанд мөрдөж ажилладаг. Бид тусгай програм хангамж, өдөр тутмын эрсдэлийн хяналтын хуудсыг ашиглан түүхэн өгөгдлүүдийг нэгдсэн мэдээллийн санд бүртгэж, Базелийн хорооны зөвлөмж болон олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн бусад арга аргачлалын дагуу үнэлгээ, судалгаа хийн өдөр тутмын шийдвэр гаргалтандаа ашигладаг. Бид зохистой хяналтын тогтолцоо, тогтмол хяналт шалгалтаар групп болон банкны боломжит эрсдэлийг хаах замаар үйл ажиллагааны эрсдэлийг удирдан ажилладаг.

Түүнчлэн бид орчин үеийн магадлал, статистикийн арга техник, дотоод гадаад хүчин зүйлийн нөлөөллийн тооцоо, сценари шинжилгээний зэрэг олон арга аргачлалаар банкны хэвийн үйл ажиллагаанд нөлөөлөхүйц эрсдэлийг урьдчилан таамаглаж, эрсдэлийн түлхүүр үзүүлэлтүүдийг тодорхойлон мөрдөж, урьдчилан сэргийлэх ажлыг өндөр түвшинд зохион байгуулж байна.

Үйл ажиллагааны эрсдэлийн удирдлагын хэлтэс нь газар нэгж, үйл ажиллагаа, бүтээгдэхүүн, үйлчилгээ тус бүрд эрсдэлийн үнэлгээг орчин үеийн дэвшилтэт арга аргачлалыг ашиглан тодорхой давтамжтайгаар хийдэг бөгөөд уг дүгнэлтийг үндэслэн цаашид сайжруулах арга хэмжээг зардал - эрсдэлийн оновчтой шийдлээр авч хэрэгжүүлдэг. Бид болзошгүй эрсдэлийн давтамж, нөлөөллийг бууруулах, урьдчилан сэргийлэх, эрсдэлийг тараан байршуулах зэрэг арга техник ашиглан эрсдэлийг удирддаг.

Эрсдэлийг гуравдагч этгээдэд шилжүүлэх үйл ажиллагаа

Голомт банк нь олон улсын даатгалын зах зээлээр дамжуулан эрсдэлийг гуравдагч этгээдэд шилжүүлэх үйл ажиллагааг мэргэжлийн өндөр түвшинд зохион байгуулж ажилладаг. Бид болзошгүй эрсдэлийг даван туулах зорилгоор "Moody's", "Fitch" агентлагуудын "AA-", "A" үнэлгээ бүхий Англи улсын "Lloyd's"-ийн гишүүн даатгагч нартай нягт хамтран ажиллаж, гадаад дотоод бүх төрлийн эрсдэлийг тогтмол даатгуулдаг. Голомт банк нь дотоодын болон олон улсын эрх бүхий байгууллагуудын шаардлага зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллахын зэрэгцээ сайн дурын даатгалын хамгаалалтыг үйл ажиллагаандаа өргөн ашиглаж хэвшсэн, оновчтой эрсдэлийн удирдлага бүхий тэргүүлэгч банк юм.

Мэдээллийн аюулгүй байдлын удирдлага

Мэдээллийн аюулгүй байдлын эрсдэл гэдэг нь санаатай болон санамсаргүй байдлаар мэдээллийн эх сурвалжуудыг ашиглах, өөрчлөх, задлах эсвэл устгах замаар банкны мэдээллийг хадгалах чадвар, бизнесийн тасралтгүй ажиллагаа, мэдээллийн нууцлалыг хамгаалах асуудлууд болон банкны нэр хүндэд сөргөөр нөлөөлөхийг хэлнэ. Бид мэдээллийн аюулгүй байдлын удирдлагыг хэрэгжүүлэхдээ олон улсын туршлагууд болон холбогдох хууль, дүрэм, журмуудыг баримтлан ажиллаж байна.

Үйл ажиллагааны эрсдэлийн удирдлагын хэлтэс нь хэрэглэгчийн эрхийн зохицуулалт, өгөгдлийн сангаас мэдээлэл татах журам, сүлжээний мониторинг, хэрэглэгчийн хандалт, хийсэн үйлдлийн бүртгэлийн хяналтын програмын тусламжтайгаар зайны хяналтыг гүйцэтгэж байгаагийн зэрэгцээ өдөр тутмын чиг үүрэг бүхий Мэдээллийн аюулгүй байдлын албатай хамтран ажиллах, чиглэл өгөх, давхар хяналтыг хэрэгжүүлж ажиллаж байна.

Луйврын шинжтэй эрсдэлийн удирдлага

Луйврын шинжтэй эрсдэлийн удирдлага нь үйл ажиллагааны эрсдэлийн нэг бүрэлдэхүүн хэсэг юм. Үйл ажиллагааны эрсдэлийн удирдлага нь төлбөр тооцоо болон бизнесийн үйл ажиллагаатай холбоотой гарсан алдаанд голчлон төвлөрдөг бол луйврын шинжтэй эрсдэлийн удирдлага нь санаатайгаар шударга бус үйлдэл хийснээс гарах эрсдэлийн магадлалд үнэлгээ хийдэг. Банкны удирдлагын гол үзэл баримтлал нь боломжит луйвар гарах магадлалыг тооцоолох, түүнийг хаах, явдал юм.

Банк нь данс бүртгэлийн алдаа, залилан гэх мэт луйврын шинжтэй бүхий л төрлийн үйл ажиллагаанаас урьдчилан хамгаалж, банкны үйл ажиллагааны бүхий л түвшний бодлого журмын хэрэгжилтэнд хяналт тавьж, хуйвалдан мэхлэх болон луйврын шинжтэй бусад үйлдлийн эсрэг тэмцэх төрөл бүрийн зохицуулалт, стратегийг иж бүрэн утгаар нь боловсруулан хэрэгжүүлсэн.

Түүнчлэн бид банкны бизнесийн бүхий л үйл ажиллагаа, нэгжүүдэд эрсдэлийн дүгнэлт гаргасан бөгөөд болзошгүй гэмт хэрэг, луйврыг таних болон төрөлжүүлэх замаар луйврын шинжтэй эрсдэлүүдийн ангиллыг гаргаж боломжит эрсдэлийг хаасан болно.

Бизнесийн тасралтгүй ажиллагааны удирдлага

Бизнесийн тасралтгүй ажиллагааны менежмент нь урьдчилж харах боломжгүй элдэв осол, саатлын улмаас бизнесийн хэвийн үйл ажиллагаа тасалдахад түүнийг богино хугацаанд хэвийн байдалд нь оруулах, системийн ажиллагааг бүрэн сэргээх, шаардлагатай арга хэмжээг зохион байгуулалттайгаар хэрэгжүүлэхэд чиглэдэг.

Голомт банк нь бизнесийн тасралтгүй ажиллагааг хангах зорилгоор Монголбанк болон бусад хууль хяналтын





байгууллагын шаардлага зөвлөмж, стандартуудыг мөрдөж ажилладаг. Бид энэ жил осол, саатлын үед системийг хэвийн байдалд эргүүлэн оруулах хугацааг боломжит хамгийн богино түвшинд байлгахыг чухалчилж, үүнтэй холбоотой банкны чадавхийг улам бэхжүүлэхийг түлхүү зорьж ажилласан.

Голомт банк нь осол саатлын үеийн хүндрэлүүдийг удирдах үйл ажиллагааг зохион байгуулалттай, хянагдахуйц хэлбэрт оруулах зорилгоор бизнесийн тасралтгүй ажиллагааны төлөвлөгөөг тогтмол сайжруулсаар ирсэн. Үйл ажиллагааны эрсдэлийн удирдлагын хэлтэс нь банкны бизнесийн тасралтгүй байдлыг хянаж удирдах, уг төлөвлөгөөний биелэлтийг хангуулах үүргийг гүйцэтгэхээс гадна уг төлөвлөгөөг хэрэгжүүлэх үүрэг бүхий “Ослын үед ажиллах баг” болон “Бизнесийн үйл ажиллагааг сэргээх баг”-уудтай нягт хамтран ажиллаж байна.

Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх үйл ажиллагаа

Голомт банк нь эрх бүхий байгууллагуудаас тогтоосон стандарт, шаардлагууд мөн мөнгө угаахтай тэмцэх хууль журмын хэрэгжилтийг хангах үүднээс данс эзэмшигчийн мэдээллийн үнэн зөв байдал, гүйлгээний явцад хатуу чанга хяналт тавих зэрэг үйл ажиллагааг өргөжүүлэн ажиллаж байна.

Голомт банк нь өөрчлөгдөж буй хууль эрхзүйн орчин нөхцөлд тохируулан бодлого, түүнийг хянах механизмаа сайжруулах замаар мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх үйл ажиллагаагаа илүү өндөр түвшинд хүргэж ажиллалаа. Банк нь 1) МУТСТ үйл ажиллагааны хэрэгжилт хариуцсан ажилтан томилох; 2) хэрэгжилтийн хяналтыг хангах зорилгоор дотоод хяналтын системийг бий болгох; 3) банкны бүх ажилтнуудад сургалт зохион байгуулах; 4) банкны дотоод хөтөлбөрийг хянах хөндлөнгийн хяналт явуулах гэсэн 4 хэсгээс бүрдсэн дотоод хөтөлбөрийг боловсруулан ажиллаж байна.

Банкны дотоод журам, бодлого нь холбогдох эрсдэл, гарч болзошгүй үр дагаврын талаар ойлголт өгөх, эрсдэлийг бууруулах, урьдчилан сэргийлэх арга хэмжээг авч хэрэгжүүлэх болон ажилтнуудын үүрэг хариуцлагыг бүрэн ухамсарлуулахад чиглэгдсэн байдаг. Үүний тулд банк нь шинэ ажилтан бүрийг улирал бүр сургалтад хамруулж МУТСТ чиглэлээр ерөнхий ойлголт өгч, ажиллаж буй ажилтнуудынхаа мэдлэгийг шинэчлэн өргөжүүлэхэд анхаарч ирсэн билээ. Түүнчлэн харилцагчтай нүүр тулж харьцаж буй фронт оффисын ажилтнууд болон үйл ажиллагааны онцлогтой зарим нэгжийн ажилтнуудыг тусгайлсан сургалтад хамруулдаг.

Банкны мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх нэгж нь банкны удирдлагыг энэ чиглэлээр мэдээллээр байнга хангаж эргээд үүрэг даалгавар, чиглэл авч ажиллаж ирсэн.

Банк нь мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх чиглэлээр мэргэжлийн боловсон хүчинтэй болохыг эрмэлзэж ирсэн бөгөөд үүний нэг жишээ нь банкны хэрэгжилт хариуцсан ажилтан нь олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх мэргэжилтэн гэсэн нэр алдрыг хүртээд байгаа явдал юм.

Голомт банк нь бусад банкуудын адилаар АНУ-ын банкуудтай корреспондент харилцаатай тул АНУ-ын Сангийн Яамнаас батлан гаргасан Patriot Act-ын гэрчилгээг (US Patriot Act certification) бөглөж гадаадын харилцагч банкуудад Голомт банкны мөнгө угаах терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх үйл ажиллагааны талаар үнэн зөв ойлголт өгөх, түүнийг бататгах, эргээд эдгээр харилцагч банкуудаас баталгаа авах ажлыг US Patriot Act-ын дагуу хийж, манай банкаар дамжсан гадаад гүйлгээний талаарх асуулгуудад түргэн шуурхай үнэн зөв мэдээлэл хүргэж гадаад харилцаа, хамтын ажиллагааг байнга сайжруулсаар ирсэн.

Тусгай активын үйл ажиллагаа

Банкны тусгай активын хэлтэс нь чанаргүй ангилалд бүртгэгдсэн, эргэн төлөлтөд тодорхой асуудал үүссэн зээл, авлагыг хянах болон төлүүлэх үйл ажиллагааг хариуцдаг. Зээлийн эргэн төлөлт асуудалтай болох нь хэд хэдэн объектив болон субъектив үзүүлэлтээр тодорхойлогддог. Үүнд: зээлдэгчийн орлогын хэмжээ буюу мөнгөн

хөрөнгийн гүйлгээнд огцом өөрчлөлт орох, зээлийн гэрээний үүргээ зөрчих, зээлийн нөхцлийг өөрчлөх хүсэлт гаргах, харилцагч банкны ажилтнуудтай харьцахаас зайлсхийх зэрэг үзүүлэлтүүд хамаарна. Авлагын хувьд банкны үйл ажиллагааны явцад гарсан авлагыг хариуцах ажилтан, гэрээт байгууллага болон иргэд төлөхгүй удаашруулах, ажилтан ажлаас чөлөөлөгдсөн, холбоо барих боломжгүй болсон, улмаар төлбөр төлөхөөс зайлсхийх хандлага гаргах зэргийг хамааруулан тооцно.

Бид зээл, авлага эргэн төлөгдөх явцад асуудал үүсэх нь тодорхой болоход тусгай активын хэлтсийн менежерүүд тухайн зээл, авлагыг хариуцсан харилцааны менежер, ажилтан, Зээлийн газрын эрсдэлийн мэргэжилтнүүдтэй хамтран зээл, авлагыг хариуцагч этгээдийн үйл ажиллагаа, эргэлтийн хөрөнгө, хөдлөх болон үл хөдлөх хөрөнгө, бусад үнэ цэнэтэй хөрөнгөд үнэлгээ хийж, ямар арга хэмжээ авах талаар төлөвлөгөө боловсруулдаг. Асуудалтай зээл, авлагыг аль болох богино хугацаанд төлүүлэх, хөрөнгийг найдвартай хамгаалах үүднээс банк бүхий л боломжит арга хэмжээг авч хэрэгжүүлдэг. Зээл, авлагыг шүүхийн бус болон шүүхийн замаар төлүүлэх ажиллагааг тусгай активын хэлтсийн менежерүүд гүйцэтгэх ба шаардлагатай тохиолдолд гэрээт өр барагдуулагч нарыг томилон ажиллуулна. Өр барагдуулагч нарын үйл ажиллагаанд тогтмол хяналтыг Тусгай активын хэлтсээс тавьж ажилладаг.

Тусгай активын хэлтэс нь зээлийн гэрээний үүргийг хангуулах зорилгоор зээлдэгчтэй уулзаж, харилцан тохиролцон үйл ажиллагааны бүтээмж үр ашгийг нь сайжруулах, авлага цуглуулах, илүүдэл бэлэн бүтээгдэхүүн, бараа материал, хөдлөх болон үл хөдлөх хөрөнгийг зарж борлуулах байдлаар хамтран ажилладаг. Зээлдэгчийн банктай харьцаж байсан түүх, зээлийг эргэн төлөх чадвар, банкнаас санал болгож буй эргэн төлөх нөхцлийг хүлээн зөвшөөрөх байдал зэргээс шалтгаалан банк дээрх арга хэмжээнүүдийг хэрэгжүүлдэг.

Шаардлагатай тохиолдолд бид зээлийн нөхцлийг өөрчлөх бодлого баримтална. Энэ тохиолдолд тусгай активын хэлтэс нь зээлийн хүү, нэмэгдүүлсэн хүүнээс чөлөөлөх, хугацааг сунгах, үндсэн зээлийн төлбөрийн хуваарийг өөрчлөх зэрэг зээлдэгчид аль болох зээл, зээлийн хүүг эргэн төлөх боломжийг олгох байдлаар хамтран ажилладаг. Зээлийн нөхцөлд өөрчлөлт оруулах болсон тохиолдолд Эрсдэлийн Удирдлагын Газрын захиралд танилцуулах бөгөөд зээлийн хэмжээнээс хамааран Зээлийн Хороо, Зээлийн Дэд Хороогоор хэлэлцүүлж батлуулна.

Тусгай активын хэлтсийн хариуцсан зээл нь чанаргүй ангиллаас хэвийн ангилалд шилжсэн тохиолдолд тухайн зээлд 6 сараас 12 сарын турш үргэлжлүүлэн хяналт тавьж ажилладаг.

Зээл, авлагыг хариуцагч нь төлбөрийг сайн дураар буюу шүүхийн бус аргаар төлөхгүй тохиолдолд шүүхийн байгууллагад шилжүүлж шийдвэрлүүлдэг. Шүүхийн шийдвэрийг үндэслэн өр төлбөрийг барагдуулах ажиллагааг явуулах ба зайлшгүй шаардлага гарвал Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын туслалцаатай өрийг төлүүлдэг. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаа нь тухайн байгууллагын үйл ажиллагаанд мөрдөгддөг хууль, эрхзүйн бусад бичиг баримтад үндэслэгдэн тодорхой цаг хугацаа, зардал шаардагддаг. Шүүхийн журмаар өрийг төлүүлэхээс өмнө банк нь мэргэжлийн экспертээр тусгай үнэлгээ хийлгүүлж, зээлийн гэрээний үүргийн гүйцэтгэлийг хангуулах боломж, барьцаа хөрөнгийн бодит үнэлгээ зэргийг тогтоолгож, зөвлөгөө авдаг.

Зээл, авлагыг хариуцагч нь олдохгүй болсон, нас барсан, шүүхийн шийдвэр гарснаас хойш төлбөр хийлгүй удсан тохиолдолд Хөнгөлөлт чөлөөлөлтийн комиссын хурлаар хэлэлцүүлж, Сангийн сайд, Монголбанкны ерөнхийлөгчийн хамтарсан тушаалаар батлагдсан Активыг ангилах, сан байгуулах, зарцуулах журмыг мөрдлөг болгон сангаас хааж, балансын гадуур бүртгэл болон Black list-д бүртгэн өр төлбөр барагдуулах ажиллагааг үргэлжлүүлэн хийдэг.





Монгол Улсын нийгэм эдийн засгийн хөгжилд хурд нэмэх санал санаачлагуудыг шинээр санаачлан хэрэгжүүлж, нийгмийн сайн сайхны төлөөх үйлсэд бодит хувь нэмрээ оруулан ажиллалаа.

Банк нь тайлант хугацаанд компанийн нийгмийн хариуцлагын чиглэлээр хийж хэрэгжүүлж ирсэн урт хугацааны уламжлалт төсөл хөтөлбөрүүдээ үргэлжлүүлэн хэрэгжүүлснээс гадна Монгол Улсын нийгэм эдийн засгийн хөгжилд хурд нэмэх санал санаачлагуудыг шинээр санаачлан хэрэгжүүлж, нийгмийн сайн сайхны төлөөх үйлсэд бодит хувь нэмрээ оруулан ажиллалаа.

Боловсролыг дэмжих чиглэлд

Монгол Улсын нийгэм, соёл болон эдийн засгийн ирээдүйн хөгжилд өндөр ур чадвартай, боловсролтой залуус чухал хувь нэмэр оруулна гэдэгт бид итгэдэг. Иймээс Голомт банк нь үүсгэн байгуулагдсан цагаасаа хойш боловсролыг дэмжсэн олон төсөл хөтөлбөрүүдийг анхлан санаачилж уламжлал болгон ажиллаж байна.

Тайлант онд:

- Монголын тэргүүлэгч их дээд сургуулиудын оюутнуудын дунд Голомт банкны нэрэмжит Эрдэм Шинжилгээний Бага Хурлыг 11 дэх удаагаа амжилттай зохион байгуулж банк санхүү, бизнесийн салбарт бодит ажил болохуйц шинэ санаанууд төрөн гарлаа.
- Шилдэг 100 оюутанд сар бүрийн тэтгэлэг олгодог Голомт банкны нэрэмжит "Оюутны тэтгэлэгт хөтөлбөр"-ийг 10 дах жилдээ амжилттай зохион байгуулж хөтөлбөр хэрэгжиж эхэлснээс хойш шилдэг 1000 залуусын сурч боловсрох, хөгжих дэвших чин хүсэл эрмэлзэлд 600 гаруй сая төгрөгийн хөрөнгө оруулалт хийгээд байна.

Голомт банк оюутнуудыг дэмжиж тэдний сурах их үйлсэд хөрөнгө оруулах нь зүйтэй гэдэг санал санаачлагыг анхлан гаргасан нь өдгөө оюутнуудын хүсэн хүлээдэг, оюуны чадавхиа сорьдог томоохон талбар болоод байна.

Соёл урлаг, спортыг дэмжих чиглэлд

Соёл урлаг, спортын салбарын хөгжилд дэмжлэг үзүүлэх, нийгэм дэх урлаг, спортын боловсрол, мэдлэгийг хөгжүүлэх нь бидний үүрэг юм. Энэхүү

үүргийнхээ хүрээнд Олимпийн наадам, олон улсын урлаг, спортын уралдаан тэмцээнд оролцох урлаг спортын гоц авъяасыг дэмжих, сонгодог урлагийн хөгжлийг эрчимжүүлэх, Монголын уламжлалт урлаг, онцгой өв соёлыг дэмжихэд голлон анхаарч ажиллалаа. Үүнд:

- Монголын Үндэсний Олимпийн Хорооны “Алтан Түнш”-ээр ажиллаж Лондон 2012 олимпод оролцсон Монголын баг тамирчдыг амжилт гаргахад дэмжлэг үзүүлж тамирчдынхаа мөнгөн медальтай хамт байлаа.
- Азийн Оюутны Аварга Шалгаруулах Эмэгтэй Воллейболын Тэмцээнийг Монголын Оюутны Спортын Хороотой хамтран эх орондоо амжилттай зохион байгуулж монголынхоо баг тамирчдын мөнгөн медальтай хамт байлаа.
- Монголын сонгодог урлагийн хөгжилд эрч нэмж Дуурь Бүжгийн Эрдмийн Театрын үйл ажиллагааг 5 дахь жилдээ тууштай дэмжлээ.
- Ж.Чулууны нэрэмжит Өсвөрийн Хөгжимчдийн олон улсын уралдааны зохион байгуулагчаар ажиллаж ирээдүйн хөгжимчдийн хүсэл мөрөөдлийг хөгжүүлэн дэмжлээ.
- Монгол Улсын Морин Хуурын Чуулгын Албан ёсны түншээр сонгогдож үндэсний соёл урлагийг хөгжүүлэх, Монголын уламжлалт урлагийн онцгой өв соёлыг хайрлан хамгаалах их үйлсэд хувь нэмрээ оруулан ажиллаж байна.
- Ажилтнуудаа нийгмийн сайн сайханд чиглэсэн үйл ажиллагаанд оролцохыг уриалж Азийн оюутны эмэгтэй воллейболлын тэмцээнийг зохион байгуулахад банкны ажилтнууд сайн дураараа ажиллалаа.

Байгаль орчныг хамгаалах чиглэлд

Хүрээлэн буй байгаль орчноо хайрлан хамгаалах асуудалд Голомт банк үйл ажиллагааны бүхий л түвшинд анхаарал тавьж хүрээлэн буй орчинд үзүүлж буй үр нөлөө, дам нөлөөллийг багасгах арга хэмжээг авч ажилладаг.

- Зээлийн судалгаа: Зээлийн судалгаа шинжилгээ хийх явцад тусгайлан анхаарч үздэг зүйл нь тухайн бизнесийн байгаль орчинд үзүүлэх нөлөө бөгөөд банк нь байгаль орчинд хор хөнөөлтэй бизнесийн төслийг дэмждэггүй. Мөн зээлийн бодлогоороо дамжуулан эрчим хүч, байгалийн нөөцийн хэмнэлттэй бизнес болоод байгаль орчинд тустай үйл ажиллагааг дэмжин ажилладаг.
- Байгальд ээлтэй бизнесийг санхүүжүүлэх: Банк нь Сангийн Яамтай хамтран Японы Олон Улсын Хамтын Ажиллагааны Агентлагийн санхүүжилтээр жижиг дунд бизнесийг дэмжих, байгаль орчныг хамгаалах хоёр үе шаттай төслийн зээлийг хэрэгжүүлдэг. Энэ онд бид Эко бизнес төслийн зээлийн уралдааныг санаачлан зохион байгуулж шалгарсан байгальд ээлтэй төслийг бага хүүтэй зээлээр санхүүжүүллээ.
- Байгаль орчинд ээлтэй хэрэглээг дэмжих: Цахим банкны үйлчилгээг шинэчлэн сайжруулж цахим банкаар авах үйлчилгээний боломж хүртээмжийг нэмэгдүүлснээр харилцагчдынхаа хэрэглээг улам нэмж албан байгууллага, иргэдийн цаас, захидал, шатахууны зардлаа багасгах байгаль орчинд ээлтэй хэрэглээг дэмжин ажиллаж байна. Түүнчлэн Монголд анх удаа өөртөө үйлчлэх банкны үйлчилгээг нэвтрүүлснээр харилцагчдынхаа цаас, шатахууны зардлыг хэмнэж нүүрстөрөгч ялгаруулалтыг багасгахад хувь нэмрээ орууллаа.
- Байгальд ээлтэй үйл ажиллагаа явуулах: Дотоодын холбоо харилцаандаа цаасны хэрэглээг багасгах, цаасгүй харилцаа холбооны хэрэглээг нэмэгдүүлэх зорилгоор Share point JIRA системийг 2011 оноос эхлэн банкныхаа үйл ажиллагаанд ашиглаж эхэлсэн нь амжилттай хэрэгжиж тайлант онд уг системээ өргөжүүлэн E-Docs системийг хэрэглээнд нэвтрүүлж өдөр тутмын үйл ажиллагаан дах цаасны хэрэглээгээ багасгалаа.

Засгийн Газрын санал санаачлагыг дэмжих чиглэлд

Банк нь Монгол Улсын гадаад харилцааг өргөтгөх, гадаадын шууд хөрөнгө оруулалтыг дэмжих чиглэлээр Монгол Улсын Засгийн Газраас санаачлан хэрэгжүүлж буй үйл ажиллагааг оюуны болон санхүүгийн хөрөнгө оруулалт үзүүлэн дэмжин ажилладаг.

- Дэлхийн Эдийн Засгийн чуулган, Олон Улсын Санхүүгийн Институт, Хөгжиж буй орнуудын Зөвлөх Консул зэрэг байгууллагын гишүүнчлэлээр дамжуулан Монгол Улсын эдийн засгийн хөгжил цэцэглэлтэд хувь нэмрээ оруулж байна.
- Mongolia Investment Summit, Coal Mongolia 2012 чуулган, IPO чуулган, Монголын Компанийн Засаглалын форум, Лондонгийн Бизнес форумын ивээн тэтгэгчээр ажиллаж Монгол Улсын хөгжилд хурд нэмэх санал санаачлагуудыг хэрэгжүүлэн дэмжлээ.





- Монголын Засгийн Газраас хэрэгжүүлсэн оюутны тэтгэлэг, хүүхдийн мөнгө олгох хөтөлбөрт нэгдэж салбар сүлжээгээрээ дамжуулан хэрэгжүүллээ.
- Монгол Улсын Засгийн Газраас Монголын эдийн засгийн чуулганы Алтан ивээн тэтгэгчээр дөрөв дэх жилдээ ажиллав.
- ХХААХҮЯамны ЖДҮХСангийн ЖДҮ эрхлэгчдийг дэмжих төслийн зээлийг Улаанбаатар хот төдийгүй орон нутгийн бизнес эрхлэгчдэд олголоо.

Голомт банкны нийгмийн хариуцлага, Монгол Улсынхаа хөгжил цэцэглэлт, нийгмийн сайн сайхны төлөө төлж буй татварыг үнэлж Нийгмийн Даатгалын Ерөнхий Газраас “Шилдэг татвар төлөгч байгууллага” шагналыг олгосон юм.

ХАРИЛЦАГЧ БАНКУУД

№	Банкны нэр	Байршил	Свифт, Телекс код	Валют	Ностро данс
1.	AUSTRALIA AND NEW ZEALAND BANKING GROUP LIMITED	Мельбурн, Австрали	ANZBAU3M	AUD	920660AUD00001
2.	ING BELGIUM SA	Бруссел, Бельги	BBRUBEBB	EUR USD GBP	301-0104461-73
3.	CANADIAN IMPERIAL BANK OF COMMERCE	Торонто, Канад	CIBCCATT	CAD	1818910
4.	THE AGRICULTURAL BANK OF CHINA	Бээжин, Хятад	ABOCCNBJ	USD	8211000908
5.	BANK OF CHINA	Эрээн, Хятад	BKCHCNBJ880	USD CNY	155605293946 154005293944
6.	BAOSHANG BANK	Баотоу, Хятад	BTBCNBJ Bank code: 313192000021	CNY USD	002105599800010 002105599800020
7.	CHINA CONSTRUCTION BANK CORPORATION	Нэймэнгү, Хятад	PCBCCNBJNME	USD CNY	NRA15014150500220100181 15001658408052502177
8.	THE AGRICULTURAL BANK OF CHINA		ABOCCNBJ050	USD CNY	05999914040000049 05999901040000053
9.	INDUSTRIAL AND COMMERCIAL BANK OF CHINA	Хөх хот, Хятад	ICBKCNBJNMA	USD CNY	0610040629200061234 0610040609200054391
10.	CHINA CITIC BANK		CIBKCNBJ010 Bank Code: 302191027101	USD CNY	7271111486000000181 7271110186000000155
11.	COMMERZBANK AG, FF/AM MAIN	Франкфурт, Герман	COBADEFF 041/415 2530 CBD	USD EUR	400 878 506 500 400 878 506 501
12.	DEUTSCHE BANK AG		DEUTDEFF	EUR	100-9517673-0000
13.	BANK OF CHINA (HONG KONG) LIMITED	Хонгконг	BKCHHKHH	HKD	012-875-60115674
14.	MIZUHO CORPORATE BANK LTD	Токио, Япон	MHCBJPJT	JPY	6740010
15.	SUMITOMO MITSUI BANKING CORPORATION		SMBJPJT	USD JPY	3623 4374
16.	KAZKOMMERTSBANK	Алмата, Казакстан	KZKOKZKX	USD	KZ769260001000694001
17.	KOREA EXCHANGE BANK		KOEXKRSE	USD KRW	963-THR-313-01-2 0963FRW001000054
18.	SHINHAN BANK	Сөүл, Өмнөд Солонгос	SHBKKRSE	USD KRW	0102245USD01 0102245KRW01
19.	KOOKMIN BANK		CZNBKRSE	USD KRW	819-8-USD-0-15 819-8-KRW-0-17
20.	LAND BANK OF TAIWAN	Тайвань, Хятад	LBOTTWTP	USD	088-185-00002
21.	SBERBANK, RUSSIA BAIKALSKY HEAD OFFICE	Эрхүү, Орос	SABRRU66 231231 SBANK.RU	USD RUB	30111840518000000003 30111810618000000001
22.	JSC BANK FOR FOREIGN TRADE		VTBRRUMM	RUB USD	30111810655550000126 30111840155550000104
23.	RUSSIAN AGRICULTURAL BANK	Москва, Орос	RUAGRUMM	USD RUB	30111840300000000006 30111810200000000013
24.	SBERBANK, RUSSIA MOSCOW HEAD OFFICE		SABR RUM 012	USD RUB	301118401000000000840 301118108000000000840
25.	UNITED OVERSEAS BANK LIMITED	Сингапур	UOVBSGSG	SGD	301-399-069-5
26.	BARCLAYS BANK PLC	Лондон, Нэгдсэн Вант Улс	BARCGB22 Sort Code: 20-32-53	GBP	43379779 IBAN: GB33BARC20325343379779
27.	WELLS FARGO BANK, N.A. (FORMERLY KNOWN AS WACHOVIA)		PNBPUS3NNYC ABA: 026005092	USD	2000191006513
28.	CITIBANK A.S	Нью-Йорк, АНУ	CITIUS33	USD	36885517
29.	STANDARD CHARTERED BANK		SCBLUS33	USD	3582-026934-001
30.	DEUTSCHE BANK TRUST COMPANY AMERICAS		BKTRUS33	USD	04453138

2012 оны 12 сарын 31-ний байдлаар



САЛБАР СҮЛЖЭЭ



48

Төв оффис: Сүхбаатарын талбай 3, Ш/Х #22, Улаанбаатар 15160, Монгол Улс

Утас: +(976)-70117676

Лавлах утас: +(976)-1646

Факс: +(976-11)-313155, 312307

И-мэйл: mail@golomtbank.com

Цахим хуудас: <http://www.golomtbank.com>

ГАДААДАД БУЙ ТӨЛӨӨЛӨГЧИЙН ГАЗАР

Банкны нэгж	Хаяг	Холбоо барих
Бээжин дэх Төлөөлөгчийн газар	10E, CITIC Building Tower A19, Jianguomen Dajie, Beijing, China 100004	Утас: +(86-10)-65033876 Факс: +(86-10)-65923727 Гар утас: +(86-139)-11737254 И-мэйл: golomt@public2.bta.net.cn
Лондон дахь Төлөөлөгчийн газар	GBRW, 27 Throgmorton Street, London EC2N 2AQ, England	Утас: +(44-0)-20 7382 9900 Факс: +(44-0)-20 7382 9988 И-мэйл: jeremy.denton-clark@gbrw.com И-мэйл: mail@gbrw.com

УЛААНБААТАР ДАХЬ САЛБАРУУД

Банкны нэгж	Хаяг	Холбоо барих
Төв Бизнес Төв	Худалдааны гудамж 6/2, Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот	Утас: +(976-11)-310759 Факс: +(976-11)-326231
Зээлийн Төв Бизнес Төв	"Бурхан халдун групп" ХХК-ийн байр, 2-р хороо, Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот	Утас: +(976-11)-330072 Факс: +(976-11)-330621
Баянзүрх Бизнес Төв	Мөнгөн гүүр ББСБ-ын байр, 12 хороолол, 3 хороо, Баянзүрх дүүрэг, Улаанбаатар хот	Утас: +(976)-70157093
Сансар Салбар	Баянцээл худалдааны төв, 15-р хороолол, 7-р хороо, Баянзүрх дүүрэг, Улаанбаатар хот	Утас: +(976-11)-456980 Факс: +(976-11)-456829
100 Айл Салбар	Анд интернэйшнлийн байр, Б корпус, 11-р хороолол, Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар хот	Утас: +(976-11)-350542 Факс: +(976-11)-350544
Ард Салбар	Он энд Он ХХК-ийн байр, 1-р хороо, Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот.	Утас: +(976-11)-320712 Факс: +(976-11)-330436
Солонго Салбар	Солонго үйлчилгээний төв, Сөүлийн гудамж, Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар хот	Утас: +(976-11)-320841 Факс: +(976-11)-318479
Саппоро Салбар	Бармон ХХК-ийн байр, 1-р хороолол, Сонгинохайрхан дүүрэг, Улаанбаатар хот	Утас: +(976-11)-681267 Факс: +(976-11)-680367
Москва Салбар	Бодь Интернэшнл ХХК-ийн байр, 4-р хороолол, Баянгол дүүрэг, Улаанбаатар хот	Утас: +(976-11)-305419 Факс: +(976-11)-368602
120 Мянгат Салбар	120 мянгат үйлчилгээний төв, 1-р хороо, Хан-Уул дүүрэг, Улаанбаатар хот	Утас: +(976)-70130080
Моннис Салбар	Моннис тауэр, 1-р хороо, Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар хот	Утас: +(976-11)-321291 Факс: +(976-11)-321273
Баянзүрх Салбар	"Бо-Бо" худалдааны төв, 15-р хороо, Баянзүрх дүүрэг, Улаанбаатар хот	Утас: +(976-11)-458250 Факс: +(976-11)-462892
Голомт Хотхон Салбар	"Голомт хотхон" цогцолборын "I" блок, 5-р хороо, Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар хот	Утас: +(976-11)-322943 Факс: +(976-11)-322943
Нисэх Тооцооны Төв	"Чингис Хаан" нисэх онгоцны буудал, 10-р хороо, Хан-Уул дүүрэг, Улаанбаатар хот	Утас: +(976-11)-283205 Факс: +(976-11)-283205
Гааль Тооцооны Төв	Улаанбаатар хотын гаалийн газрын байр, 1-р хороо, Баянгол дүүрэг, Улаанбаатар хот	Утас: +(976-11)-242945 Факс: +(976-11)-242945
Багануур Тооцооны Төв	Хэрлэн худалдааны төв, 1-р хороо, Багануур дүүрэг, Улаанбаатар хот	Утас: +(976)-70212332 Факс: +(976-01-21)-20818
Цамбагарав Тооцооны Төв	Цамбагарав худалдааны төв, 1-р хороолол, 14-р хороо, Сонгинохайрхан дүүрэг, Улаанбаатар хот	Утас: +(976-11)-680762 Факс: +(976-11)-680763

Цэцээ Гүн Тооцооны Төв	“Цэцээ гүн” дээд сургуулийн байр, 4-р хороо, Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот	Утас: +(976-11)-316395 Факс: +(976-11)-316395
13-р Хороолол Тооцооны Төв	Эм Жи Эл ХХК-ийн байр, 25-р хороо, Баянзүрх дүүрэг, Улаанбаатар хот	Утас: +(976-11)-457018
Тамир Тооцооны Төв	“Ханна- импекс” ХХК-ийн байр, 3-р хороолол, 14-р хороо, Баянгол дүүрэг, Улаанбаатар хот	Утас: +(976-11)-304959 Факс: +(976-11)-304959
Нарантуул Тооцооны Төв	Нарантуул ОУХТөвийн захиргааны байр, 14-р хороо, Баянзүрх дүүрэг, Улаанбаатар хот	Утас: +(976-11)-457018
Их Дэлгүүр Тооцооны Төв	Зан интернэшнл ХХК-ийн байр, 4-р хороо, Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар хот	Утас: +(976)-70111351
Номин Тооцооны Төв	Улсын их дэлгүүрийн байр, Энхтайвны өргөн чөлөө, Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот	Утас: +(976-11)-319977 Факс: +(976-11)-314242
Сентрал Тауэр Тооцооны Төв	Сентрал Тауэр, 8-р хороо, Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар хот	Утас: +(976-11)-326474 Факс: +(976-11)-326494
32-ийн Тойрог Тооцооны Төв	Сансар-32 худалдаа үйлчилгээний төв, 12-р хороо, Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар хот,	Утас: +(976)-77443232 Факс: +(976)-77443131
Сонгинохайрхан Тооцооны Төв	“Жавхлант” төвийн байр, 19-р хороо, Сонгинохайрхан дүүрэг, Улаанбаатар хот	Утас: +(976-11)-636205 Факс: +(976-11)-636217
ИБМУТ Тооцооны Төв	УБЕГазрын 4-р байр, 11-р хороо, Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар хот	Утас: +(976-11)-350267
ШУТИС Тооцооны Төв	ШУТИС-ийн төв байр, 8-р хороо, Залуучуудын өргөн чөлөө, Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар хот	Утас: +(976)-70111530
Офицеруудын Ордон Тооцооны Төв	Хорго Тауны 2-3 байр, 16-р хороо, Баянзүрх дүүрэг, Улаанбаатар хот	Утас: +(976)-70022002
Макс Моол Тооцооны Төв	Макс Моол худалдааны төв, 17-р хороо, Баянгол дүүрэг, Улаанбаатар хот	Утас: +(976)-70111227
Өргөө Тооцооны Төв	ХОТУ ХХК-н байр, 3-р хороолол, Баянгол дүүрэг, Улаанбаатар хот	Утас: +(976-11)-368276
Варьете Тооцооны Төв	Газар холдинг ХХК-н байр, 4-р хороо, Баянгол дүүрэг, Улаанбаатар хот	Утас: +(976)-70129701
10-р Хороолол Тооцооны Төв	ОЛД ЧЕХ ХХК-ийн байр, 10-р хороолол, 5-р хороо, Баянгол дүүрэг, Улаанбаатар хот	Утас: +(976-11)-682108
Тэнгис Тооцооны Төв	Виктори төв, 5-р хороо, Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот	Утас: +(976)-70120522 Факс: +(976)-70120522
Да Хүрээ Тооцооны Төв	Да хүрээ ХХК-ийн худалдаа үйлчилгээний 3-р төв, 17-р хороо, Баянзүрх дүүрэг, Улаанбаатар хот	Утас: +(976)-70151533
Жапан Таун Тооцооны Төв	Жапан таун, 1-р хороо, Хан-Уул дүүрэг, Улаанбаатар хот	Утас: +(976)-70129703
Зайсан Тооцооны Төв	Билэг-2 худалдааны төв, 1-р хороо, Хан-Уул дүүрэг, Улаанбаатар хот	Утас: +(976)-70110301
Найман Шарга Тооцооны Төв	Визард говь ХХК-ийн байр, 2-р хороо, Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот	Утас: +(976)-70115884
Блю Скай Тооцооны Төв	Блю скай тауэр, 1-р хороо, Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар хот	Утас: +(976)-70141530
Хувийн Банкны Алба	Бодь цамхаг, Сүхбаатарын талбай, Улаанбаатар хот	Утас: +(976)-70117676 Дотуур утас: 1104 Факс: +(976-11)-326840

ӨӨРТӨӨ ҮЙЛЧЛЭХ БАНК

Банкны нэгж	Хаяг
Өөртөө Үйлчлэх Банк №1	Москва салбар, 14-р хороо, 4-р хороолол, Баянгол дүүрэг, Улаанбаатар хот
Өөртөө Үйлчлэх Банк №2	Монголын Урчуудын эвлэлийн Б корпус, 1-р хороо, Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар хот
Өөртөө Үйлчлэх Банк №3	Солонго салбар, Сөүлийн гудамж, Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар хот



ОРОН НУТАГ ДАХЬ САЛБАРУУД



Банкны нэгж	Хаяг	Холбоо барих
Орхон Салбар	Амарын гудамж, Баян өндөр сум, Орхон аймаг	Утас: +(976)-70355100 Факс: +(976)-70355100
Орхон Пирамид Тооцооны Төв	Тод жаргал ХХК-ийн байр, Согоот баг, Баян-Өндөр сум, Орхон аймаг	Утас: +(976)-70353789 Факс: +(976)-70353789
Орхон Зээлийн Төв	Орхон Чандмань ХХК-ийн байр, Уурхайчин баг, Баян-Өндөр сум, Орхон аймаг	Утас: +(976)-70357058
Дархан Салбар	Голомт банкны байр, 13-р баг, Дархан сум, Дархан-уул аймаг	Утас: +(976)-70373928 Факс: +(976)-70377136
Дархан Зээлийн Төв Тооцооны Төв	Мандах Баясах ХХК-ийн байр, 8-р баг, Дархан сум, Дархан-Уул аймаг	Утас: +(976)-70375098 Факс: +(976)-70375098
Ховд Салбар	Монголбанкны байр, Цамбагарав баг, Жаргалант сум, Ховд аймаг	Утас: +(976)-70432115 Факс: +(976)-70432195
Ховд-Булган Тооцооны Төв	Бүрэнхайрхан баг, Булган сум, Ховд аймаг	Утас: +(976)-70432178
Ховд Баянбүрд Тооцооны Төв	Баянбүрд төв, Жаргалан баг, Жаргалант сум, Ховд аймаг	Утас: +(976)-70432175 Факс: +(976)-70432175
Баян-Өлгий Салбар	Соёлын төвийн байр, 5-р баг, Өлгий сум, Баян-Өлгий аймаг	Утас: +(976)-70442012
Тирлик Тооцооны Төв	Армон дэлгүүр, 5-р баг, Өлгий сум, Баян-Өлгий аймаг	Утас: +(976)-70422008
Өмнөговь Салбар	Голомт банкны байр, 3-р баг, Даланзадгад сум, Өмнөговь аймаг	Утас: +(976)-70533990 Факс: +(976)-70533991
Оюу Толгой Тооцооны Төв	Оюу Толгойн камп, Ханбогд сум, Өмнөговь аймаг	Утас: +(976)-70117676 Дотуур утас: 4440
Цогтцэций Тооцооны Төв	Голомт банкны байр, Ямаан хүрэн баг, Цогтцэций сум, Өмнөговь аймаг	Утас: +(976)-70117676 Дотуур утас: 4260
Ханбогд Тооцооны Төв	Гоётын 1-7-р байр, Ханбогд сум, Өмнөговь аймаг	Утас: +(976)-70535148 Факс: +(976)-70535148
Гурван Тэс Тооцооны Төв	Хурд супермаркет, 4 дүгээр баг, Гурван Тэс сум, Өмнөговь аймаг	Утас: +(976)-70536466
Дорнод Салбар	Дорнод аймгийн Хэрлэн сумын 7 дугаар баг, "Хишиг-Агро" ХХК-н Үйлчилгээний төвийн байрны 2 давхарт	Утас: +(976-01-582)-22703 Факс: +(976-01-582)-22702
Дорнод-Хэрлэн Тооцооны Төв	24-р байр, 6-р баг, Хэрлэн сум, Дорнод аймаг	Утас: +(976)-70582704
Дорноговь Салбар	Ванжилдоржийн байр, 1-р баг, Сайншанд сум, Дорноговь аймаг	Утас: +(976)-70523177
Замын-Үүд Тооцооны Төв	Төмөр замын өртөөний зорчигч үйлчилгээний төв, 1-р баг, Замын -үүд сум, Дорноговь аймаг	Утас: +(976-025-245)-43773 Факс: +(976-025-245)-43773
Аршанд Тооцооны Төв	Ган зам худалдааны төв, 4-р баг, Сайншанд сум, Дорноговь аймаг	Утас: +(976)-0252242792
Сүхбаатар Тооцооны Төв	Сүхбаатар аймаг, Баруун-Урт сум, 7-р багийн нутаг дэвсгэр, Монос төвийн байрны 1, 2 дугаар давхарт	Утас: +(976)-70512006
Хөвсгөл Салбар	Мөнхийн ундраа ХҮТөв, 3-р хороо, Мөрөн сум, Хөвсгөл аймаг	Утас: +(976)-70388474 Факс: +(976)-70388474
Өвөрхангай Тооцооны Төв	Оюу төв, Өвөрхайнгай аймаг, 5-р баг, Гэндэнгийн гудамж, Арвайхээр сум	Утас: +(976)-70322525
Сэлэнгэ Тооцооны Төв	Баянхан худалдааны төв, 2-р баг, Сүхбаатар сум, Сэлэнгэ аймаг	Утас: +(976)-70362318 Факс: +(976)-70362318
Баянхонгор Тооцооны Төв	Баянхонгор их дэлгүүр, 1-р баг, Баянхонгор сум, Баянхонгор аймаг	Утас: +(976)-70444511 Факс: +(976)-70444522
Увс Тооцооны Төв	Улаансарнай ХХК-ийн байр, 3-р баг, Улаангом сум, Увс аймаг	Утас: +(976)-70454566



ХАРААТ БУС АУДИТОРЫН ТАЙЛАН



**ГОЛОМТ БАНК болон
түүний Охин Компани**

2012 оны 12 сарын 31-ний өдрөөр
тасалбар болсон жилийн

Нэгтгэсэн Санхүүгийн Тайлан
Аудиторын дүгнэлтийн хамт



ГОЛОМТ БАНК БОЛОН ТҮҮНИЙ ОХИН КОМПАНИ

Байгууллагын талаарх мэдээлэл



54

Үүсгэн байгуулах шийдвэр	Голомт Банк (цаашид “Банк” гэх) нь 1995 оны 03 сарын 06-ны өдрийн Бодь Интернэйшнл ХХК-ийн хувьцаа эзэмшигчдийн шийдвэрээр Бодь Интернэйшнл ХХК-ийн 100 хувийн охин компани болон үүсгэн байгуулагдсан.	
Гэрчилгээ ба Лиценз	Голомт Секюритиз ХХК (цаашид “Охин компани” гэх) нь 2011 оны 05 сарын 17-ны өдрийн 01 тоот шийдвэрийн дагуу Голомт Банкны 100 хувийн эзэмшлийн охин компани болон Хязгаарлагдмал Хариуцлагатай Компанийн хэлбэрээр үүсгэн байгуулагдсан.	
Гэрчилгээ ба Лиценз	Тус Банк нь 2005 оны 12 сарын 05-ны өдөр Монгол улсын Улсын Бүртгэлийн Албанаас 2075377 тоот регистрийн дугаар бүхий 9016001014 тоот Улсын Бүртгэлийн гэрчилгээг шинэчлэн авсан.	
	Тус Банк нь 1995 оны 03 сарын 06-ны өдөр Банкны үйл ажиллагаа эрхлэх 25 тоот Тусгай зөвшөөрлийг авсан.	
	Охин Компани нь 5481589 тоот регистрийн дугаар бүхий 9011287134 тоот Улсын Бүртгэлийн гэрчилгээг Монгол улсын Улсын Бүртгэлийн албанаас 2011 оны 11 сарын 02-ны өдөр авсан.	
Төлөөлөн Удирдах	Л. Болдхуяг	ТУЗ-ийн дарга (2013 оны 10 сарын 05-ны өдөр чөлөөлөгдсөн)
Зөвлөл	Л. Болдхуяг	ТУЗ-ийн гишүүн (2013 оны 10 сарын 05-ны өдөр томилогдсон)
Зөвлөл	Д. Баясгалан	ТУЗ-ийн дарга (2012 оны 12 сарын 12-ны өдөр чөлөөлөгдсөн)
	М. Зоригт	ТУЗ-ийн гишүүн (2012 оны 12 сарын 12-ны өдөр чөлөөлөгдсөн)
	Марк Н.Кютис	ТУЗ-ийн гишүүн (2013 оны 04 сарын 15-ны өдөр чөлөөлөгдсөн)
	Ч. Мөнхцэцэг	ТУЗ-ийн гишүүн (2012 оны 12 сарын 12-ны өдөр томилогдсон)
	З. Тэмүүн	ТУЗ-ийн гишүүн (2012 оны 12 сарын 12-ны өдөр томилогдсон)
	Ж. Үнэнбат	Хараат бус гишүүн
	Урс Е.Шварценбах	Гишүүн
	Д. Мөнхтөр	ТУЗ-ийн гишүүн (2012 оны 12 сарын 12-ны өдөр томилогдсон)

Байгууллагын талаарх мэдээлэл (үргэлжлэл)

Гүйцэтгэх удирдлага	Г. Ганболд	Гүйцэтгэх Захирал
	Д. Мөнхтөр	Үйл ажиллагаа хариуцсан Тэргүүн дэд захирал
	М. Чимэгмөнх	Дэд захирал, Санхүүгийн удирдлагын газрын захирал
	Л. Оюун-Эрдэнэ	Дэд захирал, Байгууллагын банкны газрын захирал
	Б. Энхтуяа	Дэд захирал, Иргэдийн банкны газрын захирал
	М. Чингүн	Дэд захирал, Эрсдэлийн удирдлагын газрын захирал
	Б. Загал	Дэд захирал, Хөрөнгө оруулалтын банкны газрын захирал
	Р. Батсүрэн	Дотоод аудитын газрын захирал
	Н. Цэрэндаваа	Мэдээллийн технологийн газрын захирал
	Б. Мөнхбаатар	Хөрөнгийн удирдлагын газрын захирал
	Т. Нямсүрэн	Зээлийн газрын захирал
	З. Хайдар	Цахим банкны газрын захирал
	Н. Очирхуяг	Маркетингийн хэлтсийн захирал
Хаяг	Голомт Банк Голомт банкны төв байр, Сүхбаатарын талбай, Ш/х-22, Улаанбаатар 15160 , Монгол улс	
Аудитор	БДО Аудит ХХК Улаанбаатар-14193, Сүхбаатар Дүүрэг, Их Сургуулийн Гудамж 32/1, АБ Центр, 10-р давхар	



ГОЛОМТ БАНК БОЛОН ТҮҮНИЙ ОХИН КОМПАНИ

2012 оны 12 сарын 31-ний өдрөөр тасалбар болсон жилийн нэгтгэсэн санхүүгийн тайланг бэлтгэж толилуулахтай холбоотой Удирдлагын хариуцлагын талаарх мэдэгдэл



56

Энэхүү тайлангийн хараат бус аудиторын тайланд дурдсан хараат бус аудиторын дүгнэлттэй хамт уншигдах дараах мэдэгдэл нь Голомт Банк ХХК (цаашид “Банк” гэх) болон түүний охин компани (хамтад нь “Групп” гэх)-ийн 2012 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр тасалбар болсон жилийн нэгтгэсэн санхүүгийн тайлантай холбоотой удирдлагын үүрэг хариуцлага болон аудиторын хариуцлагыг тусад нь илэрхийлэх үүднээс хийгдсэн болно.

Группын захирлууд нь эдгээр нэгтгэсэн санхүүгийн тайлангуудыг Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт (“СТОУС”)-ын дагуу үнэн зөв бэлтгэх үүрэгтэй бөгөөд нэгтгэсэн санхүүгийн тайлангууд нь 2012 оны 12 сарын 31-нээрх нэгтгэсэн санхүүгийн байдал, тайлант жилийн санхүүгийн гүйцэтгэл, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийг СТОУС-ын дагуу үнэн зөв илэрхийлнэ.

Санхүүгийн тайлангуудыг бэлтгэхдээ Захирлууд нь:

- Нягтлан бодох бүртгэлийн тохирох зарчмуудыг сонгож, тууштай хэрэгжүүлэх;
- Ул үндэстэй бөгөөд оновчтой шийдэл болон тооцоолол хийх;
- СТОУС-ыг даган мөрдсөн эсэх болон СТОУС-аас зөрүүтэй байгаа зүйлсийн талаар нэмэлт тодруулга, тайлбар хийсэн эсэх талаар дурдах;
- Групп нь ойрын ирээдүйд бизнесээ үргэлжлүүлэх эсэхийг төсөөлөхөд тохиромжгүй байхаас бусад тохиолдолд санхүүгийн тайлангуудыг өөдрөг төсөөллийн сууриар бэлтгэх үүргийг хүлээдэг.

Мөн удирдлага нь дараах үүргийг хүлээнэ:

- Группын хэмжээнд дотоод хяналтын үр дүнтэй, тохирохуйц системийг зохион байгуулах, нэвтрүүлэх, хэрэгжүүлэх;
- Группын санхүүгийн байдлыг ул үндэстэй үнэнээр илэрхийлэхүйц мөн Группын санхүүгийн тайлангууд нь СТОУС-ын дагуу бэлтгэгдэх боломжоор хангасан нягтлан бодох бүртгэл хөтлөх;
- Монгол улсын Сангийн яам, Монголбанкнаас гаргасан нягтлан бодох бүртгэлийн үлгэрчилсэн заавар журам, холбогдох Монгол улсын хуулийг даган мөрдөж нягтлан бодох бүртгэлийг хөтлөх;
- Группын хөрөнгийг хамгаалахтай холбоотой зохих арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлэх;
- Заль мэх болон бусад зөрчлүүдийг илрүүлэх буюу тэдгээрээс урьдчилан сэргийлэх.

Группын удирдлагын хувьд 2012 оны 12 сарын 31-ний өдрөөр тасалбар болсон жилийн санхүүгийн тайлангуудыг гаргахыг 2013 оны 09 сарын 04-ний өдөр батлав.



Г. ГАНБОЛД
Гүйцэтгэх Захирал
Голомт Банк ХХК

М. ЧИМЭГМӨНХ
Дэд захирал,
Санхүү Удирдлагын Газрын Захирал
Голомт Банк ХХК

Огноо:

ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ

ГОЛОМТ БАНКНЫ ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДЭД

Санхүүгийн тайлангуудын талаар

Бид Голомт Банк ХХК (цаашид “Банк” гэх) болон түүний охин компани (цаашид хамтад нь “Групп” гэх)-ийн 2012 оны 12 сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдлын тайлан, тухайн өдрөөр тасалбар болсон санхүүгийн жилийн нэгтгэсэн дэлгэрэнгүй орлогын тайлан, өмчийн өөрчлөлтийн тайлан, мөнгөн гүйлгээний тайлан, нягтлан бодох бүртгэлийн гол бодлогуудын товчоо болон бусад тайлбар тодруулгуудаас бүрдсэн санхүүгийн тайлангуудад аудит хийж гүйцэтгэлээ.

Нэгтгэсэн санхүүгийн тайлангуудтай холбоотойгоор удирдлагын хүлээх хариуцлага

Группын удирдлага нь эдгээр нэгтгэсэн санхүүгийн тайлангуудыг Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандартын дагуу бэлтгэж, шударгаар толилуулах үүрэгтэй. Мөн залилан эсвэл алдааны улмаас үүсч болох материаллаг буруу илэрхийллээс ангид санхүүгийн тайлангуудыг бэлтгэх боломжийг бий болгоход шаардлагатай гэж удирдлагын тодорхойлсон дотоод хяналтыг зохион байгуулах үүрэгтэй.

Аудиторын хариуцлага

Бид гүйцэтгэсэн аудитдаа үндэслэн эдгээр нэгтгэсэн санхүүгийн тайлангуудад дүгнэлт гаргах үүрэгтэй. Бид аудитаа Аудитын Олон Улсын Стандартын дагуу хийж гүйцэтгэлээ. Эдгээр стандарт нь санхүүгийн тайлангууд материаллаг алдаагүй илэрхийлэгдсэн гэсэн зохих нотолгоог олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, ёс зүйн шаардлагуудыг баримтлан гүйцэтгэхийг биднээс шаарддаг. Аудитын ажил нь нэгтгэсэн санхүүгийн тайлан дахь дүн болон тодруулгуудын талаар аудитын нотолгоо олж авах горимуудыг гүйцэтгэх ажлыг багтаадаг. Санхүүгийн тайлангууд нь алдаа эсвэл залилангийн улмаас гарч болох материаллаг буруу тайлагналтай байж болох эрсдлийг үнэлэх зэрэг горимуудыг аудитор өөрийн шийдлээр сонгож авна. Тэдгээр эрсдэлийн үнэлгээг хийхэд Группын дотоод хяналтын системийн үр нөлөөтэй байдлын талаар дүгнэлт гаргах зорилгоор биш харин тухайн нөхцөл байдалд зохистой аудитын горимуудыг боловсруулахын тулд санхүүгийн тайлангуудыг бэлтгэх, үнэн зөв толилуулахтай холбоотой дотоод хяналтыг аудитор авч үздэг. Түүнчлэн аудитын ажил нь санхүүгийн тайланг бүхэлд нь үнэлэхээс гадна, удирдлагын зүгээс хийсэн тооцооллуудын ул үндэстэй байдал, баримталсан бүртгэлийн бодлогын зохистой байдлыг үнэлэх ажлыг өөртөө агуулдаг.

Бидний олж авсан аудитын нотолгоо нь бидний гаргасан хязгаарлалттай дүгнэлтэд хангалттай бөгөөд зохистой үндэслэл болж чадна гэдэгт бид итгэлтэй байна.

Хязгаарлалтын үндэслэл

Бид 2012 оны 12 сарын 31-ний өдрөөр тасалбар болсон жилийн санхүүгийн тайлангуудад аудит хийж гүйцэтгэсэн бөгөөд 2011 оны 12 сарын 31-ний өдрөөр тасалбар болсон жилийн Группийн санхүүгийн тайлангуудад өөр аудитын компани аудит хийж, 2012 оны 03 сарын 14-ний өдрөөр огноолсон тайлангаараа эерэг дүгнэлт илэрхийлсэн байсан.

2012 оны 12 сарын 31-ний өдрөөр тасалбар болсон жилийн санхүүгийн тайлангуудын эхний үлдэгдлийн үнэн зөв байдлын талаар хангалттай бөгөөд зохистой нотолгоо цуглуулахын тулд өмнөх аудиторын ажлын баримттай танилцаж чадаагүй бөгөөд 2012 оны 01 сарын 01-ний хуримтлагдсан ашгийн үнэн зөв байдлын талаарх баталгаа олж авахын тулд аудитын горимгоо өргөжүүлэх боломжгүй байсан болно.



ГОЛОМТ БАНК БОЛОН ТҮҮНИЙ ОХИН КОМПАНИ

ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ (үргэлжлэл)



58

Дүгнэлт

Бидний дүгнэлтээр, Хязгаарлалтын үндэслэл хэсэгт дурдсан зүйлсийн нөлөөллөөс бусад бүх материаллаг зүйлсийн хувьд, нэгтгэсэн санхүүгийн тайлангууд нь 2012 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх Группын санхүүгийн байдал, тухайн өдрөөр тасалбар болсон санхүүгийн жилийн санхүүгийн гүйцэтгэл болон мөнгөн гүйлгээг Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандартын дагуу үнэн бөгөөд шударгаар зөв толилуулсан байна.

Бусад асуудлууд

Групп нь тухайлсан аккредитив, баталгаатай холбоотойгоор хөндлөнгийн шалгалт хийлгэхээр хараат бус экспертиг ажиллуулсан бөгөөд эксперт нь 2013 оны 08 сарын 12-ны өдрөөр огноолон шалгалтын урьдчилсан тайланг Группын удирдлагад танилцуулсан байсан. Аудитын явцад бид энэхүү тайланд дурдагдсан асуудлуудын 2012 оны санхүүгийн тайланд үзүүлж болох нөлөөллийг үнэлж холбогдох залруулгыг хийсэн. Гэвч бид эдгээр асуудлуудын хавсаргасан санхүүгийн тайланд нөлөөлснөөс өөрөөр, бусад хууль тогтоомжийн мөрдөлтийн талаар шалгалт хийгээгүй бөгөөд даган мөрдөлтийн талаар дүгнэлт илэрхийлээгүй болно.

Тайлангийн хэрэглээ

Энэхүү тайланг өөр ямар нэгэн зорилгоор бус харин Монгол Улсын "Компанийн тухай хууль"-ийн 94 дүгээр зүйлд заасан хуулийн этгээд болох Группын хувьцаа эзэмшигчдэд зориулан гаргасан болно. Бид энэхүү тайлангийн агуулгын хүрээнд өөр аливаа нэг гуравдагч талын өмнө хариуцлага хүлээхгүй.



Огноо: 2013 . 11 . 08

**2012 оны 12 сарын 31-ний өдрөөр тасалбар болсон жилийн
Нэгтгэсэн Санхүүгийн Байдлын Тайлан**

	Тод	Аудитлагдсан- (Групп) 2012 оны 12 сарын 31 мян.төг	Залруулсан- (Групп) 2011 оны 12 сарын 31 мян.төг	Аудитлагдсан- (Групп) 2012 оны 12 сарын 31 мян.төг	Залруулсан- (Групп) 2011 оны 12 сарын 31 мян.төг
ХӨРӨНГӨ					
Бэлэн мөнгө, төв банкны харилцах	6	186 730 836	95 317 841	186 730 836	95 317 841
Монгол банкинд байршуулсан заавал байлгах нөөц	7	239 329 820	194 549 220	239 329 820	194 549 220
Санхүүгийн хөрөнгө оруулалт-бодит үнэ цэнэ нь олз гарцаар хүлээн зөвшөөрөгдөх	8	5 897 807	1 061 151	5 897 807	1 061 151
Бусад банк, санхүүгийн байгууллагад байршуулсан хөрөнгө	9	214 670 056	221 882 444	214 670 056	221 882 444
Санхүүгийн хөрөнгө оруулалт- борлуулахад бэлэн	10	1 778 566	2 758 940	1 778 566	2 758 940
Санхүүгийн хөрөнгө оруулалт - дуусгавар хугацаа хүртэл эзэмших	11	398 111 870	304 169 951	398 111 870	304 169 951
Репо хэлцэл	12	-	24 979 395	-	24 979 395
Охин компанид оруулсан хөрөнгө оруулалт	13	-	-	200 000	100 000
Үүсмэл санхүүгийн хэрэглүүр	14	3 220	-	3 220	-
Харилцагчдад олгосон зээл ба урьдчилгаа	15	1 427 922 400	1 249 340 888	1 427 922 400	1 249 340 888
Өмч, барилга, тоног төхөөрөмж	16	36 357 551	30 524 082	36 328 350	30 524 082
Биет бус хөрөнгө	17	802 840	645 990	800 744	643 689
ХОЗҮХХ	18	698 592	780 443	698 592	780 443
Өмчлөх бусад үл хөдлөх хөрөнгө	19	-	-	-	-
Бусад хөрөнгө	20	11 110 304	7 549 004	11 097 703	7 552 068
Хойшлогдсон татварын хөрөнгө	21	3 913 089	1 022 525	3 913 089	1 022 525
НИЙТ ХӨРӨНГӨ		2 527 326 951	2 134 581 874	2 527 483 053	2 134 682 637
ӨР ТӨЛБӨР БА ӨМЧ					
Өр төлбөр					
Бусад банк, санхүүгийн байгууллагын харилцах, хадгаламж	22	46 989 030	9 496 253	46 989 030	9 496 253
Харилцагчдын харилцах, хадгаламж	23	2 056 530 371	1 839 222 798	2 056 581 113	1 839 324 288
Зээлээр авсан эх үүсвэр	24	112 840 408	63 428 871	112 840 408	63 428 871
Хоёрдогч өглөг	25	34 691 374	47 864 614	34 691 374	47 864 614
Үүсмэл санхүүгийн хэрэглүүр	26	1 172 027	2 570 585	1 172 027	2 570 585
Болзошгүй өр төлбөр	27	2 215 362	91 375	2 215 362	91 375
Бусад өр төлбөр	28	80 739 097	25 088 688	80 739 097	25 088 688
Хойшлогдсон орлого	29	4 580 645	6 408 162	4 580 645	6 408 162
Татварын өглөг	30	361 213	1 323 328	361 167	1 323 253
Нийт өр төлбөр		2 340 119 527	1 995 494 674	2 340 170 223	1 995 596 089
Өөрийн хөрөнгө					
Хувьцаат капитал	31	25 907 593	24 591 543	25 907 593	24 591 543
Хувьцааны урамшуулал	31	42 322 298	22 344 874	42 322 298	22 344 874
Өмчийн бусад хэсэг	32	2 088 203	5 742 519	2 075 756	5 742 519
Хуримтлагдсан ашиг	33	116 889 330	86 408 264	117 007 183	86 407 612
Нийт өөрийн хөрөнгө		187 207 424	139 087 200	187 312 830	139 086 548
Нийт өр төлбөр ба өөрийн хөрөнгө		2 527 326 951	2 134 581 874	2 527 483 053	2 134 682 637



ГОЛОМТ БАНК БОЛОН ТҮҮНИЙ ОХИН КОМПАНИ

2012 оны 12 сарын 31-ний өдрөөр тасалбар болсон жилийн Нэгтгэсэн Дэлгэрэнгүй Орлогын Тайлан



60

	Тод	Аудитлагдсан- (Групп) 2012 мян.төг	Залруулсан- (Групп) 2011 мян.төг	Аудитлагдсан- (Банк) 2012 мян.төг	Залруулсан- (Банк) 2011 мян.төг
Хүү болон түүнтэй адилтгах орлого	34	200 245 015	165 165 129	200 245 015	165 165 129
Хүү болон түүнтэй адилтгах зардал	35	(143 124 972)	(116 238 119)	(143 127 131)	(116 239 704)
Хүүгийн цэвэр орлого		57 120 043	48 927 010	57 117 884	48 925 425
Харилцагчдад олгосон зээл, авлагын үнэ цэнийн бууралтын нөөц	36	(8 666 060)	(6 233 060)	(8 666 060)	(6 233 060)
Харилцагчдад олгосон зээл, авлагын үнэ цэнийн бууралтын нөөцийн дараах цэвэр хүүгийн орлого		48 453 983	42 693 950	48 451 824	42 692 365
Бодит үнэ цэнээр хэмжигдсэн санхүүгийн хөрөнгөөс үүдсэн олз/гарз	37	4 760	19 877	4 760	19 877
Борлуулах боломжтой санхүүгийн хөрөнгөөс үүдсэн олз/гарз		(328 887)	(253 065)	(328 887)	(253 065)
Агуулагдсан санхүүгийн хэрэгслийн бодит үнэ цэнийн олз/гарз		709 744	(1 063 189)	709 744	(1 063 189)
Гадаад валют, үнэт металлын арилжааны олз/гарз	38	19 293 135	19 462 783	19 293 135	19 462 783
Гадаад валют, үнэт металлын ханшийн тэгшитгэлийн олз/гарз		(2 078 050)	930 689	(2 078 050)	930 689
Ногдол ашгийн орлого		6 776	4 901	6 776	4 901
Бусад үйл ажиллагааны орлого		189 931	131 708	189 969	131 708
Хураамж ба шимтгэлийн орлого	39	19 980 330	14 029 915	19 969 184	14 029 915
Хураамж ба шимтгэлийн зардал	40	(4 937 631)	(3 760 654)	(4 935 586)	(3 760 654)
Борлуулах боломжтой санхүүгийн хөрөнгийн үнэ цэнийн бууралт	41	(1 040 666)	(2 340 179)	(1 040 666)	(2 340 179)
Хүлээж болзошгүй үүргийн үнийн бууралтын нөөц	42	(2 123 987)	(91 375)	(2 123 987)	(91 375)
Үйл ажиллагааны орлого		78 129 438	69 765 361	78 118 216	69 763 776
Үйл ажиллагааны зардал	43	(45 548 463)	(32 515 908)	(45 418 952)	(32 515 133)
Татварын өмнөх ашиг		32 580 975	37 249 453	32 699 264	37 248 643
Орлогын татварын зардал	44	(6 080 022)	(9 022 425)	(6 079 806)	(9 022 267)
Цэвэр ашиг		26 500 953	28 227 028	26 619 458	28 226 376
Бусад дэлгэрэнгүй орлого					
Борлуулахад бэлэн санхүүгийн хэрэгслийн дахин үнэлгээний нөлөө	45	(59 194)	560 342	(59 194)	560 342
Татварын дараах Бусад дэлгэрэнгүй ашиг, алдагдал		(59 194)	560 342	(59 194)	520 870
Тайлант жилийн нийт бусад дэлгэрэнгүй орлого		26 441 759	28 787 370	26 560 264	28 747 246
Нэгж хувьцааны үндсэн ашиг (төгрөг):	46	1 097	1 279	1 101	1 279
Нэгж хувьцааны шингэрсэн ашиг (төгрөг):	46	909	965	912	965

2012 оны 12 сарын 31-ний өдрөөр тасалбар болсон жилийн Нэгтгэсэн Өмчийн Өөрчлөлтийн Тайлан

Group	Хувьцаат капитал	Хувьцааны урамшуулал	Зайлшгүй байлгах нөөц	Хувьцаанд суурилсан төлбөрийн нөөц	Борлуулахад бэлэн нөөц	Бусад нөөц *	Хуримтлагдсан ашиг	Нийт өмч
	мян.төг	мян.төг	мян.төг	мян.төг	мян.төг	мян.төг	мян.төг	мян.төг
2011 оны 01 сарын 01-ний үлдэгдэл	21,934,142	-	-	-	(297,935)	-	62,161,348	83,797,555
Нэмж гаргасан хувьцаа	2,657,401	22,344,874	-	-	-	-	-	25,002,275
Тайлант жилийн ашиг	-	-	-	-	-	-	28,227,028	28,227,028
Хувьцаанд суурилсан төлбөр (Тод 47)	-	-	-	1,500,000	-	-	-	1,500,000
Зохицуулалтын нөөц рүү шилжүүлсэн	-	-	3,980,112	-	-	-	(3,980,112)	-
Бусад дэлгэрэнгүй орлого	-	-	-	-	560,342	-	-	560,342
								-
2011 оны 12 сарын 31-ний буюу 2012 оны 01 сарын 01-ний үлдэгдэл	24,591,543	22,344,874	3,980,112	1,500,000	262,407	-	86,408,264	139,087,200
Нэмж гаргасан хувьцаа	1,316,050	19,977,424	-	-	-	-	-	21,293,474
Тайлант жилийн ашиг	-	-	-	-	-	-	26,500,954	26,500,954
Хувьцаанд суурилсан төлбөр (Тод 47)	-	-	-	372,543	-	-	-	372,543
Зохицуулалтын нөөц рүү шилжүүлсэн	-	-	(3,980,112)	-	-	-	3,980,112	-
Бусад дэлгэрэнгүй орлого	-	-	-	-	(59,194)	-	-	(59,194)
Эрсдэлийн сангийн нөөц	-	-	-	-	-	12,447	-	12,447
2012 оны 12 сарын 31-ний үлдэгдэл	25,907,593	42,322,298	-	1,872,543	203,213	12,447	116,889,330	187,207,424

* Энэхүү дүн нь Банкны охин компани болох Голомт Секюритиз ХХК-ийн Санхүүгийн Зохицуулах Хорооны шаардлагын дагуу байгуулсан санг илэрхийлнэ.



ГОЛОМТ БАНК БОЛОН ТҮҮНИЙ ОХИН КОМПАНИ

2012 оны 12 сарын 31-ний өдрөөр тасалбар болсон жилийн Нэгтгэсэн Мөнгөн Гүйлгээний Тайлан



62

	Аудитлагдсан- (Групп) 2012 мян.төг	Залруулсан- (Групп) 2011 мян.төг	Аудитлагдсан- (Банк) 2012 мян.төг	Залруулсан- (Банк) 2011 мян.төг
ҮНДСЭН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ				
Татварын өмнөх ашиг	32 580 975	37 249 453	32 699 264	37 248 643
Тохируулга:				
Үнэ цэнийн бууралтын тооцооллоос үүссэн хүүгийн зардал	-	360 744	-	360 744
Агуулагдсан үүсмэл санхүүгийн хэрэгслийн бодит үнэ цэнийн өөрчлөлт	-	1 063 189	-	1 063 189
Арилжаалах зорилгоор эзэмшиж буй санхүүгийн хэрэгслийн бодит үнэ цэнийн өөрчлөлт	106 865	253 065	106 865	253 065
Валютын форвард хэлцлийн бодит бус гарз/(олз)	-	5 749	-	5 749
Үндсэн хөрөнгө борлуулсны олз/(гарз)	15 103	(14 889)	15 103	(14 889)
Валютын ханшийн өөрчлөлтийн бодит бус гарз/(олз)	2 078 050	(930 690)	2 078 050	(930 690)
Харилцагчдад олгосон зээл ба урьдчилгааны үнэ цэнийн бууралтын алдагдал	3 478 388	8 620 468	3 478 388	8 620 468
Бусад хөрөнгийн үнэ цэнийн бууралтын алдагдал	60 299	60 652	60 299	60 652
Борлуулахад бэлэн хөрөнгийн үнэ цэнийн бууралтын алдагдал	(1 398 558)	2 340 179	(1 398 558)	2 340 179
Үндсэн хөрөнгийн элэгдэл	3 910 318	2 649 241	3 903 885	2 649 241
Биет бус хөрөнгийн хорогдуулга	563 622	575 057	562 309	574 950
Данснаас хассан үндсэн хөрөнгө	-	9 403	-	9 403
Зээлийн алдагдалд байгуулсан нөөц	2 136 434	101 744	2 123 987	101 744
ӨБҮХХ үнэ цэнийн бууралтын алдагдал	110 063	1 219	110 063	1 219
Хувьцаанд суурилсан опционы төлбөрийн зардал	372 543	1 500 000	372 543	1 500 000
Ажлын капиталын өөрчлөлтийн өмнөх үйл ажиллагааны ашиг	44 014 102	53 844 585	44 112 198	53 843 668
Үйл ажиллагааны хөрөнгийн өөрчлөлтүүд:-	-	-	-	-
Монголбанкинд заавал байлгах нөөц	(44 778 000)	(140 053 610)	(44 778 000)	(140 053 610)
Харилцагчдад олгосон зээл ба урьдчилгаа	(184 287 400)	(467 529 219)	(184 287 400)	(467 529 219)
Бусад хөрөнгө	(18 514 531)	(2 571 629)	(18 502 129)	(2 571 429)
Үйл ажиллагааны өр төлбөрийн өөрчлөлтүүд:	-	-	-	-
Бусад банк, санхүүгийн байгууллагын харилцах, хадгаламж	37 492 777	(71 605 166)	37 492 777	(71 605 166)
Харилцагчдын харилцах, хадгаламж	217 256 824	522 637 089	217 256 824	522 637 089
Бусад өр төлбөр	55 647 146	13 166 665	55 650 410	13 163 400
Үйл ажиллагаанд (зарцуулсан)/ орсон мөнгө	106 830 918	(92 111 285)	106 944 680	(92 115 267)
Орлогын албан татварын төлөлт	(9 932 700)	(9 513 028)	(9 932 455)	(9 512 945)
Үйл ажиллагаанд (зарцуулсан)/ орсон цэвэр мөнгө	96 898 218	(101 624 313)	97 012 225	(101 628 212)

**2012 оны 12 сарын 31-ний өдрөөр тасалбар болсон жилийн
Нэгтгэсэн Мөнгөн Гүйлгээний Тайлан**

	Аудитлагдсан- (Групп) 2012 мян.төг	Залруулсан- (Групп) 2011 мян.төг	Аудитлагдсан- (Банк) 2012 мян.төг	Залруулсан- (Банк) 2011 мян.төг
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ГҮЙЛГЭЭ				
Охин компанид оруулсан хөрөнгө оруулалт	-	-	(100 000)	(100 000)
Худалдан авсан санхүүгийн хөрөнгө оруулалт	(163 008 617)	(51 742 097)	(163 008 617)	(51 742 097)
Дуусгавар болсон ба борлуулсан санхүүгийн хөрөнгө оруулалтын орлого	133 758 342	5 198 473	133 758 342	5 198 473
Үндсэн хөрөнгө борлуулсны орлого	742 870	67 484	742 870	67 484
Худалдан авсан үндсэн хөрөнгө	(10 419 909)	(6 672 676)	(10 384 275)	(6 672 676)
Худалдан авсан репо хэлцлүүд	(501 520 605)	(634 100 512)	(501 520 605)	(634 100 512)
Хугацаа дуусгавар болсон репо хэлцлийн орлого	526 500 000	634 100 512	526 500 000	634 100 512
Худалдан авсан биет бус хөрөнгө	(720 472)	(115 854)	(719 364)	(113 446)
Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ	(14 668 391)	(53 264 670)	(14 731 649)	(53 362 262)
САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ				
Хувьцаа нэмж гаргаснаас орж ирсэн мөнгө	21 293 474	25 002 275	21 293 474	25 002 275
Зээлийн санхүүжилтын татан авалт	77 361 713	69 318 280	77 361 713	69 318 280
Зээлийн санхүүжилтын эргэн төлөлт	(27 908 508)	(34 577 405)	(27 908 508)	(34 577 405)
Санхүүгийн үйл ажиллагаанаас орж ирсэн (зарцуулсан) цэвэр мөнгөн гүйлгээ	70 746 679	59 743 150	70 746 679	59 743 150
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн цэвэр өсөлт (бууралт)	152 976 506	(95 145 833)	153 027 255	(95 247 324)
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	495 877 858	691 071 501	495 776 367	691 071 501
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл (Тод 52)	648 854 363	595 925 669	648 803 621	595 824 178



ГОЛОМТ БАНК БОЛОН ТҮҮНИЙ ОХИН КОМПАНИ

2012 оны 12 сарын 31-ний өдрөөр тасалбар болсон жилийн Нэгтгэсэн Санхүүгийн Тайлангийн Тодруулга



64

1. ТАЙЛАГНАГЧ АЖ АХУЙН НЭГЖ

Эдгээр нэгтгэсэн санхүүгийн тайлангууд нь Голомт Банк ХХК ("Банк" гэх) болон Голомт Секюритиз ХХК ("Охин Компани" гэх)-ийн санхүүгийн тайлангуудаас бүрдэнэ.

Голомт Банк нь анх Бодь Интернэйшнл ХХК-ийн 100 хувийн охин компанийн хэлбэрээр Бодь Интернэйшнл ХХК-ийн хувьцаа эзэмшигчдийн шийдвэрээр Монгол Улсын хууль, журмын дагуу үүсгэн байгуулагдсан.

Тус банк нь 2005 оны 12 сарын 05-ны өдөр Улсын Бүртгэлийн Албанаас олгогдсон 2075377 тоот регистрийн дугаартай, 9016001014 тоот Улсын Бүртгэлийн Гэрчилгээтэй.

1995 оны 03 сарын 06-ны өдөр Монгол Банкнаас Банкны үйл ажиллагаа эрхлэх 25 тоот тусгай зөвшөөрлийг авсан.

Банкны хүчин төгөлдөр дүрмийн дагуу Банкны үндсэн үйл ажиллагаа нь:

- Хадгаламж;
- Зээлийн үйлчилгээ;
- Картын үйлчилгээ;
- Баталгаа ба Аккредитив;
- Мөнгөн шилжүүлэг;
- Гадаад валют худалдах, худалдан авах, хадгалах арилжаалах;
- Үнэт метал худалдах, худалдан авах, хадгалах арилжаалах;
- Гадаад төлбөр, тооцоо;
- Үнэт цаас гаргах, арилжаалах;
- Санхүүгийн түрээсийн үйлчилгээ;
- Зээл болон бусад санхүүгийн хэрэглүүр худалдан авах, худалдах;
- Монгол Банк болон Засгийн Газрын бусад агентлагуудаас хязгаарлаагүй бусад санхүүгийн үйлчилгээ болно.

Тус Банк нь 2011 оны 06 сарын 02-ны өдөр Монгол Улсын Санхүүгийн Зохицуулах Хорооны 163 тоот тогтоолын дагуу андеррайтерийн үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл Санхүүгийн Зохицуулах Хорооноос авсан.

Банкны гол хувьцаа эзэмшигчдийн талаарх мэдээллийг дор хуруулав:

Хувьцаа эзэмшигч	2012 он Эзэмшил (%)	2011 он Эзэмшил (%)
Бодь Интернэйшнл ХХК	84.66%	89.19%
Свисс-Мо Инвестмент Эй.Жи	10.16%	10.71%
Трафигура Бэхээр Би.Ви	5.02%	0%
Хувьцаат капиталын 5 хувиас бага хувьцаа эзэмшигчид	0.16%	0.10%
Нийт	100%	100%

Тус Групп болон Банкийг Бодь Интернэйшнл ХХК (2012 оны 12 сарын 31-нээр 84.66 хувийг эзэмшдэг), Свисс-Мо Инвестмент Эй.Жи (2012 оны 12 сарын 31-нээр 10.16 хувийг эзэмшдэг), Трафигура Бэхээр Би.Ви (2012 оны 12 сарын 31-нээр 5.02 хувийг эзэмшдэг) (2011 онд: Бодь Интернэйшнл ХХК 89.19 хувийн болон Свисс-Мо Инвестмент Эй.Жи 10.71 хувийн эзэмшилтэй байсан).

Банк нь Улаанбаатар хот болон Монгол улсын аймаг, орон нутагт 93 салбартай бөгөөд 2012 оны жилийн эцсээр 1665 (2011:1329 ажилтан) ажилтантай байсан.

Охин компани

Голомт Банк ХХК-ийн 100 хувийн охин компани болох Голомт Секюритиз ХХК ("охин компани" гэх) нь 2011 оны 05 сарын 17-ны өдрийн №1 шийдвэрийн дагуу Хязгаарлагдмал Хариуцлагатай Компанийн хэлбэрээр үүсгэн байгуулагдсан.

Компани нь 2011 оны 11 сарын 02-ны өдөр Улсын Бүртгэлийн Албанд бүртгүүлж, 5481589 тоот регистрийн дугаартай 9011287134 тоот Улсын Бүртгэлийн Гэрчилгээ авсан.

Охин компани нь Үнэт Цаасны Зах зээл дээр үйл ажиллагаа эрхлэх 3/97 тоот Тусгай Зөвшөөрлийг 2011 оны 11 сарын 02-ны өдрийн Санхүүгийн Зохицуулах Хорооны 317 тоот тогтоолын дагуу авсан.

Охин компанийн үндсэн үйл ажиллагаа нь:

- Брокерийн үйл ажиллагаа
- Дилерийн үйлчилгээ
- Санхүүгийн болон хөрөнгө оруулалтын үйлчилгээ

2. БАНК/ГРУППЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЧИН

2.1 Ерөнхий

Монгол Улсын эдийн засаг нь харьцангуй өндөр инфляцийн түвшин, бусад гадаадын улс орнуудын хөрвөх чадваргүй үндэсний валют гэх мэт хөгжиж буй зах зээлийн тодорхой шинж чанаруудыг агуулсаар байна. Монгол Улсын татвар, валют, гаалийн хууль тогтоомжуудыг өөр өнцгөөр тайлбарлаж, өөрчлөлтүүдийг ойр ойрхон хийж байна. Монгол Улс нь зах зээлийн эдийн засгийн шаардлагыг хангахуйц эрх зүй, татвар болон захиргааны тогтолцоог тасралтгүй хөгжүүлж байна. Засгийн газрын хөгжүүлж буй эдийн засгийн шинэчлэл нь Монгол Улсын эдийн засгийг шинэ техник технологиор хангах, өндөр технологийн үйлдвэрлэлийг хөгжүүлэх, хөдөлмөрийн бүтээмжийг дээшлүүлэх, үндэсний өндөр технологийн үйлдвэрийг хөгжүүлэх, дэлхийн зах зээлд үндэсний бүтээгдэхүүний өрсөлдөх чадварыг сайжруулах зорилготой юм.

Европ болон бусад улс орнуудын санхүүгийн зах зээлийн тодорхойгүй байдал үргэлжилсээр байгаа нь Монгол улсын санхүүгийн болон бизнесийн секторт томоохон сөрөг нөлөө үзүүлж болзошгүй юм.

Банкны удирдлагын баг нь нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн “Бодит алдагдал” загварыг ашиглан зээлийн үнэ цэнийн бууралтыг тооцдог аргачлалыг нэвтрүүлсэн. Энэхүү загвар нь өнгөрсөн хугацаан дахь түүхэн мэдээлэлд тулгуурлан үнэ цэнийн бууралтыг тооцоолохыг шаарддаг бөгөөд ирээдүйн эдийн засгийн орчны өөрчлөлтөд тулгуурлан үнэ цэнийн бууралтыг тооцохыг хориглодог. Тухайн үйл явдал ирээдүйд тохиолдох магадлалтай байсан хэдий ч мөн хориглодог.

Монгол Улсын эдийн засгийн ирээдүйн чиг хандлага нь Засгийн Газраас авч хэрэгжүүлж байгаа эдийн засаг, мөнгө, санхүүгийн талаарх арга хэмжээний үр дүнтэй байдал, татвар, эрх зүйн зохицуулалт болон улс төрийн өөрчлөлт шинэчлэлтээс шууд хамааралтай.

2.2 Инфляци

Монгол улс нь инфляцийн өндөр түвшинтэй байсаар байна. Сүүлийн таван жилийн инфляцийн индексүүдийг доорх хүснэгтэнд харуулав:

Жилүүд	Инфляци
2012 он	14.00%
2011 он	10.20%
2010 он	13.00%
2009 он	4.20%
2008 он	22.10%

2.3 Валютын ажил гүйлгээ

Гадаад валют, голчлон Ам.доллар болон Евро нь Монгол улсын ихэнх бизнесийн төлбөр тооцоонд хэрэглэгдэж, суурь эдийн засагт чухал үүрэг гүйцэтгэж байна. Монгол улсын Төв банкнаас зарласан Ам.доллар болон Еврогийн төгрөгтэй харьцах ханшийг доорх хүснэгтэнд харуулав:

Огноо	Ам.доллар	Евро
2012 оны 12 сарын 31	1,392.10	1,835.83
2011 оны 12 сарын 31	1,396.37	1,806.76
2010 оны 12 сарын 31	1,257.18	1,679.97
2009 оны 12 сарын 31	1,442.84	2,071.34
2008 оны 12 сарын 31	1,267.51	1,786.75



ГОЛОМТ БАНК БОЛОН ТҮҮНИЙ ОХИН КОМПАНИ

3. ТАЙЛАН БЭЛТГЭСЭН ҮНДЭСЛЭЛ

3.1 Ерөнхий зарчмууд

Групп болон Банкны эдгээр нэгтгэсэн санхүүгийн тайлангууд нь Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт("СТОУС")-ын дагуу бэлтгэгдсэн. Групп болон Банк нь Монгол Улсын холбогдох хууль тогтоомжийн дагуу нягтлан бодох бүртгэлээ хөтөлдөг. Эдгээр нэгтгэсэн санхүүгийн тайлангууд нь СТОУС-тай бүх материаллаг зүйлсийн хувьд нийцсэн нягтлан бодох бүртгэлийн суурийн дагуу бэлтгэгдсэн.

3.2 Гүйлгээний болон тайлагналын валют

Эдгээр нэгтгэсэн санхүүгийн тайлангууд нь Группын гүйлгээний болон тайлагналын валют болох Монгол улсын Үндэсний Төгрөг("төгрөг")-өөр илэрхийлэгдсэн ба өөрөөр тусгайлан зааснаас бусад тохиолдолд бүх үзүүлэлтүүдийг мянганчлан илэрхийлсэн.

3.3 Тооцоолол ба төсөөлөл

Санхүүгийн тайланг бэлтгэх нь санхүүгийн тайлан бэлтгэсэн өдрөөрх хөрөнгө, өр төлбөрийн тайлагнагдсан дүн, болзошгүй хөрөнгө, өр төлбөрийн нэмэлт тодруулга, тайлант хугацааны орлого болон зардлын тайлагнагдсан дүн зэрэгт нөлөөлөх тооцоолол болон төсөөллийг ашиглахыг шаарддаг. Удирдлагаас тооцоолол шаарддаг, санхүүгийн тайланд хамгийн чухал нөлөөтэй зүйлсийн талаар Тодруулга 4, Нягтлан бодох бүртгэлийн Гол Бодлогуудын Хураангуй-д нэмж тодруулсан.

3.4 Өөдрөг төсөөлөл

Эдгээр санхүүгийн тайлангууд нь Группын үйл ажиллагаа болон санхүүгийн байдалд үзүүлэх Монгол улсын бизнесийн орчны нөлөөллийн талаарх Группын удирдлагын үнэлгээг тусгасан. Монгол улсын эдийн засгийн ирээдүйн чиг хандлага нь Засгийн Газрын авч хэрэгжүүлэх арга хэмжээний үр дүн, зохицуулалтын болон улс төрийн хөгжил дэвшил гэх мэт Группын хяналтаас гадна орших бусад хүчин зүйлсээс багагүй хамаардаг. Эдгээр хүчин зүйлс нь Группын санхүүгийн байдалд ирээдүйд хэрхэн нөлөө үзүүлэхийг Группын удирдлага нь урьдчилан таамаглах боломжгүй юм.

Эдгээр санхүүгийн тайлангууд нь өөдрөг төсөөлөлд үндэслэгдэн бэлтгэгдсэн. 51-р Тодруулгад харуулсан Группын төлбөр түргэн гүйцэтгэх байдал нь эргэлтийн өр төлбөрөө барагдуулахад хүрэлцэхүйц түргэн хөрвөх хөрөнгөтэй болохыг илэрхийлж байна.

Хөрвөх чадварын эрсдлээ шууд удирдахын тулд Групп нь Группын хөрвөх чадварын түвшинд нөлөө үзүүлж болох гадаад хүчин зүйлсийг тогтмол хянаж, мөнгөн урсгалаа төлөвлөдөг. Хөрвөх чадварын дунд болон урт хугацааны эрсдлийг удирдахдаа хөрөнгө болон өр төлбөрийн дуусвар болох хугацааны зөрүүтэй байдлыг шинжилдэг. Эрсдэлд өртөх магадлалыг бууруулахын тулд Групп хөрвөх чадварын зөрүүний хязгаар тогтоодог бөгөөд энэхүү тогтоосон хязгаарыг гадаад болон дотоод орчны өөрчлөлттэй уялдуулан тогтмол хугацаагаар шалгадаг.

Хөрвөх чадварын шаардлагатай түвшинг хадгалахын тулд Групп болон Банк Монгол улсын Төв Банкнаас болон банк хоорондын зах зээл дээрээс эх үүсвэр татах боломжтой. Хөрвөх чадварын эх үүсвэрийг төрөлжүүлэх нь Группыг ямар нэг эх үүсвэрээс хараат байх эрсдлийг хамгийн бага түвшин хүртэл бууруулах, өр төлбөрөө бүрэн барагдуулах боломжийг олгодог. Группын хуримтлуулсан өнөөгийн хөрвөх чадварын байдал болон нэмэлт санхүүжилт бий болгох боломжит эх үүсвэр зэрэг нь Группыг урт хугацааны турш үйл ажиллагаагаа тасралтгүй явуулах боломжийг олгодог.

3.5 Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт

Мөрдөж буй нягтлан бодох бүртгэлийн бодлого нь өмнөх санхүүгийн жилийн нягтлан бодох бүртгэлийн бодлоготой ерөнхийдөө нийцдэг. Группын үйл ажиллагаанд ирээдүйд ач холбогдолтой байж болох шинэчлэгдсэн буюу өөрчлөгдсөн стандартууд болон тайлбаруудыг дор жагсаан харуулав:

- СТОУС 7, "Санхүүгийн хэрэглүүр: Тодруулга"-д оруулсан нэмэлт өөрчлөлт (2011 оны 07 сарын 01-ны өдрөөс эхлэн буюу түүнээс хойшхи санхүүгийн жилүүдэд хэрэгжүүлнэ). Санхүүгийн хөрөнгийг шилжүүлэхтэй холбоотой үүсэх эрсдэлийн тодруулгуудыг нэмж бэлтгэхийг энэхүү өөрчлөлтөөр шаардана. Энэхүү нэмэлт өөрчлөлт нь хөрөнгийн ангилал тус бүрээр нь өөр этгээдэд шилжсэн боловч аж ахуйн нэгжийн балансанд байгаа санхүүгийн хөрөнгийн дансны үнэ, түүний эрсдлүүд болон өгөөжийн талаарх тайлбарыг нэмж тодруулах шаардлагыг мөн агуулна. Түүнчлэн, тухайн хөрөнгөтэй холбоотой санхүүгийн өр төлбөр, санхүүгийн хөрөнгө болон холбогдох санхүүгийн өр төлбөрийн хоорондын хамаарал зэргийг нэмж тодруулна. Хөрөнгө үл хүлээн зөвшөөрөгдөх ба шилжүүлсэн хөрөнгөтэй холбоотой эрсдлийг хүлээж, өгөөжийг хүртэх эрх нь аж ахуйн нэгжид хэвээр байгаа үед хэрэглэгчдэд эрсдэлийн түвшний талаар ойлголт өгөхийн тулд нэмэлт тодруулга шаардлагатай.
- НББОУС 12, "Орлогын татвар"-д (2010 оны 12 сард гаргасан бөгөөд 2012 оны 01 сарын 01-ний өдрөөс хойшхи санхүүгийн жилүүдэд хүчин төгөлдөр болох) оруулсан нэмэлт өөрчлөлт нь НББОУС 40, "Хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгө"-ийн бодит үнэ цэнийн загварыг ашиглан бодит үнэ цэнээр хэмжигдсэн хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгийн дансны үнийг борлуулснаар нөхөх боломжтой гэж үндэслэсэн учраас бодит үнэ цэнээс үүдсэн хойшлогдсон татварыг тодорхойлох ёстой талаарх няцаагдах таамаглалыг шинээр тодорхойлсон. Түүнчлэн НББОУС 16, "Өмч, барилга, тоног төхөөрөмж"-ийн дахин



үнэлгээний загварыг ашиглан хэмжигдсэн элэгдэхгүй хөрөнгөөс үүдсэн хойшлогдсон татварыг борлуулсанд тооцож хэмжих шаардлагыг НББОУС 12-д нэмэлтээр оруулсан.

3.6 Хүчин төгөлдөр болоогүй СТОУС болон СТОУС-ын тайлбарууд

Тус Групп нь гаргасан болон хараахан хүчин төгөлдөр болоогүй байгаа дараах СТОУС болон Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Санхүүгийн Тайлбарын Хорооны Тайлбаруудыг мөрдөөгүй:

- НББОУС 27, “Тусдаа Санхүүгийн Тайлан (2013 оны 01 сарын 01-ний өдрөөс эхлэн буюу түүнээс хойшхи санхүүгийн жилүүдэд хэрэгжүүлнэ). Энэхүү Стандарт болон СТОУС 10 “Нэгтгэсэн Санхүүгийн Тайлан” нь НББОУС 27 “Нэгтгэсэн ба Тусдаа Санхүүгийн Тайлан”-г (2003 онд нэмэлт өөрчлөлт хийгдсэн) хүчингүй болгоно. НББОУС 27-д 2008 оны 01-р сард орсон нэмэлт өөрчлөлтөөс үүдсэн НББОУС 21, 28, 31-д орсон өөрчлөлтүүдтэй холбоотойгоор шилжилтийн шаардлагуудыг НББОУС 27 нь нэмж тодруулсан. НББОУС 27 нь тусдаа санхүүгийн тайлангуудыг бэлтгэхдээ охин компани, хараат компани, хамтарсан аж ахуйн нэгжид оруулсан аж ахуйн нэгжийн хөрөнгө оруулалтыг бүртгэх, хөрөнгө оруулалтын талаарх мэдээллийг нэмж тодруулах талаарх шаардлагуудыг тодорхойлсон.
- НББОУС 28, “Хараат компани болон хамтарсан компанид оруулсан хөрөнгө оруулалт” (2013 оны 01 сарын 01-ний өдрөөс эхлэн буюу түүнээс хойшхи санхүүгийн жилүүдэд хэрэгжүүлнэ). Энэхүү стандарт нь НББОУС 28 “Хараат компанид оруулсан хөрөнгө оруулалт (2003 онд нэмэлт өөрчлөлт хийгдсэн)-ын шинэчлэгдсэн хувилбар бөгөөд хараат компани болон хамтарсан компанид оруулсан хөрөнгө оруулалтыг бүртгэхдээ өмчийг аргыг ашиглахыг шаардсан шаардлагуудыг тодорхойлсон.
- СТОУС 9 “Санхүүгийн Хэрэглүүр” (2013 оны 01 сарын 01-ний өдрөөс эхлэн буюу түүнээс хойшхи санхүүгийн жилүүдэд хэрэгжүүлэх боловч хэрэглээг 2015 оны 01 сарын 01 хүртэл хойшлуулсан. Эрт ашиглахыг зөвшөөрсөн.) Энэхүү стандартыг НББОУС 39-ийг орлох анхны үе шат болгон 2009 оны 11-р сард гаргасан бөгөөд НББОУС 39-ийн санхүүгийн хөрөнгийн ангилал ба хэмжилттэй холбоотой хэсгүүдийг өөрчилсөн. Санхүүгийн өр төлбөрийн ангилал ба хэмжилтийн талаарх энэхүү стандартыг орлох хоёрдох үе шат нь 2010 оны 10-р сард хэрэгжсэн. Шинэ стандартын гол өөрчлөлтүүд нь:
 - санхүүгийн хөрөнгүүдийг хэмжилтийн 2 категорид ангилахыг шаардана. Дараах үеүүдэд бодит үнэ цэнээр хэмжигдэх ба дараах үеүүдэд хорогдуулсан өртгөөр хэмжигдэх санхүүгийн хөрөнгүүд. Анхны хүлээн зөвшөөрөлтөнд шийдвэрийг гаргана. Аж ахуйн нэгжийн санхүүгийн хэрэглүүрийг удирдах бизнесийн загвар болон санхүүгийн хэрэглүүрийн гэрээлсэн мөнгөн урсгалын шинж чанар зэргээс хамааруулан ангилал хийнэ;
 - санхүүгийн хэрэглүүр нь өрийн хэрэглүүр бөгөөд (i) аж ахуйн нэгжийн бизнес загварын зорилго нь гэрээлсэн мөнгөн урсгалыг цуглуулахын тулд хөрөнгийг эзэмшиж байх, мөн (ii) хөрөнгийн гэрээлсэн мөнгөн урсгал нь үндсэн болон хүүгийн төлбөрийг л зөвхөн илэрхийлж байх (үндсэн зээлийн шинж чанартай байх нөхцөлд) үед санхүүгийн хэрэглүүрийг дараа үеүүдэд хорогдуулсан өртгөөр хэмжинэ. Бусад бүх өрийн хэрэглүүрүүдийг орлогын тайланд хүлээн зөвшөөрөгдөх бодит үнэ цэнээр хэмжинэ;
 - өмчийн бүх хэрэглүүрийг дараа үеүүдэд бодит үнэ цэнээр нь хэмжинэ. Арилжаалах зорилгоор эзэмшиж буй өмчийн хэрэглүүрийг орлогын тайланд хүлээн зөвшөөрөгдөх бодит үнэ цэнээр хэмжинэ. Бусад бүх өмчийн хэрэглүүрийн хувьд анхны хүлээн зөвшөөрөлтөнд олз ба гарзаар бус бусад дэлгэрэнгүй орлогын хэрэгжээгүй болон хэрэгжсэн олз гарыг хүлээн зөвшөөрөхийн тулд буцах нөхцөлгүй сонголт хийнэ. Бодит үнэ цэнийн олз ба гарзыг ашиг ба алдагдалд дахин ашиглахгүй. Сонголтыг хэрэглүүр тус бүрийн хувьд хийнэ. Ногдол ашгийг хөрөнгө оруулалтын өгөөжийг илэрхийлэх нөхцөлд орлого үр дүнгийн тайланд толилуулна.
- СТОУС 10 “Нэгтгэсэн Санхүүгийн Тайлан” (2013 оны 01 сарын 01-ний өдрөөс эхлэн буюу түүнээс хойшхи санхүүгийн жилүүдэд хэрэгжүүлнэ). Энэхүү шинэ стандарт нь НББОУС 27 “Нэгтгэсэн ба Тусдаа Санхүүгийн Тайлан”, СТХ 12 “Нэгтгэл – Тусгай Зорилгот Тайлан”-г хүчингүй болгоно. СТОУС 10 нь хяналтын 3 түвшинт нэгдмэл загварыг толилуулсан. Дараах 3 шалгуур хангагдаж буй тохиолдолд хөрөнгө оруулагч нь хяналттай байна. Үүнд:
 - (a) хөрөнгө оруулагч нь санхүүжигчийн талаар эрх мэдэлтэй байх;
 - (b) тухайн санхүүжигчийн үйл ажиллагаанд оролцох оролцооноос тогтмол бус өгөөж хүртэх эрхтэй байх;
 - (c) хөрөнгө оруулагчийн өгөөжийн дүнд нөлөөлөхийн тулд санхүүжигчийн үйл ажиллагаанд эрх мэдлээ ашиглах чадвартай байх.
- СТОУС 11 “Хамтын хэлцэл” (2013 оны 01 сарын 01-ний өдрөөс эхлэн буюу түүнээс хойшхи санхүүгийн жилүүдэд буцаан хэрэглэх горимоор хэрэгжүүлнэ). Энэхүү шинэ стандарт нь Хамтарсан үйлдвэрийн хувь оролцоо”-г хүчингүй болгоно. СТОУС 11-ээр танилцуулж буй гол өөрчлөлт нь хамтын оролцоотой бүх үйл ажиллагаануудад бүх төрлийн хамтын хэлцлийг ангилахтай холбоотой. Энэ тохиолдолд хувь тэнцүүлэн нэгтгэх сууриар эсвэл өмчийн аргаар бүртгэгдэнэ. Хамтын хэлцлийн хэлбэр нь хамтын хэлцлийн бүтэц, хууль ёсны хэлбэр, гэрээ хэлцэл болон бусад нөхцөл байдлаас үүдэх хэлцэлд оролцогч талуудын эрх ба үүрэгт суурилна. Байгууллага нь СТОУС 10, СТОУС 12, НББОУС 27, НББОУС 28 (2011 онд нэмэлт өөрчлөлт хийгдсэн) зэргийг хугацаанаас өмнө хэрэгжүүлж буй бол СТОУС 11-ийг эрт хэрэгжүүлэхийг зөвшөөрсөн.



ГОЛОМТ БАНК БОЛОН ТҮҮНИЙ ОХИН КОМПАНИ

3. ТАЙЛАН БЭЛТГЭСЭН ҮНДЭСЛЭЛ (ҮРГЭЛЖЛЭЛ)

3.6 Хүчин төгөлдөр болоогүй СТОУС болон СТОУС-ын тайлбарууд (үргэлжлэл)

- СТОУС 12 “Бусад аж ахуйн нэгж дэх хувь оролцооны нэмэлт тодруулга” (2013 оны 01 сарын 01-ний өдрөөс эхлэн буюу түүнээс хойшхи санхүүгийн жилүүдэд хэрэгжүүлнэ). Энэхүү шинэ стандарт нь охин компани, хамтын хэлцэл, хараат компани, нэгтгэгддэггүй нарийн бүтэцтэй аж ахуйн нэгжүүдэд хувь оролцоотой аж ахуйн нэгжийн нэмэлт тодруулгын шаардлагуудыг агуулна. Өөр аж ахуйн нэгж дэх хувь оролцоо нь бусад аж ахуйн нэгжийн гүйцэтгэлээс тогтмол бус өгөөжийг аж ахуйн нэгжид өгөх магадлалтай гэрээт болон гэрээт бус оролцоог дэлгэрэнгүй тодорхойлсон. Мэдээллийг нэмж тодруулах шинэчлэгдсэн болон шинэ шаардлагууд нь санхүүгийн тайлангийн хэрэглэгчдэд өөр бусад аж ахуйн нэгж дэх тухайн аж ахуйн нэгжийн хувь оролцоотой холбоотой эрсдэлийн шинэ чанар, аж ахуйн нэгжийн санхүүгийн байдал, санхүүгийн гүйцэтгэл, мөнгөн гүйлгээнд үзүүлэх хувь оролцооны нөлөөллийг үнэлэх бололцоо олгохуйц мэдээлэл өгөх зорилготой. Шинэ шаардлагуудыг даган мөрдөхийн тулд аж ахуйн нэгж нь өөр аж ахуйн нэгж, хэлцэл дэх хувь оролцооны шинэ чанарыг тодорхойлох, аж ахуйн нэгжийн оролцож буй хамтын хэлцлийн төрлийг тодорхойлоход хэрэглэсэн чухал шийдлүүд болон төсөөллийг нэмж тодруулахын зэрэгцээ охин компани, хамтын хэлцэл, хараат компани, нэгтгэгддэггүй нарийн бүтэцтэй аж ахуйн нэгжүүдийн үйл ажиллагаанд оролцох оролцооны талаарх мэдээллийг нэмж тодруулах ёстой. СТОУС 12-ийг иж бүрэн эрт хэрэгжүүлж буй тохиолдолд СТОУС 10, СТОУС 11, НББОУС 27, НББОУС 28 (2011 онд нэмэлт өөрчлөлт хийгдсэн) зэргийг мөрдөх шаардлагатай.
- СТОУС 13 “Бодит Үнэ Цэнийн Хэмжилт” (2013 оны 01 сарын 01-ний өдрөөс эхлэн буюу түүнээс хойшхи санхүүгийн жилүүдэд буцаан хэрэглэх горимоор хэрэгжүүлэх ба эрт хэрэгжүүлэхийг зөвшөөрсөн). Энэхүү шинэ стандарт нь СТОУС тус бүрт агуулагдаж буй бодит үнэ цэнийн хэмжилтийн талаарх удирдамжийг бодит үнэ цэнийн хэмжилтийн нэг эх үүсвэрт удирдамжаар орлуулсан. Энэ нь бодит үнэ цэнийн шинэчлэгдсэн тодорхойлолт гаргаж, бодит үнэ цэнийг хэмжих тогтолцоог тогтоож, бодит үнэ цэнийн хэмжилтийн нэмэлт тодруулгын шаардлагуудыг тодорхойлж өгсөн байна. СТОУС 13 нь хөрөнгө ба өр төлбөрийг бодит үнэ цэнээр хэмжих шинэ шаардлагуудыг толилуулаагүй бөгөөд тодорхой стандартуудад хэрэглэгдэж болох бодит үнэ цэнийн хэмжилттэй холбоотой онцгой асуудлуудыг хасаагүй болно.
- НББОУС 1 “Санхүүгийн тайлангийн толилуулга: Бусад Дэлгэрэнгүй Орлогын зүйлсийн Толилуулга”-д оруулсан нэмэлт өөрчлөлт (2012 оны 01 сарын 01-ний өдрөөс эхлэх санхүүгийн жилээс хойш буцаан хэрэглэх горимоор хэрэгжүүлэх ба эрт хэрэгжүүлэхийг зөвшөөрсөн). Энэхүү өөрчлөлт нь ашиг алдагдлаар дахин ангилгдахааргүй зүйлсээс тусад нь ирээдүйд ашиг алдагдлаар дахин ангилж болох бусад дэлгэрэнгүй орлогын зүйлсийг толилуулахыг шаардсан. Түүнчлэн нэмэлт өөрчлөлт нь дэлгэрэнгүй орлогын тайлангийн нэрийг ‘ашиг алдагдлын ба бусад дэлгэрэнгүй орлогын тайлан’ гэж (өөр ижил төрлийн үг ашиглахыг зөвшөөрсөн) өөрчилсөн.
- НББОУС 19 “Ажиллагсдын Тэтгэмж” –д оруулсан өөрчлөлт (2012 оны 01 сарын 01-ний өдрөөс эхлэх санхүүгийн жилээс хойш буцаан хэрэглэх горимоор хэрэгжүүлэх ба эрт хэрэгжүүлэхийг зөвшөөрсөн) Энэхүү өөрчлөлтөөр тогтоосон тэтгэврийн тэтгэмжийн зардлыг хэмжих, хүлээн зөвшөөрөх ба тэтгэмжийг цуцлах талаарх зүйлсэд томоохон өөрчлөлт оруулсан. Ажиллагсдын бүх тэтгэмжийн нэмэлт тодруулгад томоохон өөрчлөлт хийсэн.
- СТОУС 7 “Санхүүгийн хэрэглүүр-Нэмэлт тодруулга”-д оруулсан нэмэлт өөрчлөлт (2013 оны 01 сарын 01-ний өдрөөс эхлэх санхүүгийн жилээс хойш буцаан хэрэглэх горимоор хэрэгжүүлэх ба эрт хэрэгжүүлэхийг зөвшөөрсөн). Энэхүү өөрчлөлт нь санхүүгийн тайлан хэрэглэгчдийг хэлцлийг цэвэрлэх, хооронд нь хаах эрхийн нөлөөлөл эсвэл болзошгүй нөлөөллийг үнэлэхэд туслах нэмэлт тодруулга бэлтгэхийг шаардсан.
- НББОУС СТОУС 7 “Санхүүгийн хэрэглүүр-Нэмэлт тодруулга”-д оруулсан нэмэлт өөрчлөлт (өөрчлөлтүүдийг 2013 оны 01 сарын 01-ний өдрөөс эхлэх санхүүгийн жилээс хойш буцаан хэрэглэх горимоор хэрэгжүүлэх ба эрт хэрэгжүүлэхийг зөвшөөрсөн). Эдгээр нэмэлт өөрчлөлтүүд нь хооронд нь хаах шалгуурын зарим зүйлсийг ашиглахтай холбоотой нийцэмжгүй зүйлсийг арилгахын тулд НББОУС 32-ийг ашиглах удирдамжийг танилцуулсан. Өөрчлөлтүүдийн дагуу ‘хооронд нь хаах эрх зүйн хувьд хүчин төгөлдөр эрх байгаа’ гэсэн ойлголтыг тодруулж, зарим нийт төлбөр тооцооны систем нь цэвэр төлбөр тооцоотой тэнцэх тухай асуудлыг авч үзэх талаар тайлбарласан.

Тус Групп нь эдгээр СТОУС, түүний өөрчлөлтүүдийн хэрэглээ, Группд хэрэглэснээс үүдэх нөлөөлөл, мөрдөх хугацаа зэргийг үнэлж байгаа болно.

3.7 Охин компани

50 хувиас дээш саналын эрхийг шууд буюу шууд бус хувь оролцоогоор дамжуулан Групп нь эзэмшиж байх эсвэл санхүүгийн болон үйл ажиллагааны бодлогод хяналт тавих эрхтэй байх аж ахуйн нэгжүүдийг охин компани гэнэ.

Охин компаниуд нь хяналт Группт шилжиж ирсэн өдрөөс эхлэн нэгтгэгдэх бөгөөд хяналт байхгүй болсон өдрөөс эхлэн нэгтгэгдэхгүй. Групп дотор хийгдсэн бүх ажил гүйлгээ, үлдэгдэл, ажил гүйлгээнээс үүдэлтэй хэрэгжээгүй олз зэрэг нь цэвэрлэгдэх бөгөөд шилжсэн хөрөнгийн үнийн бууралттай холбоотой нотолгоо байгаа бол хэрэгжээгүй



гарзыг мөн цэвэрлэнэ. Шаардлагатай тохиолдолд Группын баримталж буй бодлоготой нийцүүлэх үүднээс охин компаниудын нягтлан бодох бүртгэлийн бодлогыг өөрчилдөг.

2011 онд Банк нь Голомт Секюритиз ХХК-г үүсгэн байгуулсан. 2012 болон 2011 оны 12 сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн тайланд дараах охин компаниуд багтсан. Үүнд:

Охин компани	Бизнесийн үйл ажиллагаа	Эзэмшил, (%)	Нийт хөрөнгө оруулалт	
			2012/12/31	2011/12/31
			мян.төг	мян.төг
Голомт Секюритиз ХХК	Брокер, дилер	100 %	200,000	100,000

4. НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН ГОЛ БОДЛОГУУДЫН ХУРААНГУЙ

Групп болон Банкны нэгтгэсэн санхүүгийн тайлангуудыг бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн дараах гол бодлогуудыг баримталсан. Үүнд:

4.1 Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө

Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө нь нэг өдрийн дотор бэлэн мөнгөнд хөрвөх чадвартай байх ба бэлэн мөнгө, Группын харилцах дансдын үлдэгдэл, овернайт хадгаламж, бусад арилжааны банкуудад байршуулсан хадгаламж болон брокерийн дансны бэлэн мөнгөнөөс бүрдэнэ. Банк хоорондын богино хугацаат бүхий л мөнгөн хөрөнгүүд нь (1 хоногийн хугацаат хадгаламжаас бусад) бусад арилжааны банкуудад байршуулсан мөнгөн хөрөнгөнд багтана. Хязгаарлагдмал шинж чанар бүхий санхүүжилттэй холбоотой дүнгүүд нь мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгөд орохгүй. Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгөд Төв Банкинд байршуулсан заавал байлгах нөөцийн үлдэгдлийг оруулахгүй.

4.2 Монгол Улсын Төв Банкинд байршуулсан заавал байлгах нөөц

Монгол Улсын Төв Банкинд байршуулсан заавал байлгах нөөцийн үлдэгдэл гэж Группын өдөр тутмын үйл ажиллагааг санхүүжүүлэх боломжгүй, Төв Банкинд байршуулсан нөөцийн дансыг хэлнэ. Энэхүү нөөцийн үлдэгдлийг мөнгөн гүйлгээний тайлангийн зорилгоор мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгөд оруулахгүй.

4.3 Санхүүгийн хөрөнгүүд

Групп нь санхүүгийн хөрөнгүүдээ дараах байдлаар ангилна:

- Бодит үнэ цэнийн өөрчлөлтийг орлого, зардлаар хүлээн зөвшөөрөх санхүүгийн хөрөнгө оруулалт;
- Зээл ба авлага (энэ ангилалд харилцагчдад олгосон зээлүүд багтана);
- Дуусгавар хугацаа хүртэл нь эзэмших хөрөнгө оруулалтууд;
- Борлуулах зориулалттай санхүүгийн хөрөнгүүд.

Групп санхүүгийн хөрөнгүүдийн ангиллыг анхдагч хүлээн зөвшөөрөлтөөр тодорхойлдог. Анхдагч хүлээн зөвшөөрөлтөөрх санхүүгийн хөрөнгүүдийн ангилал нь тэдгээрийг олж эзэмших болсон зорилго болон тэдгээрийн шинж чанараас хамаарна.

(i) Санхүүгийн хөрөнгийн анхдагч хүлээн зөвшөөрөлт

Групп нь санхүүгийн хэрэглүүрийн гэрээт үүргийн нэг тал болох үед санхүүгийн байдлын тайландаа санхүүгийн хөрөнгө болон өр төлбөрүүдийг хүлээн зөвшөөрнө. Санхүүгийн хөрөнгө болон өр төлбөрийн энгийн худалдан авалт, борлуулалтыг төлбөр хийгдэх өдрийг ашиглан хүлээн зөвшөөрнө. Ашиг, алдагдлаар дамжсан бодит үнэ цэнээрх санхүүгийн хөрөнгөөс бусад бүх санхүүгийн хөрөнгүүдийг бодит үнэ цэнэ дээр нь санхүүгийн хөрөнгийг олж эзэмших, гаргахтай шууд холбогдон гарсан гүйлгээний өртгийг нэмсэн дүнгээр анх хүлээн зөвшөөрнө.

(ii) Бодит үнэ цэнийн хэмжилт

Тайлант хугацааны эцэст идэвхтэй зах зээл дээр арилжаалагдаж буй санхүүгийн хэрэгслүүдийн бодит үнэ цэнийг тухайн зах зээлийн эсвэл арилжааны жишиг үнэ (гүйлгээний өртгийн хамт)-д суурилан тодорхойлно. Хэрэв зах зээлийн жишиг үнэ мэдэгдэхгүй бол санхүүгийн хөрөнгө болон өр төлбөрийг бодит цэнээр нь санхүүгийн байдлын тайланд бүртгэхдээ ижил төстэй санхүүгийн хэрэглүүрийн зах зээлийн жишиг үнэд суурилж эсвэл математик загвар зэрэг олон төрлийн үнэлгээний арга ашиглан тооцно. Тэдгээр үнэлгээний загваруудад ашиглагдах өгөгдлүүд нь олж болохуйц зах зээлийн мэдээлэл эсвэл шийдэлд суурилна. Энэхүү шийдэл нь мөнгөний цаг хугацааны үнэ цэнэ, зээлийн эрсдэлийн түвшин, хэрэглүүрийн хувьсагч, зах зээлийн эрсдэлийн түвшин болон бусад холбогдох хүчин зүйлсэд үндэслэгдэнэ.



ГОЛОМТ БАНК БОЛОН ТҮҮНИЙ ОХИН КОМПАНИ

4. НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН ГОЛ БОДЛОГУУДЫН ХУРААНГУЙ (үргэлжлэл)

4.3 Санхүүгийн хөрөнгө (үргэлжлэл)

(iii) Санхүүгийн хэрэгслийн хорогдуулсан өртөг

Санхүүгийн хөрөнгө эсвэл өр төлбөрийн хорогдуулсан өртөг гэж тэдгээрийн анхдагч хүлээн зөвшөөрөлтөөр хэмжигдсэн дүнгээс үндсэн дүнгийн эргэн төлөлтийг хасч, анхны дүн болон дуусгавар хугацааны дүнгийн аливаа зөрүүний үр ашигт хүүгийн арга ашиглан тооцсон хуримтлагдсан хорогдуулгыг нэмж эсвэл хасаад, үнэ цэнийн бууралт эсвэл эргэн цугларахгүй аливаа суутгал (шууд эсвэл нөөцийн данс ашиглан)-ыг хассан дүн байна

Үр ашигт хүүгийн арга нь санхүүгийн хөрөнгө, өр төлбөрийн (эсвэл бүлэг санхүүгийн хөрөнгө, өр төлбөр) хорогдуулсан өртгийг тооцох, хамаарах хугацааны хүүгийн орлого болон хүүгийн зардлыг хуваарилах арга юм. Үр ашигт хүүгийн түвшин нь тооцоолсон ирээдүйн мөнгөн төлбөрүүд эсвэл хүлээн авах дүнгүүдийг санхүүгийн хэрэгслүүдийн хүлээгдэж буй хугацаанд нь эсвэл санхүүгийн хөрөнгө, өр төлбөрийн дансны цэвэр дүн хүртэлх богино хугацаанд нь яг зөв дүнгээр хорогдуулж буй түвшинг хэлнэ. Групп үр ашигт хүүгийн түвшин тооцохдоо санхүүгийн хэрэгслүүдийн (тухайлбал, урьчилгаа төлбөр, дуудах опцион болон төстэй опционууд) бүх гэрээт нөхцлүүдийг хамарсан мөнгөн урсгалыг тооцоолох ба ирээдүйн алдагдлыг харгалзан үзэхгүй. Тооцоололд гэрээний талуудын хооронд үр ашигт хүүгийн түвшин, ажил гүйлгээний өртөг, бусад бүх урамшуулал, хөнгөлөлттэй салшгүй холбоотой төлсөн эсвэл хүлээн авсан бүх төлбөрүүд багтана. Энд ижил төстэй бүлэг санхүүгийн хэрэгслүүдийн мөнгөн урсгал болон хүлээгдэж буй хугацааг найдвартай тооцож болно гэж таамаглана. Гэсэн хэдий ч санхүүгийн хэрэгсэл (эсвэл бүлэг санхүүгийн хэрэгслүүд)-ийн мөнгөн урсгал, хүлээгдэж буй хугацааг найдвартай тооцоолох боломжгүй тэдгээр ховор тохиолдлуудад Групп санхүүгийн хэрэгсэл (эсвэл бүлэг санхүүгийн хэрэгслүүд)-ийн иж бүрэн гэрээний нөхцлийн хүрээн дэх гэрээт мөнгөн урсгалыг ашиглана.

(iv) Санхүүгийн хөрөнгийн үл хүлээн зөвшөөрөлт

Санхүүгийн хөрөнгө (эсвэл санхүүгийн хөрөнгийн нэг хэсэг эсвэл ижил төстэй санхүүгийн хөрөнгүүдийн бүлэг)-ийг дараах тохиолдлуудад үл хүлээн зөвшөөрнө:

- Хөрөнгөөс орох мөнгөн урсгалыг хүлээн авах эрх дуусвар болсон бол;
- Групп хөрөнгөөс мөнгө хүлээн авах эрхээ шилжүүлсэн эсвэл уг эрх нь байгаа боловч тэдгээрийг хугацаа алдалгүйгээр гуравдагч талд бүхэлд нь төлөх үүргийг хүлээж байгаа бол;
- Групп хөрөнгийн эрсдэл, өгөөжийг бүхэлд нь шилжүүлсэн эсвэл хөрөнгийн эрсдэл, өгөөжийг бүхэлд нь шилжүүлээгүй бөгөөд хадгалсан хэвээр боловч хөрөнгийн хяналтаа шилжүүлсэн. Хэрэв хүлээн авагч тал нь хөрөнгийг холбоогүй гуравдагч талд шилжүүлэгт нэмэлт хязгаарлалт ногдуулалгүйгээр бүхэлд нь худалдан борлуулах туршлагагүй бол аж ахуйн нэгжид хяналт хадгалагдан үлдэнэ.

Групп нь хөрөнгөөс орох мөнгөн урсгалыг хүлээн авах эрхээ шилжүүлсэн, хөрөнгөтэй холбоотой бүх эрсдэл болон өгөөжийг иж бүрэн шилжүүлээгүй бөгөөд хадгалж үлдээгүй, хөрөнгийн хяналтыг шилжүүлээгүй тохиолдолд Группын хөрөнгийг эзэмших хугацааны турш хөрөнгө хүлээн зөвшөөрөгдөнө. Шилжүүлсэн хөрөнгөнд гаргасан баталгааны хэлбэрээр оролцоогоо хадгалж буй бол хөрөнгийг анхны дансны үнэ болон Группын төлөх шаардлагатай хамгийн их дүнгийн аль багаар хэмжинэ.

(v) Санхүүгийн хөрөнгийн дахин ангилал

Групп нь үүсмэл санхүүгийн хэрэгслийг эзэмшиж эсвэл гаргахдаа ашиг, алдагдлаар дамжсан бодит үнэ цэнээр анх хүлээн зөвшөөрч ангилсан бол тэдгээр ашиг, алдагдлаар дамжсан бодит үнэ цэнээрх санхүүгийн хэрэгслийг дахин ангилахгүй.

Хэрэв Групп борлуулах зориулалттай санхүүгийн хөрөнгүүдийн талаар эерэг таамаглалтай бөгөөд ойрын ирээдүй эсвэл дуусгавар хугацаа хүртэл нь эзэмших боломжтой бол эдгээр хөрөнгийг зээл болон авлагаар дахин ангилж болно. Хэрэв санхүүгийн хөрөнгүүдийг зээл ба авлага эсвэл дуусгавар хугацаа хүртэл нь эзэмших хөрөнгө оруулалт гэж дахин ангилсан бол дахин ангиллын өдрөөрх бодит үнэ цэнэ нь эдгээр санхүүгийн хөрөнгүүдийн шинэ өртөг болно. Дараа үед эдгээр хөрөнгүүдийг үр ашигт хүүгийн арга ашиглан хорогдуулсан өртгөөр хэмжинэ.

Таамаглал эсвэл боломжийн өөрчлөлтийн үр дүнд хэрэв дуусгавар хугацаа хүртэл нь эзэмших хөрөнгө оруулалт гэж ангилах нь тохиромжгүй болвол үүнийг борлуулах зориулалттай санхүүгийн хөрөнгө гэж дахин ангилан, бодит үнэ цэнээр нь дахин хэмжинэ. Борлуулах зориулалттай санхүүгийн хөрөнгийн бодит үнэ цэнийн өөрчлөлтөөс үүссэн хэрэгжээгүй олз, гарзыг дэлгэрэнгүй орлогын тайланд бусад дэлгэрэнгүй орлогоор бүртгэнэ.

Тухайн тайлант жил эсвэл өмнөх хоёр тайлант жилүүдэд дуусгавар хугацаа хүртэл нь эзэмших хөрөнгө оруулалтын ялимгүй хэмжээнээс илүүг дуусгавар хугацаанаас нь өмнө (дуусгавар хугацаа хүртэл нь эзэмших хөрөнгө оруулалтын нийт дүнд ялимгүй хэмжээтэй дүнгээс илүү дүн) дараах тохиолдлуудаас бусад үед борлуулж эсвэл дахин ангилсан бол Групп ямар нэг санхүүгийн хөрөнгийг дуусгавар хугацаа хүртэл нь эзэмших хөрөнгө оруулалт гэж ангилж болохгүй:



- Дуусгавар хугацаа эсвэл хөрөнгийн дуудах өдөр болоход маш ойрхон (тухайлбал, дуусах хугацаа болоход гурван сараас бага хугацаа үлдсэн) зах зээлийн хүүгийн түвшний өөрчлөлт нь санхүүгийн хөрөнгийн бодит үнэ цэнэд материаллаг нөлөө үзүүлэхээргүй байвал;
- Аж ахуйн нэгж нь санхүүгийн хөрөнгийн анхны үндсэн төлбөрийг хуваарийн дагуу эсвэл урьдчилан бүхэлд нь цуглуулсны дараа тохиолдсон бол; эсвэл
- Аж ахуйн нэгжийн хяналтаас гадуур, үл тохиолдох бөгөөд аж ахуйн нэгж бодитоор урьдчилан таамаглах боломжгүй тусгаарлагдсан үйл явдалтай холбоотой бол.

Дуусгавар хугацаа хүртэл нь эзэмших хөрөнгө оруулалтын ялимгүй хэмжээнээс илүүг борлуулж эсвэл дахин ангилсан нь ангиллын аль ч нөхцлийг хангаж чадахгүй бол, дуусгавар хугацаа хүртэл нь эзэмших хөрөнгө оруулалтын аливаа үлдэх бүх хэсгийг борлуулах зориулалттай гэж дахин ангилна.

(vi) Бодит үнэ цэнийн өөрчлөлтийг орлого, зардлаар хүлээн зөвшөөрөх санхүүгийн хөрөнгө

Бодит үнэ цэнийн өөрчлөлтийг орлого, зардлаар хүлээн зөвшөөрөх санхүүгийн хөрөнгөнд арилжааны үнэт цаас болон бусад ашиг, алдагдлаар дамжсан бодит үнэ цэнээрх санхүүгийн хөрөнгүүд багтана.

Арилжааны үнэт цаас нь үнийн эсвэл арилжаалагчийн ашгийн түвшний богино хугацааны хэлбэлзлээс ашиг хүртэх зорилгоор олж эзэмшсэн үнэт цаас эсвэл богино хугацааны арилжааны загвар оршин буй тохиолдолд багцад багтсан үнэт цааснуудыг илэрхийлнэ. Групп нь үнэт цаасыг худалдан авснаас хойш богино хугацааны дотор борлуулахаар зорьж байвал арилжааны үнэт цаас гэж ангилна. Арилжааны үнэт цаасыг ойрын хугацаанд тохиолдох магадлал маш өндөр, ер бусын, маш тодорхойгүй нэг үйл явдлаас үүссэн ховор тохиолдлоос бусад үед дахин ангилахгүй.

Арилжааны үнэт цаасыг бодит үнэ цэнээр нь хүлээн зөвшөөрнө. Арилжааны үнэт цааснаас олсон хүүг нэгтгэсэн орлогын тайланд хүүгийн орлогоор тусгана. Ногдол ашгийг Групп авах эрх нь үүссэн бөгөөд хүлээн авах нь тодорхой үед нэгтгэсэн орлогын тайланд хүлээн авсан ногдол ашгаар хүлээн зөвшөөрнө. Бодит үнийн цэнийн өөрчлөлт болон үл хүлээн зөвшөөрөлтөөс үүссэн олз, гарзын бусад бүх элементүүдийг үүссэн тайлант үед нь нэгтгэсэн орлогын тайланд ашиг, алдагдлаар дамжсан бодит үнэ цэнээрх санхүүгийн хөрөнгөөс үүссэн олзоос хасах нь гарз гэж бүртгэнэ.

Хэйджид зориулагдсан үүсмэл хэрэглүүрээс бусад бодит үнэ цэнэ бүхий фючерс, валют солилцооны гэрээ болон хүүгийн түвшний своп солилцоо зэрэг Үүсмэл санхүүгийн хэрэгслүүдийг санхүүгийн байдлын тайланд анх өртгөөр (ажил гүйлгээний өртгийг багтаана) нь бусад хөрөнгөөр хүлээн зөвшөөрч, бүртгэх ба дараа үеүдэд тэдгээрийн бодит үнэ цэнээр дахин хэмжинэ. Бодит үнэ цэнийг зах зээлийн жишиг үнэ эсвэл ажил гүйлгээний төрлөөс хамааран жилийн эцэс дэх спот ханш ашиглан гаргана.

Үүсмэл санхүүгийн хэрэгслүүдийн бодит үнэ цэнийн өөрчлөлтийг ашиг, алдагдлаар дамжсан бодит үнэ цэнээрх санхүүгийн хөрөнгөөс үүссэн гарзыг хассан олз эсвэл ажил гүйлгээний төрлөөс хамаарч гадаад валютын эсвэл үнэт металын арилжаанаас үүссэн гарзыг хассан олзод бүртгэнэ.

Ашиг, алдагдлаар дамжсан бодит үнэ цэнээрх бусад санхүүгийн хөрөнгөд дараах шалгууруудын аль нэгийг хангаж энэ ангилалд анх ангилагдсан үнэт цаасууд багтана:

- өөр өөр суурь ашиглан Хөрөнгийг хэмжих, олз гарзыг хүлээн зөвшөөрөхөөс үүдэн бий болж болох тогтвортой бус хандлагыг бууруулах буюу үгүй болгох зорилгыг агуулдаг; эсвэл
- баримтжуулсан эрсдэлийн удирдлагын болон хөрөнгө оруулалтын стратеги, мэдээллийн дагуу бүлэг санхүүгийн хөрөнгө болон/эсвэл санхүүгийн өр төлбөрийг удирдаж, үүний гүйцэтгэлийг бодит үнэ цэнийн сууриар хэмжих ба энэхүү суурийн талаарх мэдээллийг Группын удирдлага энгийнээр тодруулж, шалгадаг.

Энэхүү ангилалд тодорхойлогдсон санхүүгийн хөрөнгүүдийн хүлээн зөвшөөрөлт ба хэмжилт нь дээр дурдсан арилжааны үнэт цаастай холбоотой нягтлан бодох бүртгэлийн бодлогод нийцсэн байна.

4.4 Бусад банкуудаас авах авлага

Бизнесийн хэвийн үйл ажиллагааны явцад Групп нь бусад банкуудад янз бүрийн хугацаагаар хөрөнгө байршуулдаг. Тогтоосон дуусгавар болох хугацаатай бусад банкуудаас авах авлагыг нэн даруй эсвэл богино хугацаанд арилжаалахыг зорьдоггүй ба үр ашигт хүүгийн арга ашиглан хорогдуулсан өртгөөр нь хэмжинэ. Тогтоосон хугацаагүй авлагыг таамаглаж буй дуусгавар болох хугацаанд суурилан тооцож хорогдуулсан өртгөөр бүртгэнэ. Бусад банкинд байршуулсан харилцах, хадгаламж нь үнэ цэнийн бууралтыг хассан дүнгээр тайлагнадаг.



ГОЛОМТ БАНК БОЛОН ТҮҮНИЙ ОХИН КОМПАНИ

4. НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН ГОЛ БОДЛОГУУДЫН ХУРААНГУЙ (үргэлжлэл)

4.5 Харилцагчдад олгосон зээл

Энэ ангилалд идэвхтэй зах зээл дээр арилжаалагдаггүй тогтмол эсвэл тодорхойлж болох төлбөрүүд бүхий дараахаас бусад үүсмэл бус санхүүгийн хөрөнгүүд багтана:

- арилжаалагдах зориулалтаар эзэмшиж буй гэж ангилагдах нэн даруй эсвэл ойрын хугацаанд борлуулахаар зорьж буй бөгөөд анхдагч хүлээн зөвшөөрөлтийн хүрээнд ашиг, алдагдлаар дамжсан бодит үнэ цэнээр илэрхийлэгдсэн хөрөнгүүд;
- анхдагч хүлээн зөвшөөрөлтийн хүрээнд борлуулах зориулалттай гэж тодорхойлсон хөрөнгүүд;
- борлуулах зориулалттай гэж ангилагдах чанар муудсан зээлээс бусад анхны хөрөнгө оруулалтаа эргэн нөхөх боломжгүй тэдгээр хөрөнгүүд.

Харилцагчдад олгосон зээлийг анх өртгөөр нь буюу харгалзан үзэх зүйлсийн бодит үнэ цэнээр нь бүртгэнэ. Дараа үед тэдгээрийг үр ашигт хүүгийн арга ашиглан хорогдуулсан өртгөөс зээлд байгуулсан нөөцийг хассан дүн байна. Харилцагчдад олгосон зээлийг зээлдэгчдэд мөнгөөр урьдчилан олгосон үед бүртгэнэ.

Зах зээлийн хүүгийн түвшнээс ялгаатай хүүгийн түвшинд харилцагчдад олгосон зээлийг ижил төрлийн зээлийн зах зээлийн хүүгийн түвшнээр дискаунтласан ирээдүйн хүүгийн төлбөр болон үндсэн өрийн эргэн төлбөрийг ашиглан, олгосон тухайн үед нь бодит үнэ цэнээр хэмждэг. Зээл олгох үеийн бодит үнэ цэнэ болон нэрлэсэн үнийн зөрүү нь зах зээлийн хүүгээс илүү/дутуу түвшинд хөрөнгө гаргаснаас үүссэн олз ба гарзаар дэлгэрэнгүй орлогын тайланд тайлагнадаг. Дараах үеүдэд ийм зээлийн дансны үнэ нь гаргасан зээлийн олз ба гарзын хорогдуулалтаар тохируулагдан холбогдох олз ба гарз нь үр ашигт хүүгийн аргаар дэлгэрэнгүй орлогын тайланд бүртгэгддэг.

4.6 Дуусгавар хугацаа хүртэл нь эзэмших хөрөнгө оруулалт

Санхүүгийн хөрөнгийн энэ ангилал нь тогтмол буюу тодорхойлж болох төлбөрүүд бүхий, дуусгавар болох хугацаа хүртэл нь эзэмшинэ гэсэн эерэг төсөөлөл болон боломж бүхий тогтоосон хугацаатай үүсмэл бус санхүүгийн хөрөнгүүдийг илэрхийлнэ. Группын удирдлага нь худалдан авах үедээ санхүүгийн хөрөнгүүдийн зохистой ангиллыг тодорхойлдог.

Санхүүгийн хөрөнгийг анх хүлээн зөвшөөрөх үед болон тайлант хугацаа бүрийн эцэст Групп нь санхүүгийн хөрөнгийг дуусгавар хугацаа хүртэл нь эзэмших зорилго ба боломж байгаа эсэхийг үнэлнэ. Дуусгавар хугацаа хүртэл нь эзэмших хөрөнгө оруулалтыг анх бодит үнэ цэнээр (ажил гүйлгээний өртгийг багтаасан) нь бүртгэх ба дараа үед хорогдуулсан өртгөөр нь бүртгэнэ. Дуусгавар хугацаа хүртэл нь эзэмших хөрөнгө оруулалтын олз, гарзыг тухайн хөрөнгийн үнэ цэнэ нь буурсан үед нь болон хорогдуулах үйл явцын туршид дэлгэрэнгүй орлогын тайланд хүлээн зөвшөөрнө.

Хэрэв Групп дуусгавар хугацаа хүртэл нь эзэмших хөрөнгө оруулалтын багцын нөлөө бүхий хэсгийг хугацаанаас нь өмнө борлуулвал энэхүү ангиллын үлдэх санхүүгийн хөрөнгүүдийг борлуулах зориулалттай санхүүгийн хөрөнгөөр дахин ангилна.

Дуусгавар хугацаа хүртэл нь эзэмших хөрөнгө оруулалтаас бий болсон хүүг дэлгэрэнгүй орлогын тайланд хүүгийн орлогоор хүлээн зөвшөөрнө.

4.7 Борлуулахад бэлэн санхүүгийн хөрөнгө

Борлуулахад бэлэн санхүүгийн хөрөнгүүд нь үүсмэл бус санхүүгийн хөрөнгө болох ба дээрх ангиллуудын алинд нь ч орохгүй.

Борлуулахад бэлэн санхүүгийн хөрөнгийг анх бодит үнэ цэнэ дээр санхүүгийн хөрөнгийг худалдан авах эсвэл гаргахтай шууд холбоотой гарсан ажил гүйлгээний өртгийг нэмсэн дүнгээр хүлээн зөвшөөрнө. Дараа үеүдэд борлуулахад бэлэн санхүүгийн хөрөнгийг зах зээл дээрх үнэнд үндэслэн бодит үнэ цэнээр нь дахин хэмжинэ. Тусдаа зах зээлийн жишиг үнэгүй борлуулахад бэлэн санхүүгийн тухайлсан хөрөнгүүдийг ижил төрлийн санхүүгийн хөрөнгийг холбоотой бус гуравдагч этгээдэд худалдсан сүүлийн үеийн арилжааны үр дүнд эсвэл үнэт цаасны ангилал тус бүрийн худалдан авах/худалдах мэдээллийн агентлаг болон үнэт цаасны зах зээлийн мэргэжлийн оролцогчийн нийтэд хэвлэсэн тодорхой үнэнд үндэслэн Группын удирдлага үнэлнэ. Идэвхитэй зах зээл байхгүй бөгөөд итгэж болохуйц аргыг ашиглан өмчийн үнэт цаасны бодит үнэ цэнийг тодорхойлох боломжгүй тохиолдолд хөрөнгө оруулалтыг худалдан авсан өртгөөр нь бүртгэнэ.

Борлуулахад бэлэн санхүүгийн хөрөнгийн бодит үнэ цэнийн өөрчлөлтөөс үүссэн хэрэгжээгүй олз, гарзыг дэлгэрэнгүй орлогын тайланд бусад дэлгэрэнгүй орлогоор хүлээн зөвшөөрнө. Борлуулахад бэлэн санхүүгийн хөрөнгийг борлуулах үед өмнө нь бусад дэлгэрэнгүй орлогоор хүлээн зөвшөөрөгдсөн хуримтлагдсан хэрэгжээгүй олз, гарзыг дэлгэрэнгүй орлогын тайланд борлуулахад бэлэн санхүүгийн хөрөнгөөс үүссэн олзоос хасах нь гарз гэж дахин ангилна. Борлуулахад бэлэн санхүүгийн хөрөнгийн борлуулалтыг ЭАЭЗ аргыг ашиглан бүртгэнэ.



Борлуулах зориулалттай өрийн үнэт цааснаас бий болох хүүг үр ашигт хүүгийн арга ашиглан тодорхойлох ба дэлгэрэнгүй орлогын тайланд хүүгийн орлогоор тусгана. Борлуулах зориулалттай өмчийн хөрөнгө оруулалтаас хүлээн авсан ногдол ашгийг Групп хүлээн авах эрх нь үүссэн бөгөөд авах нь тодорхой болсон үед дэлгэрэнгүй орлогын тайланд бүртгэнэ.

4.8 Худалдан авсан өрийн бичиг

Худалдан авсан өрийн бичиг нь тэдгээрийн эдийн засгийн мөн чанараас хамааран борлуулахад бэлэн санхүүгийн хөрөнгө, дуусгавар хугацаа хүртэл нь эзэмших хөрөнгө оруулалт, бусад банкнаас авах авлага эсвэл харилцагчдад олгосон зээлд багтах ба дараа үед хөрөнгийн эдгээр ангиллуудын нягтлан бодох бүртгэлийн бодлогын дагуу бүртгэнэ.

4.9 Санхүүгийн хөрөнгийн үнэ цэнийн бууралт

Групп нь санхүүгийн хөрөнгийн зүйл эсвэл бүлэг зүйлсийн үнэ цэнэ нь буурсан гэх бодит нотолгоо байгаа эсэхийг хаалтын өдрөөр үнэлнэ. Үнэ цэнийн бууралтын алдагдлыг хөрөнгийг ('алдагдлын үйл явдал') анх хүлээн зөвшөөрснөөс хойш тохиолдсон нэг буюу түүнээс дээш үйл явдлуудын үр дүнд үүссэн тухай бүрт нь дэлгэрэнгүй орлогын тайланд хүлээн зөвшөөрөх ба тэрхүү алдагдлын үйл явдал (эсвэл үйл явдлууд) нь найдвартай хэмжигдэх боломжтой санхүүгийн хөрөнгийн эсвэл бүлэг хөрөнгийн тооцоолсон ирээдүйн мөнгөн гүйлгээний дүн эсвэл хугацаанд нөлөөлнө. Хэрэв Групп тус бүртээ үнэлэгдсэн санхүүгийн хөрөнгөд үнэ цэнийн бууралт оршин байх бодит нотолгоо байхгүй гэж тодорхойлсон бол хөрөнгийг ижил төстэй өрийн эрсдэлийн үзүүлэлт бүхий санхүүгийн хөрөнгүүдийн бүлэгт багтааж, бүхэлд нь үнэ цэнийн бууралтыг үнэлнэ.

(i) Бусад банкинд байршуулсан хөрөнгө болон харилцагчдад олгосон зээлийн үнэ цэнийн бууралт

Хорогдуулсан өртгөөр хэмжигдсэн бусад банкуудаас авах авлага болон харилцагчдад олгосон зээлийн хувьд Групп дангаараа нөлөө бүхий санхүүгийн хөрөнгүүдэд тус бүрт нь эсвэл дангаараа нөлөө бүхий бус санхүүгийн хөрөнгүүдэд бүхэлд нь үнэ цэнийн бууралт байгаа гэх бодитой нотолгоо байгаа эсэхийг эхлээд үнэлнэ.

Бусад банкуудаас авах авлага болон харилцагчдад олгосон зээлийн үнэ цэнэ буурсан гэх бодитой нотолгоонд тусдаа нөлөө бүхий санхүүгийн хөрөнгөтэй холбоотой дараах үйл явдлуудын талаар олж авсан мэдээлэл багтана:

- төлбөрийн хугацаа хэтрэлт;
- Группд мэдэгдсэнээр зээлдэгч санхүүгийн нөлөө бүхий хүндрэлд орох;
- зээлдэгч дампуурах эсвэл санхүүгийн бусад дахин зохион байгуулалтын хэлбэрт орох нь магадлалтай болох;
- үндэсний эсвэл дотоодын эдийн засгийн орчин муудах нь зээлдэгчид нөлөөлөх;
- хүүгийн болон үндсэн өрийн хугацаа хэтрэлт буюу удаашрал гэх мэт гэрээний заалт зөрчих;
- зээлдэгчийн санхүүгийн хүндрэлтэй холбоотой эдийн засгийн эсвэл эрх зүйн шалтгаанаар зээлдүүлэгч нь авч үзэхээргүй хөнгөлөлтийг зээлдэгчид зээлдүүлэгч нь олгох.

Тус бүрт нь үнэ цэнийн бууралтыг үнэлсэн бөгөөд үнэ цэнийн алдагдлыг хүлээн зөвшөөрсөн хөрөнгүүдийг үнэ цэнийг бууралтыг бүлгийн үнэлгээнд хамруулахгүй. Хэрэв дангаар нь үнэлсэн санхүүгийн хөрөнгөд үнэ цэнийн бууралт бий гэх бодитой нотолгоо байхгүй гэж Групп тодорхойлбол тухайн хөрөнгийг ижил төстэй өрийн эрсдэлийн шинж чанартай санхүүгийн хөрөнгийн бүлэгт оруулж, үнэ цэнийн бууралтыг бүлгээр нь үнэлнэ.

Үнэ цэнийн бууралтыг бүлгээр нь үнэлэх зорилгоор санхүүгийн хөрөнгүүдийг ижил төстэй зээлийн эрсдэлд тухайлбал, хөрөнгийн төрөл, салбар, барьцааны төрөл, төлбөрийн байдал болон бусад хүчин зүйлсэд нь суурилан бүлэглэнэ. Сонгосон шинж чанарууд нь үнэлэгдэж буй хөрөнгүүдийн гэрээний нөхцлүүдийн дагуу зээлдэгчийн төлбөр барагдуулах чадварыг харуулахуйц хөрөнгүүдийн бүлгийн ирээдүйн мөнгөн урсгалын тооцоололд хамааралтай.

Бүлгээр нь хэмжсэн санхүүгийн хөрөнгийг харуулах бусад банкуудаас авах авлага болон харилцагчдад олгосон зээлийн үнэ цэнийн бууралтаас үүсэх гарзын бодитой нотолгоог тодорхойлоход ашиглагдах гол шалгуур нь тэдгээр хөрөнгүүдийн анхдагч хүлээн зөвшөөрөлтөөс хойш санхүүгийн бүлэг хөрөнгөөс бий болохоор тооцсон ирээдүйн мөнгөн урсгал дахь хэмжигдэхүйц бууралтыг илэрхийлэх мэдээллийн нээлттэй байдал, мөн бүлэг санхүүгийн хөрөнгөд дангаараа байгаа санхүүгийн хөрөнгөд бууралтыг тодорхойлж чадахгүй байх явдал юм. Ийм мэдээллүүдэд бүлэгт багтсан зээлдэгчдийн төлбөрийн байдал дахь сөрөг өөрчлөлт (жишээлбэл, төлбөрийг хугацаа хоцроосон тохиолдлууд нэмэгдэх, зээлийн хязгаартаа хүрсэн бөгөөд сар бүрийн хамгийн бага төлбөрийг төлж буй зээлийн картын зээлдэгчийн тоо ихсэх), бүлэг дэх хөрөнгийн хугацаа хэтрэлттэй хамааралтай үндэсний буюу дотоодын эдийн засгийн нөхцөл байдал (жишээлбэл, зээлдэгчийн газарзүйн бүс нутаг дахь ажилгүйдлийн түвшин ихсэх, холбогдох бүс нутаг дахь моргейжийн үл хөдлөх хөрөнгийн үнийн бууралт, газрын тосны үйлдвэрлэгчид олгосон зээлийн хувьд газрын тосны үнийн бууралт, эсвэл бүлэг дэх зээлдэгчид үзүүлж болох салбарын нөхцлийн сөрөг өөрчлөлт) зэрэг нь багтана.



4. НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН ГОЛ БОДЛОГУУДЫН ХУРААНГУЙ (үргэлжлэл)

4.9 Санхүүгийн хөрөнгийн үнэ цэнийн бууралт (үргэлжлэл)

(i) Бусад банкинд байршуулсан хөрөнгө болон харилцагчдад олгосон зээлийн үнэ цэнийн бууралт

Хэрэв үнэ цэнийн бууралт байгаа гэх бодитой нотолгоо байвал гарзын хэмжээг хөрөнгийн дансны үнэ болон хүлээгдэж буй ирээдүйн мөнгөн урсгалуудын өнөөгийн үнэ цэнийн зөрүүгээр хэмжинэ. Хөрөнгийн дансны үнийг үнэ цэнийн бууралтын нөөцийн дансыг ашиглан бууруулах ба гарзын дүнг дэлгэрэнгүй орлогын тайланд хүлээн зөвшөөрнө.

Өнөөгийн үнэ цэнийг тодорхойлоход тооцоолсон ирээдүйн мөнгөн гүйлгээг санхүүгийн хөрөнгийн бодит хүчин төгөлдөр хүүгийн түвшнээр хөнгөлнө (дискаунтчилна). Хэрэв зээл нь хувьсах хүүтэй бол үнэ цэнийн бууралтын гарзыг хэмжих дискаунтын түвшин нь тухайн үеийн хүчин төгөлдөр хүүгийн түвшин байна. Барьцаалагдсан санхүүгийн хөрөнгийн тооцоолсон мөнгөн урсгалын өнөөгийн үнэ цэнийн тооцоолол нь барьцааны зүйлийг худалдан авах эрхээс барьцааг олж авах болон борлуулахад гарсан зардлыг хассанаас үүсэх мөнгөн гүйлгээнд үндэслэгдэнэ.

Үнэ цэнийн бууралтыг нь бүлгээр үнэлсэн бүлэг зээлийн ирээдүйн мөнгөн урсгалыг тухайн бүлэг дэх зээлүүдтэй зээлийн эрсдэлийн ижил шинж чанартай зээлийн алдагдлын түүхэн мэдээлэлд үндэслэн эсвэл хугацаа хэтэрсэн зээлийг цуглуулахтай холбоотой түүхэн мэдээлэлд үндэслэн тооцно. Алдагдлын түүхэн туршлагыг суурь болгон авсан хугацаанд нөлөө үзүүлэхгүй өнөөгийн нөхцөл байдлын үр нөлөөллийг тусгах болон одоо оршин байгаа бус түүхэн хугацааны нөхцөл байдлын үр нөлөөг арилгахын тулд өнөөгийн ашиглаж болохуйц мэдээлэлд суурилан алдагдлын түүхэн мэдээллийг тохируулдаг. Хугацаа тус бүрийн холбогдох ашиглаж болохуйц мэдээлэл дэх өөрчлөлтийг ирээдүйн мөнгөн гүйлгээний өөрчлөлтийн тооцоололд тусгадаг бөгөөд тэрхүү өөрчлөлттэй (ажилгүйдлийн түвшин, үл хөдлөх хөрөнгийн үнэ, өргөн хэрэглээний барааны үнэ, төлбөрийн чадвар болон бүлгийн хувьд алдагдалд хүргэж болох шинж тэмдгийг илэрхийлэх бусад хүчин зүйл дэх өөрчлөлт ба тэдгээрийн хэмжээ) нийцсэн байдаг. Ирээдүйн мөнгөн урсгалыг тооцоолоход ашигласан арга зүй болон төсөөлөл нь алдагдлын тооцоолол болон алдагдлын түүхэн туршлагын хоорондох зөрүүг бууруулахын тулд тогтмол хугацаагаар шалгагддаг.

Дараагийн үед хэрэв үнэ цэнийн бууралтын гарзын дүн буурч, тэрхүү бууралт нь үнэ цэнийн бууралтыг хүлээн зөвшөөрснөөс хойш (тухайлбал зээлдэгчийн зээлийн түвшний өсөлт) тохиолдсон нь баттай бол өмнө нь хүлээн зөвшөөрсөн үнэ цэнийн бууралтын гарзыг хасагдуулгын дансыг залруулах замаар дэлгэрэнгүй орлогын тайланд буцаана.

Эргэн цугларахгүй хөрөнгүүдийг бүхэлд нь эсвэл хэсэгчлэн эргэн нөхөх шаардлагатай бүх горимуудыг гүйцэтгэсний дараа үнэ цэнийн бууралтад байгуулсан нөөц рүү хааж, гарзын эцсийн дүнг тодорхойлно. Үнэ цэнэ нь буурсан санхүүгийн хөрөнгийн дансны үнийг шууд хасч болохгүй.

Монгол улсын хууль дүрмийн дагуу эргэн цугларахгүй зээл болон холбогдох хүүг данснаас хасах тохиолдолд Групп энэхүү үлдэгдэл зээлийг цуглуулахын тулд шаардлагатай бөгөөд тохиромжтой алхмуудыг хуульд шаардсаны дагуу, бизнесийн жишиг туршлагаар эсвэл гэрээгээр хийнэ.

(ii) Дуусгавар хугацаа хүртэл нь эзэмших хөрөнгө оруулалтын үнэ цэнийн бууралт

Групп дуусгавар хугацаа хүртэл нь эзэмших хөрөнгө оруулалтад үнэ цэнийн бууралтын бодит нотолгоо байгаа эсэхийг дангаар нь үнэлнэ. Хэрэв үнэ цэнийн бууралтын гарз байгаа гэх бодит нотолгоо байвал гарзын дүнг хөрөнгийн дансны үнэ болон тооцон ирээдүйн мөнгөн гүйлгээний өнөөгийн үнэ цэнийн зөрүүгээр хэмжинэ. Хөрөнгийн дансны үнийг бууруулж, гарзын дүнг дэлгэрэнгүй орлогын тайланд хүлээн зөвшөөрнө. Хэрэв дараагийн жилд үнэ цэнийн бууралтын гарз буурч, бууралт нь үнэ цэнийн бууралтыг хүлээн зөвшөөрснөөс хойш тохиолдсон нь бодитой бол өмнө нь хүлээн зөвшөөрсөн үнэ цэнийн бууралтын гарзыг дэлгэрэнгүй орлогын тайланд орлогоор хүлээн зөвшөөрнө.

(iii) Борлуулахад бэлэн санхүүгийн хөрөнгийн үнэ цэнийн бууралт

Групп борлуулах зориулалттай санхүүгийн хөрөнгө оруулалт эсвэл бүлэг хөрөнгө оруулалтын үнэ цэнэ буурсан гэх бодит нотолгоо байгаа эсэхийг тайлант хугацаа бүрийн эцэст үнэлнэ.

Өмчийн хөрөнгө оруулалтыг борлуулах зориулалттай гэж ангилсан үед үнэ цэнийн бууралтын бодит нотолгоонд тухайн санхүүгийн хөрөнгө гаргагчийн нээлттэй мэдээллээр баталгаажсан нөлөө бүхий санхүүгийн бэрхшээлийг багтаана. Үнэ цэнийн бууралтын аливаа шинж тэмдэг байгаа эсэхийг үнэлэхдээ Групп санхүүгийн хөрөнгө гаргагчийн эдийн засгийн хүчин зүйлс тухайлбал, гаргагч талын үйл ажиллагаа явуулж буй салбарын техникийн, зах зээлийн, эдийн засгийн, хуулийн орчин зэргийн нөлөөллийг харгалзан үйл ажиллагаанд нь шинжилгээ хийнэ. Мөн нэгж хувьцааны үнийн өөрчлөмтгий байдал зэрэг бусад хүчин зүйлсийг үнэлнэ.

Худалдан авалтын өртөг болон тайлант хугацааны бодит үнэ цэнийн зөрүүгээр хэмжигдсэн хуримтлагдсан гарзаас ашиг, алдагдлаар дамжуулан өмнө нь хүлээн зөвшөөрсөн хөрөнгийн үнэ цэнийн бууралтын аливаа гарзыг хассан дүнг бусад дэлгэрэнгүй орлогоос ашиг, алдагдлын данс руу шилжүүлнэ.



Өмчийн хэрэгслүүд дэх үнэ цэнийн бууралтын гарзыг ашиг, алдагдлын дансаар буцаахгүй: үнэ цэнийн бууралтын дараах бодит үнэ цэнийн өсөлтийг бусад дэлгэрэнгүй орлогод шууд бүртгэнэ.

Бодит үнэ цэнээр бүртгэсэн хаалттай өрийн хэрэгслүүдийг борлуулах зориулалттай гэж ангилсан тохиолдолд үнэ цэнийн бууралтыг хорогдуулсан өртгөөр нь бүртгэсэн санхүүгийн хөрөнгүүдтэй адил шалгуурт суурилан үнэлнэ. Хүүгийн орлогыг бууруулсан дансны үнэд суурилан, үнэ цэнийн бууралтын гарзыг хэмжих зорилгоор ирээдүйн мөнгөн урсгалыг дискаунтчилахад ашигласан хүүг ашиглан хуримтлуулна. Хүүгийн орлогыг дэлгэрэнгүй орлогын тайлан дахь хүүгийн орлогын хэсэгт бүртгэнэ.

Хэрэв дараагийн жилд өрийн хэрэглүүрийн бодит үнэ цэнэ өссөн бөгөөд тэрхүү өсөлт үнэ цэнийн бууралтыг дэлгэрэнгүй орлогын тайланд хүлээн зөвшөөрсний дараа тохиолдсон нь бодитой бол үнэ цэнийн бууралтын гарзыг буцааж, холбогдох сэргээх дүнг дэлгэрэнгүй орлогын тайланд бүртгэнэ.

4.10 Санхүүгийн өр төлбөр

Санхүүгийн өр төлбөрүүд нь ашиг, алдагдлаар дамжин бодит үнээр хэмжигдсэн санхүүгийн өр төлбөр болон хорогдуулсан өртгөөр хэмжигдэх санхүүгийн өр төлбөр гэж ангилагддаг.

Ашиг алдагдлаар дамжуулан бодит үнэ цэнээр хэмжихээс бусад санхүүгийн өр төлбөрийг анх бүртгэхдээ бодит үнэ цэнэ дээр тухайн санхүүгийн өр төлбөрийг гаргах буюу олж бэлтгэхтэй шууд холбоотой ажил гүйлгээний зардлуудыг нэмсэн дүнгээр хэмжинэ.

Тухайн өр төлбөртэй холбоотой үүрэг хариуцлага нь хангагдах, хүчингүй болох эсвэл дуусвар болох үед санхүүгийн өр төлбөрийг үл хүлээн зөвшөөрнө.

Санхүүгийн өр төлбөр нь өөр нөхцөл бүхий гэвч ижил зээлдүүлэгчээс авсан санхүүгийн өр төлбөрөөр сольсон тохиолдолд эсвэл тухайн өр төлбөрийн нөхцөл өөрчлөгдсөн тохиолдолд ийм төрлийн солилцоо болон өөрчлөлт нь анхны өр төлбөрийг үл хүлээн зөвшөөрч, өр төлбөрийг шинээр хүлээн зөвшөөрөхөд хүргэх бөгөөд дансны үнийн зөрүүг дэлгэрэнгүй орлогын тайланд хүлээн зөвшөөрнө.

4.11 Хорогдуулсан өртгөөр илэрхийлэгдсэн санхүүгийн өр төлбөр

Хорогдуулсан өртгөөр илэрхийлэгдсэн санхүүгийн өр төлбөр нь бусад банкнаас байршуулсан эх үүсвэр, харилцагчдын харилцах, хадгаламж, өрийн үнэт цаас болон бусад зээлийн эх үүсвэр зэргээс бүрдэнэ.

Бусад банкнаас байршуулсан эх үүсвэр. Бусад банкнуудаас мөнгө болон бусад хөрөнгийг урьдчилгаа болгон олгоход бусад банкнаас байршуулсан эх үүсвэрийг бүртгэдэг.

Харилцагчдын данс. Харилцагчдын харилцах, хадгаламж нь хувь хүмүүс, төрийн болон хувийн хэвшлийн харилцагчдад төлөх үүсмэл бус санхүүгийн өр төлбөрүүд юм.

Гаргасан өрийн үнэт цааснууд. Өрийн үнэт цааснууд нь Группын гаргасан өрийн бичгээс бүрдэнэ. Хэрэв Групп нь өөрийн гаргасан өрийн үнэт цаасыг худалдан авбал, санхүүгийн байдлын тайлангаас хасах бөгөөд өр төлбөрийн дансны үнэ болон төлсөн төлбөрийн дүнгийн зөрүү нь үйл ажиллагааны бусад орлогод өрийн бичгийг данснаас хассаны олзоор бүртгэгддэг.

Бусад зээлийн эх үүсвэр. Бусад зээлийн эх үүсвэр нь Группын хоёрдогч өглөгийг агуулах бөгөөд Групп нь мөнгөө хүлээн авах үед бүртгэгддэг.

4.12 Буцаан худалдан авах буюу урвуу буцаан худалдах авах гэрээ

Борлуулалт ба буцаан худалдан авах гэрээ ("репо" хэлцэл) нь барьцаат санхүүжилтийн ажил гүйлгээ гэж бүртгэгдэнэ. Борлуулалт ба буцаан худалдан авах гэрээний дагуу борлуулсан үнэт цаасыг үл хүлээн зөвшөөрөхгүй ба үнэт цаасыг дахин ангилахгүй. Холбогдох өр төлбөр нь бусад банкинд байршуулсан эх үүсвэр хэсэгт толилуулагддаг.

Дахин борлуулах гэрээний ("буцаах репо" хэлцэл) дагуу худалдан авсан үнэт цаас нь бусад банкнаас байршуулсан эх үүсвэр эсвэл харилцагчдад олгосон зээлийн аль тохиромжтойгоор нь бүртгэгддэг. Борлуулалтын болон буцаан худалдан авах үнийн зөрүүг дэлгэрэнгүй орлогын тайланд хүүгийн орлогоор хүлээн зөвшөөрөх ба үр ашигт хүүгийн аргыг ашиглан репо хэлцлийн хугацааны турш хуримтлуулдаг.

Бусад талуудад Группын зээлдүүлсэн үнэт цаас нь санхүүгийн тайланд үнэт цаасаар хүлээн зөвшөөрөгдөх тогтмол нөхөн төлбөртэй зээлээр тайлагнагдана. Гуравдагч талд борлуулснаас бусад тохиолдолд тогтмол нөхөн төлбөртэй зээлээр авсан үнэт цаас нь Группын санхүүгийн тайланд хүлээн зөвшөөрөгдөхгүй. Энэ тохиолдолд ийм үнэт цаасыг борлуулснаас болон худалдан авснаас үүсэх санхүүгийн үр дүнг ашиг алдагдлаар дамжин бодит үнэ цэнээр хүлээн зөвшөөрөгдсөн санхүүгийн хөрөнгийн олз гарзаар дэлгэрэнгүй орлогын тайланд хүлээн зөвшөөрнө. Үнэт цаасыг буцаах үүрэг нь ашиг алдагдлаар дамжин бодит үнэ цэнээр хүлээн зөвшөөрөгдсөн санхүүгийн өр төлбөр болон бүртгэгдэнэ.



ГОЛОМТ БАНК БОЛОН ТҮҮНИЙ ОХИН КОМПАНИ

4. НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН ГОЛ БОДЛОГУУДЫН ХУРААНГУЙ (үргэлжлэл)

4.13 Хооронд нь цэвэрлэх

Хүлээн зөвшөөрөгдсөн дүнгүүдийг хооронд нь хаах эрх зүйн хувьд хүчин төгөлдөр эрх байгаа тохиолдолд болон цэврээр нь эцсийн төлбөрийг хийх эсвэл хөрөнгийг хэрэгжүүлэх, өр төлбөрийг барагдуулах зорилготой бол л санхүүгийн хөрөнгө болон өр төлбөрийг хооронд нь цэвэрлэж, цэвэр дүнгээр нь санхүүгийн байдлын тайланд тайлагнана.

4.14 Өмч, барилга, тоног төхөөрөмж

Өмч, барилга, тоног төхөөрөмж нь өртөг эсвэл дахин үнэлэгдсэн үнээс хуримтлагдсан элэгдэл болон үнэ цэнийн бууралтын нөөцийг хассан дүнгээр тайлагнагдана.

Хаалтын өдөр тус бүрээр Групп өмч, барилга, тоног төхөөрөмжийн үнэ цэнэ буурсан гэх шинж тэмдэг байгаа эсэхийг үнэлэнэ. Ийм шинж тэмдэг байгаа бол Групп хөрөнгийн бодит үнэ цэнээс борлуулах зардлыг хассан дүн болон хөрөнгийн ашиглалтын үнэ цэнийн аль ихээр нь эргэн нөхөгдөх дүнг тооцоолно. Өмч, барилга, тоног төхөөрөмжийн дансны үнэ нь тогтоосон эргэн нөхөгдөх үнээс давсан тохиолдолд дансны үнийг хөрөнгийн эргэн нөхөгдөх дүн хүртэл нь бууруулах бичилт хийж, зөрүүг дэлгэрэнгүй орлогын тайлангийн үнэ цэнийн бууралтын гарзаар тайлагнана.

Өмч, барилга, тоног төхөөрөмжийг борлуулсан/данснаас хассанаас үүссэн олз ба гарзыг дансны үнэтэй нь уялдуулан тодорхойлж, дэлгэрэнгүй орлогын тайланд үйл ажиллагааны зардлаар бүртгэдэг. Засвар үйлчилгээтэй холбоотой гарсан зардлуудыг гарсан тухайн үед нь дэлгэрэнгүй орлогын тайланд зардлаар тайлагнана.

Дуусаагүй барилга нь өртгөөс үнийн бууралтын нөөцийг хассан дүнгээр тайлагнагддаг. Барилгын ажил дуусвар болоход дансны үнээрээ өмч, барилга, тоног төхөөрөмжөөр дахин ангилагддаг. Хөрөнгө ашиглалтанд бэлэн болох хүртэл дуусаагүй барилгад элэгдэл тооцохгүй.

Элэгдэл

Ашиглалтанд бэлэн болсон өдрөөс эхлэн Өмч, барилга, тоног төхөөрөмжийг элэгдүүлж эхэлнэ. Хөрөнгийн тогтоосон ашиглалтын хугацааны турш нь шулуун шугамын аргаар элэгдүүлнэ.

- Барилга — 480 сар;
- Тээврийн хэрэгсэл — 120 сар;
- Тоног төхөөрөмж ба компьютер — 36 -120 сар;
- Тавилга — 120 сар.

Газар нь тодорхойгүй ашиглалтын хугацаатай тул элэгддэггүй.

Хэрэв хөрөнгийн ашиглалтын хугацаа дууссан ба хөрөнгө ашиглалтын хугацааны эцэст хүлээгдэж буй нөхцөл байдалд байх тохиолдолд ашиглалтын хугацааны эцэс дэх хөрөнгийн үлдэх өртөг нь хөрөнгийг данснаас хассанаас олж авч болох дүнгээс хөрөнгийг данснаас хасахтай холбоотой зардлыг хассан дүн байна. Хөрөнгийн үлдэх өртөг болон ашиглалтын хугацааг тайлант хугацаа бүрийн эцэст шалгаж, тохиромжтой бол залруулдаг.

4.15 Хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгө

Хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгө нь өртгөөс хуримтлагдсан элэгдлийг хассан дүнгээр тайлагнагддаг. Хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгийн өртөг нь худалдан авсан үнэ болон түүнтэй шууд холбогдолтой зардлуудаас бүрдэнэ. Хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгийг 10 жилийн хугацаанд шулуун шугамын аргаар элэгдүүлдэг.

Анхны хүлээн зөвшөөрөлтийн дараах үеүдэд хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгийн өртгөөс хуримтлагдсан элэгдэл болон үнийн бууралтын алдагдлыг хассан дүнгээр тайлагнана.

Групп нь хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгийг өртгийн загвар ашиглан хэмжиж, бүртгэнэ.

Хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгө нь хөрөнгийг данснаас хасах эсвэл ашиглалтаас бүр мөсөн хасах үед болон хөрөнгийн ашиглалтаас ирээдүйд өгөөж олохооргүй бол үл хүлээн зөвшөөрнө. Хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгийг данснаас хасах, актласнаас үүсэх олз ба гарз нь тухайн жилдээ орлогын тайланд хүлээн зөвшөөрөгддөг.

4.16 Биет бус хөрөнгө

Биет бус хөрөнгө нь биет шинж чанар агуулаагүй мөнгөн бус хөрөнгө болно. Биет бус хөрөнгийг дараах шалгуур хангагдсан үед анх хүлээн зөвшөөрнө. Үүнд:



- хөрөнгө нь Группд ирээдүйд эдийн засгийн өгөөж бий болгохоор байх;
- хөрөнгийн өртгийг итгэж болохуйц байдлаар хэмжих боломжтой байх;
- хөрөнгө нь Группээс тусгаарлагдах, дангаараа болон холбогдох гэрээ ба үүргийн хамт борлуулагдах, шилжих, тусгай зөвшөөрөл авах, түрээслэх болон солилцох боломжтой байх.

Тусад нь олж бэлтгэсэн биет бус хөрөнгийг анхны хүлээн зөвшөөрөлтөөр өртгөөр нь хэмжинэ. Анхны хүлээн зөвшөөрөлтийн дараах үеүдэд өртгөөс хуримтлагдсан хорогдуулалт ба үнэ цэнийн бууралтын хуримтлагдсан нөөцийг хассан дүнгээр хүлээн зөвшөөрч, бүртгэнэ.

Биет бус хөрөнгийн ашиглалтын хугацааг тодорхойлж болохуйц эсвэл тодорхойлж болохгүй байгаа эсэхээр нь үнэлнэ. Тодорхойлж болохуйц ашиглалтын хугацаа бүхий биет бус хөрөнгийг эдийн засгийн ашиглалтын бодит хугацааны турш хорогдуулж, биет бус хөрөнгийн үнэ цэнэ буурсан эсэх талаар шинж тэмдэг байгаа эсэхийг мөн үнэлнэ. Тодорхойлж болохуйц ашиглалтын хугацаа бүхий биет бус хөрөнгийн хорогдуулах хугацаа ба аргыг хамгийн багадаа тайлант жил бүрийн эцэст хянана.

Тодорхойлж болохооргүй ашиглалтын хугацаатай хөрөнгүүдийг хорогдуулахгүй бөгөөд зөвхөн дангаар нь эсвэл мөнгө бий болгогч нэгжийн түвшинд нь үнийн бууралтын шинжилгээг хийнэ. Тодорхойгүй ашиглалтын хугацаа бүхий хөрөнгийн ашиглалтын хугацааг дэмжих зүйл байгаа эсэхийг тодорхойлохын тулд жил бүр хянана.

4.17 Үйл ажиллагааны түрээс

Үйл ажиллагааны түрээс – Групп нь түрээслэгч бол

Эзэмшлийг дагалдах эрсдэл ба өгөөж нь түрээслүүлэгчид хүчинтэй хэвээр байх үе дэх үл хөдлөх хөрөнгийн түрээсийг турш хорогдуулж, түрээсээр ангилдаг. Үйл ажиллагааны түрээсийн дагуух түрээсийн төлбөрүүдийг түрээсийн хугацааны турш шулуун шугамын аргаар зардлаар хүлээн зөвшөөрч, дэлгэрэнгүй орлогын тайланд үйл ажиллагааны зардлаар тайлагнана

Үйл ажиллагааны түрээс – Групп нь түрээслүүлэгч бол

Групп нь үйл ажиллагааны түрээстэй холбоотой хөрөнгийг санхүүгийн байдлын тайланд хөрөнгийн шинж чанараас хамааруулан толилуулна. Үйл ажиллагааны түрээсийн орлогыг түрээсийн хугацааны турш шулуун шугамын аргаар дэлгэрэнгүй орлогын тайланд бусад үйл ажиллагааны орлогоор хүлээн зөвшөөрнө. Түрээслэгчид олгосон урамшууллын хуримтлагдсан зардлыг түрээсийн хугацааны турш шулуун шугамын аргаар түрээсийн орлогыг бууруулж хүлээн зөвшөөрнө. Үйл ажиллагааны түрээсээс орлого олохтой холбоотой анхны шууд зардлуудыг түрээсийн хөрөнгийн дансны үнэн дээр нэмэх ба түрээсийн орлоготой ижил сууриар түрээсийн хугацааны туршид зардалд хүлээн зөвшөөрдөг.

4.18 Хувьцаат капитал

Энгийн хувьцаа ба хуримтлалгүй, оролцоогүй давуу эрхтэй хувьцаанууд нь хувьцаат капиталаар ангилагдан, бүртгэгддэг. Хувьцаат капитал нь анхны өртгөөрөө тайлагнагддаг. Хувьцаат капиталд оруулсан мөнгөн бус оролцоог тухайн оролцоо гарсан өдөр оруулсан хөрөнгийн бодит үнэ цэнээр бүртгэгдэнэ.

4.19 Хувьцааны урамшуулал

Хувьцааны урамшуулал нь гаргасан хувьцааны нэрлэсэн үнээс давуулан оруулсан хөрөнгө оруулалтыг илэрхийлнэ.

4.20 Ногдол ашиг

Тайлагналын өдрөөс өмнө буюу тайлагналын өдрөөр ногдол ашгийг зарласан бол тайлант хугацааны эцэст ногдол ашгийг өр төлбөрөөр хүлээн зөвшөөрөх бөгөөд ногдол ашиг нь хувьцаа эзэмшигчдийн өмчийг бууруулна. Тайлант хугацаанаас хойш зарлагдсан ногдол ашгийн талаарх мэдээллийг тайлангийн дараах үйл явдлаар тодруулдаг. Санхүүгийн тайланд тусгагдсан тайлант жилийн цэвэр ашиг нь ногдол ашгийг хуваарилах болон төлөх үндсэн суурь нь болно.

Хувцаа эзэмшигчдийн хурлаас ногдол ашгийг баталснаар ногдол ашгийг санхүүгийн тайланд хуваарилсан ашгаар хүлээн зөвшөөрнө.

4.21 Болзошгүй хөрөнгө ба болзошгүй өр төлбөр

Болзошгүй хөрөнгийг санхүүгийн тайланд хүлээн зөвшөөрөхгүй боловч эдийн засгийн өгөөжийн орох урсгал магадлалтай үед санхүүгийн тайланд нэмж тодруулна.

Төлбөрийг барагдуулахтай холбоотой мөнгөн гарах урсгал нь магадлалгүй бол болзошгүй өр төлбөрийг санхүүгийн тайланд хүлээн зөвшөөрөхгүй боловч нэмж тодруулна.



ГОЛОМТ БАНК БОЛОН ТҮҮНИЙ ОХИН КОМПАНИ

4. НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН ГОЛ БОДЛОГУУДЫН ХУРААНГУЙ (үргэлжлэл)

4.22 Зээлтэй холбоотой хариуцлага

Групп баталгаа, зээлийн хугацаа сунгах амлалт гэх мэт зээлтэй холбоотой хариуцлагад гэрээ байгуулдаг. Баталгаа нь харилцагч нь гуравдагч талд үүргээ биелүүлэх боломжгүй болсон үед Групп өмнөөс нь төлбөрийг хийх буцалтгүй баталгааг илэрхийлэх бөгөөд зээлтэй адилтгах зээлийн эрсдлийг өөртөө агуулж байдаг. Зээлийг сунгах үүрэг нь зээл ба баталгааны хэлбэрээр эрхийн ашиглагдаагүй хэсгийг илэрхийлнэ. Зээлийг сунгах хариуцлагатай холбоотой зээлийн эрсдэлийн хувьд Групп нь нийт ашиглаагүй хариуцлагатай тэнцүү хэмжээний дүнгээр алдагдал хүлээх эрсдэлд өртөх магадлалтай. Гэвч ихэнх тохиолдолд алдагдал хүлээх магадлалтай дүн нь ашиглаагүй хариуцлагын нийт дүнгээс бага байдаг. Учир нь зээлийг сунгах ихэнх хариуцлага нь харилцагчийн зээлийн тусгай стандарттай байхтай холбоотойгоор болзошгүй байдаг.

Зээлтэй холбоотой хариуцлага нь анх бодит үнэ цэнээрээ хүлээн зөвшөөрөгддөг. Дараах үеүдэд, тайлант хугацаа бүрийн эцэст шинжилж, өнөөгийн хамгийн сайн тооцооллыг тусгахын тулд тохируулдаг. Өнөөгийн үүрэг хариуцлагыг барагдуулахад шаардлагатай зарцуулалтын хамгийн сайн тооцоолол нь Группын тайлант хугацааны эцсээр үүргийг хангах эсвэл гуравдагч талд шилжүүлэхэд төлөх төлбөрийн дүн байна.

4.23 Нөөц/сан

Группд өнгөрсөн үйл явдлын үр дүнд үүссэн өнөөгийн үүрэг (хуулийн эсвэл ёс зүйн) байгаа болон энэхүү үүргээ биелүүлэхэд эдийн засгийн өгөөж агуулсан баялгийг зарцуулах нь тодорхой болсон ба үүргийн дүнг бодитойгоор ойролцоолон тооцоолох боломжтой үед нөөц/санг хүлээн зөвшөөрнө.

4.24 Татвар

Орлогын татварын зардал/нөхөлт нь тайлант хугацааны татвар ба хойшлуулсан татвараас бүрдэх бөгөөд бусад дэлгэрэнгүй орлогоор шууд бүртгэгдэж буй ажил гүйлгээтэй холбоотойгоос бусад дэлгэрэнгүй орлогод тайлагнагдснаас бусад тохиолдолд дэлгэрэнгүй орлогын тайланд тайлагнагдана. Орлогын татварын зардал нь Монгол улсын холбогдох хууль тогтоомжийн дагуу орлогын тайланд бүртгэгдэнэ. Тайлант хугацааны татварыг тайлант хугацааны турш хүчин төгөлдөр байсан хувь хэмжээг ашиглан тайлант жилийн татвар ногдох орлогод суурилан тооцоолно.

Тайлант хугацааны татвар нь тайлант хугацааны болон өмнөх тайлант хугацааны татвар ногдох орлого эсвэл алдагдалтай холбоотойгоор татварын байгууллагад төлөх буюу нөхөн авах дүнг илэрхийлнэ. Татварын тайланг бэлтгэхээс өмнө санхүүгийн тайланг баталж буй тохиолдолд татварын дүнгүүд нь тооцоололд үндэслэнэ. Хойшлуулсан орлогын албан татварыг хөрөнгө, өр төлбөрийн татварын суурь, тэдгээрийн санхүүгийн тайлангийн зорилгоорх дансны үнийн хоорондох түр зөрүү болон алдагдал шилжүүлэн тооцохтой холбоотойгоор балансын аргыг ашиглан тооцдог.

Түр зөрүүг буцаах болон шилжүүлсэн татварын алдагдал хэрэгжих үед нь ашиглах зорилгоор тайлант хугацааны эцэс дэх хүчин төгөлдөр эсвэл батлагдсан хувь хэмжээгээр хойшлуулсан татварын үлдэгдлийг хэмжинэ. Нэг татвар төлөгч, нэг татварын байгууллагад хамаарах хойшлуулсан орлогын албан татварын хөрөнгө ба өр төлбөрийг хооронд нь цэвэрлэн тайлагнах хуулиар олгогдсон эрхтэй бол хойшлуулсан орлогын албан татварын хөрөнгө ба өр төлбөрийг хооронд нь цэвэрлэн тайлагнаж болно.

Суутгагдах түр зөрүү болон татварын алдагдлыг ирээдүй рүү шилжүүлснээс үүссэн хойшлогдсон татварын хөрөнгө нь ирээдүйн татвар ногдох орлого нь тухайн суутгалыг хийх магадлалтай байх үед бүртгэгддэг. Санхүүгийн тайланд ирээдүйн татвар ногдох орлогын дүн болон хугацаа нь магадлалтай байх тохиолдолд ирээдүйн татварын төлөвлөгөө стратегид суурилан хүлээн зөвшөөрөгдөх хойшлогдсон татварын дүнг тодорхойлоход шийдвэр гаргах хэрэгтэй болдог.

Монгол улс нь өөр бусад татваруудтай бөгөөд Группын үйл ажиллагаанд үзүүлэх нөлөөллийг үнэлдэг. Эдгээр бусад татварыг дэлгэрэнгүй орлогын тайланд үйл ажиллагааны зардлаар тайлагнадаг.

4.25 Ажиллагсдын тэтгэмж ба нийгмийн халамж

(i) Богино хугацааны тэтгэмж

Цалин, хөлс, бусад цалин хөлстэй холбоотой зардлууд нь Групп болон Банкинд ажилтан нь холбогдох үйлчилгээг үзүүлсэн тухайн жилдээ зардлаар хүлээн зөвшөөрөгддөг. Ээлжийн амралт гэх мэт богино хугацааны хуримтлагдах, нөхөн төлбөр бүхий амралт чөлөө нь ажилтан үйлчилгээг үзүүлсэн тухайн хугацаанд нь хүлээн зөвшөөрөх бөгөөд өвчний чөлөө гэх мэт хуримтлалгүй түр хугацааны чөлөө нь чөлөө олгогдсон тухайн үедээ хүлээн зөвшөөрөгддөг.



(ii) Тогтоосон тэтгэмжийн төлөвлөгөө

Монгол Улсын холбогдох хууль, тогтоомжид заасны дагуу Монгол Улсад үйл ажиллагаа явуулж байгаа компаниуд нь Монгол Улсын эрүүл мэнд, нийгмийн даатгалын санд шимтгэл төлнө. Эдгээр шимтгэлийг гарсан хугацаанд нь орлого, үр дүнгийн тайланд зардлаар хүлээн зөвшөөрнө. Групп ба Банк мөн өөрсдийн байгуулсан тэтгэврийн санд шимтгэл төлдөг. Төлсөн шимтгэлийг ажилтны банкинд ажилласан хугацаанд нь хувь тэнцүүлэн "Тэтгэврийн сангийн зардал" дансанд бүртгэнэ.

4.26 Орлого ба зардал хүлээн зөвшөөрөлт

(i) Хүү болон түүнтэй адилтгах орлого ба зардал

Хүүгийн орлого ба зардлыг үр ашигт хүүгийн түвшинг ашиглан бүх өрийн хэрэгслүүдийн хувьд дэлгэрэнгүй орлогын тайланд аккреул сууриар бүртгэдэг. Үр ашигт хүүгийн арга нь санхүүгийн хөрөнгө ба санхүүгийн өр төлбөрийн хорогдуулсан өртгийг тооцож, хүүгийн орлого ба хүүгийн зардлыг холбогдох хугацаанд нь хуваарилдаг арга юм. Үр ашигт хүүгийн түвшин гэдэг нь санхүүгийн хэрэглүүрийн хүлээгдэж буй хугацааны турш хүлээн авах мөнгөн орлого болон төлөх мөнгөн төлбөрийг санхүүгийн хөрөнгө ба санхүүгийн өр төлбөрийн дансны цэвэр үнэ хүртэл нь хөнгөлөх түвшин юм. Үр ашигт хүүгийн түвшинг тооцоолохдоо Групп нь санхүүгийн хэрэглүүрийн гэрээний бүх нөхцлүүдийг харгалзан үзэж мөнгөн урсгалыг тооцоолох боловч ирээдүйн зээлийн алдагдлыг харгалзан үздэггүй. Энэхүү тооцоолол нь гэрээнд оролцогч талуудын төлсөн буюу хүлээн авсан бүх шимтгэл, хураамж, ажил гүйлгээний зардал бусад бүх хөнгөлөлт эсвэл урамшууллыг үр ашигт хүүгийн түвшний салшгүй хэсэгт болгон авч үздэг.

Хүүгийн орлого нь тогтмол орлоготой санхүүгийн хөрөнгөөс олсон хүүгийн төлбөр, бонд, вексел, бусад дискаунталсан хэрэглүүрийн хуримтлуулсан урамшуулал ба хөнгөлөлтийг багтаана. Зээл төлөгдөх эсэх нь эргэлзээтэй болсон тохиолдолд зээлийн дүнг нөхөгдөх дүн хүртэл нь бууруулах ба түүнээс хойшхи хүүгийн орлогыг эргэн нөхөгдөх дүнг хэмжих зорилгоор ирээдүйн мөнгөн урсгалыг дискаунтлахад ашигласан хүүгийн түвшинд үндэслэн хүлээн зөвшөөрнө.

(ii) Хураамж, шимтгэлийн орлого

Хураамж, шимтгэл болон бусад орлого зардлын зүйлс нь үйлчилгээг үзүүлсэн үед аккреул суурийн дагуу бүртгэгддэг. Олгогдоогүй боловч олгогдох нь магадлалтай болсон зээлийн үүслийн шимтгэлийг бусад хөрөнгөөр хүлээн зөвшөөрч, дараах үеүдэд зээлийн **үр ашигт өгөөжийн тооцооллыг** харгалзан үзнэ. Зээл, хувьцаа, бусад үнэт цаас худалдан авах, бизнесийг борлуулах буюу худалдан авах гэх мэт гуравдагч талтай хийж буй хэлцлээс үүдсэн хураамж ба шимтгэлийг ажил гүйлгээг иж бүрэн болсон үед нь дэлгэрэнгүй орлогын тайланд бүртгэдэг. Хөрөнгө оруулалтын багц болон бусад зөвлөх үйлчилгээний шимтгэл нь холбогдох үйлчилгээний гэрээний хүрээнд хүлээн зөвшөөрөгддөг.

Тодорхой хугацааны турш үйлчилгээг үзүүлснээс олох хураамжийн орлогыг тухайн хугацааны турш хуримтлуулдаг. Ийм төлбөрүүдэд шимтгэлийн орлого, хөрөнгө удирдлагын, кастодиан, бусад удирдлагын болон зөвлөх үйлчилгээний төлбөр багтана.

Олгогдохоор хүлээгдэж буй зээлүүдийн амлалттай холбоотой төлбөр болон бусад зээлтэй холбоотой төлбөрүүдийг (бусад өсөн нэмэгдэх зардлуудын хамт) хойшлуулах ба зээлийн үр ашигт хүүгийн түвшний залруулгаар хүлээн зөвшөөрөгддөг. Зээл олгогдохооргүй болсон үед зээлийн амлалтын төлбөр нь амлалтын хугацааны турш шулуун шугамын аргаар хүлээн зөвшөөрөгддөг.

4.27 Гадаад валют ба үнэт метал

Гадаад валютаарх ажил гүйлгээнүүдийг ажил гүйлгээний өдрөөр хүчин төгөлдөр байгаа Төв Банкнаас зарласан ханшаар ажил гүйлгээний үндсэн валют руу хөрвүүлдэг. Гадаад валютаар илэрхийлэгдсэн мөнгөн хөрөнгө, өр төлбөрийг тайлант хугацааны эцсээрх Төв Банкны ханшаар тайлагнагч валют руу хөрвүүлдэг. Гадаад валютаарх болон үнэт металиар хийгдсэн ажил гүйлгээний ханшийн тэгшитгэл хийхээс үүссэн ханшийн олз ба гарзыг дэлгэрэнгүй орлогын тайлангийн гадаад валют, үнэт металийн ханшийн тэгшитгэлийн олзоос, гарзыг хасч бүртгэдэг. Гадаад валютаарх өртгөөрөө илэрхийлэгдсэн мөнгөн бус хөрөнгө, өр төлбөрийн зүйлсийг ажил гүйлгээ гарсан өдрийн Төв Банкны ханшаар тайлагнадаг. Бодит үнэ цэнээр илэрхийлэгдсэн гадаад валютаарх мөнгөн бус зүйлсийг бодит үнэ цэнийг тодорхойлсон өдрийн хүчин төгөлдөр ханшаар тэгшитгэн тайлагнадаг.

Алт, мөнгө болон бусад үнэт металлууд нь Төв Банкнаас тогтоосон арилжааны ханшаар бүртгэгддэг. Төв Банкны арилжааны үнэнд орсон өөрчлөлтийг дэлгэрэнгүй орлогын тайланд гадаад валютын болон үнэт металийн ханшийн тэгшитгэлийн олзоос гарзыг хассан дүнгээр ханшийн зөрүү гэж бүртгэдэг. Үнэт металийг бусад хөрөнгөөр бүртгэнэ.

Гадаад валют, үнэт метал худалдан авах болон борлуулахаас үүссэн олз ба гарзыг ажил гүйлгээ гарсан өдрөөрх дансны үнэ болон борлуулсан үнийн зөрүүгээр тодорхойлдог.



ГОЛОМТ БАНК БОЛОН ТҮҮНИЙ ОХИН КОМПАНИ

4. НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН ГОЛ БОДЛОГУУДЫН ХУРААНГУЙ (үргэлжлэл)

4.28 Сегментийн тайлагнал

Орлого олж, зардал гаргадаг бизнесийн үйл ажиллагаа, сегментэд хуваарилагдах нөөцийн талаар шийдвэр гаргахын тулд байгууллагын үйл ажиллагааны шийдвэр гаргагчид үйл ажиллагааных нь үр дүнд байнга хяналт тавьж байдаг, санхүүгийн тусдаа мэдээлэл бэлтгэх боломжтой Группын бүрэлдэхүүн хэсгүүдийг үйл ажиллагааны сегмент гэдэг.

Групп нь нэгтгэсэн санхүүгийн тайландаа дараах тоон шаардлагуудын аль нэгийг хангасан үйл ажиллагааны сегментийн талаарх мэдээллийг тусад нь тайлагнана. Үүнд:

- Тухайн сегментийн гадны харилцагчдад болон сегмент хоорондын нийт тайлагнасан орлого нь Группын бүх үйл ажиллагааны сегментүүдийн дотоод болон гадаад нийт орлогын 10 хувь болон түүнээс их бол;
- Тайлагнасан ашиг ба алдагдлын үнэмлэхүй дүн нь;
- Тайлант хугацаанд алдагдал тайлагнаагүй нийт сегментүүдийн нийлмэл ашгийн 10 хувь ба түүнээс их бол;
- Тайлант хугацаанд алдагдал тайлагнасан сегментүүдийн тайлагнасан нийлмэл алдагдлын 10 хувь ба түүнээс их бол ;
- Хөрөнгө нь үйл ажиллагааны бүх сегментийн нийлмэл хөрөнгийн дүнгийн 10 хувь ба түүнээс их бол.

Хэрэв удирдлага нь сегментийн талаарх мэдээлэл нь нэгтгэсэн санхүүгийн тайлангийн хэрэглэгчдэд үр дүнтэй мэдээлэл өгнө гэж итгэж буй бол дээрх тоон үзүүлэлтийн шалгуурыг хангаагүй үйл ажиллагааны сегментийн талаар тайлагнах, тусд нь нэмж тодруулах боломжтой.

Удирдлагын тайлагналын мэдээлэл нь СТОУС-ын дагуух санхүүгийн тайлангаас ялгаатай байж болох бөгөөд тохируулга хийж, шалтгааныг нэмж тодруулдаг. Материаллаг бүх тохируулгын зүйлсийг тусад нь тодорхойлж, тайлбар оруулдаг. Жишээлбэл, өөр бүртгэлийн бодлого баримталснаас үүдэн тайлагнах сегментийн ашиг алдагдлыг Группын ашиг, алдагдал руу тохируулахад шаардлагатай материаллаг залруулгын дүнгүүдийг тодорхойлж, тусад нь тайлбарлана.

5. СЕГМЕНТИЙН ТАЙЛАГНАЛ

Тус Групп нь бизнесийн үндсэн 4 сегменттэй.

Иргэдийн банк	Харилцагчдын харилцах , хадгаламжийн данс, хэрэглээний зээл, кредит карт болон шилжүүлгийн гүйлгээ
Байгууллагын банк	Байгууллага болон аж ахуй нэгж харилцагчдад үзүүлдэг харилцах, хадгаламжийн данс, зээл болон зээлийн хэрэгслүүд
Хөрөнгө оруулалтын банк	Байгууллагын санхүү болон худалдан авалт, бизнесийн нэгдэл, тусгай санхүүгийн зөвөлгөө, арилжаа зэргийг оролцуулсан хөрөнгө оруулалтын банкны үйлчилгээ
Хөрөнгийн Удирдлага	Хөрөнгө зохицуулалт, санхүүжилт болон бусад төвийн үйл ажиллагаа.
Брокер, дилер	Санхүүгийн зах зээл дэх брокер, дилерийн үйлчилгээ

Удирдлага нь бизнесийн нэгжүүдийн үйл ажиллагааны үр дүнг нөөцийн хуваарилалт, гүйцэтгэлийн үнэлгээний талаар шийдвэр гаргах зорилгоор тусад нь хянан удирддаг. Сегментийн гүйцэтгэлийг үйл ажиллагааны ашиг, алдагдал (зарим тохиолдолд санхүүгийн тайлангууд дээрх үйл ажиллагааны ашиг алдагдлаас өөрөөр хэмждэг) дээр нь үндэслэн үнэлдэг. Орлогын албан татварыг компанийн түвшинд удирддаг ба сегментүүдэд хуваарилдаггүй.

Удирдлагын гүйцэтгэлийн хэмжүүр нь нийт хүүгийн орлого, зардал биш цэвэр хүүгийн орлого байдаг учраас хүүгийн орлогыг цэвэр дүнгээр нь тайлагнадаг.

Үйл ажиллагааны сегментүүдийн хооронд шилжих үнэ нь гуравдагч талтай хийж байгаа гүйлгээний нэг адил зарчмаар хийгддэг.

2012 ба 2011 онд нэг хөндлөнгийн харилцагч эсвэл талтай хийсэн гүйлгээний орлого нь Групп ба Банкны нийт орлогын 10%-иас илүү гараагүй.

Дараах хүснэгтэнд 2012 болон 2011 оны 12 сарын 31-ний өдрөөр тасалбар болсон жилийн банкны үйл ажиллагааны сегментүүдийн орлого, ашиг ба зарим нэг хөрөнгө, өр төлбөрүүдийн мэдээллийг үзүүлсэн болно.



	Байгууллагын банк	Иргэдийн банк	Хөрөнгө оруулалтын банк	Хөрөнгийн удирдлагын газар	Хувиарлаг -даагүй	Нийт
	2012	2012	2012	2012	2012	2012
	мян.төг	мян.төг	мян.төг	мян.төг	мян.төг	мян.төг
Гуравдагч тал	97,045,531	(36,798,389)	12,307	28,660,036	-	88,919,485
Сегмент хоорондын	(70,948,198)	86,521,658	-	(15,573,460)	-	-
Нийт үйл ажиллагааны орлого	26,097,333	49,723,269	12,307	13,086,576	-	88,919,485
Зээлийн үнэ цэнийн бууралтын алдагдал	(7,574,826)	(3,186,125)	-	(29,096)	-	(10,790,047)
Санхүүгийн хөрөнгө оруулалтын үнэ цэнийн бууралтын алдагдал	-	-	-	-	-	-
Цэвэр үйл ажиллагааны орлого	18,522,507	46,537,144	12,307	13,057,480	-	78,129,438
Үр дүнгүүд						
Хүү түүнтэй адилтгах орлого	93,656,610	72,761,010	-	33,827,395	-	200,245,015
Хүү түүнтэй адилтгах зардал	(71,889,930)	(43,783,865)	-	(27,451,177)	-	(143,124,972)
Цэвэр хүүгийн орлого	21,766,680	28,977,145	-	6,376,218	-	57,120,043
Хураамж, шимтгэлийн орлого	4,257,716	10,228,033	27,534	5,467,047	-	19,980,330
Хураамж, шимтгэлийн зардал	(1,564)	(807,411)	(15,284)	(4,113,372)	-	(4,937,631)
Цэвэр хураамж, шимтгэлийн орлого	4,256,152	9,420,622	12,250	1,353,675	-	15,042,699
Зээлийн үнэ цэнийн бууралтын зардал	(7,574,825)	(3,186,125)	-	(29,096)	-	(10,790,046)
Гадаад валютын ханшийн зөрүүгийн болон бусад олз/(гарз)	74,501	11,325,541	57	4,774,320	-	16,174,419
Цэвэр арилжааны олз/(гарз)	-	-	-	385,618	-	385,618
Үндсэн хөрөнгийн элэгдэл	(370,670)	(2,893,269)	(6,719)	(154,198)	(382,056)	(3,806,912)
Биет бус хөрөнгийн хорогдол	(164,087)	(418,789)	(50)	(65,520)	(10,837)	(659,283)
Үйл ажиллагааны зардал	(5,247,330)	(31,186,231)	(252,263)	(4,396,444)	-	(41,082,268)
Бусад үйл ажиллагааны зардал	-	-	-	196,707	-	196,707
Сегментийн ашиг (алдагдал)	12,740,419	12,038,894	(246,725)	8,441,280	(392,892)	32,580,975
Орлогын татварын зардал						(6,080,022)
Тайлант жилийн ашиг						26,500,953
Хөрөнгө						
Капитал зардал						
Өмч, барилга, тоног төхөөрөмж	58,207	7,632,413	4,395	24,890	2,589,495	10,309,400
Бусад биет бус хөрөнгө	-	379,022	-	-	719,364	1,098,386
Нийт хөрөнгө	970,634,104	583,872,806	456,108	818,074,828	154,289,105	2,527,326,951
Нийт өр төлбөр	954,492,025	564,501,188	702,926	813,672,450	6,750,938	2,340,119,527



ГОЛОМТ БАНК БОЛОН ТҮҮНИЙ ОХИН КОМПАНИ

5. СЕГМЕНТИЙН МЭДЭЭЛЭЛ (үргэлжлэл)

Дараах хүснэгтэнд Группын 2011 оны 12 сарын 31-нээрх сегментүүдийн орлого, ашиг ба зарим хөрөнгө өр төлбөрүүдийн мэдээллүүдийг үзүүлсэн болно.

	Байгууллагын банк	Иргэдийн банк	Хөрөнгө оруулалтын банк	Хөрөнгийн удирдлагын газар	Хувиарлаг -даагүй	Нийт
	2011	2011	2011	2011	2011	2011
	мян.төг	мян.төг	мян.төг	мян.төг	мян.төг	мян.төг
Гуравдагч тал	35,363,899	370,412	241,668	42,362,621	-	78,338,600
Сегмент хоорондын	(9,961,029)	37,666,562	-	(27,705,533)	-	-
Нийт үйл ажиллагааны орлого	25,402,870	38,036,974	241,668	14,657,088	-	78,338,600
Зээлийн үнэ цэнийн бууралтын алдагдал	(1,928,279)	(4,304,781)	-	-	-	(6,233,060)
Санхүүгийн хөрөнгө оруулалтын үнэ цэнийн бууралтын алдагдал	-	-	-	(2,340,179)	-	(2,340,179)
Цэвэр үйл ажиллагааны орлого	23,474,591	33,732,193	241,668	12,316,909	-	69,765,361
Үр дүнгүүд						
Хүү түүнтэй адилтгах орлого	62,587,877	62,747,220	235,161	40,024,083	-	165,594,341
Хүү түүнтэй адилтгах зардал	(39,353,724)	(43,873,235)	(48,329)	(33,392,043)	-	(116,667,331)
Цэвэр хүүгийн орлого	23,234,153	18,873,985	186,832	6,632,040	-	48,927,010
Хураамж, шимтгэлийн орлого	2,146,481	7,543,588	56,277	4,283,569	-	14,029,915
Хураамж, шимтгэлийн зардал	(3,064)	(852,884)	(1,439)	(2,903,267)	-	(3,760,654)
Хураамж, шимтгэлийн цэвэр орлого	2,143,417	6,690,704	54,838	1,380,302	-	10,269,261
Зээлийн үнэ цэнийн бууралтын зардал	(1,928,279)	(4,304,781)	-	-	-	(6,233,060)
Гадаад валютын ханшийн зөрүүгийн болон бусад олз/(гарз)	25,300	12,472,284	-	5,464,334	-	17,961,918
Арилжааны цэвэр олз/(гарз)	-	-	-	(1,296,377)	-	(1,296,377)
Үндсэн хөрөнгийн элэгдэл	(296,758)	(2,010,130)	(1,822)	(138,878)	(201,652)	(2,649,241)
Биет бус хөрөнгийн хорогдол	(112,001)	(238,295)	(86)	(74,182)	(150,385)	(574,950)
Үйл ажиллагааны зардал	(6,549,160)	(19,292,854)	(207,441)	(3,242,262)	-	(29,291,717)
Бусад үйл ажиллагааны зардал	-	-	-	136,609	-	136,609
Сегментийн ашиг (алдагдал)	16,516,671	12,190,914	32,319	8,861,587	(352,038)	37,249,453
Орлогын татварын зардал	-	-	-	-	-	(9,022,425)
Тайлант жилийн ашиг						28,227,028
Хөрөнгө						
Капитал зардал	-	-	-	-	-	-
Өмч, барилга, тоног төхөөрөмж	9,402	3,323,314	5,848	5,977	1,623,565	4,968,107
Бусад биет бус хөрөнгө	-	-	-	-	113,446	113,446
Нийт хөрөнгө	733,632,184	602,967,008	491,894	766,065,709	31,425,078	2,134,581,874
Нийт өр төлбөр	762,352,458	509,125,206	497,235	718,302,826	5,216,949	1,995,494,674

6. CASH AND CASH EQUIVALENTS

	2012 оны 12 сарын 31 мян.төг	2011 оны 12 сарын 31 мян.төг
Бэлэн мөнгө	98,334,103	89,417,750
Төв банкин дахь харилцах	327,726,553	200,449,311
Хасах нь: Групп болон банкны өдөр тутмын үйл ажиллагааг санхүүжүүлэх зорилгогүй Монгол банкинд заавал байлгах нөөц	(239,329,820)	(194,549,220)
	186,730,836	95,317,841



7. МОНГОЛ БАНКИНД БАЙРШУУЛСАН ЗААВАЛ БАЙЛГАХ НӨӨЦ

	2012 оны 12 сарын 31 мян.төг	2011 оны 12 сарын 31 мян.төг
Монгол банкинд байршуулсан заавал байлгах нөөц	239,329,820	194,549,220

Монголбанкнаас тавигддаг шаардлагын дагуу Монголбанкнд харилцах данс байршуулдаг. Монголбанкнд байршуулах бэлэн мөнгөний заавал байлгах үлдэгдэл нь 14 хоногийн татан төвлөрүүлсэн хөрөнгийн 12.0% (2011: 11.0 %) аас багагүй байдаг. 2012 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар Банкны байлгах шаардлагатай 14 хоногийн дундаж нөөцийн хэмжээ дотоод валютаар 133,384 сая төгрөг (2011: 117,466 сая төгрөг) ба гадаад валютаар 105,945 сая төгрөг (2011: 77,804 сая төгрөг) байсан.

8. БОДИТ ҮНЭ ЦЭНИЙН ӨӨРЧЛӨЛТ НЬ ОРЛОГО ЗАРДЛААР ХҮЛЭЭН ЗӨВШӨӨРӨГДӨХ САНХҮҮГИЙН ХӨРӨНГӨ

2012 болон 2011 оны 12 сарын 31-нээрх нэгтгэсэн санхүүгийн байдлын тайланд бодит үнэ цэнийн өөрчлөлт орлого, зардлаар хүлээн зөвшөөрөгдөх санхүүгийн хөрөнгө нь арилжааны үнэт цаасуудыг агуулна.

	2012 оны 12 сарын 31 мян.төг	2011 оны 12 сарын 31 мян.төг
Бирж дээр арилжаалагдаж буй үнэт цаас	5,897,807	1,061,151

Хөрөнгийн биржид арилжаалагддаг борлуулахад бэлэн үнэт цаас болон дуусвар хугацаа хүртэл эзэмших үнэт цааснууд нь Монгол улсын Хөрөнгийн Бирж болон Хонг Конгийн Хөрөнгийн Биржид бүртгэлтэй өмчөөрх хөрөнгө оруулалтыг илэрхийлнэ. Хөрөнгийн биржид бүртгэлтэй дуусвар хугацаа хүртэл нь эзэмших өрийн үнэт цааснууд нь Сингапурийн Хөрөнгийн Биржид арилжаалагдаж буй Худалдаа Хөгжлийн Банкнд оруулсан хөрөнгө оруулалтыг илэрхийлнэ.

2012 болон 2011 оны 12 сарын 31-ний өдрөөр дуусвар болсон жилд бодит үнэ цэнийн өөрчлөлт нь орлого, зардлаар хүлээн зөвшөөрөгдөх санхүүгийн хөрөнгийн багцад гарсан өөрчлөлт нь дараах байдалтай байна. Үүнд:

	2012 мян.төг	2011 мян.төг
1 сарын 1-нээрх дансны үнэ	1,235,916	267,389
Байгуулсан сан /сангийн нөхөлт	(174,765)	78,083
1 сарын 1-нээрх бодит өртөг	1,061,151	345,472
Дуусвар хугацаа хүртэл эзэмших санхүүгийн хөрөнгө рүү дахин ангилсан	-	254,767
Худалдаж авсан	5,736,943	868,966
Худалдсан	(724,412)	
Гадаад валютын ханшийн зөрүүгийн нөлөө	205,966	(155,206)
12 сарын 31-нээрх дансны үнэ	6,454,413	1,235,916
Байгуулсан сан /сангийн нөхөлт	(556,606)	(174,765)
12 сарын 31-нээрх бодит өртөг	5,897,807	1,061,151

9. БУСАД БАНК САНХҮҮГИЙН БАЙГУУЛЛАГА ДАХЬ ХАРИЛЦАХ, ХАДГАЛАМЖ

	2012 оны 12 сарын 31 мян.төг	2011 оны 12 сарын 31 мян.төг
Дотоодын банк дахь харилцах данс	11,096,853	1,043,177
Гадаадын банк дахь харилцах данс	203,536,118	175,109,583
Хадгаламж-дотоодын банк	30,308	1,001,667
Хадгаламж –гадаадын банк	-	44,574,171
Бусад	6,777	153,846
	214,670,056	221,882,444



ГОЛОМТ БАНК БОЛОН ТҮҮНИЙ ОХИН КОМПАНИ

10. БОРЛУУЛАХАД БЭЛЭН САНХҮҮГИЙН ХӨРӨНГӨ

	2012 оны 12 сарын 31	2011 оны 12 сарын 31
	мян.төг	мян.төг
Хөрөнгийн биржид бүртгэлгүй хувьцаа-өртгөөр	679,271	642,922
Хөрөнгийн биржид бүртгэлтэй хувьцаа-бодит үнээр	1,099,295	2,116,018
	1,778,566	2,758,940

2012 болон 2011 оны 12 сарын 31-ний өдрөөр дуусвар болсон жилийн турш борлуулахад бэлэн санхүүгийн хөрөнгийн багцад гарсан өөрчлөлт нь дараах байдалтай байна. Үүнд:

	2012 он	2011 он
	мян.төг	мян.төг
Хөрөнгийн биржид бүртгэлгүй	4,341,912	4,190,463
Хөрөнгийн биржид бүртгэлгүй	642,922	3,712,922
01 сарын 01-ний өдрөөрх дансны үнэ	4,984,834	7,903,385
Бодит үнэ цэнийн тохируулга	(2,225,894)	(446,055)
01 сарын 01-ний өдрөөрх бодит үнэ цэнэ	2,758,940	7,457,330
Нэмэгдсэн:		
Хөрөнгийн биржид бүртгэлгүй	33,700	130,000
Хөрөнгийн биржид бүртгэлтэй	86,203	-
Нийт нэмэгдсэн	119,903	130,000
Гадаад валютын ханшийн нөлөө	(417)	405,014
Хасагдсан:		
Хөрөнгийн биржид бүртгэлтэй	-	(253,566)
Хөрөнгийн биржид бүртгэлгүй	-	(3,200,000)
Нийт хасагдсан	-	(3,453,566)
12 сарын 31-ний өдрөөрх дансны үнэ	5,104,319	4,984,833
Бодит үнэ цэнийн тохируулга	(3,325,753)	(2,225,893)
12 сарын 31-ний өдрөөрх бодит үнэ цэнэ	1,778,566	2,758,940

11. ДУУСГАВАР ХУГАЦАА ХҮРТЭЛ НЬ ЭЗЭМШИХ САНХҮҮГИЙН ХӨРӨНГӨ

		2012 оны 12 сарын 31	2011 оны 12 сарын 31
		мян.төг	мян.төг
Монголбанкны үнэт цаас	(a)	247,402,728	178,576,862
Засгийн Газрын бонд	(b)	72,554,598	50,846,777
Хөрөнгийн бирж дээр бүртгэлтэй хувьцаа	(c)	2,784,250	2,738,152
Вексел	(d)	75,370,294	72,008,160
		398,111,870	304,169,951

(a) Монголбанкны ("the BOM") үнэт цаас

Монголбанкны үнэт цаас нь хөнгөлөлттэй гаргасан хүү бүхий үнэт цаас болно. 2012 болон 2011 оны 12 сарын 31-ний өдрөөр дуусвар болсон жилийн турш Монголбанкны үнэт цаасны багцад гарсан өөрчлөлт нь дараах байдалтай байна. Үүнд:

	2012 он мян.төг	2011 он мян.төг
01 сарын 01-ний өдрөөрх дансны үнэ	181,640,000	355,500,000
Бодит үнэ цэнийн тохируулга	(3,063,138)	(1,883,918)
01 сарын 01-ний өдрөөрх бодит үнэ цэнэ	178,576,862	353,616,082
Нэмэгдсэн	2,262,267,000	9,310,732,000
Хасагдсан	(2,193,907,000)	(9,484,592,000)
12 сарын 31-ний өдрөөрх дансны үнэ	250,000,000	181,640,000
Бодит үнэ цэнийн тохируулга	(2,597,272)	(3,063,138)
12 сарын 31-ний өдрөөрх бодит үнэ цэнэ	247,402,728	178,576,862

(b) Засгийн Газрын бонд

Засгийн газрын бонд нь Сангийн яамнаас хөнгөлөлттэй гаргасан 7 жилийн дотор дуусгавар болох хугацаатай бондыг илэрхийлнэ. 2012 болон 2011 оны 12 сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон жилийн турш Засгийн Газрын Бондын багцад гарсан өөрчлөлт нь дараах байдалтай байна. Үүнд:

	2012 он мян.төг	2011 он мян.төг
01 сарын 01-ний өдрөөрх дансны үнэ	49,280,000	2,000,000
Хуримтлуулсан хүүгийн орлого	1,566,777	42,400
01 сарын 01-ний өдрөөрх бодит үнэ цэнэ	50,846,777	2,042,400
Нэмэгдсэн	48,765,000	49,280,000
Хасагдсан	(24,500,000)	(2,000,000)
Хуримтлуулсан хүүгийн орлого	718,976	1,566,777
12 сарын 31-ний өдрөөрх дансны үнэ	73,545,000	49,280,000
Бодит үнэ цэнийн тохируулга	(1,709,378)	-
12 сарын 31-ний өдрөөрх бодит үнэ цэнэ	72,554,598	50,846,777

(c) Хөрөнгийн биржид бүртгэлтэй өрийн үнэт цаас

Хөрөнгийн биржид бүртгэлтэй дуусгавар хугацаа хүртэл нь эзэмших өрийн үнэт цаас нь Сингапурийн Хөрөнгийн биржид бүртгэлтэй Худалдаа Хөгжлийн Банкны хөрөнгө оруулалтыг илэрхийлнэ. 2012 болон 2011 оны 12 сарын 31-ний өдрөөр дуусвар болсон жилийн турш хөрөнгийн биржид бүртгэлтэй өрийн үнэт цаасны багцад гарсан өөрчлөлт нь дараах байдалтай байна. Үүнд:

	2012 он мян.төг	2011 он мян.төг
01 сарын 01-ний өдрөөрх дансны үнэ	2,792,740	-
Хуримтлуулсан хүүгийн орлого	44,104	-
Бодит үнэ цэнийн тохируулга	(98,692)	-
01 сарын 01-ний өдрөөрх бодит үнэ цэнэ	2,738,152	-
Нэмэгдсэн	-	2,576,040
Гадаад валютын ханшийн нөлөө	(8,540)	216,700
Хуримтлуулсан хүүгийн орлого	44,210	44,104
12 сарын 31-ний өдрөөрх дансны үнэ	2,828,410	2,836,844
Бодит үнэ цэнийн тохируулга	(44,160)	(98,692)
12 сарын 31-ний өдрөөрх бодит үнэ цэнэ	2,784,250	2,738,152



ГОЛОМТ БАНК БОЛОН ТҮҮНИЙ ОХИН КОМПАНИ

11. ДУУСГАВАР ХУГАЦАА ХҮРТЭЛ НЬ ЭЗЭМШИХ САНХҮҮГИЙН ХӨРӨНГӨ (үргэлжлэл)

(d) Вексел

	2012 он мян.төг	2011 он мян.төг
01 сарын 01-ний өдрөөрх дансны үнэ	72,062,060	-
Хуримтлуулсан хүүгийн орлого	87,599	-
Бодит үнэ цэнийн тохируулга	(141,498)	-
01 сарын 01-ний өдрөөрх бодит үнэ цэнэ	72,008,161	-
Нэмэгдсэн:		
Хөнгөлөлттэй вексел	-	9,878,080
Хүү бүхий вексел	106,094,914	60,801,100
	106,094,914	70,679,180
Хасагдсан:		
Хөнгөлөлттэй вексел	(10,996,508)	-
Хүү бүхий вексел	(98,460,200)	-
	(109,456,708)	-
Гадаад валютын ханшийн нөлөө	192,548	-
12 сарын 31-ний өдрөөрх дансны үнэ	68,892,814	72,062,060
Хуримтлуулсан хүүгийн орлого	6,477,479	87,599
Бодит үнэ цэнийн тохируулга	-	(141,498)
12 сарын 31-ний өдрөөрх бодит үнэ цэнэ	75,370,293	72,008,161

12. РЕПО ХЭЛЦЭЛ

2011 онд репо хэлцлийн хүрээнд 25 тэрбум төгрөгийн Төв Банкны үнэт цаасыг худалдан авсан. Энэхүү үнэт цаас нь 3-5 хоногийн хугацаатай байсан бөгөөд 2012 оны 01 сарын 02 болон 04-ний өдөр дуусвар болсон. Эдгээр үнэт цааснуудын бодит үнэ цэнэ нь 2011 оны 12 сарын 31-ний өдрөөрх дансны үнэтэй нь ойролцоо байсан бөгөөд 2012 онд репо хэлцлийн үлдэгдэлгүй байсан.

13. ОХИН КОМПАНИД ОРУУЛСАН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ

	2012 оны 12 сарын 31 мян.төг	2011 оны 12 сарын 31 мян.төг
Хөрөнгө оруулалт-Өртгөөр	200,000	100,000

Энэхүү дүн нь Монгол улсад үүсгэн байгуулагдаж, брокер, дилерийн үйл ажиллагаа явуулдаг Голомт Секюритиз ХХК-ийн 100 хувийн эзэмшлийн хөрөнгө оруулалтыг илэрхийлнэ.

14. ҮҮСМЭЛ САНХҮҮГИЙН ХЭРЭГСЭЛ

	2012 оны 12 сарын 31 мян.төг	2011 оны 12 сарын 31 мян.төг
Хөрөнгө		
- Борлуулах зорилгоор эзэмшиж буй үүсмэл хэрэгсэл-гадаад валютын форвард хэлцэл	3,220	-
Өр төлбөр		
- Борлуулах зорилгоор эзэмшиж буй үүсмэл хэрэгсэл -гадаад валютын форвард хэлцэл	-	1,264
- Өмчийн болон валютын үүсмэл хэрэглүүр	1,172,027	2,569,321
	1,172,027	2,570,585
	1,168,807	2,570,585



15. ХАРИЛЦАГЧДАД ОЛГОСОН ЗЭЭЛ БА УРЬДЧИЛГАА-ЦЭВЭР

	2012 оны 12 сарын 31 мян.төг	2011 оны 12 сарын 31 мян.төг
Бизнесийн зээл	754,920,977	719,650,807
Жижиг дунд бизнесийн зээл	301,498,666	214,880,293
Хэрэглээний зээл	130,739,347	126,569,077
Орон сууцны зээл	248,220,122	192,879,827
	1,435,379,112	1,253,980,004
Нэмэх нь: Хуримтлагдсан хүүгийн авлага	18,492,530	12,915,190
Хасах нь: Үнэ цэнийн бууралтын сан	(25,949,242)	(17,554,306)
Нийт зээл	1,427,922,400	1,249,340,888

2012 оны 12 сарын 31-ний өдрөөрх үнэ цэнэ нь буурсан зээлийн хуримтлагдсан хүүгийн авлага нь 12,049,228 мянган төгрөг (2011 онд 7,231,500 мянган төгрөг) байсан.

2012 оны 09-р сард Банк нь Монголын Ипотекийн Корпорацид орон сууцны моргейжийн зээлийн багцаас орох мөнгөн урсгалын 100 хувийн эрхийг худалдаж, зээлийн чанарт баталгаа гаргасан. Банк нь энэхүү багцын эрсдэл ба өгөөжийг хэвээр хадгалан үлдээж, зээлүүдийг үл хүлээн зөвшөөрөөгүй. Банк нь энэхүү ажил гүйлгээг барьцаат зээллэг хэлбэрээр бүртгэж, хүлээн авсан мөнгийг санхүүгийн өр төлбөрөөр бүртгэсэн. Шилжүүлсэн зээлийн багцын 2012 оны 12 сарын 31-ний өдрөөрх дансны үнэ нь 1,863 сая төгрөг бөгөөд санхүүгийн өр төлбөрийн дансны үнэ нь 1,864 сая төгрөг байсан.

2011 болон 2012 оны харилцагчдад олгосон зээлийн үнэ цэнийн бууралтын санд гарсан хөдөлгөөн дараах байдалтай байна :

	Бизнесийн зээл мян.төг	Жижиг дунд бизнесийн зээл мян.төг	Хэрэглээний зээл мян.төг	Орон сууцны зээл мян.төг	Нийт мян.төг
2011 оны 1 сарын 1-ний өдрөөрх зээлийн үнэ цэнийн бууралтын сан	6,696,841	2,353,077	756,209	411,492	10,217,619
Нэмэгдсэн сан/(сангийн нөхөлт)	2,878,574	5,332,301	(678,876)	(195,312)	7,336,687
2011 оны 12 сарын 31-ний өдрөөрх зээлийн үнэ цэнийн бууралтын сан	9,575,415	7,685,378	77,333	216,180	17,554,306
Нэмэгдсэн сан/(сангийн нөхөлт)	7,360,575	844,038	268,573	57,713	8,530,899
Сангаас хассан зээл	-	(81,158)	(54,806)	-	(135,964)
2012 оны 12 сарын 31-ний өдрөөрх зээлийн үнэ цэнийн бууралтын сан	16,935,990	8,448,258	291,100	273,893	25,949,241

Зээлийн гэрээний дагуу цуглуулах боломжгүй 135,964 мянган төгрөгийн зээлийг 2012 оны 09 сарын 03-ны болон 2012 оны 12 сарын 28-ны өдрийн Гүйцэтгэх Захирлын шийдвэрээр сангаас хаасан.



ГОЛОМТ БАНК БОЛОН ТҮҮНИЙ ОХИН КОМПАНИ

15. ХАРИЛЦАГЧДАД ОЛГОСОН ЗЭЭЛ БА УРЬДЧИЛГАА-ЦЭВЭР (үргэлжлэл)

Группын зээлийн нийт багцыг эдийн засгийн салбараар төвлөрөлийг харуулав:

	2012 оны 12 сарын 31-нээр		2011 оны 12 сарын 31-нээр	
	мян.төг	%	мян.төг	%
Хөдөө аж ахуй	17,652,584	1.23%	24,483,203	1.95%
Уул уурхай, хайгуул	147,034,059	10.24%	167,655,687	13.37%
Үйлдвэрлэл	124,892,340	8.70%	121,208,861	9.67%
Эрчим хүч, газрын тос	130,976,578	9.12%	70,088,410	5.59%
Барилга	138,187,750	9.63%	69,594,516	5.55%
Дэд бүтэц	23,924,755	1.67%	40,417,072	3.22%
Бөөний болон жижиглэнгийн худалдаа	147,815,956	10.30%	120,537,264	9.61%
Засвар үйлчилгээ	15,539,355	1.08%	19,493,660	1.55%
Зочид буудал, зоогийн газар	9,715,915	0.68%	34,372,580	2.74%
Аялал жуулчлал	41,318,695	2.88%	27,816,028	2.22%
Харилцаа холбоо	75,478,828	5.26%	87,555,744	6.98%
Санхүү	83,611,926	5.83%	66,548,295	5.31%
Үл хөдлөх хөрөнгө	72,412,165	5.04%	56,090,320	4.47%
Боловсрол	1,382,989	0.10%	1,270,754	0.10%
Эрүүл мэнд	7,126,253	0.50%	3,374,808	0.27%
Нийгмийн халамжийн систем	17,506,137	1.22%	17,370,759	1.39%
Хувиараа эрхлэх аж ахуй	689,900	0.05%	1,064,487	0.08%
Олон улсын байгууллага	2,784	0.00%	90,004	0.01%
Нийтийн үйлчилгээ	1,150,675	0.08%	5,708,414	0.46%
Моргейж, орон байрны засвар	248,263,205	17.30%	192,907,394	15.38%
Авто машин	7,688,923	0.54%	5,370,877	0.43%
Гэр ахуйн цахилгаан бараа	2,239,074	0.16%	3,546,555	0.28%
Цалин	120,768,266	8.41%	117,414,312	9.36%
Нийт харилцагчдад олгосон зээл	1,435,379,112	100.00%	1,253,980,004	100.00%

2012 оны 12 сарын 31-ний өдрийн байдлаар Группын 21 (2011 онд: 25) зээлдэгч өөрийн хөрөнгийн 10 хувиас давсан зээлтэй байсан. Эдгээр зээлийн дүн нь нийт 595,700,219 мянган төгрөг буюу харилцагчдад олгосон зээлийн 42 хувь (2011 онд: 545,919,967 мянган төгрөг буюу харилцагчдад олгосон нийт зээлийн 44 хувь)-тай тэнцүү байсан.



2012 оны 12 сарын 31-ний байдлаар зээлүүдийн чанарын шинжилгээ нь дараах байдалтай байна.

	Нийт зээл мян.төг	Үнэ цэнийн бууралтын нөөц мян.төг	Үнэ цэнийн бууралт хассан цэвэр зээл мян.төг	Үнэ цэнийн бууралт/Нийт зээл %
Бизнесийн зээл				
Тусгай үнэлгээгээр үнэ цэнэ буурсан зээл	16,480,610	13,113,039	3,367,570	79.57%
Хэвийн зээл (хугацаандаа байгаа)				
Бүлгийн үнэлгээгээр үнэ цэнэ буурсан зээл	738,440,367	3,822,951	734,617,416	0.52%
Хэвийн зээл (хугацаандаа байгаа)	734,264,067	3,822,951	730,441,116	0.52%
Хугацаа хэтрэлт-1 сар	-	-	-	0.00%
Хугацаа хэтрэлт-1-2 сар	4,176,300	-	4,176,300	0.00%
Хугацаа хэтрэлт-2-3 сар	-	-	-	0.00%
Хугацаа хэтрэлт-3 сараас дээш	-	-	-	0.00%
Нийт бизнесийн зээл	754,920,977	16,935,990	737,984,986	2.24%
Жижиг дунд бизнесийн зээл				
Тусгай үнэлгээгээр үнэ цэнэ буурсан зээл	22,943,736	6,608,569	16,335,167	28.80%
Хэвийн зээл (хугацаандаа байгаа)				
Бүлгийн үнэлгээгээр үнэ цэнэ буурсан зээл	278,554,930	1,839,689	276,715,241	0.66%
Хэвийн зээл (хугацаандаа байгаа)	266,792,037	1,519,682	265,272,355	0.57%
Хугацаа хэтрэлт-1 сар	3,120,832	12,342	3,108,490	0.40%
Хугацаа хэтрэлт-1-2 сар	2,097,497	57,411	2,040,086	2.74%
Хугацаа хэтрэлт-2-3 сар	1,761,165	82,940	1,678,225	4.71%
Хугацаа хэтрэлт-3 сараас дээш	4,783,399	167,314	4,616,085	3.50%
Нийт жижиг дунд бизнесийн зээл	301,498,666	8,448,258	293,050,408	2.80%
Хэрэглээний зээл				
Тусгай үнэлгээгээр үнэ цэнэ буурсан зээл	203,857	203,857	-	100.00%
Хэвийн зээл (хугацаандаа байгаа)				
Бүлгийн үнэлгээгээр үнэ цэнэ буурсан зээл	130,535,490	87,243	130,448,247	0.07%
Хэвийн зээл (хугацаандаа байгаа)	126,615,334	32,447	126,582,886	0.03%
Хугацаа хэтрэлт-1 сар	1,527,968	5,171	1,522,797	0.34%
Хугацаа хэтрэлт-1-2 сар	251,323	2,995	248,329	1.19%
Хугацаа хэтрэлт-2-3 сар	237,842	3,826	234,016	1.61%
Хугацаа хэтрэлт-3 сараас дээш	1,903,023	42,804	1,860,219	2.25%
Нийт хэрэглээний зээл	130,739,347	291,100	130,448,247	0.22%



ГОЛОМТ БАНК БОЛОН ТҮҮНИЙ ОХИН КОМПАНИ

15. ХАРИЛЦАГЧДАД ОЛГОСОН ЗЭЭЛ БА УРЬДЧИЛГАА-ЦЭВЭР (үргэлжлэл)

2012 оны 12 сарын 31-ний байдлаар зээлүүдийн чанарын шинжилгээ нь дараах байдалтай байна.

	Нийт зээл мян.төг	Үнэ цэнийн бууралтын нөөц мян.төг	Үнэ цэнийн бууралт хассан цэвэр зээл мян.төг	Үнэ цэнийн бууралт/ Нийт зээл %
Орон сууцны зээл				
Тусгай үнэлгээгээр үнэ цэнэ буурсан зээл	437,753	34,368	403,385	7.85%
Хэвийн зээл (хугацаандаа байгаа)				
Бүлгийн үнэлгээгээр үнэ цэнэ буурсан зээл	247,782,369	239,526	247,542,844	0.10%
Хэвийн зээл (хугацаандаа байгаа)	241,282,890	179,618	241,103,274	0.07%
Хугацаа хэтрэлт-1 сар	1,706,056	1,103	1,704,954	0.06%
Хугацаа хэтрэлт-1-2 сар	1,135,442	7,605	1,127,837	0.67%
Хугацаа хэтрэлт-2-3 сар	822,604	7,485	815,118	0.91%
Хугацаа хэтрэлт-3 сараас дээш	2,835,377	43,715	2,791,661	1.54%
Нийт орон сууцны зээл	248,220,122	273,894	247,946,229	0.11%
Нийт харилцагчдад олгосон зээл	1,435,379,112	25,949,242	1,409,429,870	1.81%

Тусгай үнэлгээгээр үнэлэгдсэн зээлүүд нь үнэ цэнийн хувьд материаллаг ба/эсвэл үнэ цэнийн бууралтын шинж агуулсан зээлүүд бөгөөд Групп тусгайлан үнэлсэн.

Үнэ цэнэ нь буураагүй зээлүүд нь төлбөр гүйцэтгэх болон ашигт ажиллагааны өндөр түвшинд харилцагчдад олгосон зээлийг илэрхийлэх бөгөөд тус бүртээ үнэ цэнэ нь буурсан шинж тэмдэггүй зээлүүд болно.

Бүлгээр нь үнэлсэн зээлүүд нь эрсдэлийн хувьд буюу үнэ цэнийн бууралтын ижил буюу энгийн шинж чанараар нь нэг төрлийн санд бүлэглэсэн зээлүүдийг агуулна.

Үнэ цэнийн бууралтын шинж тэмдэггүй харилцагчдад олгосон зээлийн чанар нь салбарын эрсдэл болон зээлдэгчдийн санхүүгийн байдлын шинж чанарын хувьд ялгаатай тул нэг төрлийн байдаггүй.

Хугацаа хэтэрсэн зээлээр хүлээн зөвшөөрөгдсөн дүнгүүд нь бүх үлдэгдлээрээ болон графикт төлбөрийн хугацаа хэтэрсэн дүнгүүдийг илэрхийлнэ.



2011 оны 12 сарын 31-ний байдлаар зээлүүдийн чанарын шинжилгээ нь дараах байдалтай байна.

	Нийт зээл мян.төг	Үнэ цэнийн бууралтын сан мян.төг	Үнэ цэнийн бууралт хассан цэвэр зээл мян.төг	Үнэ цэнийн бууралт/ Нийт зээл %
Бизнесийн зээл				
Тусгай үнэлгээгээр үнэ цэнэ буурсан зээл	11,515,894	4,957,479	6,558,415	43.05%
Хэвийн зээл (хугацаандаа байгаа)				
Бүлгийн үнэлгээгээр үнэ цэнэ буурсан зээл	708,134,913	4,617,935	703,516,978	0.65%
Хэвийн зээл (хугацаандаа байгаа)	693,187,379	4,069,396	689,117,983	0.59%
Хугацаа хэтрэлт-1 сар	5,953,406	15,015	5,938,391	0.25%
Дараах хүснэгтэд тухайн жилийн хугацаанд ажиллагсдын хөдөлмөрийн хөлсөнд хүлээн зөвшөөрсөн зардлыг харуулав:

	2012	2011
Төлбөрийг хувьцаагаар олгох,		
Хувьцаанд суурилсан опционы ажил гүйлгээний зардал	372,543	1,500,000

Удирдлага болон ажилчдын хувьцааны опционы хөтөлбөр

Банк нь 2011 оны 04 сарын 12-ны өдөр 523,000 хувьцааны опционыг тус өдрөөр 5-с дээш жил ажилласан удирдлага болон бусад ажилчдад олгосон. Опционы хэрэгжих үнэ нь опционыг гаргаснаас өмнөх тайлант жилийн нэгж хувьцаанд ногдох цэвэр хөрөнгийн дүн буюу 3,834 төгрөг байхаар тодорхойлсон. Опцион нь олгосон өдрөө хэрэгжсэн. Олгогдсон опционы гэрээний хүчинтэй хугацаа 3 жил байх ба төлбөрийг мөнгөөр барагдуулах хувилбаргүй байна.

2012 оны 03 сарын 14-ны өдөр Банк нэмж 310,000 хувьцааны опционыг тус өдрөөр 5-с дээш жил ажилласан удирдлага болон бусад ажилчдад олгосон бөгөөд энэ нь олгосон өдрөөс хойш 2,5 жилийн дотор бүтэн дүнгээр хэрэгжинэ. Опционы хэрэгжих үнэ нь опционыг гаргаснаас өмнөх тайлант жилийн сүүлийн өдрийн нэгж хувьцаанд ногдох цэвэр хөрөнгийн дүн буюу 5,702 төгрөг байхаар тодорхойлсон. Опцион тус бүрийн хувьд гэрээний хугацаа 3 жил бөгөөд төлбөрийг мөнгөөр барагдуулах хувилбаргүй байна.

Опционы бодит үнэ цэнийг опционыг олгох өдрөөр Биноминал үнэлгээний аргачлал ашиглан олгосон өдрийн өгөгдөл, нөхцөлд оролцуулан тооцно.

	2012		2011	
	Хувьцааны опционы тоо	Жигнэсэн дундаж хэрэгжих үнэ	Хувьцааны опционы тоо	Жигнэсэн дундаж хэрэгжих үнэ
Тайлант хугацааны эхний үлдэгдэл	498,150	3,834	-	
Тухайн жилд олгосон	310,000	5,702	523,000	3,834
Тухайн жилд хэрэгжсэн	(16,050)	3,834	(24,850)	3,834
	792,100	4,768	498,150	3,834

2012 оны 12 сарын 31-ний байдлаар хувьцааны опционы гэрээний жигнэсэн дундаж үлдэгдэл хугацаа 1,74 жил байсан (2011: 2.28 жил).

Тайлант жилд олгосон опционы жигнэсэн дундаж бодит үнэ 3,795 төгрөг байсан (2011: 3,317 төгрөг).

Хувьцаанд суурилсан опционы тооцооллыг хийхэд хувьцааны одоогийн 8,385 төгрөгийн үнэ (2011: 6,158 төгрөг), хэрэгжих үеийн 5,702 төгрөгийн үнэ (2011: 3,834 төгрөг), хүлээгдэж буй хазайлт 7.382 хувь (2011: 5.195 хувь), мөн эрсдэлгүй хүүгийн түвшин 7.5 хувь (2011: 10 хувь) зэргийг ашигласан болно.

Хувьцааны хүлээгдэж буй хугацаа нь заавал хэрэгжих гэсэн утгыг илэрхийлэхгүй ба түүхэн өгөгдөлд суурилсан болно. Хүлээгдэж буй хазайлт нь түүхэн хазайлт бол бодит нөхцөл байдалтай ижил байх шаардлагагүй ирээдүйн хандлагыг илэрхийлнэ гэсэн төсөөллийг тусгана. Бодит үнэ цэнийн тооцоололд опцион гаргахтай холбоотой өөр ухагдахуун тусгаагүй болно.



ГОЛОМТ БАНК БОЛОН ТҮҮНИЙ ОХИН КОМПАНИ

48. БОЛЗОШГҮЙ ӨР ТӨЛБӨР БОЛОН ҮҮРЭГ

Харилцагчдын санхүүгийн хэрэгцээ, шаардлагыг хангахын тулд Банк болон Групп нь янз бүрийн буцалтгүй үүрэг болон болзошгүй өр төлбөр хүлээж байдаг. Хэдийгээр эдгээр үүргийг санхүүгийн байдлын тайланд хүлээн зөвшөөрөхгүй ч эдгээр нь Групп болон Банкны нийт эрсдэлийг бүрдүүлэх зээлийн эрсдэлийг агуулж байдаг. Доорх хүснэгтэд мэдээллийг харуулав:

	2012	2011
	мян.төг	мян.төг
Гаргасан санхүүгийн баталгаа	54,297,834	13,511,110
Гүйцэтгэлийн баталгаа	131,108,157	79,426,228
Аккредитив	99,881,607	112,134,143
Хасах: Зээлтэй холбоотой үүргийн үнэ цэнийн бууралтын нөөц	(2,215,362)	(91,374)
	283,072,236	204,980,107
Олгогдоогүй зээл	39,446,920	29,804,038
Зээлтэй холбоотой нийт үүрэг хариуцлага	322,519,156	234,784,145

Аккредитив, баталгаа (нээлтэй аккредитив хамаарагдана) нь тусгайлсан ажил гүйлгээнд ихэнхдээ бараа бүтээгдэхүүний импорт болон экспорттой холбоотойгоор харилцагчийн өмнөөс төлбөр хийх үүргийг Банкинд ногдуулдаг байна. Баталгаа, нээлтэй аккредитив нь хэдийгээр болзошгүй шинж чанартай боловч зээлтэй ижил төрлийн эрсдэлийг агуулдаг. Эдгээр ажил гүйлгээний үр дүнд материаллаг алдагдал байхгүй гэж таамаглаж байна.

2012 оны 12 сарын 31-ны байдлаар Банкны эсрэг 2012 оны 07 сарын 09 өдөр Япон Улсын аж ахуйн нэгжээс үүсгэсэн томоохон хэмжээний шүүхийн нэхэмжлэх байсан. Тус нэхэмжлэх нь 2007 болон 2008 онд Япон Улсын аж ахуйн нэгжийн зөвшөөрснөөр Банкнаас гаргасан 18 ширхэг аккредитивтай холбоотой бөгөөд төлөгдөөгүй үлдэгдлийн нийт дүн 3,421,46,272 иен (ойролцоогоор 57.34 тэрбум төгрөг) юм. Банк уг аккредитивтай холбоотой худалдааны ажил гүйлгээ нь хүчингүй болсон гэж үзсэн удирдлагын шийдвэрт тулгуурлан нэхэмжлэхийг хүлээн зөвшөөрөхгүй байгаагаа илэрхийлсэн.

2013 оны 02 сарын 05 өдөр буюу тайлант жилийн дараа хоёр тал болох Япон Улсын аж ахуйн нэгж болон Банкны хооронд гэрээ байгуулж, тус гэрээгээр нэхэмжлэгчийн худалдан авагчид хүлээлгэн өгсөн бараа бүтээгдэхүүний үнийн дүнтэй тэнцэхүйц дүн болох 1,2 сая ам.доллар (ойролцоогоор 1,67 тэрбум төгрөг)-г гэрээ хүчин төгөлдөр болсноос 7 өдрийн хугацаанд төлөхөөр зөвшөөрсөн байна. Тус төлбөр нь талуудын хоорондын маргааныг бүрэн шийдвэрлэснээр Япон Улсын аж ахуйн нэгж Банкны эсрэг үүсгэсэн нэхэмжлэхийг шүүхээс буцаан авах хүсэлт гаргасан бөгөөд тус хүсэлтээр уг хэрэг Монгол Улсын Иргэний Хуулийн дагуу хаагдсан.

2012 оны 12 сарын 31-ны байдлаар Банк нэхэмжлэхийн нийт бөгөөд эцсийн төлбөр болох 1,2 сая ам.доллар (ойролцоогоор 1,67 тэрбум төгрөг)-н нөөцийг байгуулсан. Тайлант хугацааны эцсээр Банк Япон Улсын аж ахуйн нэгжид 1,2 сая ам.долларын төлбөрийг төлсөн.

49. ХОЛБООТОЙ ТАЛУУД

Эдгээр санхүүгийн тайлангийн зорилгоор талууд нь НББОУС 24 буюу "Холбоотой Талын Тодруулга"-д тодорхойлсноор хэрвээ тухайн компани нь нөгөө этгээдийн санхүүгийн болон бусад үйл ажиллагаатай холбоотой шийдвэр гаргалтанд нөлөө үзүүлэх буюу хянах чадвартай бол холбоотой талууд гэж тодорхойлно. Холбоотой талуудын магадлалт хамаарлыг авч үзэхдээ хуулийн хэлбэрээс илүү эдийн засгийн холбоо хамаарлыг авч үздэг.

Бизнесийн ердийн үйл ажиллагааны явцад Банк болон Групп нь хувь нийлүүлэгчид, захирлууд болон бусад холбоотой талуудтай ажил гүйлгээ явуулдаг. Эдгээр ажил гүйлгээнүүдэд төлбөр тооцоо, зээл олгох, хадгаламж татан төвлөрүүлэх, арилжаа, гадаад валютын худалдаа зэрэг нь хамаарагдана. Группын бодлогын дагуу холбоотой талуудын ажил гүйлгээнүүд гэдэгт тухайн ажил гүйлгээнд зонхилон гарч ирдэг ижил нөхцлөөр хийгдсэн холбоотой талуудын ажил гүйлгээг хамруулна.



2012 болон 2011 оны 12 сарын 31-ний байдлаар холбоотой талуудтай хийсэн ажил гүйлгээнүүдийн үлдэгдэл доорх хүснэгтэд илэрхийлэгдсэн:

	Захирлууд болон гол удирдах албан тушаалтнууд		Бусад холбоотой талууд	
	2012 мян.төг	2011 мян.төг	2012 мян.төг	2011 мян.төг
Харилцагчдад олгосон зээл				
01 сарын 01 байдлаар харилцагчдад олгосон зээл (нийт)	324,658	67,655	15,790,758	2,917,544
Тайлант хугацаанд харилцагчдад олгосон зээл	9,029,985	252,709	16,007,290	14,294,092
Тайлант хугацаанд төлөгдсөн	(129,589)	(16,866)	(17,520,418)	(2,617,241)
Ханшийн зөрүү	314,979	21,160	97,795	1,196,364
12 сарын 31-ны байдлаарх харилцагчдад олгосон зээл (нийт)	9,540,033	324,658	14,375,425	15,790,759

2012 оны байдлаар холбоотой талуудтай хийсэн хөрөнгийн ажил гүйлгээний үлдэгдлийг доорх хүснэгтэд харуулав:

	Хувьцаа эзэмшигчид	Захирлууд болон гол удирдах албан тушаалтнууд	Бусад	Нийт
	мян.төг	мян.төг	мян.төг	мян.төг
Харилцагчдад олгосон зээл				
01 сарын 01 байдлаар харилцагчдад олгосон зээл (нийт)	877,323	324,658	14,913,435	16,115,416
Тайлант хугацаанд харилцагчдад олгосон зээл	384,230	9,029,985	15,623,060	25,037,275
Тайлант хугацаанд төлөгдсөн	(224,964)	(129,589)	(17,295,454)	(17,650,007)
Ханшийн зөрүү	-	314,979	97,795	412,774
12 сарын 31-ны байдлаарх харилцагчдад олгосон зээл (нийт)	1,036,589	9,540,033	13,338,836	25,037,275

2011 оны байдлаар холбоотой талуудтай хийсэн хөрөнгийн ажил гүйлгээний үлдэгдлийг доорх хүснэгтэд харуулав:

	Хувьцаа эзэмшигчид	Захирлууд болон гол удирдах албан тушаалтнууд	Бусад	Нийт
	мян.төг	мян.төг	мян.төг	мян.төг
Харилцагчдад олгосон зээл				
01 сарын 01 байдлаар харилцагчдад олгосон зээл (нийт)	286,325	67,655	2,631,219	2,985,199
Тайлант хугацаанд харилцагчдад олгосон зээл	669,092	252,709	13,625,000	14,546,801
Тайлант хугацаанд төлөгдсөн	(78,094)	(16,866)	(2,539,147)	(2,634,107)
Ханшийн зөрүү	-	21,160	1,196,364	1,217,524
12 сарын 31-ны байдлаарх харилцагчдад олгосон зээл (нийт)	877,323	324,658	14,913,436	16,115,417

2012 оны байдлаар холбоотой талуудтай хийсэн өр төлбөрийн ажил гүйлгээний үлдэгдлийг доорх хүснэгтэд харуулав:

	Хувьцаа эзэмшигчид	Захирлууд болон гол удирдах албан тушаалтнууд	Бусад	Нийт
	мян.төг	мян.төг	мян.төг	мян.төг
Харилцагчдын харилцах, хадгаламж				
2012/01/01 –р харилцагчдын харилцах, хадгаламж	9,714,489	434,918	10,238,194	20,387,602
Тайлант жилд хүлээн авсан	182,624,580	3,283,628	112,983,037	298,891,244
Тайлант жил буцаан төлсөн	(188,322,172)	(3,130,658)	(118,870,050)	(310,322,880)
Ханшийн зөрүү	(285,032)	31,178	4,411	(249,443)
2012/12/31 –р харилцагчдын харилцах, хадгаламж	3,731,865	619,066	4,355,592	8,706,523



ГОЛОМТ БАНК БОЛОН ТҮҮНИЙ ОХИН КОМПАНИ

49. ХОЛБООТОЙ ТАЛУУД (үргэлжлэл)

Тайлант хугацааны эцэст холбоотой талуудад гаргасан баталгааны үлдэгдэл дүнг доорх хүснэгтэд харуулав:

	2012 мян.төг	2011 мян.төг
Баталгаа		
01 сарын 01-ний өдрөөрх банкны батлалгаа	-	-
Гаргасан баталгаа	16,539,150	-
12 сарын 31-ний өдрөөрх банкны баталгаа	16,539,150	-

Захирлууд болон гол удирдах албан тушаалтнуудад ерөнхийдөө ТУЗ болон гүйцэтгэх удирдлагын зөвлөлийн гишүүд багтана.

Бусад холбоотой талуудад банк болон Банкны гол хувьцаа эзэмшигчдийн хяналтанд байдаг компаниуд багтана.

2012 онд гол удирдах албан тушаалтнуудад олгосон төлбөр болон цалин хөлс нь нийт 706,750 мянган төгрөг байна (2011:442,151 мянган төгрөг).

	2012 Зардал мян.төг	Хуримтлуулсан өр төлбөр мян.төг	2011 Зардал мян.төг	Хуримтлуулсан өр төлбөр мян.төг
Богино хугацаат төлбөрүүд:				
- Цалин	609,312	37,230	346,578	22,280
- Богино хугацаат урамшуулал	27,075	-	33,989	-
- Бусад богино хугацаат төлбөрүүд	27,013	-	30,334	-
- Жилийн бонус	43,350	-	31,250	-
Хувьцаанд суурилсан төлбөр:				
- Ногдол ашиг				
Нийт	706,750	37,230	442,151	22,280

50. САНХҮҮГИЙН ХЭРЭГЛҮҮРҮҮДИЙН БОДИТ ҮНЭ ЦЭНЭ

Татан буугдалт эсвэл албадан борлуулалтаас бусад тохиолдолд, тухайн хэрэглүүрийг сонирхож буй талуудын хоорондох идэвхитэй зах зээл дээр арилжаалагдах дүнгээр бодит үнэ цэнийг тодорхойлдог. Идэвхитэй зах зээлд арилжаалагддаг санхүүгийн хэрэглүүр нь бодит үнэ цэнийн хамгийн тодорхой нотолгоо юм.

Хэрвээ Группын санхүүгийн хэрэглүүрийн голлох хэсэгт идэвхитэй зах зээл байхгүй бол бодит үнэ цэнэ нь тухайн эдийн засгийн нөхцөл байдал болон хэрэглүүртэй шууд хамааралтай тусгай эрсдэлд суурилагддаг. Доорх үзүүлсэн тооцоолол нь Группын тодорхой хэрэглүүрийг зах зээл дээр бүхэлд нь арилжихад хэрэгжих мөнгөн дүнг илэрхийлэх шаардлагагүй болно.

2012 болон 2011 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх Группын санхүүгийн хэрэглүүрүүдийн хэмжигдсэн бодит үнэ цэнийг доорх хүснэгтэд харуулав:



	2012		2011	
	Дансны үнэ мян.төг	Бодит үнэ мян.төг	Дансны үнэ мян.төг	Бодит үнэ мян.төг
Санхүүгийн хөрөнгө				
Мөнгө болон түүнтэй адилтгах хөрөнгө	186,730,836	186,730,836	95,317,841	95,317,841
Төв банк дах мөнгөн хөрөнгийн заавал байх нөөц	239,329,820	239,329,820	194,549,220	194,549,220
Бусад банк санхүүгийн байгууллагад байршуулсан хөрөнгө	214,670,056	214,721,585	221,882,444	221,882,444
Харилцагчдад олгосон зээл	1,427,922,400	1,427,922,400	1,249,340,888	1,249,340,888
Санхүүгийн хөрөнгө				
-Борлуулахад бэлэн	5,104,319	1,778,566	4,984,833	2,758,940
- Бодит үнэ цэнийн өөрчлөлт нь орлого, зардлын дансанд бүртгэгдсэн	6,454,413	5,897,807	1,235,916	1,061,151
- дуусвар хугацаа хүртэл нь эзэмших	402,462,679	398,111,870	307,473,280	304,169,951
Бусад авлага	10,132,834	10,132,834	6,833,456	6,833,456
Санхүүгийн өр төлбөр				
Бусад банк, санхүүгийн байгууллагын харилцах, хадгаламж	46,989,030	46,989,030	9,496,253	9,228,503
Харилцагчдын харилцах, хадгаламж	2,056,530,371	2,056,530,371	1,839,222,798	1,839,222,798
Зээлээр авсан эх үүсвэр	112,840,408	93,910,933	63,428,871	54,275,492
Үүсмэл санхүүгийн хэрэглүүр	1,172,027	1,172,027	2,570,585	2,570,585
Хоёрдогч өглөг	34,691,374	34,691,374	47,864,614	47,864,614
Бусад өр төлбөр	80,739,098	80,739,098	25,088,688	25,088,688

Доорх тооцоолол болон төсөөллүүд нь Группын санхүүгийн хэрэглүүрүүдийг бодит үнэ цэнээр хэмжих үед ашиглагдсан болно. Үүнд:

Мөнгө болон түүнтэй адилтгах хөрөнгө. Мөнгө болон түүнтэй адилтгах хөрөнгийн бодит үнэ цэнэ нь тэдгээрийн дансны үнээр тодорхойлогдоно.

Бодит үнээр бүртгэгдэх санхүүгийн хэрэглүүр. Ашиг, алдагдлаар дамжин бодит үнэ цэнээр тусгагдах санхүүгийн хөрөнгө ба санхүүгийн өр төлбөр, борлуулахад бэлэн санхүүгийн хөрөнгө, репо хэлцэлээр баталгаажсан санхүүгийн хэлцэлүүд нь бодит үнэ цэнээрээ санхүүгийн байдлын тайланд тусгагдана. Зах зээл дээрх үнийг нь тусад нь тогтоох боломжгүй тухайлсан борлуулахад бэлэн санхүүгийн хөрөнгийн хувьд холбоотой бус гуравдагч талд оруулсан хөрөнгө оруулалтын сүүлийн үеийн борлуулалтын мэдээлэл, дискаунтласан мөнгөн урсгал, санхүүжигчийн санхүүгийн мэдээлэлд үндэслэн, үнэлгээний бусад арга техникийг ашиглан бодит үнэ цэнийг тогтоодог.

Бусад банк санхүүгийн байгууллагад байршуулсан харилцах хадгаламж. Хөвөгч хүүтэй хэрэглүүрүүдийн бодит үнэ цэнэ нь тэдгээрийн дансны үнэ байдаг. Тогтмол хүүгийн түвшинтэй хэрэглүүрийн тооцоологдсон бодит үнэ цэнэ нь ижил төрлийн зээлийн эрсдэл болон дуусгавар хугацаатай санхүүгийн хэрэглүүрүүдийн тухайн гүйлгээнд давамгайлалч мөнгөний зах зээлийн хүүгийн түвшнээр дискаунтчилсан мөнгөн урсгалд үндэслэнэ. Группын удирдлагууд 2012 болон 2011 оны 12 сарын 31 байдлаарх бусад банк санхүүгийн байгууллагад байршуулсан харилцах, хадгаламжийн бодит үнэ цэнэ нь дансны үнээс материаллаг зөрүүгүй гэдэгт итгэж байгаа. Учир нь эдгээр нь хөрөнгө оруулалтын богино хугацааны шинж чанарыг агуулна.

Харилцагчдад олгосон зээл. Харилцагчдад олгосон зээл нь үнэ цэнийн бууралтын нөөцийг хассан цэвэр дүнгээр тайлагнагдсан. Харилцагчдад олгосон зээлийн тооцоологдсон бодит үнэ цэнэ нь ирээдүйд хүлээн авахаар хүлээгдэж буй мөнгөн урсгалын дискаунтласан дүнг илэрхийлнэ. Бодит үнэ цэнийг тодорхойлохдоо хүлээгдэж буй мөнгөн урсгалыг одоогийн зах зээлийн хүүгийн түвшнээр дискаунтчилна.

Дуусгавар хугацаа хүртэл эзэмших санхүүгийн хөрөнгө. Хорогдуулсан өртөгөөр бүртгэгдсэн тогтмол хүүгийн түвшинтэй дуусгавар хугацаа хүртэл эзэмших санхүүгийн хөрөнгө оруулалтын бодит үнэ цэнийг тодорхойлохдоо эдгээр хэрэглүүрүүдийн анхны хүлээн зөвшөөрөлтөөрх зах зээлийн хүүгийн түвшинг ижил төрлийн санхүүгийн хэрэглүүрүүдийн одоогийн зах зээлийн хүүгийн түвшинтэй харьцуулан тодорхойлно. Тогтмол хүүгийн түвшинтэй дуусгавар хугацаа хүртэл эзэмших санхүүгийн хөрөнгө оруулалтын тооцоологдсон бодит үнэ цэнэ нь ижил төрлийн зээлийн эрсдэлтэй болон дуусгавар хугацаатай өрийн хэрэглүүрүүдийн зах зээлийн хүүгийн түвшнээр дискаунтласан мөнгөн урсгалд суурилна.

Бусад банк санхүүгийн байгууллагын харилцах хадгаламж. 1 сараас доош хугацаатай бусад банк санхүүгийн байгууллагын харилцах хадгаламжийн бодит үнэ цэнэ нь тэдгээрийн богино хугацаанд дуусгавар болох байдлаас шалтгаалан дансны үнэтэй нь ойролцоо байна. 1 сараас дээш хугацаатай бусад банк санхүүгийн байгууллагын харилцах хадгаламжийн бодит үнэ цэнэ нь тухайн жилийн эцэс дэх зээлийн хүүгийн түвшнээр дискаунтчилан тооцоологдсон ирээдүйн мөнгөн урсгалын өнөөгийн үнэ цэнэ байна. Группын зүгээс 2012 болон 2011 оны 12 сарын 31-нээрх бусад банк санхүүгийн байгууллагын харилцах хадгаламжийн бодит үнэ цэнэ нь дансны үнээсээ материаллаг зөрүүгүй гэдэгт итгэж байгаа. Учир нь эдгээр нь өр төлбөрийн богино хугацаанд дуусвар болох шинж чанарыг агуулдаг.



ГОЛОМТ БАНК БОЛОН ТҮҮНИЙ ОХИН КОМПАНИ

50. САНХҮҮГИЙН ХЭРЭГЛҮҮРҮҮДИЙН БОДИТ ҮНЭ ЦЭНЭ (үргэлжлэл)

Харилцагчдын харилцах хадгаламж. Хугацаагүй өр төлбөрийн бодит үнэ цэнийн тооцоолол нь зээлдэгчийн хүсэлтээрх өр төлбөрийн дүнд үндэслэгдэнэ. Тогтмол хүүгийн түвшинтэй болон хөрөнгийн биржид арилжаалагддаггүй бусад өр төлбөрийн тооцоологдсон бодит үнэ цэнэ нь ижил дуусгавар болох хугацаатай өрийн хэрэглүүрүүдийн хувьд хүүгийн түвшний мөнгөн урсгалыг дискаунтчилна.

Бусад зээлээр авсан эх үүсвэр. Хөрөнгийн биржид арилжаалагддаггүй тогтмол хүүгийн түвшинтэй бусад зээлээрх эх үүсвэрийн бодит үнэ цэнэ нь ижил хугацаанд дуусгавар болох өрийн хэрэглүүрүүдийн хувьд мөнгөн урсгалын хүүгийн түвшнээр дискаунтчилагдана. Хөвөгч хүүтэй зээлээрх эх үүсвэрийн бодит үнэ цэнэ нь тэдгээрийн дансны үнээр тусгагдана.

Доорх хүснэгтэд 2012 оны 12 сарын 31-ны байдлаарх санхүүгийн хөрөнгийн бодит үнэ цэнийн шатлалыг харуулав. Түвшин 1-д идэвхитэй зах зээл дээр арилжаалагдаж байгаа санхүүгийн хөрөнгүүдийг хамруулах бөгөөд эдгээр нь зах зээлийн үнээр хэмжигдэнэ. Түвшин 3-т бодит үнэ цэнэ нь тодорхой үнэлэмж эсвэл бодит үнийг тооцох тусгай арга хэрэгсэл ашигладаг гэхдээ энэ аргад ашигласан үзүүлэлтүүд нь зах зээлийн өгөгдөлд суурилагаагүй санхүүгийн хөрөнгүүдийг хамруулна.

Доорх хүснэгт нь 2012 оны 12 дугаар сарын 31-ны байдлаарх санхүүгийн хөрөнгийн бодит үнэ цэнийн шатлалын түвшинг илэрхийлнэ.

	Түвшин 1 мян.төг	Түвшин 1 мян.төг	Түвшин 3 мян.төг	Нийт мян.төг
Санхүүгийн хөрөнгө				
<i>Үүсмэл санхүүгийн хэрэглүүр</i>				
Гадаад валютын форвард хэлцэл	-	3,220	-	3,220
<i>Арилжаалах зорилгоор эзэмшиж буй санхүүгийн хөрөнгө оруулалт</i>				
Биржид бүртгэгдсэн үнэт цаас	5,897,807	-	-	5,897,807
<i>Борлуулахад бэлэн санхүүгийн хөрөнгө оруулалт</i>				
Биржид бүртгэлгүй үнэт цаас	-	-	679,271	679,271
Биржид бүртгэгдсэн үнэт цаас	1,099,295	-	-	1,099,295
Нийт	6,997,102	3,220	679,271	7,679,593
Санхүүгийн өр төлбөр				
<i>Үүсмэл санхүүгийн хэрэглүүр</i>				
Өмч, валютын үүсмэл хэрэглүүр	-	-	1,172,027	-
Нийт	-	-	1,172,027	-

Доорх хүснэгт нь 2011 оны 12 дугаар сарын 31-ны байдлаарх санхүүгийн хөрөнгийн бодит үнэ цэнийн шатлалын түвшинг илэрхийлнэ.

	Түвшин 1 мян.төг	Түвшин 1 мян.төг	Түвшин 3 мян.төг	Нийт мян.төг
Санхүүгийн хөрөнгө				
<i>Үүсмэл санхүүгийн хэрэглүүр</i>				
Гадаад валютын форвард хэлцэл	-	-	-	-
<i>Арилжаалах зорилгоор эзэмшиж буй санхүүгийн хөрөнгө оруулалт</i>				
Биржид бүртгэгдсэн үнэт цаас	1,061,151	-	-	1,061,151
<i>Борлуулахад бэлэн санхүүгийн хөрөнгө оруулалт</i>				
Биржид бүртгэлгүй үнэт цаас	-	-	642,922	642,922
Биржид бүртгэгдсэн үнэт цаас	2,116,018	-	-	2,116,018
Нийт	3,177,169	-	642,922	3,820,091
Санхүүгийн өр төлбөр				
<i>Үүсмэл санхүүгийн хэрэглүүр</i>				
Өмч, валютын үүсмэл хэрэглүүр	-	-	2,758,940	2,758,940
Нийт	-	-	2,758,940	2,758,940



51. ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГА

Банк болон Группийн эрсдэлийн удирдлагад санхүүгийн (зээлийн, зах зээлийн, гадаад валютын, хөрвөх чадварын болон хүүгийн түвшний эрсдэл) эрсдлүүд, үйл ажиллагааны болон хууль зүйн эрсдэлүүд хамаардаг. Санхүүгийн эрсдэлийн удирдлагын үндсэн зорилго нь хүлээх эрсдэлийн хязгаарлалтыг тогтоож хүлээсэн эрсдэлийн хэмжээг эдгээр хязгаарлалтаас хэтрүүлэхгүй байлгахад оршино. Эрсдэлийн хэмжээг үнэлэх нь мөн эрсдэлээр тохируулагдсан капиталын хуваарилах, бизнесийн гүйцэтгэлийн үнэлэгээ болон ажил гүйлгээний үнэ тогтооход үндсэн суурь болж байдаг. Үйл ажиллагааны болон хууль зүйн эрсдэлийн удирдлага нь дотоодын бодлого журмын зөв хэрэгжилтийг хангаснаар үйл ажиллагааны болон хууль зүйн эрсдэлүүдийг хамгийн бага түвшинд байлгахад чиглэгдэнэ.

51.13 Зээлийн эрсдэл

Банк болон Групп нь хамтрагч тал нь төлбөрийн үүргээ хугацаанд нь биелүүлээгүйгээс үүдэж гарах зээлийн эрсдэлд өртөх магадлалтай. Групп ба Банк нь тухайн нэг зээлдэгч болон бүлэг зээлдэгчдийн хувьд өөрийн хүлээн зөвшөөрч болох эрсдэлийн дүнд тохирсон хязгаарыг бий болгох түүнийг хянах замаар эрсдэлийг удирддаг. Энэ эрсдэлүүдийг Банк болон Групп тогтмол хянан удирддаг бөгөөд хязгаарлалтыг сар (Зээлдэгч нь зээлийн байгууллага үед), улирлаар (зээлдэгч нь зээлийн байгууллага бус үед), тогтоон хяналт тавьдаг. Бүтээгдэхүүн, зээлдэгч, салбарын сегментийн түвшин дэх хязгаарлалтуудыг Зээлийн Хороо нь баталдаг.

Банк, брокерийн компани зэрэг аль нэг зээлдэгчтэй холбоотой үүсч болох эрсдэл нь балансын болон балансын гадуурх эрсдэлийн магадлалын хязгаараар хязгаарлагддаг. Өдөр бүрийн хязгаарын дагуу эрсдэлийн бодит магадлалыг хянадаг.

Үндсэн төлбөрийн эргэн төлөлт болон хүүгийн төлбөрөө төлөх үүргээ биелүүлэх зээлдэгч болон бүлэг зээлдэгчийн чадвар болон боломжид шинжилгээ хийж, зарим тохиолдолд зээлийн хязгаарлалтыг өөрчлөх замаар зээлийн эрсдэлийг удирддаг. Зээлийн эрсдэлийг мөн байгууллага болон хувь хүний баталгаа, барьцаа хөрөнгийг олж авах зэргээр удирдаж байна.

Группийн зээлийн эрсдэлийн хамгийн өндөр нөлөөлөл нь санхүүгийн байдлын тайланд санхүүгийн хөрөнгийн дансны үнээр тусгагдсан байна. Зээлийн эрсдэлийг бууруулахын тулд хөрөнгө ба өр төлбөрийг цэвэрлэснээс үүдэх томоохон нөлөөлөлгүй. Баталгаа болон үүргийн хувьд зээлийн эрсдэлд нөлөөлөх нөлөөлөл нь Эрсдэлийн удирдлагын тэмдэглэл 51-д тайлбарласан нийт өр төлбөртэй тэнцүү байна.

Балансын гадуурх санхүүгийн хэрэглүүрийн зээлийн эрсдэл нь санхүүгийн хэрэглүүрийн гэрээний нэг тал гэрээний дагуух үүргээ биелүүлээгүйгээс гэрээний нөгөө тал алдагдал хүлээх магадлал юм. Групп ажил гүйлгээг батлах, эрсдэлийн хяналтын хязгаар болон хяналтын үйл ажиллагааны горимуудаар баланс дахь санхүүгийн хэрэглүүрт ашигладагтай ижил зээлийн журмуудыг болзошгүй үүргүүдэд баримтална.

Групп нь зээлийн хугацаанд шинжилгээ хийн хугацаа хэтрэлтгүй зээл байгаа эсэхийг тодорхойлдог. Иймд удирдлага нь Эрсдэлийн удирдлага, тэмдэглэл 51-т тайлбарласан зээлийн эрсдэлийн талаар бусад мэдээлэл болон хугацаа хэтэрсэн хугацааны талаарх мэдээллийг гаргана.

Групп нь дуусвар хугацаанаас нь өмнө зээлээ барагдуулах эрх олгодог мөргөйжийн гэх мэт тогтмол болон хувьсах хүүтэй зээлийг олгосноор хугацаанаас өмнө зээлийг хаах эрсдэл хүлээдэг. Тайлант хугацааны эцсээрх болон тайлант жилийн Группийн өмч, санхүүгийн үр дүн нь дээрх эрсдэлийн хэлбэлзлийн хувиас шалтгаалахгүй бөгөөд учир нь эдгээр зээлүүд нь харилцагчдад олгосон зээлийн хорогдуулсан үнэтэй ойролцоо эсвэл үүргээ өмнө биелүүлснээр хорогдуулсан өртгөөр бүртгэгдсэн байна.

51.2 Зах зээлийн эрсдэл

Групп болон Банк нь ерөнхий болон тусгайлсан зах зээлийн өөрчлөлтөнд өртөх магадлалтай хүүгийн түвшин, гадаад валют, өмчийн хэрэглүүрийн нээлттэй позициос зах зээлийн эрсдэлд өртдөг. Зээлийн хороо нь хүлээн зөвшөөрөгдөх эрсдэлийн хязгаарыг бий болгож өдөр бүр хянаж байдаг. Гэсэн хэдий ч энэхүү ашиглаж байгаа арга нь зах зээлийн хүчтэй өөрчлөлтийн үед тогтоосон хязгаараас илүү гарсан алдагдлаас урьдчилан сэргийлж чадахгүй юм.

Зах зээлийн эрсдэлийн удирдлагын зорилго нь эрсдэлийг зөвшөөрөгдсөн хэмжээнд байлгах хүлээн зөвшөөрөгдөх үзүүлэлтүүдийг хянах болон удирдахад оршино.

51.3 Гадаад валютын эрсдэл

Групп болон Банк нь санхүүгийн төлөв байдал болон мөнгөн урсгалаас үүсэх гадаад валютын өөрчлөлтийн нөлөөнд өртдөг. Банкны зээлийн хороо өдөртөө байж болох болон хоног дамжиж болох нээлттэй позицийн хязгаарлалтыг нэг валют болон нийт валютын нийлбэр дүнгээр тогтоон өдөр болгон хянаж байдаг байна.

ТУЗ-өөс гадаад валютын багцын тухайд хүлээж болох эрсдэлийн хязгаарлалтуудыг тогтоож өгсөн. 99%-ийн магадлалтайгаар банкны нээлттэй позицийг үнэлэх, Монголбанкны ханшийн өөрчлөлтийг хэд хэдэн үзүүлэлт болон төсөөлөлтэйгээр авч үзэн, үүнээс учирч болох эдийн засгийн алдагдлыг тооцоолох VaR аргыг Банк болон Групп хэрэглэж байна. VaR нь тодорхой цаг хугацааны хүрээнд, тодорхой магадлалтайгаар Групп ба Банкны гадаад валютын багцын ашиггүй хөдөлгөөн, өөрчлөлтийг тооцох замаар банкинд учирч болох санхүүгийн эрсдэлийг тодорхойлох аргачлал юм.



ГОЛОМТ БАНК БОЛОН ТҮҮНИЙ ОХИН КОМПАНИ

51. ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГА (үргэлжлэл)

51.3 Гадаад валютын эрсдэл (үргэлжлэл)

VaR аргын зорилго болон хязгаарлалтууд

Өнгөрсөн нэг жилийн түүхэн мэдээлэлд үндэслэн гадаад валютын багцын боломжит өөрчлөлтийг тооцоолох зорилгоор банк VaR-ын Делта нормал, Монте Карло, Түүхэн загварчлалын аргуудыг хэрэглэж байна. VaR аргачлал нь зах зээлийн ердийн нөхцөл байдалд гадаад валютын эрсдэлийг тооцоход зориулагдсан. Эдгээр аргуудад хэвийн зах зээлийн орчинд нөлөөлөгч эрсдэлийн хүчин зүйлсийн аливаа өөрчлөлт нь хэвийн тархалттай гэж үздэг. Тархалт нь илтгэгч зэргээр жигнэгдсэн түүхэн мэдээллийг ашиглан тооцоологддог. Эдгээр VaR аргууд нь тодорхой дутагдалтай талуудтай учир нь эдгээр аргууд нь гадаад валютын түүхэн корроляци, хэлбэлзэлд үндэслэдэг ба ирээдүйн валютын ханшийн өөрчлөлт хэвийн тархалттай гэж таамагладаг.

VaR арга нь түүхэн өгөгдөлд үндэслэдэг болохоор эрсдэлийн хүчин зүйлсийн ирээдүйн өөрчлөлтийг сайн тусгаж чадахгүй байх талтай бөгөөд хэвийн тархалтын таамаглалд эрсдэлийн хүчин зүйлсийн өөрчлөлт нь нийцээгүй тохиолдолд гадаад валютын ханшийн их хэмжээний өөрчлөлтийг дутуу үнэлж болох талтай. VaR нь эрсдэлийн хүчин зүйлсийн хоорондын хамаарал, эрсдэлийн хүчин зүйлсүүдэд тавьсан таамаглалаас шалтгаалж эрсдэлийг дутуугаар эсвэл илүүгээр үнэлэх боломжтой. Гадаад валютын позици өдрийн турш өөрчлөгддөг боловч VaR нь зөвхөн өдрийн төгсгөлд хаагдсан багцын эрсдэлийг хэмждэг ба 99% итгэх завсараас хэтэрч алдаж болзошгүй алдагдлын дүнг тооцож чадахгүй.

Практикт гадаад валютын бодит үр дүнгүүд VaR тооцооллоос зөрдөг. Тухайлбал, хэвийн бус зах зээлийн нөхцөлд тооцоолол бодит ашиг алдагдалтай уялдаж чаддаггүй. VaR загварын бодит байдалтай нийцэж буйг тодорхойлохын тулд бодит үр дүнгүүдийг тодорхой хугацааны /гурван сар/ давтамжтайгаар VaR тооцоололтой харьцуулж үзэн Backtesting хийдэг. Зах зээлийн онцгой хүндрэлийн нөлөөг Банк даван туулж чадах эсэхэд баталгаатай байх үүднээс банк гадаад валютын багцдаа тогтмол стресс тест хийдэг.

VaR таамаглалууд

Банк болон Групп нь 99%-ийн итгэх завсар ашиглан VaR тооцдог тул гадаад валютын нээлттэй позиц нэг өдрийн турш өөрчлөгдөхгүй гэж үзвэл боломжит алдагдлын хэмжээ VaR-аас их байх бараг боломжгүй. Нэг өдрийн хугацаанд 99%-ийн итгэх завсартай VaR гэдэг нь аливаа 100 өдрийн бодит ашиг алдагдлын дүн тооцоолж гаргасан VaR-с дунджаар нэг удаа их байхыг илтгэнэ.

VaR нь банкны гадаад валютын эрсдэлийн салшгүй хэсэг тул гадаад валютын нээлттэй позицуудад VaR лимит тогтоосон бөгөөд эдгээр лимитүүдтэй нээлттэй позицийн дүнг өдөр тутам харьцуулж хянаж байдаг. Загварт Монголбанкны гадаад валютын ханшийн эрсдэлийг VaR аргаар хэмжих аргачлалын таамаглалуудаас нэгтгэж өгсөн байдаг.

	Делта нормал	Монте Карло	Түүхэн загварчлал
	мян.төг	мян.төг	мян.төг
2012 – 12 сарын 31	114,443	118,334	129,954
2012 – Өдрийн дундаж	140,253	141,948	183,030
2012 – Хамгийн их	561,410	648,023	740,283
2012 – Хамгийн бага	14,366	14,132	16,130
2011 – 12 сарын 31	94,273	82,478	146,194
2011 – Өдрийн дундаж	104,820	107,649	141,578
2011 – Хамгийн их	339,147	362,101	477,653
2011 – Хамгийн бага	8,632	9,046	11,103

Банк гадаад валютаар илэрхийлэгдсэн зээлүүдийг гаргасан. Зээлдэгчдийн орлогын урсгалаас хамааран Монгол төгрөгийн эсрэг гадаад валютын ханш өсвөл зээлдэгчийн зээлээ эргэн төлөх чадварт сөргөөр нөлөөлөх бөгөөд мөн ирээдүйн зээлийн алдагдлыг өсгөнө.



Доорх хүснэгт нь хэрвээ бүх нөхцөл өөрчлөгдөхгүй үед тайлант хугацааны эцсээрх ашиглагдсан ханшийн зөрүүгийн өөрчлөлтийн боломжит хэлбэлзлийг санхүүгийн үр дүн болон өмчид нөлөөлөх нөлөөг үзүүлсэн. Гадаад валютын ханшийн боломжит өөрчлөлтийг 2012 оны 12 сарын гадаад валютын хамгийн өндөр ханшийн зөрүүд хийсэн шинжилгээгээр тодорхойлсон. 2012 оны гадаад валютын ханшийн хэлбэлзлийн шинжилгээ нь 2012 оны 12 сарын ам.долларын ханшийн хэлбэлзэл нь 0,2% 2012 оны 12 сарын 31-рх бусад валют болон еврогийн ханшийн боломжит хэлбэлзэл нь 0,5% ба 0,9% байгааг харуулсан.

	2012 оны 12 сарын 31	
	Татварын өмнөх ашигт нөлөөлөх нөлөө	Өмчид нөлөөлөх нөлөө
Ам.долларын 0.2%-н өсөлт	-42,728	54,719
Ам.долларын 0.2%-н бууралт	42,728	-54,719
Евро-н 0.9%-н өсөлт	-162,557	-162,557
Евро-н 0.9%-н бууралт	162,557	162,557
Бусад валютын 0.5%-н өсөлт	32,711	32,711
Бусад валютын 0.5%-н бууралт	-32,711	-32,711

Доорх хүснэгт нь хэрвээ бүх нөхцөл өөрчлөгдөөгүй үед тайлант хугацааны эцсээрх ашиглагдсан ханшийн зөрүүгийн өөрчлөлтийн боломжит хэлбэлзлийг санхүүгийн үр дүн болон өмчид нөлөөлөх нөлөөг үзүүлсэн. Гадаад валютын ханшийн боломжит өөрчлөлтийг 2011 оны 12 сарын гадаад валютын хамгийн өндөр ханшийн зөрүүд хийсэн шинжилгээгээр тодорхойлсон. 2011 оны гадаад валютын ханшийн хэлбэлзлийн шинжилгээ нь 2011 оны 12 сарын ам.долларын ханшийн хэлбэлзэл нь 1,0% 2011 оны 12 сарын 31-ний өдрөөрх бусад валют болон еврогийн ханшийн боломжит хэлбэлзэл нь 1,7% ба 1,7% байгааг харуулсан.

	2012 оны 12 сарын 31	
	Татварын өмнөх ашигт нөлөөлөх нөлөө	Өмчид нөлөөлөх нөлөө
USD appreciation by 1.0%	-95,051	393,679
USD depreciation by 1.0%	95,051	-393,679
EUR appreciation by 1.7%	-134,390	-134,390
EUR depreciation by 1.7%	134,390	134,390
Other currencies appreciation by 1.7%	26,030	26,030
Other currencies depreciation by 1.7%	-26,030	-26,030

51.4 Хөрвөх чадварын эрсдэл

Хөрвөх чадварын эрсдэл нь санхүүгийн хөрөнгө болон өр төлбөрийн дуусгавар хугацаандаа төлбөр гүйцэтгэж чадахгүй байх эрсдэл юм. Групп болон Банк нь өөрийн бэлэн мөнгөний эх үүсвэрээс өдөр тутмын гүйлгээ болох харилцах хадгаламж, харилцах дансууд, хугацаа дуусаж байгаа хадгаламжууд, зээл олголт, баталгаа зэрэгтэй холбоотой татан авалтуудыг хийдгээс үүдэн эрсдэлд өртөх магадлалтай. Группын туршлагаас үзэхэд дээрх үүрэг хариуцлагуудыг хангах шаардлагатай мөнгөний нөөцийн түвшинг хангалттай хэмжээнд урьдчилан таамаглах боломжтой байдаг тул банк дээрх бүх татан авалтуудыг хангах хэмжээний бэлэн мөнгөний эх үүсвэр бэлэн байдаггүй.

Групп нь бусад банкуудын байршуулсан хөрөнгө, хуулийн этгээд болон хувь хүмүүсийн харилцагчдын хадгаламж, зээл зэрэг тогтвортой эх үүсвэрүүдийг бүрдүүлэн хадгалан авах сонирхолтой мөн урьдчилан таамаглаагүй төлбөрийн шаардлага үүсэхэд түүнийг хурдан бөгөөд бэрхшээлгүй төлөх чадвартай байх үүднээс Групп хөрөнгийн төрөлжсөн багцад хөрөнгө оруулдаг.

Хөрвөх чадварыг удирдахын тулд Групп нь олон төрлийн эх үүсвэр бүхий санхүүжилт, санхүүжилттэй холбоотой асуудлуудыг шийдвэрлэх эх үүсвэр татах төлөвлөгөө, холбогдох хууль тогтоомж дүрэм журамтай нийцсэн хөрвөх харьцааг байнга хянах замаар хөрвөх чадвартай хөрөнгийн түвшинд шинжилгээ хийх шаардлагатай болдог. Банк хөрвөх чадварын харьцааг өдөр болгон Монголбанкны шаардлагын дагуу тооцоолдог. Жилийн турш хадгалсан харьцааг доор хүснэгтэд үзүүлэв:



ГОЛОМТ БАНК БОЛОН ТҮҮНИЙ ОХИН КОМПАНИ

51. ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГА (үргэлжлэл)

51.4 Хөрвөх чадварын эрсдэл (үргэлжлэл)

	2012	2011
12 сарын 31	41.06%	38.90%
Тайлант жилийн дундаж	36.00%	45.30%
Хамгийн их	41.40%	50.50%
Хамгийн бага	32.30%	38.90%

Банкны Хөрөнгийн Удирдлага нь санхүүгийн хөрөнгө болон өр төлбөрийн талаар мэдээлэл цуглуулдаг. Банкны хөрөнгийн удирдлагын хэлтэс нь өдөр болгоны хөрвөх чадварын харьцааг хянадаг бөгөөд хэрвээ шаардлагатай гэж үзвэл санхүүгийн зах зээл, банкны дотоод зээлээс санг өсгөдөг мөн түүнчлэн тухайн нөхцөл байдлын болон түргэн хөрвөх чадварыг удирддаг.

Группын удирдлагууд нь өдөр бүрийн хөрвөх чадварын позицийг хянан удирдаж, хэвийн болон хэвийн бус зах зээлийн нөхцөл дэх өөр нөхцөл байдлуудад шинжилгээ хийдэг.

Доорх хүснэгт нь 2012 оны 12 дугаар сарын 31-р гэрээний дагуу дуусвар хугацаагаар нь харуулсан өр төлбөрийн дүнг илэрхийлнэ. Хүснэгтэд үзүүлсэн дүн нь мөнгөн урсгалын дискаунтчилаагүй гэрээний дүнг илэрхийлнэ. Эдгээр дискаунтчилаагүй мөнгөн урсгал нь санхүүгийн тайлан дээрх мөнгөн урсгалын дискаунтчилсан үлдэгдлээс ялгаатай байна.

Төлөгдөх дүнгүүд нь тогтмол бус байх тохиолдолд хүснэгтэд харуулсан дүнгүүд нь тайлант үеийн эцсээрх илэрхийлэгдэж байгаа нөхцөлд үндэслэн тодорхойлно. Гадаад валютаарх төлбөрүүд нь тайлант хугацааны эцсээрх хүчин төгөлдөр Монголбанкны ханшаар хөрвүүлэгдсэн.

	3 сараас доош мян.төг	3 сараас 12 сар хүртэл мян.төг	12 сараас дээш мян.төг	Нийт мян.төг
Санхүүгийн хөрөнгө				
Мөнгө болон түүнтэй адилтгах хөрөнгө	186,730,836	-	-	186,730,836
МБ-нд заавал байлгах нөөц	239,329,820	-	-	239,329,820
Бусад банк санхүүгийн байгууллагад байршуулсан мөнгө	214,639,748	30,308	-	214,670,056
Санхүүгийн хөрөнгө оруулалт	347,278,941	42,338,061	16,371,241	405,988,243
Харилцагчдад олгосон зээл	303,815,701	439,055,202	685,051,497	1,427,922,400
Бусад хөрөнгө	9,825,531	1,612,513	3,585,349	15,023,393
Нийт хөрөнгө	1,301,620,577	483,036,084	705,008,087	2,489,664,748
Санхүүгийн өр төлбөр				
Банк, санхүүгийн байгууллагын харилцах, хадгаламж	27,719,582	19,269,448	-	46,989,030
Харилцагчдын харилцах, хадгаламж	922,277,003	709,514,450	424,738,918	2,056,530,371
Үүсмэл санхүүгийн хэрэглүүрүүд			1,172,027	1,172,027
Зээлээр авсан эх үүсвэр	939,955	42,238,322	69,662,131	112,840,408
Хоёрдогч өглөг	-236,470	125,344	34,802,500	34,691,374
Бусад өр төлбөр	70,275,941	15,522,147	2,098,230	87,896,318
Нийт өр төлбөр	1,020,976,011	786,669,711	532,473,806	2,340,119,528
Цэвэр санхүүгийн хөрөнгө /(санхүүгийн өр төлбөр)	280,644,566	(303,633,627)	172,534,281	149,545,220



Доорх хүснэгтэд 2011 оны 12 сарын 31-ны байдлаарх санхүүгийн хөрөнгө болон өр төлбөрийн дуусгавар болох хугацааны шинжилгээг үзүүлэв:

	3 сараас доош мян.төг	3 сараас 12 сар хүртэл мян.төг	12 сараас дээш мян.төг	Нийт мян.төг
Хөрөнгө				
Мөнгө болон түүнтэй адилтгах хөрөнгө	95,317,841	-	-	95,317,841
МБ-д заавал байлгах нөөц	194,549,220	-	-	194,549,220
Бусад банк санхүүгийн байгууллагад байршуулсан мөнгө	221,882,444	-	-	221,882,444
Санхүүгийн хөрөнгө оруулалт	230,599,366	74,397,957	28,072,114	333,069,437
Харилцагчдад олгосон зээл	166,077,087	377,932,364	705,331,437	1,249,340,888
Бусад хөрөнгө	5,874,536	527,235	2,169,757	8,571,528
Нийт хөрөнгө	914,300,494	452,857,556	735,573,308	2,102,731,358
Өр төлбөр				
Банк, санхүүгийн байгууллын харилцах, хадгаламж	9,496,253	-	-	9,496,253
Харилцагчдын харилцах, хадгаламж	890,818,058	519,918,399	428,486,341	1,839,222,798
Үүсмэл санхүүгийн хэрэглүүр			2,570,585	2,570,585
Зээлээр авсан эх үүсвэр	1,475,397	2,925,629	59,027,845	63,428,871
Хоёрдогч өглөг	119,631	13,894,512	33,850,471	47,864,614
Бусад өр төлбөр	25,460,028	5,427,686	2,023,839	32,911,553
Нийт өр төлбөр	927,369,367	542,166,226	525,959,081	1,995,494,674
Цэвэр санхүүгийн хөрөнгө /(санхүүгийн өр төлбөр)	(13,068,873)	(89,308,670)	209,614,227	107,236,684

Хүлээгдэж буй дуусвар хугацаанд үндэслэсэн дээрх шинжилгээгээр, борлуулах зориулалттай санхүүгийн хөрөнгийн багц нь бүхэлдээ удирдлагын тогтоосон багц хөрвөх чадварын үнэлгээгээр “1 сараас доош буюу хугацаандаа байгаа” гэсэн хэсэгт ангилагдсан.

Группийн удирдлагын үзэж байгаагаар хөрөнгө ба өр төлбөрийн хүүгийн түвшин болон дуусвар хугацааны хоорондын уялдаа нь Группийг амжилттай удирдах үндсэн зарчим юм. Банкны бизнесийн үйл ажиллагаа нь тодорхой бус хугацаатай болон олон төрлийн байдаг нь бүх зүйлс уялдаатай байх боломжгүйд хүргэдэг. Уялдаагүй байдал нь банкны ашгийг өсгөх боловч мөн алагдал хүлээх эрсдэлийг ч өсгөдөг. Хөрөнгө өр төлбөрийн дуусвар хугацаа болон хугацаа дуусвар болоход хүү бүхий өр төлбөрийг өөр хэрэглүүрээр солих чадвар нь Группийн хөрвөх чадварыг үнэлэх болон хүү болон ханшийн зөрүүний өөрчлөлтийг тогтооход чухал хүчин зүйл болно.

Харилцагчдын харилцах данснуудын нилээд хэсэг нь хугацаагүй, эдгээр хадгаламжийн тоо болон хадгаламж эзэмшигчдийн төрөл зэргийн ялгаатай байдал зэргээс шалтгаалан Группийн өмнөх туршлага нь харилцагчдын харилцах дансууд нь урт хугацаатай, санхүүгийн тогтвортой эх үүсвэр болж чадна гэж удирдлага нь итгэж байна.

Групп ерөнхийдөө нь гэрээний хүрээнд гуравдагч талыг эх үүсвэрээ гэрээний дагуу буцаан татна хүлээгээгүй учраас Баталгаа болон аккредитивын хувьд хөрвөх чадварын шаардлага нь түүнтэй холбоотой болзошгүй өр төлбөрийн дүнгээс доогуур байх ёстой. Эдгээр үүрэг хариуцлагын ихэнхийн хугацаа нь нэмэлт санхүүжилтгүйгээр дуусах учраас гэрээний дагуу болзошгүй өр төлбөрийн нийт үлдэгдэл нь ирээдүйн мөнгөний хэрэгцээг илэрхийлэхгүй.

51.5 Хүүгийн түвшний эрсдэл

Групп болон Банкны санхүүгийн байдал болон мөнгөн гүйлгээндээ зах зээл дээр идэвхитэй байгаа хүүгийн түвшний хэлбэлзлийн нөлөөллөөс эрсдэл орж байдаг. Энэхүү өөрчлөлтөөс шалтгаалан хүүгийн маржин нь ихсэж болох боловч тооцоолоогүй өөрчлөлтийн улмаас буурч эсвэл бүр алдагдал хүлээж ч болох юм.

Групп нь хүүгийн түвшнээс эрсдэл хүлээх бөгөөд энэ нь тухайн хугацаа болон дүнгээр илэрхийлэгдсэн зээлийн тогтмол хүүгийн түвшин нь татан төвлөрүүлсэн эх үүсвэрийн тогтмол хүүгийн түвшнээс зөрүүтэй үед үүснэ. Практикт хүүгийн түвшин нь богино хугацаанд голдуу тогтмол байдаг. Мөн хөрөнгө болон өр төлбөрийн хувьд гэрээгээр тогтмол хүүгийн түвшинтэй бол энэ нь тухайн зах зээлийн нөхцөл байдлыг тусгахын тулд дахин гэрээ байгуулдаг.

Зээлийн хороо нь дахин үнэ тогтоох хүүгийн түвшний нийцэлтийн түвшинд хязгаар тогтоох хянаж ажилладаг. Боломжит хэджийн хэрэглэл байхгүйгээс Групп нь ерөнхийдээ эдгээрийн хүүгийн түвшинг тохируулахыг хичээж байна.



ГОЛОМТ БАНК БОЛОН ТҮҮНИЙ ОХИН КОМПАНИ

51. ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГА (үргэлжлэл)

51.5 Хүүгийн түвшний эрсдэл (үргэлжлэл)

2012 оны 12 сарын 31	Үндсэн цэг дээрх өөрчлөлт	Хүүгийн цэвэр орлогын мэдрэмж мян.төг
EUR	120	(13,364)
USD	120	(822,398)
MNT	120	(102,289)
EUR	-120	13,364
USD	-120	822,398
MNT	-120	102,289
2011 оны 12 сарын 31		
USD	120	(679,851)
MNT	120	(96,926)
USD	-120	679,851
MNT	-120	96,926

52. МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАНД ТУСГАГДСАН МӨНГӨ БОЛОН ТҮҮНТЭЙ АДИЛТГАХ ХӨРӨНГӨ

	2012 оны 12 сарын 31 мян.төг	2011 оны 12 сарын 31 мян.төг
Бэлэн мөнгө болон Төв банкин дах мөнгө	426,060,656	289,867,061
Бусад банкинд байршуулсан мөнгөн хөрөнгө	214,670,056	221,882,444
Монголбанкны үнэт цаас	247,402,728	178,576,862
	888,133,440	690,326,367
Хасах нь: Групп болон Банкны өдөр тутмын үйл ажиллагааг санхүүжүүлэхэд ашиглагдахгүй Төв банкинд заавал байлгах нөөц	(239,329,820)	(194,549,220)
Мөнгөн гүйлгээний тайланд хүлээн зөвшөөрөгдсөн мөнгө болон түүнтэй адилтгах хөрөнгө	648,803,620	495,777,147

53. ХӨРӨНГИЙН ЗОХИСТОЙ ХАРЬЦАА

Банк нь өөрийн хөрөнгийг удирдахдаа дараах зорилгуудыг баримталдаг. Үүнд: Монголбанкнаас тавьсан өөрийн хөрөнгийн шаардлагуудыг чанд мөрдөх, Банкны үйл ажиллагаа өөдрөг төсөөлөлд үндэслэх мөн Монголбанкны шаардлагын дагуух нийт өөрийн хөрөнгө болон нийт активыг эрсдэлийн шинж чанараар тохируулсан дүнд суурилсан өөрийн хөрөнгийн харьцаа нь хамгийн багадаа 8% (2011: 6%) эрсдэлээр жигнэсэн хөрөнгийн харьцаа нь 13% (2011: 12%) байх шалгуурыг ханган ажиллах. Монголбанкнаас тавьдаг өөрийн хөрөнгийн харьцааны шаардлага хангасан эсэхийг өдөр бүрийн бодит мэдээлэл болон сар бүр өөрсдийн хийсэн тооцоолол дээр үндэслэн Банкны удирдлагууд болон Санхүү эрхэлсэн захирлаар хянуулдаг.

Банк нь Банкны ирээдүйн үйл ажиллагааг өргөжүүлэн хөгжүүлэх зах зээлд болоод хөрөнгө оруулагчид, эзэлдэгчдийн итгэлийг хадгалан ажиллахын тулд өөрийн хөрөнгийн шаардлагатай түвшинг ханган ажиллах сонирхолтой байна. Монголбанкны тодорхойлсон өөрийн хөрөнгийн шаардлагын дагуу эрсдэлээр жигнэгдсэн хөрөнгийн харьцаа нь (өөрийн хөрөнгийн харьцаа) заасан хамгийн бага түвшнээс дээгүүр байх ёстой.



Доорх хүснэгт нь Монгол Улсын хуулийн дагуу бэлтгэгдсэн Банкны тайланд үндэслэсэн өөрийн хөрөнгийн бүтцийг харуулав:

	2012	2011
Өөрийн хөрөнгийн харьцаа	11.25%	9.47%
Эрсдэлээр жигнэсэн хөрөнгийн харьцаа	13.28%	12.85%

	2012 мян.төг	2011 мян.төг
I зэрэглэлийн хөрөнгө		
Энгийн хувьцаа	25,907,593	24,591,543
Нэмж төлөгдсөн капитал	42,322,298	22,344,874
Хуримтлагдсан ашиг	117,007,183	86,407,612
Өөрийн хөрөнгийн бусад хэсэг	2,075,756	5,742,519
Нийт I зэрэглэлийн хөрөнгийн дүн	187,312,830	139,086,548
II зэрэглэлийн хөрөнгө		
Хоёрдогч өглөг	34,802,500	48,872,950
Нийт капитал/Капиталын суурь	222,115,330	187,959,498

12 сарын 31-ний өдрийн байдлаар эрсдэлээр жигнэсэн хөрөнгийг ангилал тус бүрээр доорх хүснэгтэд харуулав:

	2012 оны 12 сарын 31		2011 оны 12 сарын 31	
	Хөрөнгө мян.төг	Эрсдэлээр жигнэсэн актив мян.төг	Хөрөнгө мян.төг	Эрсдэлээр жигнэсэн актив мян.төг
0%	723,655,847	-	498,197,712	-
20%	321,330,367	64,266,073	339,264,661	67,852,932
50%	388,628,910	194,314,455	269,952,860	134,976,430
100%	1,356,066,041	1,356,066,041	1,212,740,347	1,212,740,347
150%	9,776,388	14,664,583	6,629,078	9,943,617
	2,799,457,553	1,629,311,152	2,326,784,658	1,425,513,326

54. БАЛАНСЫН ДАРААХ ҮЙЛ ЯВДАЛ

10 сая долларын үнэ бүхий Credit Suisse-н хоёрдогч өглөг нь 2012 оны 12 сарын 19 байдлаар хугацаа дууссан бөгөөд 2012 оны 12 сарын 31-ны өдрөөр тус өглөгийг бусад өр төлбөр лүү дахин ангилал хийсэн. Балансын өдрөөс хойш Банкны гол хувь нийлүүлэгч нь Credit Suisse-с тус хоёрдогч өглөгийг шилжүүлэн авахаар шийдвэрлэсэн бөгөөд Банкны өмнөөс буцаан төлсөн. Энэхүү тайлангийн өдрөөр Банкны хувь нийлүүлэгч болон Credit Suisse-н хооронд гэрээ байгуулах үйл явц явагдаж байсан.

Аккредитивтай холбоотой Банкны эсрэг гаргасан томоохон нэхэмжлэл нь Японы Иточу Корпораци болон Голомт банкны хооронд байгуулагдаж байгаа шүүхээс нэхэмжлэхийг эргүүлэн татах гэрээний дагуу шийдвэрлэгдсэн. Талууд 1,2 сая ам.доллараар төлбөр хийхээр тохиролцсон бөгөөд Банк тус хүлээн авсан барааны төлбөрийг Иточу Корпорацид 2013 оны 03 сарын 15 өдөр төлсөн.



ГОЛОМТ БАНК БОЛОН ТҮҮНИЙ ОХИН КОМПАНИ

55. ХАРЬЦУУЛСАН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Тодорхой харьцуулах үзүүлэлтүүдийг тайлант жилийн тайлагналтай нийцүүлэх үүднээс дахин ангилсан болно.

56. МОНГОЛ ХЭЛНИЙ ОРЧУУЛГА

Эдгээр санхүүгийн тайлангууд нь мөн Англи хэл дээр бэлтгэгдсэн болно. Монгол болон Англи хэл дээрх хувилбаруудын хооронд ямар нэг зөрүү, ялгаа гарсан тохиолдолд Англи хувийг баримтална.

